

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ
8 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудас
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-16
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	17-152
	<i>Нэг. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын гишүүд 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжлэл/</i>	17-152

**Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы
8 дугаар сарын 30-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 75 гишүүнээс 59 гишүүн ирж, 78.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 57 минутад Төрийн ордны Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд эхлэв.

Чөлөөтэй: С.Жавхлан, Ш.Раднаасэд;

Эмнэлгийн чөлөөтэй: Л.Болд, Д.Ганболд, Д.Дамба-Очир;

Тасалсан: Б.Наранхүү, Н.Номтойбаяр, О.Содбилэг, С.Эрдэнэ, Ж.Эрдэнэбат;

Хоцорсон: О.Баасанхүү-1цаг 40 минут, Б.Жавхлан-40 минут, М.Оюунчимэг- 15 минут, Ч.Хүрэлбаатар-15 минут.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.1-д “Үндсэн хуулийн Жаран есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын нийт /76/ гишүүний дөрөвний гурав /57/-аас доошгүйн ирцтэй бол түүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг авч хэлэлцэхэд хүчин төгөлдөр гэж үзнэ” хэмээн заасныг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар танилцуулж, чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын 75 гишүүнээс 59 гишүүн ирж, 78.7 хувийн ирцтэй байгааг дуулган “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл”-ийн хоёр дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулав.

Нэг. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын гишүүд 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын дэд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Парламентын ардчиллыг төлөвшүүлж, ард түмний засаглах эрхийг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн ахлагч, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Р.Хатанбаатар, Нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн ахлагч, Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, Гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн ахлагч,

Монгол Улсын гавьяат хуульч Н.Лувсанжав, Шүүх эрх мэдлийн хариуцлагыг дээшлүүлж, хараат бус байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан, Парламентын ардчиллыг төлөвшүүлж, ард түмний засаглах эрхийг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн гишүүн, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Д.Ламжав, Нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн гишүүн, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, профессор, хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал, Гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг нэмэгдүүлж,

тогтвортой байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн гишүүн, Үндсэн хууль судлаач О.Машбат, Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүн, доктор Б.Лхагважав, мөн зөвлөлдөх зөвлөлийн гишүүн, Монголын Бурхан шашинтны төв Гандантэгчлэн хийдийн Тэргүүн хамба лам, Ардын Их Хурлын депутат асан Д.Чойжамц, “Монфемнет Үндэсний сүлжээ” төрийн бус байгууллагын зөвлөх Д.Сүхжаргалмаа, Улсын Их Хурлын гишүүн асан Н.Батбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Хууль, эрх зүйн асуудал хариуцсан нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Түвшинжаргал, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх Ц.Болормаа, А.Солонго, Б.Хатантуул, референт Б.Золбоо, Ж.Ганчимэг нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар төр, нийгмийн ахмад зүтгэлтнүүдээс Улсын Их Хурлын гишүүдэд хандаж төр, ард түмний эрх ашгийг дээдлэн Үндсэн хуулийн хэлэлцүүлэгтээ хариуцлагатай оролцохыг уламжилж өгөөрэй гэж хүссэнийг мэдэгдэв.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг. Парламентын ардчиллыг төлөвшүүлж, ард түмний засаглах эрхийг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Г.Занданшатар: 1. 5.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу Хорин хоёрдугаар зүйлийн 4 дэх хэсэг нэмэх:

“4.Энэ зүйлийн 2, эсхүл 3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр гаргаснаас хойш Улсын Их Хурал арав хоногийн дотор сонгуулийг товлон зарлаж, жар хоногийн дотор явуулна. Шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хадгална.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	57
Татгалзсан:	4
Бүгд:	61

93.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2. 5.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу Хорин хоёрдугаар зүйлийн 4 дэх хэсэг нэмэх:

“4.Энэ зүйлийн 2, эсхүл 3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр гаргаснаас хойш Улсын Их Хурал арав хоногийн дотор сонгуулийг товлон зарлаж, жар хоногийн дотор явуулна. Шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хадгална.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	59
Татгалзсан:	3
Бүгд:	62

95.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3. 6.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу Хорин долдугаар зүйлийн 7 дахь хэсэг нэмэх:

“7.Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хууль, бусад хуульд заасан, эсхүл хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн бол нууц санал хураалт явуулна.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	57
Татгалзсан:	5
Бүгд:	62

91.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4. 7.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг нэмэх:

“2.Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Ц.Даваасүрэн, Д.Хаянхярваа, Б.Бат-Эрдэнэ, Ж.Мөнхбат нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	54
Бүгд:	63

14.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Чуулганы нэгдсэн хуралдаанд ирэхгүй байгаа гишүүдийг ирүүлэх шаардлагыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Нямдорж хэлэв.

5.Ажлын хэсгийн гаргасан, 7.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна. Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Д.Эрдэнэбат, М.Билэгт, С.Бямбацогт нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	18
Татгалзсан:	45
Бүгд:	63

28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Ажлын хэсгийн гаргасан, 7.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна. Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	56
Татгалзсан:	7
Бүгд:	63

88.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх санал хураалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Ундармаа, Ц.Мөнх-Оргил нарын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан учир санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалгах санал хэлэв.

7.Ажлын хэсгийн гаргасан, 7.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна. Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэсэн санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	52
Татгалзсан:	11
Бүгд:	63

82.5 хувийн саналаар дээрх санал хураалтыг хүчингүй болгов.

8.Ажлын хэсгийн гаргасан, 7.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна. Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн дахин санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	55
Татгалзсан:	8
Бүгд:	63

87.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх санал хураалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Л.Энхболд нарын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан учир санал хураалтыг хүчингүй болгох санал хэлэв.

9.Ажлын хэсгийн гаргасан, 7.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна. Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэсэн санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 16

Бүгд: 63

74.6 хувийн саналаар дээрх санал хураалтыг хүчингүй болгов.

10.Ажлын хэсгийн гаргасан, 7.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна. Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн дахин санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 4

Бүгд: 63

93.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11. 8.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу Хорин наймдугаар зүйлийн 3 дахь хэсэг нэмэх:

“3.Хянан шалгах түр хороо нь холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн, хараат бус шинжээч томилох, гэрч дуудах, тайлбар, мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах бүрэн эрхтэй. Түр хороо дүгнэлт гаргаж, шаардлагатай бол тухайн асуудлыг эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлж болно. Түр хорооны дүгнэлт шүүхэд үүрэг хүлээлгэхгүй. Хорооны хэлэлцсэн баримтыг нотлох баримтад тооцох эсэхийг шүүх шийдвэрлэнэ.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Х.Болорчулуун, С.Бямбацогт нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 40

Бүгд: 62

35.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

12. 8.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу Хорин наймдугаар зүйлийн 3 дахь хэсэг нэмэх:

“3.Хянан шалгах түр хороо нь холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн, хараат бус шинжээч томилох, гэрч дуудах, тайлбар, мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах бүрэн эрхтэй. Түр хороо дүгнэлт гаргаж, шаардлагатай бол тухайн асуудлыг эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлж болно. Түр хорооны дүгнэлт шүүхэд үүрэг хүлээлгэхгүй. Хорооны хэлэлцсэн баримтыг нотлох баримтад тооцох эсэхийг шүүх шийдвэрлэнэ.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн дахин санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	33
Татгалзсан:	30
Бүгд:	63

52.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх төслийн заалтыг дэмжээгүй тул Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Г.Тэмүүлэн нарын гаргасан, **8.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу Хорин наймдугаар зүйлийн 3 дахь хэсгийг хасах** гэсэн саналын томьёоллоор санал хураалт явагдаагүй болно.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Парламентын ардчиллыг төлөвшүүлж, ард түмний засаглах эрхийг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн төслийн 9, 9.1, 9.2, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.7 дахь саналын томьёоллын санал хураалтыг хойшлуулж байгаа тухай мэдэгдэв.

Мөн төслийн 10, 10.1, 10.2, 10.3, 10.4 дэх саналын томьёололтой холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Г.Тэмүүлэн, Д.Тэрбишдагва, С.Батболд, Д.Эрдэнэбат, Д.Лүндээжанцан, З.Нарантуяа, Б.Баттөмөр нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Энх-Амгалан 12 цаг 52 минутаас 13 цаг 38 минут хүртэл хуралдааныг даргалав.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 41 минут үргэлжилж, 75 гишүүнээс 63 гишүүн ирж, 84.0 хувийн ирцтэйгээр, 13 цаг 38 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 15 цаг 43 минутад эхлэв.

*Чөлөөтэй: С.Жавхлан, Ш.Раднаасэд;
Эмнэлгийн чөлөөтэй: Л.Болд, Д.Ганболд, Д.Дамба-Очир;
Тасалсан: Б.Наранхүү, Н.Номтойбаяр, О.Содбилэг, С.Эрдэнэ,
Ж.Эрдэнэбат;
Хоцорсон: Ё.Баатарбилэг-44 минут, Ж.Мөнхбат-20 минут, Д.Сарангэрэл-40 минут, Д.Сумъяабазар-50 минут, Г.Тэмүүлэн-40 минут, А.Ундраа-15 минут, Ө.Энхтүвшин-40 минут.*

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг үргэлжлүүлэн явуулав.

Г.Занданшатар: 13. 10.Төслийн 2 дугаар зүйл буюу “Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын “нийгмийн хөгжлийн” гэсний дараа “бодлого” гэж, мөн заалтын “батлах” гэсний дараа “Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа Засгийн газрын зөвшөөрөлгүй зардлын шинэ төрөл үүсгэж, зарлага нэмэгдүүлэхгүй. Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх

байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэсэн 2, 3 дахь өгүүлбэр” тус тус нэмэх гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	53
Бүгд:	64

17.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

14.Ажлын хэсгийн гаргасан, **10.1.**Төслийн 2 дугаар зүйлийн “Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын “нийгмийн хөгжлийн” гэсний дараа “бодлого” гэж, мөн заалтын “батлах” гэсний дараа “Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа Засгийн газрын зөвшөөрөлгүй зардлын шинэ төрөл үүсгэж, зарлага нэмэгдүүлэхгүй. Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэсэн 2, 3 дахь өгүүлбэр” гэснийг хасаж, төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16 дахь заалт буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт нэмэх:

16/Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

“7/төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах; Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно. Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна. Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Д.Эрдэнэбат, О.Баасанхүү, С.Чинзориг, Х.Баделхан, Я.Содбаатар, С.Бямбацогт, Ц.Мөнх-Оргил, М.Билэгт, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	58
Татгалзсан:	5
Бүгд:	63

92.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх санал хураалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Элдэв-Очирын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан учир санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн Л.Элдэв-Очирын саналыг оруулж тооцоод 59 гишүүн дэмжиж, 93.7 хувийн саналаар дэмжигдсэнд тооцов.

15.Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, Д.Дамба-Очир, Б.Жавхлан, М.Оюунчимэг, Д.Тэрбишдагва, Б.Ундармаа нарын гаргасан, **10.2.**Төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын “батлах” гэсний дараа “Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг

урт, дунд хугацааны хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлнэ. Энэхүү бодлого, төлөвлөлтийг тогтвортой залгамж чанартай хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллагатай байна.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналын томьёололтой холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тэрбишдагва, Ж.Бат-Эрдэнэ, Ц.Даваасүрэн, О.Баасанхүү, Б.Баттөмөр, Ж.Батзандан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	53
Бүгд:	63

15.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр **10.3.Төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын “бодлого” гэснийг “дунд, урт хугацааны бодлого” гэж өөрчлөх гэсэн саналаа татаж авав.**

16.Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатын гаргасан, **10.4.Төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Засгийн газрын өрийн дээд хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас илүүгүй байна. Төрийн татвар хураамжийг зөвхөн хуулиар тогтооно.” гэсэн өгүүлбэр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Д.Эрдэнэбат, М.Билэгт, З.Нарантуяа, Н.Цэрэнбат, Б.Бат-Эрдэнэ, Д.Тэрбишдагва, О.Баасанхүү, Л.Энх-Амгалан, Д.Хаянхярваа, Ж.Батзандан, М.Оюунчимэг, Б.Баттөмөр, Ц.Мөнх-Оргил, Ц.Гарамжав нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	4
Татгалзсан:	60
Бүгд:	64

6.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

17.Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатын гаргасан, **10.4.Төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Засгийн газрын өрийн дээд хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас илүүгүй байна. Төрийн татвар хураамжийг зөвхөн хуулиар тогтооно.” гэсэн өгүүлбэр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	41
Бүгд:	64

35.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 18 цаг 36 минутад чуулганы хуралдааны цагийг сунгаж хуралдах тухай хэлэв.

18.Ажлын хэсгийн гаргасан, **11.Төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалтад “Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх аливаа оролдлогыг үл зөвшөөрөх бөгөөд мөнхүү зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг хориглоно;” гэсэн агуулгатай 2 дахь өгүүлбэр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Д.Эрдэнэбат, С.Бямбацогт нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	58
Татгалзсан:	6
Бүгд:	64

90.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх санал хураалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, Б.Бат-Эрдэнэ, Б.Чойжилсүрэн, Ц.Даваасүрэн нарын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан учир санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, Б.Бат-Эрдэнэ, Б.Чойжилсүрэн, Ц.Даваасүрэн нарын саналыг оруулж тооцоод 62 гишүүн дэмжиж, 96.9 хувийн саналаар дэмжигдсэнд тооцов.

Мөн төслийн 12, 12.1, 12.2, 12.3 дахь саналын томъёоллын санал хураалтыг хойшлуулж байгаа тухай мэдэгдэв.

19. 13.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж Улсын Их Хурал шийдвэрлэсэн бол Улсын Их Хурал тарна.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	15
Татгалзсан:	48
Бүгд:	63

23.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

20.Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат болон ажлын хэсгийн гаргасан, 13.1.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэн эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн санал болгосноор Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар өөрөө тарах шийдвэр гаргаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	60
Татгалзсан:	4
Бүгд:	64

93.8 хувийн саналаар дэмжигдлээ.

21. 14.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуулийг Улсын Их Хурлын нийт

гишүүний олонхийн саналаар батална.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	53
Бүгд:	64

17.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

22.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, **14.1.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“6.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуулийг Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар эцэслэн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	55
Татгалзсан:	9
Бүгд:	64

85.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх санал хураалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатар, Н.Учрал, Б.Жавхлан нарын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан учир санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалгах санал хэлэв.

23.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, **14.1.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“6.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуулийг Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар эцэслэн батална.” гэсэн саналыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	54
Татгалзсан:	9
Бүгд:	63

85.7 хувийн саналаар дээрх санал хураалтыг хүчингүй болгов.

24.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, **14.1.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“6.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуулийг Улсын Их Хурлын нийт

гишүүний олонхийн саналаар эцэслэн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	57
Татгалзсан:	6
Бүгд:	63

90.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатарын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан учир санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатарын саналыг оруулж тооцоод 58 гишүүн дэмжиж, 92.1 хувийн саналаар дэмжигдсэнд тооцов.

25.Ажлын хэсгийн гаргасан, 15.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17 дахь заалт буюу Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг нэмэх:

17/Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан тодруулга хийж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат, Л.Мөнхбаатар, Х.Нямбаатар, С.Бямбацогт, Ц.Даваасүрэн, С.Чинзориг, Ц.Мөнх-Оргил, О.Батнасан, Н.Энхболд нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	49
Татгалзсан:	11
Бүгд:	60

81.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх санал хураалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Оюунхоролын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан учир санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалгах санал хэлэв.

26.Ажлын хэсгийн гаргасан, 15.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17 дахь заалт буюу Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг нэмэх:

17/Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно.” гэсэн санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	52
Татгалзсан:	10
Бүгд:	62

83.9 хувийн саналаар дээрх санал хураалтыг хүчингүй болгов.

27.Ажлын хэсгийн гаргасан, **15.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17 дахь заалт буюу Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг нэмэх:**

17/Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	55
Татгалзсан:	7
Бүгд:	62

88.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх санал хураалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Ундармаа, С.Чинзориг нарын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан учир санал хураалтыг хүчингүй болгох санал хэлэв.

28.Ажлын хэсгийн гаргасан, **15.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17 дахь заалт буюу Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг нэмэх:**

17/Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	51
Татгалзсан:	11
Бүгд:	62

82.3 хувийн саналаар дээрх санал хураалтыг хүчингүй болгов.

29.Ажлын хэсгийн гаргасан, **15.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17 дахь заалт буюу Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг нэмэх:**

17/Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	57
Татгалзсан:	5
Бүгд:	62

91.9 хувийн саналаар дэмжигдлээ.

30. **17.Төслийн 4 дүгээр зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд,” гэснийг “Ерөнхий сайд,” гэж өөрчлөх гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Зөвшөөрсөн:	1
Татгалзсан:	61
Бүгд:	62

1.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

31. **17.Төслийн 4 дүгээр зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд,” гэснийг “Ерөнхий сайд,” гэж өөрчлөх гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.**

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, Ц.Мөнх-Оргил, Д.Тэрбишдагва, Д.Лүндээжанцан, С.Бямбацогт нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	39
Татгалзсан:	23
Бүгд:	62

62.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх санал хураалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан тайлбар хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн **17.Төслийн 4 дүгээр зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд,” гэснийг “Ерөнхий сайд,” гэж өөрчлөх гэсэн төслийн заалтын санал хураалтыг хойшлуулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.**

32.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан, **17.Төслийн 4 дүгээр зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд,” гэснийг “Ерөнхий сайд,” гэж өөрчлөх гэсэн төслийн заалтын санал хураалтыг хойшлуулах нь зүйтэй гэсэн горимын саналыг дэмжье санал хураалт явуулъя.**

Зөвшөөрсөн:	50
Татгалзсан:	12
Бүгд:	62

80.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг төслийн заалтын санал хураалтыг хойшлуулав.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, **17.1.Төслийн 4 дүгээр зүйлээс “Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд” гэснийг “Ерөнхий сайд,” гэж,” гэснийг хасах гэсэн саналын томъёоллын санал хураалтыг хамтад нь хойшлуулав.**

33. **20.Төслийн 4 дүгээр зүйл буюу Хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тавиас доошгүй” гэснийг “далан таваас доошгүй” гэж өөрчлөх гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Зөвшөөрсөн:	55
Татгалзсан:	7
Бүгд:	62

88.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх санал хураалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Д.Лүндээжанцан, Ц.Гарамжав нарын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан учир санал хураалтыг хүчингүй болгох санал хэлэв.

34. **20.Төслийн 4 дүгээр зүйл буюу Хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тавиас доошгүй” гэснийг “далан таваас доошгүй” гэж өөрчлөх гэсэн санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.**

Зөвшөөрсөн:	53
Татгалзсан:	6
Бүгд:	59

89.8 хувийн саналаар дээрх санал хураалтыг хүчингүй болгов.

35. 20.Төслийн 4 дүгээр зүйл буюу Хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тавиас доошгүй” гэснийг “далан таваас доошгүй” гэж өөрчлөх гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 4

Бүгд: 59

93.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх санал хураалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, О.Батнасан нарын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан учир санал хураалтыг хүчингүй болгох санал хэлэв.

36. 20.Төслийн 4 дүгээр зүйл буюу Хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тавиас доошгүй” гэснийг “далан таваас доошгүй” гэж өөрчлөх гэсэн санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 6

Бүгд: 62

90.3 хувийн саналаар дээрх санал хураалтыг хүчингүй болгов.

37. 20.Төслийн 4 дүгээр зүйл буюу Хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тавиас доошгүй” гэснийг “далан таваас доошгүй” гэж өөрчлөх гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 2

Бүгд: 62

96.8 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэгийн гаргасан, **20.1.Төслийн 4 дүгээр зүйлийн Хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ээлжит чуулганы ажлын өдрийг тухайн жилийн 3 дугаар сарын 01-ээс, мөн 7 дугаар сарын 29-нөөс эхлэн тоолно.”** гэсэн 2 дахь өгүүлбэр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 47

Бүгд: 62

24.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

39. 21.Төслийн 4 дүгээр зүйл буюу Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн дугаарыг “4” гэж, “Байнгын” гэснийг “Байнгын болон бусад” гэж өөрчлөх гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 48

Бүгд: 61

21.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

40.Ажлын хэсгийн гаргасан, **21.1.Төслийн 4 дүгээр зүйлийн “далан таваас доошгүй” гэж** гэсний дараа “Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн дугаарыг “4” гэж, “Байнгын” гэснийг “Байнгын болон бусад” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 4
Бүгд: 62
93.5 хувийн саналаар дэмжигдлээ.

41. 22.Төслийн 4 дүгээр зүйл буюу Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Ерөнхий сайд, Засгийн гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь” гэснийг “Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол албан үүрэгт нь” гэж өөрчлөх гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 52
Бүгд: 62
16.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22.1 дэх саналын томъёоллын санал хураалтыг хойшлуулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

42.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан, ажлын хэсгийн гаргасан, **22.1.Төслийн 4 дүгээр зүйлийн “Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь” гэснийг “Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол албан үүрэгт нь” гэснийг хасаж, төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18 дахь заалт буюу Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг нэмэх:**

18/Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайдаас бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангарагаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно.” гэсэн саналын томъёоллын санал хураалтыг хойшлуулах нь зүйтэй гэсэн горимын саналыг дэмжье санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 11
Бүгд: 64

82.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг ажлын хэсгийн гаргасан саналын томъёоллын санал хураалтыг хойшлуулав.

**Хоёр.Гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг нэмэгдүүлж,
тогтвортой байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн
талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол**

43. 23.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу Дөчин зургадугаар зүйлийн 4 дэх хэсэг нэмэх:

“4.Төрийн жинхэнэ алба нь мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай байх, шатлан дэвших зарчимд үндэслэнэ. Төрийн албан хаагчийг улс төрийн шалтгаанаар ялгаварлан гадуурхах, сонгуулийн үр дүнгээр, эсхүл хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөх, халахыг хориглоно. Төрийн албаны

чадахуйн зарчмын хэрэгжилтэд тавих хяналт хараат бус байна.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 57
Бүгд: 63
9.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Л.Мөнхбаатар нарын болон ажлын хэсгийн гаргасан, **23.1**.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу Дөчин зургадугаар зүйлийн 4 дэх хэсгийг “Төрийн жинхэнэ алба нь мэргэшсэн, тогтвортой, ёс зүйтэй, хариуцлагатай байх, шатлан дэвших чадахуйн зарчимд үндэслэх бөгөөд түүний хэрэгжилтэд тавих хяналт хараат бус байна. Төрийн жинхэнэ албан хаагчийг хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөх, халахыг хориглоно.” гэж өөрчлөх гэсэн саналын томъёололтой холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Ж.Ганбаатар, Д.Лүндээжанцан, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Л.Энх-Амгалан, С.Чинзориг, С.Батболд, М.Билэгт, Н.Учрал, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Дээрх төслийн 23.1 дэх саналын томъёоллын санал хураалттай холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн завсарлага авах тухай мэдэгдэж, завсарлага авав. /22:24/

Чуулганы нэгдсэн хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтын үйл ажиллагааг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга З.Нямцогт, мөн хэлтсийн шинжээч Р.Дэлгэрмаа, М.Номиндулам нар хариуцан ажиллав.

Хуралдаан 9 цаг 23 минут үргэлжилж, 75 гишүүнээс 64 гишүүн ирж, 85.3 хувийн ирцтэйгээр 22 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ
ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ 8 ДУГААР САРЫН 30-НЫ
ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Занданшатар: Эрхэм гишүүдийн ирцийг танилцуулъя. Нийт ирвэл зохих 75 гишүүнээс өвчтэй, чөлөөтэй 4, 71 гишүүн ирэхээс 59 гишүүн ирж, ирц 78,7 хувьтай бүрдсэн байна.

Иймд Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг үргэлжилнэ.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11-ийн 11.3.1-д Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурав буюу 57-оос доошгүй ирцтэй бол түүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг авч хэлэлцэхэд хүчин төгөлдөр гэж үзнэ гэж заасан. Ирц 59 гишүүний ирцтэй бүрдсэн байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай. Ажлын хэсгийн гишүүдийн нэрийг танилцуулъя. Дэд ажлын хэсгийн ахлагч, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Р.Хатанбаатар, дэд ажлын хэсгийн ахлагч, Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, дэд ажлын хэсгийн гишүүн Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Д.Ламжав, дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын гавьяат хуульч Н.Лувсанжав, дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор, профессор О.Мөнхсайхан, дэд ажлын хэсгийн гишүүн, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга, дэд профессор, хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал, дэд ажлын хэсгийн гишүүн, Үндсэн хууль судлаач, Аюулгүй байдал судлалын үндэсний хүрээлэнгийн захирал О.Машбат, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор, профессор Д.Гангабаатар.

Мөн урилгаар оролцож байгаа Зөвлөлдөх зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Гадаад хэргийн сайд асан Ц.Гомбосүрэн, Монголын Бурхан шашинтны төв Гандантэгчлэн хийдийн Тэргүүн хамба лам, Ардын Их Хурлын депутат асан Д.Чойжамц, Улсын Их Хурлын гишүүн асан Н.Жанцанноров, Улсын Их Хурлын гишүүн асан, Ардын Их Хурлын депутат, Ардын Их Хурлын орлогч дарга асан Нямжавын Батбаяр, Монголын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч асан Б.Лхагважав, “Монфемнет Үндэсний сүлжээ” төрийн бус байгууллагын зөвлөх Д.Сүхжаргалмаа, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор

Ц.Сарантуяа, Хүний эрхийн Үндэсний комиссын дарга Ж.Бямбадорж нар урилгаар оролцож байна.

Санал, асуулт дууссан. Одоо санал хураалт үргэлжилнэ.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ, бид эх орон, ард түмний дээд эрх ашиг, эрх чөлөө, шударга ёс, тусгаар тогтнол, аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхийн төлөө энэхүү өөрчлөлт, шинэчлэлтийг хийх нийгмийн хариуцлагаа гүнзгий ухамсарлах ёстой. Хөгжил дэвшил, аюулгүй байдлын баталгааг хангах төрийн тогтвортой байдал, хяналт тэнцлийг хангах зорилготой Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэн батлах нь нийгмийн захиалга, ард түмний хүсэл эрмэлзэл болсон байна гэдгийг анхаарвал зохино. Өчигдөр, өнөөдөр төр, нийгмийн ахмад зүтгэлтнүүдээс хандаж, Улсын Их Хурлын гишүүдэд гагцхүү төр, ард түмний эрх ашгийг дээдлэн Үндсэн хуулийн хэлэлцүүлэгтээ хариуцлагатай оролцохыг Улсын Их Хурлын гишүүдэд уламжилж өгөөрэй гэж хүссэнийг та бүхэндээ дамжуулан мэдэгдэж байна.

Одоо нэмэлт, өөрчлөлтийн санал хураалтаа үргэлжлүүлье. Ирцэд орсон хүмүүс чуулганы танхимдаа орж ирцгээгээрэй.

5 дахь санал хураалтын 1 дэх санал хураалтыг хийгээд зогссон байгаа.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу Хорин хоёрдугаар зүйлийн 4 дэх хэсэг нэмэх:

4.Энэ зүйлийн 2, эсхүл 3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр гаргаснаас хойш Улсын Их Хурал 10 хоногийн дотор сонгуулийг товлон зарлаж 60 хоногийн дотор явуулна. Шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хадгална гэсэн ийм төслийн заалт байгаа.

Эхний санал хураалтаар энэ санал унасан. Энэ бол дордуулсан гэгддэг долоон өөрчлөлтийг засах хүрээнд орж ирсэн өөрчлөлт. Энэ өөрчлөлт, Төрийн байгуулалтын байнгын хорооноос ирүүлсэн томъёолол бол 4.1 дэх заалт дэмжигдсэн учраас Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах шийдвэр гаргаснаас хойш тодорхойгүй байдал үргэлжлэхээр байгаа учраас тодруулж, Улсын Их Хурлыг тарааснаас хойш сонгууль явуулах хугацааг зааж өгөхгүй бол хязгааргүй үргэлжлээд байх бололцоотой гэсэн ийм үндэслэлээр 60 хоногийн гэдэг хугацааг оруулж байгаа ийм асуудал байна.

Санал хураалтад гишүүд бэлэн болсон уу? Энэ заалт бол төслийн заалт буюу 62 гишүүний өргөн мэдүүлсэн зөвшилцлийн ажлын хэсэг, Төрийн байгуулалтын байнгын хороон дээр хөндөж өөрчлөөгүй төсөл болно. 1 дэх санал хураалт явагдсан. 2 дахь санал хураалт явагдана. Үг хэлэх дэг алга аа.

За, төслийн заалтыг уншсан. Санал хураалтаа явуулъя. Сахилгагүй гишүүдийг хүлээсээр байтал төрийн ажил цалгардлаа. Тамгын газар хоёр хаалган дээр сандал тавиад хүн суулга. Одоо хүн гаргахгүй.

Санал хураалтаа явуулъя. Нэгд, энэ дордуулсан долоон өөрчлөлтийг засаад, хоёрт, Улсын Их Хурал тарснаас хойш хугацаагүй байгааг тодруулж байгаа гэсэн. Оюунчимэг, Жавхлан гишүүн хоёр орж ирээрэй. Гишүүд дэгээ сахина шүү.

Чуулганы танхимд Улсын Их Хурлын гишүүн
Октябрийн Баасанхүү, Самандын Жавхлан, Шатарбалын Раднаасэд,
Лувсанвандангийн Болд, Жамъянгийн Мөнхбат, Отгонбилэгийн Содбилэг,
Даваагийн Ганболд, Батсүхийн Наранхүү, Нямтайширийн Номтойбаяр,
Содномзундуйн Эрдэнэ, Болдын
Жавхлан, Мөнхөөгийн Оюунчимэг, Жаргалтулгын Эрдэнэбат нар чуулганы
танхимдаа ирээрэй.

Оюунчимэг гишүүн 1 цаг 20 минут хоцорлоо шүү. Танхим дүүрэн гишүүд
хүлээлгээд. Гишүүд хариуцлагатай байна шүү.

Санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу Хорин хоёрдугаар зүйлийн 4
дэх хэсэг нэмэх:

4.Энэ зүйлийн 2, эсхүл 3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр гаргаснаас хойш
Улсын Их Хурал 10 хоногийн дотор сонгуулийг товлон зарлаж, 60 хоногийн дотор
явуулна. Шинээр сонгогдсон гишүүд тангараг өргөтөл, Улсын Их Хурал бүрэн
эрхээ хадгална. Төслийн заалт.

Санал хураалт явуулахад бэлэн боллоо.

Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт эхэллээ.

Санал хураалтад 61 гишүүн оролцож, 57 гишүүн дэмжиж, төслийн заалт
дэмжигдлээ. Ингээд, дахин санал хураалт энэ заалтаар хураагдаж дэмжигдэж
байж энэ заалт босно. Одоогоор бол нэг унаж, нэг дэмжигдсэн байгаа. Ахиж унших
шаардлагагүй, шууд санал хураалт явуулчих уу? Энэ төслийн 5 дахь заалт шүү.

5 дахь санал хураалт.

Санал хураалт.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 59 гишүүн дэмжиж, 95.2 хувийн
саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. 6 дугаар заалт.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу Хорин долоодугаар зүйлийн
7 дахь хэсэг нэмэх:

7.Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ.
Үндсэн хууль, бусад хуульд заасан, эсхүл хуралдаанд оролцсон
гишүүдийн олонх дэмжсэн бол нууц санал хураалт явуулна. Төслийн
заалт. Төслийн заалт гэдэг нь 62 гишүүнээс өргөн мэдүүлсэн төслийн заалт.
Долоон өөрчлөлттэй холбоотойгоор залруулж байгаа заалт байна.

Санал хураалт

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 57 гишүүн дэмжиж, 91.9 хувиар санал
дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг нэмэх:

2.Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь Хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна. 62 гишүүнээс өргөн мэдүүлсэн төслийн заалт байна. Цаашид төслийн заалт гэж товчилж хэлнэ.

Журмын болон дэгийн тухай хуулиар асуулт байхгүй. Дэмжсэн, дэмжээгүй, хүн үг хэлж болно. Шууд санал хураалтаа явуулах уу? Үг хэлэх гишүүд кнопоо дараарай. Бат-Эрдэнэ гишүүнээр үг тасаллаа.

Эрхэм гишүүн Данзангийн Лүндээжанцан үг хэлнэ.

Д.Лүндээжанцан: Энэ заалт бол хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар, Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь Хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал, Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна гэж байгаа юм. Төсөл дээрээ ингэж орж ирсэн. Энэ ямар учиртай вэ гэхээр, санал хурааж, Түр хороо байгуулъя гэж яриад бүтэн жил явдаг. Тэгээд тэрийг нь Их Хурал шийддэг.

Энэ дээр Үндсэн хуульд ингэж орж ирснээрээ хуулийн биелэлттэй холбоотой нийтийн сонирхлыг хөндсөн том, том асуудал гараад нийгэмд эргэлзээ төрчихсөн, энэ дээр нь хууль, хяналтын байгууллага анхаарч байна уу, анхаарахгүй байна уу гээд. Эсхүл түүнээс гадуур өөр асуудлууд гараад ирсэн үед энэ 19 гишүүн буюу дөрөвний нэг нь асуудлыг тавибал тэрийг заавал цөөнхийн төлөөллийг оролцуулаад байгуулна гэдэг ийм чухал заалт байгаа юм.

Дэлхийн олон улс оронд, парламентад энэ Хянан шалгах түр хороо байгуулах асуудал орж ирсэн байдаг. Дээр нь гэрч дуудах, нотлох баримт энэ тэртэй холбоотой юмыг нь хасъя. Ерөнхий энэ нь үлдэг гээд ингээд үлдсэн. Тэгээд төслийн энэ дэмжигдэхгүй юм гэхэд ард нь найруулгаар авсан байгаа. Яагаад гэвэл энэнтэй яг адилхан, тэгсэн мөртөө Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гээд энэ заалтаа ард нь бусад хууль зүйн техникийн хувьд бусад Байнгын хороо болон бусад хорооны энэ бүрэн эрхийг хуулиар зохицуулна гэдгийг нь хамтруулаад хийгээд өгөхгүй бол Түр хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, журмыг хуулиар тогтооно, энийг бас хуулиар тогтооно гээд ийм хууль зүйн техникийн хувьд засаад орж ирж байгаа юм гэдгийг та бүхэндээ хэлье.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Одоогийн энэ заалт дэмжигдээд тэгээд дараагийн нэг заалт байна шүү дээ, гэрч дуудах, тайлбар мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах. Энийг нь ингээд хасаад явчихсан юм байна лээ л дээ. Тэгвэл зүгээр л хуучин Их Хурлын тухай хуулиараа Түр хороо байгуулаад явахтайгаа ялгаагүй болчхоод байгаа юм. Тэр чинь мөн л бас ингээд тодорхой асуудлаар Түр хороо байгуулж болдог эд шүү дээ. Тэгэхээр энэ заалтыг нь, дараагийн хоёр дахь заалтыг дэмжихгүй бол энэ ямар ч үр дүнгүй болно.

Ер нь ийм зүйл байх хэрэгтэй. Яагаад гэвэл төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой асуудлууд, прокурор, шүүхийн удирдлагуудтай холбоотой асуудлууд энэ тэрийг олон улсын парламентын жишиг ерөөсөө ийм л байгаа шүү дээ. Энд одоо Их Хурлын гишүүд, сайд, энэ улсуудтай бол хууль, хүчний байгууллагууд нь бол чаддаггүй. Яагаад гэвэл янз бүрийн байдлаар дарамт үзүүлчихнэ. Тийм учраас Их Хурал төрийн эрх барих дээд байгууллага парламент өөр дээрээ татаж авч энэ асуудлыг шийддэг. Та нар Клинтонь асуудлыг санаж байгаа байх тийм ээ? Нэг хүүхэнтэй орооцолдсон асуудлаар. Яг түүн шиг одоо ингээд дуудаад гэрчийн мэдүүлэг аваад, зүгээр тангараг өргүүлж байгаад хэлдэг нь хаашаа юм бэ. Гэхдээ ийм байх хэрэгтэй. Ингэж байж ёс зүй төлөвшинө.

Тэгээд хэрэгтэй, хэрэгтэй юмнуудаа авч хаячхаад байвал Үндсэн хуулийн өөрчлөлт ямар ч хэрэг байхгүй. Нуухыг нь авах гээд нүдийг нь сохолно, тэгээд долоо дордуулснаа дал дордууллаа гэдэг ийм шүүмжлэлд өртөнө. Би хэрвээ энэ заалт дэмжигдсэн тохиолдолд дараагийн хоёр дахь, үүнтэй холбоотой мэргэжлийн бус энэ Түр хороо нь шинжээч томилох, гэрч дуудах, тайлбар мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах ийм бүрэн эрхтэй байх энэ юу нь уначих юм бол энэ шал дэмий юм болно. Зүгээр л нэг тунхгийн чанартай. Ийм тунхгийн чанартай заалтуудыг оруулмааргүй байгаа юм.

Одоо ингээд л баялгийг тэгш хуваарилна гээд. Тэгш хуваарил гэснээр тэгш хуваарилахгүй шүү дээ. Тэр хувьцаа эзэмшиж байгаа байдлаасаа шалтгаална, нөгөө талаараа хөрөнгө оруулснаасаа шалтгаална. Хэзээ ч тийм биелэхгүй мөртөө лоозонгийн чанартай ийм юмнуудыг бид нар хийгээд байна шүү дээ. Тийм учраас би энэ Үндсэн хууль дээр оруулж байгаа юмнууд тодорхой байх хэрэгтэй. Баялгийн сан гэхэд яг юунаас бүрдэх юм бэ? Баялгийн сантай байна л гэж байгаа юм. Энэ дээр одоо ингээд хэрвээ яг энэ гол юмнуудыг нь аваад хаячих юм бол энэ Түр хороо үүргээ гүйцэтгэж чадахгүй ээ. Зүгээр дэмий л ийм юм болно. Тэгэхээр, Үндсэн хууль хэлэлцэж байгаа энэ үедээ, үнэхээр болж бүтэхгүй байгаа авлига, төрийг сулруулж байгаа хариуцлагагүй байдал зэргээ засъя гэж байгаа бол энэ чинь л хэрэгтэй шүү дээ.

Ялангуяа хууль, шүүхийн байгууллага дээр бид нар Шүүхийн хяналтын зөвлөлийг аваад хаячхаж байгаа юм. Яг ингээд сайжраад, бас нэг хэрэгтэй юм болов уу гэж байсан юмнуудаа аваад хаячихсан учраас би энэ Үндсэн хуулийн асуудал дээр бас нэг тийм итгэл үнэмшил төрж өгөхгүй оргиод байгаа юм. Хэрвээ энийг дэмжсэн тохиолдолд дараагийн энэ заалтыг заавал дэмжих хэрэгтэй. Тэгж байж энэ чинь явна. Яагаад ажлын хэсэг дээрээ энийгээ ингээд Байнгын хорооны хуралдаан дээр хасах гэдгийг нь дэмжчихсэн юм, бүү мэд. Энэ бол маш буруу. Тэгэхээр энэ дээр гишүүд минь анхаарч явахгүй бол хоёрын хооронд Үндсэн хуулийн өөрчлөлт хийсэн нэр зүүж, тэгээд ингээд олонхи байгаа бид нар дээр тэр нь тохогдож үлдээд нэг ийм ядарсан юм хийсэн юм даа гэсэн ийм ярианд орчих вий гэж би бодоод байгаа юм.

Тийм учраас хэлэлцүүлэг явахдаа бас сайн яриад, хөөрөөд ингээд явахгүй бол, өчигдрийн үдээс хойш харж байхад асуухаа больчихож, ярихаа больчихож, хэлэлцэхээ больчихож. Ийм ардчилалгүй байж болохгүй шүү дээ. Энэ олон түмний төлөөлөл болж яваа юм бол олон түмний хэлж, ярьж байгааг л ярьдаг байх хэрэгтэй. Албан тушаал авсан гээд амаа үдүүлээд байх албагүй, авч болно.

Ер нь Улсын Их Хурлын гишүүн бол тэр олон түмний өмнө очихдоо юу гэдэг билээ, юу гэж ярьдаг билээ, юу гэж ганганадаг билээ? Тэгээд энд ирэхээрээ шал өөр юм болчихно. Тэгээд дараа нь сонгуульдаа янз бүрийн дүн авцгаачихна. Байр суурин дээрээ зөв илэрхийлээд, асуудлаа тодорхой яриад л явах хэрэгтэй шүү дээ. Энд гайхаад байх юм юу байгаа юм бэ? Ингээд яв л гэж бид нар энэ Их Хурлыг чинь байгуулсан. Хууль нь тийм шүү дээ.

Тийм учраас энэ ярих юмнууд дээрээ сайн яриад. Үнэхээр одоо Үндсэн хуулийг бас нэг гайгүй хууль гаргачихъя гэж байгаа бол сайн ярьж шүүгээд. Өчигдөр бол одоо нэг инээдтэй юм харагдаж л байна лээ л дээ.

Боссон юман дээр бол одоо ингээд миний санал одоо буруу гарчихлаа гээд ингээд нэмж болно. Унасан юм нь дээр болохгүй гэсэн мөртөө дараа нь нэмээд хаячхаж байгаа байхгүй юу. Инээдэмтэй. Нэг санал дутсан чинь.

Тэгээд ер нь бол унасан зүйл дээр одоо миний санал ингээд гацсанаас болж энийг нэмье гэсэн ийм зүйл хэлж болохгүй. Ц.Нямдорж сайд одоо өчигдөр та нарт сануулаад л байна лээ шүү дээ. Энэ хариуцлагатай зүйл шүү. Үндсэн хууль өөрчилнө гэдэг бол. Яг тоглоомынхоо дүрмийг тогтож аваад яг түүгээрээ явах хэрэгтэй. Энэ чинь түүх. Тийм учраас одоо энэ цаашдаа цаашдын 20 жил, 100 жил, магадгүй 200 жилийг ингээд зохицуулах хуулийн заалт дээр бол бид нар хайнга хандаж болохгүй шүү дээ. Сайн ярих хэрэгтэй.

Би бол одоогийн энэ яригдаж байгаа энэ нэг Их Хурлын Түр хороог бол зөв юм гэж бодож байгаа. Хяналтын хамгийн дээд талын тогтолцоо бол Их Хурал. Энийгээ гүйцэтгэж чадахгүйгээс болоод тэр прокурор, тэр шүүхүүд чинь өнөөдөр ингээд давраад хөх тэнгэр дээр байна гэдгээс өөр юмгүй болчихоод байгаа юм. Энэ төрийн өндөр эрх мэдэлтнүүд, өндөр албан тушаалтнууд чинь ингээд дураараа дургидаж болчихоод байгаа юм. Их Хурлаа давж харьцдаг. Их Хурлаа муулдаг. Их Хурал нь өөрөө албан тушаал дээрээ, байр суурь дээрээ эзэн шиг байж чаддаггүйгээс болж өнөөдөр Их Хурлын нэр хүнд бол олон түмэнд унасан. Их Хурал Их Хурал шигээ байж чадаад ингээд үүргээ гүйцэтгээд явдаг бол өөр. Их Хурал нь хувцасгүй шалдан хүн шиг. Ямар ч эрх мэдэл байхгүй. Ямар ч тойрсон бүтэц байхгүй.

Тийм учраас өнөөдөр Их Хурлыг зүгээр нэг 76 гишүүн аваад явчих юм шиг бодоод байгаа. Үгүй. Тэнд бүх институци нь байх ёстой. Хэрвээ хяналтын байгууллага байгаа бол энэ түр хороонд байгаад, энийгээ бэхжүүлсэн хуулийн мэргэшлүүдээр дэмжүүлсэн ийм бүтэцтэй явж байж энэ юм чинь явна уу гэхээс биш зүгээр нэг ажлын хэсэг шиг нэг хэдэн гишүүн гарч ирээд бүх юмыг хийгээд яваад байна гэвэл үүн шиг худлаа юм байхгүй. Төсвийн хороо байгуулъя гэсэн байхгүй. Нэг судалгааны нэг албатай байсан. Тэр нь овоо явж байсан. Одоо үхчихсэн, байхгүй. Тийм учраас Их Хурал бол хүчтэй байх ёстой. Тийм учраас Их Хурлынхаа энэ үүргийг сайн хэрэгжүүлье. Сайн гүйцэтгэж ажиллая. Хяналтаа сайн тавья гэж байгаа бол энэ дараа нь тэр хассан байгаа заалтаа эргэж хараарай гэдгийг одоо би бас гишүүддээ хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Дамдины Хаянхярваа үг хэлнэ.

Д.Хаянхярваа: Би саяны энэ заалтыг бол яах вэ энүүгээрээ ороход болох юм гэсэн байдлаар харж байгаа юм. Ер нь зүгээр тэгэхдээ одоогийн байгаа Их Хурлын, Үндсэн хуулиар бол түр хороо байгуулаад явж уг нь болоод л байгаа шүү

дээ. Заавал энэ заалт байх шаардлагатай ч юм уу, үгүй ч юм уу гэдгийг нь одоо би бас сайн хэлж мэдэхгүй л байна.

Тэр ингээд ингээд цувсан 3 заалт байгаа юм. Тэр цувсан 3 заалтаа хамгийн сүүл дээр нь сая Ц.Даваасүрэн гишүүний хэлээд байгаа түр хороо байгуулна, дүгнэлт гаргана, шинжээч томилох, гэрч дуудах гээд. Тэрийг бол би ерөөсөө эрс эсэргүүцэж байгаа. Ийм байж болохгүй. Бид нар яагаад энэ шударга бус явдал, яагаад энэ хууль хяналтын байгууллага өөрийн хүрээнд ажлаа хийж чадахгүй байна вэ гэдэг дээр ганцхан дүгнэлтээ хийх ёстой. Өнөөдөр бид нарын одоо энэ Үндсэн хуулийн, өнөөдрийн хэлэлцэж байгаа Үндсэн хуулийн амин сүнс нь бол гарцаа байхгүй ерөөсөө энэ шүүхийн хараат бус байдалтай холбогдож оруулсан 9 заалтыг бол би одоо энэ өнөөдрийн Үндсэн хуулийн хэлэлцэж байгаагийн ач холбогдол гэж үзэж байгаа. Ард иргэдтэй уулзаад энд тэнд явж байхад бол ерөөсөө л ганцхан энийг л ярьж байгаа. Шударга ёсны хүсэмжлэл их өндөр байна гэж манай Их Хурлын гишүүд хаа ч очсон бүгдээрээ ярьж байгаа.

Шударга ёсны хүсэмжлэл үнэхээр их өндөр байгаа бол бид шударга шүүхтэй байх ёстой. Шударга шүүхтэй байя, шударга хууль хяналтын байгууллагатай байя гэвэл хараат бус шүүхтэй, хараат бус байх ёстой гэдэг энэ л зарчим үйлчилнэ.

Хэрвээ үнэхээр бид нар энэ хараат бус шүүхтэй байх тухай асуудлыг, хууль хяналтын байгууллагуудыг улс төрөөс ангид байлгах тухай асуудлыг Үндсэн хуулиар ямар нэгэн байдлаар бид нар энийг шийдэж чадахгүй бол бид нар энд мянган түр хороо байгаад ч, мянган одоо янз бүрийн сайн муу байгууллагууд байгаа ч энэ асуудлыг шийдэж чадахгүй. Энэ удаагийн Үндсэн хуулиар хийх гэж байгаа бид нарын өөрчлөлтийн гол зорилго бол би тэгж л харж байгаа. Аль болохоор сайн засаглалтай, хуулийн сайн засаглалтай орнуудын тэр шүүхийн хараат бус байдлыг хэрхэн яаж Үндсэн хуульдаа тусгадаг, бусад органик хуулиудаараа яаж зохицуулдаг, энэнээс улс төрчид нь яаж ангид байдаг вэ гээд. Энэ бүхнийг үзэж байж нэлээн нарийвчлан судалж байж сүүлийн хоёр гурван жил судалж байж оруулсан тэр заалт дээрээ бид нар хатуу байх ёстой. Тэгэхгүй бол зүгээр одоо өнөөдөр ингээд бүгдийг нь нийлүүлээд нэг хоёр өгүүлбэр болгоод тэгээд шүүхийн хараат бус байдалтай болгоно гээд томилгоо чөлөөлөх асуудлыг бас л бахь байдаг нэг хүний эрх мэдэлтэй үлдээх юм бол бид нарын энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг ярьсны ач холбогдол оршихгүй гэж би бодож байгаа юм.

Чи яагаад энэ түр хороон дээр одоо энэ шинжээч томилох, гэрч дуудах, тайлбар мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах гээд ийм бүрэн эрхтэй хороо байна гэдгийг эсэргүүцээд байгаа юм бэ гэх юм бол одоо энэ чинь бол өнөөдрийн манай улс төрийн амьдрал харж байгаа юмыг харахад бол юу ч хийж болохоор байна. Бид нар хороо байгуулбал.

Мэдээж одоо энд сайн талууд бий. Би энийг үгүйсгэхгүй. Үнэхээр одоо бас нийгэмд болохгүй байгаа томоохон дуулиантай энэ асуудлууд дээр хяналт тавиад хууль хяналтын байгууллагуудыг нь одоо шахалт үзүүлээд. Тэд нарын буруу зөрүү ажиллагааг хянаад явах тэр боломж сайн тал байгаа хэдий ч гэсэн, нөгөө талдаа бол бид өнөөдөр одоо ингээд бид нарын улс төрийн төлөвшил ямар байгаа билээ. Энэ улс төрийн төлөвшил ийм сул байгаа үед бол нөгөө ёстой жинхэнэ цэгэн чинээ хар юмыг уулын чинээ болгож, уулын чинээ хар юмыг цэгэн чинээ болгож доош нь хийж болох боломжийг эндээс бид нар бүрдүүлж гарах магадлалтай. Тийм учраас аливаа асуудлын шийдэл нь, зөв шударга шийдэл гарна гэдэгт бол,

бас яахын арга байхгүй эргэлзээ төрж байгаа ийм асуудал учраас бид тэр эхний саяны одоо баталъя гэж байгаа оруулж ирсэн санал дээрээ байх нь зөв юм болов уу даа ингэж бодож байгаа.

Тэгэхдээ “хуулиар тогтооно” гэдэг үгийг бас нэг бичсэн байгаа юм л даа. Энэ “хуулиар тогтооно” гэдгийн цаад талд одоо бид нар өнөөдөр энэ Үндсэн хуульдаа нэлээн хэд хэдэн асуудлууд дээр бол зөвшилцөх тэр одоо ажлын хэсгийнхэн бол хуулиар тогтооно, хуулиар тогтооно гэсэн юмнууд оруулаад байгаа юм. Тэр бол бас цаад талд нь бид нар энэ хууль ямар хууль гарах вэ, энийг яаж ямар хуулиар яаж зохицуулах вэ, хуульдаа яаж тусгах вэ гээд цааш цаашдаа бол бас нэлээн бодох нарийн ширийн зүйлүүд бол байгаа байх гэж ингэж бодож байгаа юм.

Тэгээд энэ Үндсэн хуулийг батлах явцдаа бол аль болохоор бид нар өнөөдөр нийгмийн хүсэн хүлээсэн хамгийн гол асуултад л хариулт өгөх хэмжээний ийм л нэмэлт, өөрчлөлтийг батлах ёстой шүү гэдгийг хамгийн гол нь иргэд одоо энд байгаа Их Хурлын гишүүд бид нар ухамсарлаж энэ дээр яг өөрсдийнхөө бодлоор энэ дээр аягүй сайн одоо анхааралтай хандаж ажиллах ёстой гэсэн ийм саналыг би хэлмээр байна.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Б.Бат-Эрдэнэ үг хэлнэ.

Б.Бат-Эрдэнэ: За, та бүхнийхээ амгаланг айлтгая. Би бол энэ төслийн заалтаа дэмжмээр байгаа юм л даа. Түрүүн Ц.Даваасүрэн гишүүний хэлж байгаа энэ саналтай бол нэг саналтай байгаа юм.

Хоёрдугаарт, нэг хэлэх гээд байгаа юм бол манай Их Хурлын гишүүд жаахан хариуцлагатай бөгөөд тэвчээртэй баймаар байна. Би энд одоо үг хэлье гэсэн нэрээ өгч байгаа гишүүд бол 10 минутыг ашиглаж үг хэлж байгаа хүн тун цөөхөн байгаа шүү дээ. Хоёр гуравхан минутад. Хамгийн их нь 5 минутад багтаагаад л үгээ хэлж байгаа учраас. Тэгээд үг, нэр авахаар зэрэг л дэрхийгээд л босоод гараад алга болчих юм. Ийм байж болмооргүй байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт бол одоо түрүүн Д.Тогтохсүрэн дарга хэлсэн. Энэ гишүүдэд одоо сонголттой ийм байдлаар хандаж болмооргүй байгаа юм. Зарим нэг гишүүд нь бол одоо жишээлэх юм бол тааллаараа энэ хуралд ордог. Саналаа өгөхгүй байж болдог. Ийм байж болохгүй шүү дээ. Тэгээд энэ улсууд чинь ирэхгүй байгаа улсууд ямар санаа, шалтгаантай байгаа юм. Тэгээд наад талдаа одоо эрүүл мэндийн шалтгаан хэлчихдэг. Үнэхээрийн ийм бодитой шалтгаан байгаа юм уу, үгүй юу. Ийм байж одоо болмооргүй байна шүү дээ.

Би энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал тавигдсанаас хойш би тодорхой шаардлагыг тавьж байгаа. Энэ Их Хуралд одоо суудалтай байгаа улс төрийн намууд энд одоо сонгогдсон хүмүүсийн оролцоог нь хангаач ээ. Улсын Ерөнхийлөгчийн саналыг аваач ээ. Цаашилбал, одоо улс төрийн намууд, тэгээд одоо иргэдийн хэлэлцүүлэг оролцоог хангаач. Дээр нь хамгийн чухал нь бол хуулийн дагуу ард түмний санал асуулгыг явуулаач ээ гэж би маш тов тодорхой шаардлага, саналыг хэлж байгаа. Тийм ч учраас өнөөдөр энд одоо байгаа бололцоотой улсуудын оролцоог нь хангаад ингээд явах хэрэгтэй байхгүй юу. Энд нэг хүн эргэлзээтэй байх юм бол маш одоо ноцтой үр дагавар гарна шүү. Тухайлбал, өнөөдөр одоо хурал эхлэхээс өмнө манай Ц.Даваасүрэн нөхөр бол хэллээ шүү дээ. Та нар энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал ярьж байгаа бол энэ төр, ард түмний эсрэг гэмт хэрэгтнүүд шүү гэж хэлж байгаа байхгүй

юу. Би энэ олон удаа сонгогдсон, одоо кабинетын гишүүн ийм шударга хүн бол ямар нэгэн асуудал байгаа юм биш биз. Бид бол цэвэр итгэл үнэмшлээрээ энэ 2000 оны дордуулсан долоо өөрчлөлтийг сэргээхтэй холбоотой асуудлуудыг оруулж байна. Хэд хэдэн улс төрийн намууд, баялгийн хуваарилалттай холбоотой хэд, хэдэн чухал өөрчлөлтүүдийг оруулж байна. Ямар ч байсан одоо, тогтолцооны хувьд нэлээн, үр дүнтэй ийм өөрчлөлтийг оруулах нь гээд ингээд одоо өөрийн итгэл үнэмшлээрээ, би энд чинь сууж байна шүү дээ. Зөвхөн өөрийн итгэл үнэмшлээрээ биш, иргэд олон түмэнтэй энэ, шатар алсан хэлэлцүүлэгт оролцоод иргэдийнхээ, сонгогчидтойгоо уулзаад, тэндээс төрсөн итгэл үнэмшлээрээ энд ингээд сууж байгаа байхгүй юу.

Тийм учраас, одоо ингээд нэг гишүүн ийм байр суурьтай байж байхад, зүгээр одоо хаяад, өө тэр нэг хүн ямар хамаатай юм. Өчигдөр, жишээлэх юм бол О.Баасанхүү үг хэлэх асуудлыг нь хаачхаад, тэр хамаа байхгүй гээд ингээд зүтгээд явж болохгүй шүү дээ. Өнөөдөр Ц.Даваасүрэн гишүүн маш тодорхой асуудал хэлж байгаа учраас энийг одоо намын удирдлагууд, энэ Их Хурлын удирдлага, одоо та бүхэн минь, энийгээ нэг мөр мухарлах хэрэгтэй. Тэгэхгүй ерөөсөө ингээд л, зарим нэг нь бол Ц.Даваасүрэн гишүүн ингээд байр сууриа илэрхийлж байна. Зарим нь бол хэлэхгүй, чихгүй толгойлоод таг алга болчихоод байгаа улсууд энд чинь зөндөө байна шүү дээ. Ийм байдлаар бол ажил асуудалд хандаж болохгүй шүү гэдгийг би хариуцлагатайгаар хэлье.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Жамъянгийн Мөнхбат үг хэлнэ.

Ж.Мөнхбат: За энэ, Улсын Их Хурлын хяналтыг сайжруулах энэ заалтыг дэмжиж байгаа юм. Өнөөдөр бид нар энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр бол нэлээн хэдэн хэдэн чухал зүйлүүдийг хөндсөний нэг бол энэ.

Хариуцлагыг сайжруулъя гэдэг асуудал яригдсан. Хариуцлага сайжруулъя гэдэг үүднээс энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр Улсын Их Хурлын гишүүнийг эргүүлэн татдаг болж байна. Улсын Их Хурал хариуцлагагүй ажиллах юм бол хугацаанаасаа өмнө тарах асуудлыг хуучин, Үндсэн хуульд байсан заалтыг нэлээн тодорхой болгож тодруулж, энэ зохицуулалтыг нь хийж өгч байна. Давхар дээлийн асуудлыг одоо бас нэлээн оруулж ирж байгаа.

Ийм, ийм зүйлүүд ингээд явж байгаа. Тэгээд энэ үед бол энэ Ерөнхий сайдыг зөвхөн Их Хурал томилдог. Засгийн газрын гишүүдийг нь томилдоггүй байдлаар одоо Засгийн газарт тодорхой хэмжээний боломж мэдээлэл өгч байгаа энэ үед бол Улсын Их Хурал төрийн эрх барих дээд байгууллага, парламентын засаглалтай улс орны хувьд бол, энэ одоо Засгийн газар гүйцэтгэх ажиллагааныхаа түвшинд, энэ улс орны түвшинд одоо нийгмийн өмнө, ард түмний өмнө одоо санал сэтгэлийг нь зовоосон ийм асуудал байх юм бол хяналт тавьдаг, түр хороо байгуулж энэ асуудлыг нь одоо мэдээллийг нь цуглуулдаг, энэ шалгалтыг хийдэг ийм хяналтын хороотой байх нь зөв.

Тэгээд энэ дээр бол бас ахиц дэвшилттэй заалт орж ирж байгаа шүү дээ. Цөөнхөө хүндэтгэж байна. Цөөнхийн төлөөллийг оролцуулна гэсэн ийм заалтыг бас Үндсэн хуульдаа хуульчилж өгч байгаа. Ингэснээрээ өнөөдөр ардчиллын бас амин сүнсний нэг болсон энэ цөөнхийн байр суурь, эрх ашгийг хүндэтгэнэ гэдэг энэ зүйл Үндсэн хуульд орж албажиж баталгаажиж байна. Ийм ийм зүйлүүд байгаа.

Тэгээд ийм хариуцлагатай асуудлыг ярьж байгаа. Монгол Улсын Үндсэн хуулийг өөрчилж байгаа энэ үед бол манай Их Хурлын гишүүд хариуцлагатай баймаар байна. Ц.Нямдорж сайдын уурлаад бухимдаад байгаа нь зөв шүү дээ. Аргагүй. Энэ гишүүдийн бухимдаад байгаа зөв.

Өглөө 9, 10 цагаас эхлээд л оройн 8, 9 цаг болтол ирээд суудаг. 1 хүн хүлээдэг, 2 хүн хүлээдэг. Кнопоо хийж ирцдээ бүртгүүлчхээд, гараад явчихсан хүнийг хүлээдэг. Иймэрхүү байдлаар л Үндсэн хуулийг өөрчлөх гээд явж байна. Тэгээд одоо сүүлдээ энэ ажил төрөлд нь тус дэм болъё гэж явсныхаа төлөө энэ зарим бүлгийн дарга, удирдлагууд хүртэл энэ гишүүд рүүгээ дайрч томордог энэ юмаа болих хэрэгтэй. Энэ олонхын бүлгийн дарга энэ бүлгээ цуглуул. Энэ шаардлагыг одоо би энэ өнөөдрөөс яг энэ мөчөөс эхлэн дахин дахин тавина. Тийм. Олонх юм бол олонх шиг байх ёстой. Яах гэж ард түмнээс 64, 65 суудал авч ард түмний итгэлийг авч, ард түмнийхээ саналаа сонсож байж Үндсэн хуулиа өөрчилнө гэж мөрийн хөтөлбөртөө тусгасан юм.

Энд цөөнхийн буруу байхгүй шүү дээ. О.Баасанхүүгийн ч буруу байхгүй шүү дээ. Жаран дөрвүүлээ байж 56, 57 хүн цуглуулж чадахгүй байвал энэ олонхын бүлгийн бүлэг удирдаж байгаа хүмүүсийн л асуудал шүү дээ. Энийг би ялангуяа одоо бүлгийн даргад хандаж хэлмээр байна. Цаашдаа энийг одоо үйл ажиллагаа дээрээ бодоорой.

Г.Занданшатар: Гишүүд хэлэлцэж байгаа асуудлаа ярина шүү. Гишүүд орж ирнэ шүү одоо. Санал хураалт.

Ц.Нямдорж гишүүн горимын санал хэлнэ.

Ц.Нямдорж: Үндсэн хуулийн энэ хэлэлцүүлэг хийгдэж байгаа ажлыг дөрөв дэх удаагаа харж байна. 1992 онд, энэ Д.Лүндээжанцан эд нар Бага Хурлаар хэлэлцэж байхад харж л байсан. 1999 оны өөрчлөлтийг харж л байсан. 2001 оныхыг харж л байсан. Энэ удаагийнхыг харж байна.

Энэ дотор яг миний хувьд бол санал нийлэхгүй юмнууд байгаа. Тэгэхдээ энэ олон гишүүд санал нийлээд асуудал ярьж байгаа учраас хүндэтгэлтэй хандаад өнөөдрийг хүрч байна.

Би гол юм энэ байхгүй байгаа гишүүдээ ирүүлээч ээ л гэж хэлэх гэж байгаа юм. Энэ хэн болчихсон юм, юу болчихсон юм. Энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг болсон болоогүй ард түмэн туйлын анхааралтайгаар ажиглаж байгаа. Ганц ч болов амьдралд садаа болоод байгаа заалтыг өөрчлөөсэй гэж залбираад гэртээ байж байгаа.

Энэ О.Баасанхүү гишүүн, Б.Пүрэвдорж гишүүн, Ардчилсан намын гишүүдийн тавьж байгаа шаардлагатай би 100 хувь санал нэг байна. Ардын намын харьяалалтай албан тушаал авах болохоороо ганцхан удаа сонгогдчихоод Ерөнхий сайд болчихдог. Бараг сонгогдоогүй байж сайд болчихдог атлаа Үндсэн хуулийн асуудал улс орны амин чухал эрх ашгийн асуудалтай. Магадгүй дараачийн 10 жилд ярих бололцоогүй ийм асуудал ярьж байхад яагаад энэ хүмүүс чинь ирдэггүй юм. Хэн болчихсон юм, юу болчихсон юм.

Жаргалтулгын Эрдэнэбат нэг удаа сонгогдоод Ерөнхий сайд болсон. Хоёр ч юм уу. Энэ Нямтайширын Номтойбаяр ганц удаа сонгогдоод сайд болсон. Хоёр

дахиа. Эд нар хаачсан юм. Энэ Отгонбилэгийн Содбилэг хаачсан юм. Аав нь Их Хурлын гишүүн байсан. Ээж нь Их Хурлын гишүүн байсан. Өөрөө болсон. Монголын төр, Монгол Ардын Нам хоёр энэ гэр бүлд бүх чадах чинээгээрээ тусалж дэмжиж явсан. Энэ хүн чинь хаашаа алга болчихдог юм.

Та нар энэ залуучууд албан тушаал болохоор би, би гээд давхидаг. Төрийн, ард түмний амин чухал эрх ашгийн асуудал ярихаар яагаад алга болчихдог юм. Яагаад та нар өглөө 10 цагтаа хуралдаа ирж сурдаггүй юм. Бүтэн 3 жил зарим нь унтлаа. Одоо болоо юм биш үү. Өөр хэн хэн алга энд. За, тэр Д.Дамба-Очир гишүүн. Өчигдөр тэр Чингэлтэйн Ганболд гишүүн, Үндсэн хуулийн асуудал хэлэлцэнэ гэдгийг мэдсээр байгаад онгоцонд суугаад алга болсон гэж байна лээ.

Д.Дамба-Очир гишүүн шалтгаантай байгааг ойлгож байна. Ч.Хүрэлбаатар шалтгаантай байгааг ойлгож байна. Өөр. Ш.Раднаасэд шалтгаантай байгаа. Гэр бүлийн хүн эмчлэх. Бусад нь шалтгаан байхгүй. Энэ гишүүдээ дууд.

Энэ Лүндээ мань мэтийг янз янзаар нь дуудаад өчнөөн л юм болж байгаа. Бид нар та нараас ичиж байна. Сая нэр хэлсэн этгээдүүдээс. Энэ этгээдүүдээс болж бид нар О.Баасанхүү гишүүн өдөр болгон бичлэг хийлгүүлж байна. Б.Пүрэвдорж гишүүнээр өдөр болгон загнуулж байна. Энэ зөв. Хүний өмнөөс ичих шиг адгийн юм байдаггүй юм байна. Монгол Ардын намын парламентын бүрэлдэхүүн ийм сахилгагүй байсныг би, Лүндээ би хоёр энэ 30 жилийн хугацаанд үзээгүй юм байна. Үзээгүй юм байна.

Монгол Улсын Үндсэн хуульд Ерөнхийлөгч Их Хурлын чуулганд тааллаараа ирнэ гээд биччихсэн байдаг юм. Бусад нь энд сууж байх ёстой юм. Би түрүүн хэлсэн.

Тэгэхээр, би Их Хурлын дарга горимын ямар шаардлага тавих гэж байна вэ гэхээр энэ сая нэр дурдсан энэ баян тарган гишүүд ээ дууд аа. Хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхахгүй гээд Үндсэн хуульд биччихсэн байдаг юм. Хөрөнгөндөө аархаад байгаа юм уу, хаашаа юм эд нар чинь. Өөрсдийнх нь хөдөлмөрлөж бий болгосон хөрөнгө биш л дээ. Гарал үүсэл мэтийг нь бол, мань мэт нь гадарлана. Хэзээ, энэ Их Хурал чинь сахилгатай болох юм.

Ардчилсан нам засаг барьж байсан үед ч гэсэн энэ ингээд ирц байхгүй. Байнгын мөнхийн ийм хэрүүл болж байдаг. Одоо Ардын намынхан яг тийм тал руугаа явлаа. Ардын намын харьяалалтай 40-өөд шинэ гишүүн бий. Та нар хэзээ бид нарын дараа энэ төрийг төр шиг аваад явж чадах юм бэ. 2016 онд та нарыг нялх хүүхдүүд дэвшиж байхад мань мэт нь цагаан магтаалаар магтаад өдөр шөнөгүй явж байсан юм. Та нарыг Монголын төрд ороод аятайхан ажиллалч болов уу гэж горьдож байсан юм. Хаана байна тэр горьдлого. За яах вэ мань мэтийнх нь сэтгэл рүү ус хийчих. Тэр сонгосон ард түмнийхээ сэтгэл рүү битгий ус хийгээч дээ та нар.

Бид нар явна. Бид нар явсны дараа, та нар яаж төр барих гэж байгаа юм. Яаж энэ 3 сая ард түмний амьдралыг авч явах гэж байгаа юм та нар. Албан тушаал, эрх мэдэл, мөнгөнөөс өөр бодох юм байхгүй. Ядаж л ажилдаа цагтаа ирж сураач дээ. Цэцэрлэгийн хүүхэд биш дээ та нар чинь. Унтаад байх юм. Юугаа хийгээд яваад байдаг юм. Шөнөжин бааранд ажил амьдралаа өнгөрүүлдэг юм уу, хаашаа юм та нар. Арай хэтэрч байна. Яг энэ цалгар назгай байдал чинь энэ

парламентын нэр төрийг гутаахад олон түмний дунд таагүй амьсгал бий болоход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байгаа.

Их Хурлын дарга энэ шаардлагуудаа тавиач дээ. Энэ Их Хурлын гишүүдийн дотор чинь тусгай дархан эрхтэй гишүүн нэг ч байхгүй. Бүгдээрээ адилхан энд сууж байх ёстой. Тэр тусмаа Үндсэн хуулийн асуудал хэлэлцэж байхад, ямар учиртай юм.

Намайг загнаж байна л гэж хэлэх байх, би загнаж байна, тэгээд юу гэж. Би жирийн хүн загнаагүй, ард түмний төлөө үхэн хатан зүтгэнэ гэж тангараг өргөсөн гишүүд чинь хуралд ирэхгүй болохоор би тэр гишүүдэд чинь хандаж үг хэлж байна. Надад тийм ёс суртахууны эрх байгаа байх, Лүндээд байгаа байх, Энхтүвшинд байгаа байх, Улаанд байгаа байх.

Г.Занданшатар: Санал хураалт явуулна. Ер нь өглөө онцлон хэлсэн. Бид энэ эх орон, ард түмэн, эрх чөлөө, шударга ёс, тусгаар тогтнол, аюулгүй байдал, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэхийн төлөө энэхүү өөрчлөлт шинэчлэлтийг нийгмийн захиалга, ард түмний хүсэн хүлээлт гэж үзэх ёстой. Энэ бүх судалгаа ард түмэн өөрөө хүсээд байна. Энэ захиалгад оролцохгүй санаатайгаар юм уу, санамсаргүй байдлаар оролцохгүй байгаа гишүүд үүнийг анхаараарай, энэ Нямдорж гишүүний анхааруулж хэлж байгаа зөв шүү. Тэгээд эсэргүүцээд юм яриад байх шаардлагагүй. Саяны нэр дурдсан гишүүд яагаад энэ чуулгандаа оролцдоггүй, яагаад энэ ажилдаа оролцохгүй мөртөө гэнэт өөр өөр юм яриад байдаг юм.

Одоо санал хураалтаа явуулна.

Төслийн заалтаар түрүүн уншиж танилцуулсан, төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу хорин хоёрдугаар зүйлийн 3 дахь хэсэг нэмэх:

Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаан эхэлснээс 45 хоногийн дотор эсхүл Ерөнхий сайдыг шинээр томилох нөхцөл үүссэн өдрөөс . . . /энэ биш/

7 дугаар заалт байна.

7 дугаар заалт. Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийг нэмэх:

2.Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороо байгуулна гэсэн төслийн заалт байна.

Төслийн заалтыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 63 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, энэ санал дэмжигдсэнгүй.

Дараагийн заалтыг хамтатган хэлэлцэнэ гэсэн 1 агуулгатай заалт өөрчлөн найруулсныг танилцуулъя.

7.1. Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

2. Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.

Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

Санал гаргасан: Ажлын хэсэг.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал байна.

Дэмжсэн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтыг хүчингүй болгоё. Хүчингүй болгосон.

Энэ 1 агуулгатай заалтыг хамтатган хэлэлцье гэсэн дэгтэй. Тэр дагуу Тэрбишдагва гишүүн өчигдөр санал гаргаад дэмжигдсэн уг нь. Ер нь хамтатган хэлэлцэнэ, дэг нь хамтатган хэлэлцэнэ гэж байгаа.

Санал дээр харин үг хэлэх асуудлыг зөвшөөрсөн.

Үг хэлэх хүн байвал кнопоо л дарна шүү дээ. Бямбацогт гишүүнээр тасаллаа. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Би уг нь энэ төслийн заалт нь үлдээд, одоо үүний дараагийн дараагийн тэр хасчхаад байгаа заалт нь босоо үлдээд явбал дээр юм болов уу гэж ингэж бодоод байгаа юм. Тэгэхгүй яг одоогийн энэ байгаагаараа орчих юм бол цөөнхийн төлөөллийг оролцуулна гэсэн нь сайн зүйл. Тэгэхдээ энэ тэр дараагийн заалт хасагдах юм бол ямар ч олигтой юм болохгүй. Тэгэхээр Үндсэн хуулийн асуудал дээр байр сууриа илэрхийлнэ. Зарим хүн Бат-Эрдэнэ гишүүн Засгийн газрын гишүүн байхдаа дуугүй байсан бол таны хэрэг ээ. Би бол Хэнтийн тойргийг төлөөлөөгүй, би Хөвсгөлийн тойргийг төлөөлж байна. Тийм учраас, бас зарим нэг хүмүүс намайг үг хэлэхэд янз бүрийн байр суурь битгий илэрхийл.

Г.Занданшатар: Төслийн заалтаараа л үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Тийм учраас би энэ гарч байгаа саналууд дээр иргэдийн хэлсэн байр суурийг илэрхийлнэ. Долоон өөрчлөлт хийх гэж байгааг би ойлгож байна. Долоон өөрчлөлтөө буцаах гэж байгааг ойлгож байна. Би долоон өөрчлөлтийг оруулахад байгаагүй шүү. Өөрсдөө та нар тэр үед байсан. Та нар эсэргүүцэж дуугарсан уу? Дуугарсан бол өнөөдөр намайг загнаж болно.

Г.Занданшатар: Энэ төслийн заалтын талаар л үг хэлнэ, өөр асуудал яриад байна та. Долоон заалт гээд өөр асуудал.

Өчигдөр Тэрбишдагва гишүүн горимын саналаар татчихсан юм.

Одоо эрхэм гишүүн Дондогдоржийн Эрдэнэбат.

Дараагийн заалт дээр та үгээ хэлнэ.

Д.Эрдэнэбат: Баярлалаа. Гишүүд жаахан чимээгүй болохгүй юм уу. Тэр хамтатган хэлэлцэж бол болохгүй ээ. Заалт болгон дээр цөөнх өөрсдийнхөө үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх ёстой шүү дээ, тэр эрхийг хааж болохгүй гэж би ойлгож байна. Одоо бол тус тусдаа хэлэлцэнэ гэж ойлгож болох уу? Их Хурлын дарга аа, тус тусдаа биз дээ.

Г.Занданшатар: Журмын тухай хуулиар хамтатган хэлэлцэнэ гэж байгаа юм.

Саналын зүйл болгон дээр тус тусдаа.

Д.Эрдэнэбат: Санал болгон дээр тус тусдаа, саналаа хэлнэ.

Энэ дээр ийм байгаа юм. Хоёр өөр заалт энэ заалт дээр хамтатгаад орчхоод байгаа юм. Хянан шалгах түр хороо гэдэг бол яг статусаараа Их Хуралд яг бусад түр хороотой адилхан ижил эрхтэй, зохион байгуулалттай түр хороо. Үүнийг тэгж онцолж оруулдаг нь ямар шалтгаан байсан бэ гэдгийг би анхнаасаа байр сууриа илэрхийлэхдээ хэлж байсан. Наадах чинь буруу байна аа. Тэгсэн мөртөө энэ өгүүлбэрийнхээ эцэст 1 багц дотор, 1 зүйл, заалт дотор Байнгын хороо болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гээд ерөнхийлөөд оруулчихсан байгаа юм.

Тэгэхээр энэ бол хуулийн биелэлтийг хангахтай холбоотой асуудлыг тэртэй тэргүй Их Хурал өөрөө хянадаг, үүрэгтэй Байнгын хороодтой. Тэгээд үүнийг ингэж онцолж оруулдаг би буруу гээд байгаа юм. Ерөөсөө ганцхан өгүүлбэр л энд хангалттай. Байнгын хороо болон бусад хороодын бүрэн эрх, зохион байгуулалтыг үйл ажиллагааны журмаар хуулиар тогтооно гээд органик хуульдаа оруулаад явах хангалттай заалтыг энд илүү оруулж ирээд байна. Үндсэн хуульд ийм илүү, дутуу заалт хэрэггүй шүү дээ. Яана гэж үүнийг оруулаад байгаа юм бэ? Төсөв, санхүүтэй холбоотой түр хороо байж л байдаг. Гишүүний эрх зүйтэй, ёс зүйтэй холбоотой түр хороо байж л байдаг. Тэгээд одоо үүнийг дахиад ийм түр хороо гэдэг нэр заалтыг Үндсэн хуульд оруулдаг нь зарчмын хувьд би буруу гэж ингэж харж байгаа юм.

Үндсэн хууль хэлэлцэхэд гишүүд өөр, өөрсдийнхөө үзэл бодлоор саналаа өгч байгаа хэдий ч гэсэн Их Хурлын гишүүд өөрсдөө энэ Их Хурлынхаа бүрэн эрхийг ойлгодог байх ёстой шүү дээ. Үндсэн хуульд энэ заалтыг хийснээрээ ямарваа нэгэн давуу эрх олгогдож байгаа бол өөр хэрэг. Ямар ч давуу эрх олгогдохгүй энэ дээр, ямар ч давуу эрх олгогдохгүй.

Тийм учраас би энэ заалтыг буруу гэж ингэж харж байна. Энэ заалтыг дэмжих шаардлагагүй. Харин дэмжвэл, үлдвэл тэр Байнгын хороо болон бусад хорооны эрх зүй, зохион байгуулалтыг хуулиар тогтооно гэдэг энэ заалт байхад л хангалттай.

Тийм учраас энэ толгой эргүүлсэн илүү үг, өгүүлбэрийг Үндсэн хуульд оруулах шаардлагагүй ээ. Үндсэн хуульд үндсэндээ яг л ерөнхий нийгмийн гэрээнд тусгагдах ерөнхий заалт орно уу гэхээс биш ингэж онцгойлсон заалт орж болохгүй ээ. Би бол тийм санаа бодолтой байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, өчигдрийн хуралдааны байдлыг ингээд сонсоод, үзээд, харж байхад Үндсэн хуулийн зөрчилтэй маш олон зүйлүүд явлаа. Нэг 56 болоод л, нэг 57 болоод л, тэгээд одоо энэ явж байгаа нь ерөөсөө бүр кааш болсон шүү дээ өчигдөр. Тэгээд өнөөдөр Ардчилсан нам аргагүй ирцийг нь бүрдүүлээд, ямар ч байсан Үндсэн хууль бол нийтийн эрх ашгийн асуудал учраас оролцоод явъя гээд ингээд оролцож байгаа. Оролцсон ч гэсэн бодит байдал өнөөдөр ямар байгааг Нямдорж гишүүн хэлчихлээ. Цаашдаа энэ Үндсэн хууль ингэж

хэлэлцэгдэж ерөөсөө огт болохгүй. Одоо хэрвээ энэ өчигдрийн асуудлаар ямарваа нэгэн маргаан Цэцэд үүсэх юм бол бидний Үндсэн хуулийн эхний асуудлууд бүгд асуудал үүсгэнэ.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай асуудлаар дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа 3 хүртэл санал хураана гэж оруулсан байсан. Тэгэхдээ ямар шалтгааныг нь заагаагүй. Би 3 хүртэл гэж оруулсныг юу гэж ойлгож байгаа вэ гэхээр, хэрвээ ямар нэгэн гишүүн үнэхээр асуудал үүсгээд, кноп юм уу, ямарваа нэгэн юм буруу ажилласан байвал энэ нь протоколд тусгагдаад дахин санал хураалтаар 3 хүртэл явж болох юм байна гэж ингэж ойлгож байгаа, энэ заалтыг. Тэгтэл зарим нь болохоор -өө 56 болсон, энэ буруу дарсан байна, үүнийг 57 болгочихъё гэдэг энэ асуудал чинь хуулийн зөрчил. Тэгсэн мөртөө дараа нь буцаагаад 2-3 хүн би болохоо болжээ гэхээр дахиад санал хураагдаад бас дахиад хуулийн зөрчил болж эхэлж байгаа юм. Ийм байдлаар бид нар цаашдаа Үндсэн хуулийн хэлэлцүүлэг хийж болохгүй ээ, Их Хурлын дарга аа. Одоо өнөөдөр ийм асуудал гарах юм бол бид нар дахиад байр сууриа илэрхийлээд энэ ирцээс гарахаас өөр аргагүй болно шүү. Би үүнийг анхааралтай ажиглаж байсны хувьд та бүхэнд сануулаад хэлчихье гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Магваны Билэгт гишүүн үг хэлнэ.

М.Билэгт: Гишүүдийнхээ амрыг эрье. Би энэ Улсын Их Хурлаас хянан шалгах түр хороо байгуулах энэ заалт орох нь зөв байхаа гэж бодож байна. Яагаад гэвэл өмнө нь Ардын хянан шалгах хороо гэж том байгууллага байсан, өмнөх 60-70 жилд. Энэ бол ер нь Монгол Улсын төрийн хэмжээнд байгаа бүх хууль хяналтын байгууллагыг зангидаж, бас дээр нь том шийдвэр гаргадаг, атгадаг ийм газар байсан гэж боддог. Тэгэхээр зэрэг өнөөдөр Авлигатай тэмцэх газар нэг шийдвэр гаргачихдаг, тэгж байтал нөгөө дэх нь прокурор дээр очоод бас сулраад явчихдаг. Прокурор нь эсхүл бас гайгүй шийдвэр гаргаад явуулчихдаг, тэгэнгүүт нь шүүх дээр очоод нөгөө дэх нь шийдэгдэхгүй уначихдаг. Энэ нь дандаа төрийн өндөр эрх мэдэл, албан тушаал үүнийгээ буруу хэрэгжүүлж, буруу шийдвэр гаргаж, хууль зөрчсөн шийдвэр гаргаж, эх орон, ард түмнээ гэсэн биш эд нарт сөргөөр нөлөөлөх ийм шийдвэр гаргачхаад, тэгээд энэ хүмүүс дээр арга хэмжээ авагдах гэхээр, эргээд энэ бол хууль хүчний байгууллагын хүч нь дутаад байгаа юм гэж харагдаад байгаа.

Тийм учраас яах аргагүй, Улсын Их Хурлын дэргэдэх энэ хянан шалгах хороо хэрэв байгуулагдах юм бол, тэр байгууллагуудыг дээрээс нь хянаж, тухайн асуудлаар шийдвэр гаргаж, шахахад бас хэрэгтэй болох болов уу гэж бодож байна. Тэгэхгүй бол өнөөдөр ерөөсөө бүгд л хэлж байгаа.

Авлигатай тэмцэх газар, прокурор, шүүхийн байгууллагад, энэ төрийн өндөр эрх мэдэлтэй албан тушаалтнууд нөлөөлөөд, үүнтэй холбоотой энэ улс орны, ард түмний эсрэг хууль бус шийдвэр гарсан байхад төрийн өндөр эрх мэдэлтнүүдтэй холбоотой энэ хууль зөрчсөн шийдвэрүүд хууль хяналтын байгууллагаар хурдан шийдэгдэхгүй байна. Мөн, одоо энэ ингээд, замхраад өнгөрч байна гээд ингээд ийм байдал гарч ирээд байгаа, байнга үүнээс болж, төрдөө итгэх иргэдийн итгэл үнэхээр уначхаад байгаа.

Тийм учраас, энэ бол, энэ ард түмнээс сонгогдож байгаа, ард түмнийхээ өмнө очоод, мэдээж байцаагдаад, хариулт өгөөд бүлтгэнээд явж байдаг энэ төлөөлөл болсон, энэ Улсын Их Хурлын гишүүд түр хороо байгуулаад, энэ бас иргэдийн асуудлыг шийдэхэд, шаардлага тавихад нөлөөлөх байхаа гэж бодож байна. Тийм учраас энэ, саналыг дэмжих нь зүйтэй юм байна гэж бодож байна. Энэ бол тусдаа нэг том институци байгуулагдаад, тусдаа төрөөс том цалин авах

хэмжээний байгууллага биш байхаа гэж бодож байна. Тэгэхээр үүнийг дэмжиж байна гэж хэлэх байна.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлнэ.

С.Бямбацогт: Гишүүд маань ойлголтын зөрүүнүүд нэлээн байх шиг байна. Тэгэхээр одоо энэ Хянан шалгах түр хороо байгуулах асуудал маань үндсэндээ шүүх эрх мэдэл уруу халдаад, төрийн өндөр эрх мэдэлтэн, албан тушаалтнуудыг шалгадаг, шүүдэг, ялладаг ийм зорилгоор байгуулах гэж байгаа юм шиг ийм ойлголтоор зарим хүмүүс ярьж байна. Тийм юм бол байхгүй ээ. Улсын Их Хурал төрийн бодлого тодорхойлдог. Улсын Их Хурлын тодорхойлсон бодлогыг Засгийн газар хэрэгжүүлдэг. Улсын Их Хурлын тодорхойлсон бодлогыг Засгийн газар хэрэгжүүлэхдээ хэрхэн яаж хэрэгжүүлж байна, зөв хэрэгжүүлж байна уу, буруу хэрэгжүүлж байна уу, хууль зөрчиж байна уу, зөрчихгүй байна уу, бодлогыг зөв авч явж байна уу, үгүй юу гэдэг дээр хяналтаа тавина. Тодорхой асуудлууд үүсэх юм бол тэр үүссэн асуудлууд дээр хянан шалгах түр хороо байгуулж, энэ асуудлыг шийдье, ийм байя гэдэг зорилгоор орж ирж байгаа юм, нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь, бид нар гүйцэтгэх засаглалын эрх мэдэл уруу Улсын Их Хурал хэт халддаг байсан, давхар дээлтэй байгаа Засгийн газрын гишүүний ажлыг давхар хийгээд Улсын Их Хурлын гишүүд, дээрээс нь төсөв батлахад нь дур зоргоороо төсвийн зарлагыг нэмэгдүүлдэг, энэ эрхүүдийг хязгаарлаж байгаа. Өөрөөр хэлбэл одоо дахиад дээрээс нь сайд нарын томилоход Улсын Их Хурал томилдог байсан бол одоо энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр сайд нарыг Улсын Их Хурал томилохгүй. Өөрөөр хэлэх юм бол гүйцэтгэх засаглал нь тэр Улсын Их Хурлын тодорхойлсон бодлогыг хэрэгжүүлэхэд нь Улсын Их Хурал хэт их хошуу дүрэхгүй байя гэдэг байдлаар томьёолж байгаа.

Үүнтэй холбоотойгоор нөгөө талдаа харин Засгийн газарт, гүйцэтгэх засаглалд ажлаа хийх боломжийг нь олгож байгаа юм чинь нөгөө талаасаа хяналт тавих эрхээ тодорхой нэмж авъя. Ийм байхгүй бол хяналтаа тавьж чаддаггүй өнөөдөр, нөгөө талаасаа гүйцэтгэх засаглалынхаа ажилд хэт их оролцдог, үүнийг л жаахан зааг ялгаатай болгоё гэдэг агуулгаар төсөл санаачилсан 62 гишүүн энэ заалтыг оруулж ирсэн. Ингээд хэлэлцэж байх явцад нь 28.2, 28.3 гэсэн энэ 2 заалтыг хэлэлцэж байх явцад, тэр хянан шалгах түр хороо нь холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн хараат бус шинжээч томилох, гэрч дуудах, тайлбар мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах бүрэн эрхтэй гэдэг маань, үндсэндээ бас давхар шүүхийн ажлыг хийх гээд байна. Энэ бас буруу байна гэдэг саналыг манай Раднаасэд гишүүн, Тэмүүлэн гишүүн нар гаргасан. Ажлын хэсэг үүнийг нь дэмжсэн, Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн. Ийм учраас 28.3 дахь заалтыг хасъя. Харин 28.2 дээрээ тэр хуулийн биелэлтийг хангалтай холбоотой, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар, Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна гэдэг байдлаар томьёолж оруулж байгаа юм.

Үүнтэй холбоотой бусад Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гээд 2 дахь өгүүлбэр нэмж байгаа. Энэ маань үндсэндээ органик хууль буюу Үндсэн хуульчилсан хуулиараа Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульдаа үүнийг нарийвчлаад Байнгын хорооны эрх, үүргийг, түр хорооны эрх, үүргийг тодорхой заагаад өгчихье. Үүн дотроо тэр түр хороо, хянан шалгах түр хороо ямар эрхтэй байхыг нь тодорхой зааж өгье гэдэг байдлаар авч үлдэж байгаа юм. Үүнийг гишүүд зөв ойлгоод яваарай гэж хүсье.

Одоогийн төслийн 28.2-т бол Байнгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гэсэн байгаа. Энэ дээр нэмээд Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, журмыг хуулиар тогтооно гэж орж ирж байгаа юм. Энэ санал бол 62 гишүүний төсөл дээр байж байгаа, мөн урд нь Ардчилсан намын 47 гишүүн санаачилсан төсөл дотор Батчимэг гишүүн, Тэмүүжин гишүүн нарын саналаар тусгагдаад явж байгаа. Өөрөөр хэлбэл, өмнөх Батбаяр нарын гишүүдийн санаачилсан 47 гишүүний төсөлд ч байгаа, 62 гишүүний төсөлд ч байж байгаа, ажлын хэсэг дээр ярихдаа нийлүүлээд авчихъя, харин тодорхой нарийвчилсан шүүх эрх мэдэл уруу халдаад байна гэсэн заалтыг бид нар органик хуулиар зохицуулъя гэдэг байдлаар томъёолсон шүү гэдгийг гишүүддээ тайлбарлаад хэлчихье.

Дараагийнх нь, үндсэндээ эндээ багтаж байгаа.

Г.Занданшатар: Эрдэнэбат гишүүн, Даваасүрэн гишүүн нарын саналтай холбогдуулан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг уншиж танилцуулъя.

Ер нь гишүүдийнхээ үг хэлж байгаа, санал бодлоо чөлөөтэй илэрхийлж байгаа энэ идэвхтэй оролцоог хүндэтгэж үзэж байна. Дэгээ зөрчиж болохгүй байгаа юмаа. Дэгд, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаар Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн болон эсрэг байр суурьтай гишүүн 10 минутаас илүү хугацаанд үг хэлж болно, зөвхөн тухайн саналын талаар үг хэлж болно гэж байгаа юм.

14.3 нь үүнийгээ харин тодруулсан нь Байнгын хороод Улсын Их Хурлын гишүүдээс төсөлд оруулахаар гаргасан зарчмын зөрүүтэй саналыг тусад нь хэлэлцүүлэхгүй, харин 2 дахь хэлэлцүүлэгт оруулсан төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр нь дэс дараалан санал хураалт явуулахдаа хамтатган хэлэлцэнэ гэж дэгийн хуульд заасан байгааг би бас гишүүддээ анхааруулж байна.

Одоо ингээд санал хураалтаа явуулъя.

7.1. Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2. Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.

Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. Санал гаргасан, ажлын хэсэг.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал байна.

Гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй. Санал хураахад кноп дарахад хугацаа хэрэгтэй байгаа. Хурууны хээ уншуулах, кноп дарахад хугацаа хэрэгтэй байгааг ойлгож байгаа.

Санал хураалт.

Ундармаа гишүүнд үг өгье.

Б.Ундармаа: Би сая энэ саналыг дэмжиж санал өгсөн. Тэгээд энэ тоног төхөөрөмж маань ажилласангүй. Тийм учраас намайг протоколд дэмжсэнээр тооцож оруулна уу.

Г.Занданшатар: Нэгдүгээрт, санал хураалт шаардлагатай бол 3 хүртэл явуулна. Пүрэвдорж гишүүнээ тайван. Санал хураалт шаардлагатай бол 3 дахин явуулна.

Хоёрдугаарт, өчигдөр горимын санал гаргаад Мөнх-Оргил гишүүний саналаар нэмж гишүүн өөрөө миний санал техник төхөөрөмж гацлаа миний санал буруу дарагдлаа гээд, хөөе Пүрэвдорж гишүүн ээ, гишүүн өөрөө саналаа гаргаад миний төхөөрөмж ажилласангүй ээ. Би дэмжсэн санал өгсөн гэх юм бол дэмжсэн саналд тооцож болно гэсэн ийм горимын саналаар Мөнх-Оргил гишүүн санал гаргаад дэмжигдсэн юм. Тэгэхдээ баараггүй байх нь зүйтэй гээд энэ санал хураалтыг хүчингүй болгох гэсэн санал хураалт явуулаад, дахин санал хураалгах горимоор өчигдөр явсан. Тийм учраас. Ингээд Ундармаа гишүүний саналыг дэмжсэнд тооцоод 57 гэж үзээд дахин баталгаажуулах санал хураалт явуулъя.

Төхөөрөмж ажиллахгүй бол болохгүй байгаа юм. За Мөнх-Оргил гишүүн. Энэ саналыг хүчингүй болгох горимын санал гаргавал санал хураалт явуулна.

Ц.Мөнх-Оргил: Энэ саяны саналыг хүчингүй болгох горимын санал гаргаад анхны санал хураалтаа дахиад явуулъя.

Г.Занданшатар: Мөнх-Оргил гишүүний саналаар саяын санал хураалт дээр техникийн саатал гарсан учраас хүчингүй болгох санал хураалт явуулъя. Горимын саналаар санал хураалт явуулъя. Саяын санал хураалтыг хүчингүй болгож байж энэ санал хураалтыг явуулна. Олонхын саналаар өмнөх санал хураалт хүчингүй боллоо. Одоо төхөөрөмж юмандаа хариуцлагатай хандаж хариуцлагатай саналаа өгцгөөгөөрэй.

Ардчилсан намын бүлгийн саналыг бас анхааралтай сонсох хэрэгтэй. Санал хураалт. Өчигдөр гараар санал хураах санал ийм учраас гараад. Цогтбаатар гишүүн бол эхнээс нь хэлсэн. Ажиллахгүй байна гэж. Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Би саналаа бол сая дэмжиж өгсөн. Тэгээд үнэхээр орохгүй байна. Би эхнээс нь хэлсэн, орохгүй байна шүү гээд.

Г.Занданшатар: Л.Энхболд гишүүн. 2 удаа эсрэг гараад байна. Төхөөрөмж нь ингээд байгаа юмыг яах вэ. Машин техник битгий хэл махан хэл гацдаг шүү дээ.

Л.Энхболд: Би дэмжиж хоёр удаа дарсан, хоёуланд нь ажиллахгүй байсан учраас техникээ солиод сууж байна. Хажууд техникийн улсууд байж байна. Тийм учраас саяынхыг хүчингүй болгоод дахиж санал хураалгах саналтай байна.

Г.Занданшатар: Техникийн улсууд хяналт тавьж байгаа. Ийм техникийн саатал гараад байгааг одоо 2 гишүүн хоёр дахь удаагаа ийм санал гаргалаа.

2 гишүүний санал техникийн шалтгаанаас шалтгаалж сөрөг гарсан учраас саяын 2 гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцох гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалтыг хүчингүй болгох гэсэн санал хураалт явуулж байна.

Энэ дэмжигдэж байж дараагийнх чинь дэмжигдэх үү, үгүй юү яригдана шүү дээ.

Олонхын саналаар энэ санал хураалт хүчингүй боллоо. Гишүүд тайван байцгаа, нухацтай асуудал хэлэлцэж байж. Техникийн хэлтэс энэ ажиллахгүй

байгаа төхөөрөмжүүдийг шалгаад баталгаажуулаад өг. Гэрэл ассаны дараа хуруугаа уншуулаарай. Яарахаар болохгүй байгаа.

Санал хураалт хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалтад 63 гишүүн оролцож, 59 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ. Дараагийн заалтыг уншиж танилцуулъя.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу Хорин наймдугаар зүйлийн 3 дахь хэсэг нэмэх:

“3.Хянан шалгах түр хороо нь холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн, хараат бус шинжээч томилох, гэрч дуудах, тайлбар, мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах бүрэн эрхтэй. Түр хороо дүгнэлт гаргаж, шаардлагатай бол тухайн асуудлыг эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлж болно. Түр хорооны дүгнэлт шүүхэд үүрэг хүлээлгэхгүй. Хорооны хэлэлцсэн баримтыг нотлох баримтад тооцох эсэхийг шүүх шийдвэрлэнэ.” Төслийн заалт.

Даваасүрэн гишүүн. Даваасүрэн гишүүнээр тасаллаа.

Ц.Даваасүрэн: Би энэ үгээ хэлж болно шүү дээ. Ядаргаатай хэрүүлч улсууд энэ Их Хуралд нэлээд орж ирж ээ. Урдаас ингээд хачин хачин юм яриад байх юм. За Ганбаатар ярь. Миний гарах гарахгүй чи мэдэх шүү дээ. Ямар хаашаа, янзын нөхөр бэ. Ерөөсөө төлөвшөөгүй. Ингээд хар аа, хашхирч байгааг нь хүмүүс сонсож л байгаа байх. Ийм хүмүүс сонгоод хаячихсан. Орж ирээд ингээд үймүүлээд. Үндсэн хууль дээр хэн ч үгээ хэлэх эрхтэй. Би Үндсэн хууль учраас тэгээд байна. Тэрнээс биш бусад хууль дээр бас тэр Засгийн газраас оруулж ирсэн юман дээр нь бол юмаа баримтлаад явж л байгаа. Энэ бол Үндсэн хууль. Тийм учраас бид нар сайн ярих ёстой. Энэ дээр ингээд хэрвээ Түр хороо байгуулах юм бол тэр шинжээч томилох, гэрч дуудах тайлбар мэдээллийг авах, нотлох баримт гаргуулах гэдэг юмыг нь аваад хаячих юм бол тэгээд яах вэ хуулиар хуулиар журамлана л гээд байгаа юм л даа. Тэгээд дараа нь одоо авч хаяж байгаа улсууд яаж журамлах вэ дээ. Энэ бол гол энэ заалтын сүнсийг нь аваад хаяж байгаа байхгүй юу. Тэрнээс биш энэ хэрвээ байсан бол төрийн өндөр албан тушаалтнууд ялангуяа тэр шүүх, прокурорын тэр өндөр эрх мэдэлтнүүдтэй харьцахад бол бас энэ заалт хэрэгтэй байсан байхгүй юу. Үндсэн хуульд оруулаад өгчхөж байгаа юм чинь.

Ингээд аваад хаячихаар чинь зарим нь мухардсан гар хөлгүй юм шиг л юм болчихлоо. Энэ заалтыг гишүүд бас нэг анхаараач дээ. Ер нь яадаг юм бэ одоо ингээд төрийн өндөр албан тушаалтнууд дээр тайлбар мэдүүлэг авдаг л байя. Нотлох баримт шаарддаг л байя. Өнөөдөр тиймдээ энэ бусад орны парламент энэ улс төрчид цэвэр байгаад байна шүү дээ. Ер нь төрийн өндөр албан тушаалтнууд дээр бол одоо иргэдийн шүүмжилж байгаа нэг юм байгаа юм. Ингээд барьж аваад хийх юм. Тэгээд одоо өвдөөд гарчих юм гэж. Ард түмний хүүхэд бол өвдөөд байсан ч шорондоо үхчих юм гэж.

Бодит байдал тийм л байгаад байгаа шүү дээ. Тийм учраас энэ хэрвээ одоо энэ заалт байхгүй бол угаасаа тэр түр хороо гэдэг юм чинь Улсын Их Хурлын тухай хууль дээрээ байгаа юм.

Янз бүрийн түр хороо байгуулаад байж бид болно. Энийг онцгой байр суурьтай байлгаж. Улс төрийн өндөр албан тушаалтнуудтай бас асуудал тооцдог байя гэдэг агуулгаар л энэ заалт чинь орсон юм билээ шүү дээ. Тэгээд бид нар эхнээсээ орсон юмнаасаа буцаад байна гэдэг чинь энэ Үндсэн хуульд бид нар эхнээсээ зарчимтай хандаагүй байна гэж ойлгоод байна шүү дээ. Өөрсдийнхөө оруулсан юмыг хасаад байхаар. Энийгээ бас бодож үзээч дээ гишүүд минь.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Хаянгаагийн Болорчулуун үг хэлнэ. Дэмжсэн, дэмжээгүй.

Х.Болорчулуун: Энэ, Үндсэн хуулийн шинэчлэлийн гол бас нэг заалт, ашиг тус бол Улсын Их Хурлын гишүүн, сайд давхар хийдэг энэ байдал бол өөрчлөгдөх гэж байгаа. Сайд нь сайдаа хийнэ. Гишүүн нь гишүүнээ хийгээд явна. Яг ийм нөхцөлд бол Улсын Их Хурал бол зөвхөн одоогийн практикаар хууль гаргаад үндсэндээ гүйцэтгэх засаглал дээрээ хяналт тавих байдал маш тааруу байгаа шүү дээ. Улсын Их Хурлаас Хянан шалгах түр хороо байгуулагдсанаар гүйцэтгэх засаглал дээрээ хяналт тавих байдал бол эрс сайжирна. Аливаа нэг хүний эрх зөрчигдсэн юм уу, гүйцэтгэх засаглал дээр эрх мэдэл хэтрүүлсэн асуудал гарахад хяналт шалгах түр хороо бол аливаа нэг асуудлаар бол ажлаа явуулж гүйцэтгэх засаглал дээр жинхэнэ хууль тогтоох байгууллагынхаа хяналтыг бол тавих юм. Энэ нь байр байрандаа, Их Хурал нь Их Хуралдаа, Засгийн газар нь Засгийн газраараа ажиллах, яг төр дээрээ суудлаа олох нөхцөл бүрдэх юм. Тийм учраас энэ хянан шалгах түр хороог бол зайлшгүй бид дэмжих ёстой. Ер нь гадаад оронд ч гэсэн бид нар туршлага судаллаа, зөндөө парламентын туршлага судалсан.

Хяналтын түр хороо парламентад нь байдаг. Энэ бол гол хийдэг ажлынх нь нэг юм байна лээ шүү дээ. Тэгэхээр энэ байдлыг бол бид нар дэмжих ёстой гэсэн байр суурьтай байна. Баярлалаа.

Г.Занданшатар: С.Бямбацогт гишүүн хоёр минут л тайлбар хийнэ.

С.Бямбацогт: Энэ 8 дугаар санал. Хорин наймдугаар зүйлийн 3 дахь хэсэг нэмэх гэж байгаа. Энэ гишүүд санаачилсан. Гэхдээ бас манай гишүүд их ярьсан. Энэ хэт их шүүх эрх мэдэл рүү халдсан энүүгээр далимдуулаад өөр цаашаа юу гэдэг юм хуулийн нугалаа завхрал гарч магадгүй байна. Тийм болохоор энийг хасъя. Гэхдээ органик хуульдаа маш тодорхой оруулж өгье гэж санал гарсан учраас энийг одоо дэмжихгүй байгаад органик хуулиараа зохицуулъя гэж үзсэн байгаа. Энэ санал ингээд дэмжигдээгүй тохиолдолд энэ саналыг хасах гэсэн Раднаасэд гишүүн, Тэмүүлэн гишүүн нарын гаргасан, ажлын хэсэг дэмжсэн, Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн саналаар санал хураах шаардлагагүй болно. Ингээд цаашдаа бас Их Хурлын дарга ийм байдлаар ингээд яваарай гэдгийг хүсье. Тэгээд энэ санал бол дэмжих шаардлагагүй санал байгаа шүү гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Санал хураалт. Хуулиар тогтооно гээд органик хуульд оруулна гэж ажлын хэсэг шийдсэн гэж Бямбацогт яриад байна л даа. Санал дэмжигдсэнгүй. Нямдорж гишүүн үг хэлэх үү. Нямдорж гишүүн.

Ц.Нямдорж: Энэ сая Даваасүрэн гишүүний яриад байгаа энэ нэг түр хороо байгуулахаар бол бүрэн эрхийнх нь асуудлыг Үндсэн хуульд хашаад өгчих гээд байгаа санаа нь зөв шүү дээ. Энэ бид нарын хоёр том зовлон байгаа юм. Энэ Америк, Англи мэтийн улсууд зарим нь 400, 500 жил, зарим нь 200 жил яваад өнгөрүүлсэн замыг бид нар 30-хан жил явж байгаа. Энэ зах зээлийн эдийн засгийн харилцаа, олон намын тогтолцоонд.

Хоёрдугаарт, энэ нүүдэлчний хэв маягийн амьдралаас суурин амьдралд Монголчууд маш эрчимтэй шилжиж байгаа. Ийм үед энэ сонгодог, хэвшсэн тогтсон орнуудын замаар асуудалд хандсанаас болоод бид нарын алдаа гараад байгаа. Энэ заалт орсноор шүүхийн бие даасан байдал парламенттай хутгалдаад байх юм байхгүй. Одоогоос лав миний харж байгаар хоёр гурван үедээ Монголын төрийн өнгө иймэрхүү байх зураг харагдаад байгаа. Ялангуяа энэ бүх насаараа томилогддог шүүгч нар. Энэ хуулийн эрх мэдэл атгаад сууж байдаг прокурор гэх мэтийн байгууллагууд, энэ төрийн өндөр албан тушаалтнуудын асуудал бүр

болохоо байхын цагт Их Хурал дээр авч ирээд хэлэлцдэг нэг ийм журмыг нь энд оруулаад өгөхөд ер гэм байхгүй шүү.

Бид нар бүх юм өнөөдөр харлаа шүү дээ. Энэ 30 жилд. Шүүх, прокурорынхон яаж дураараа авирладаг. Энэ төрийн өндөр албан тушаалтнууд албан тушаалтай байх үедээ яаж бүлэглэл үүсдэг энийг чинь шалгаж нэг тийшээ болгож цаашид цэвэрлэж явахгүй бол мөнхийн ийм дураараа авирлалд цаашдаа байх болно. Энэ байдлаа харгалзаж үзэж органик хууль руу түлхээд байлгүй энэ түр хорооныхоо бүрэн эрхийн асуудлыг Үндсэн хууль дотроо хийгээд өгөөч дээ. Энэ Америкт импичментийн систем гээд юм байдаг. Энэний л санаа яваад байгаа юм. Бүр ядарсан цагт парламент дээр ил гаргаж ирээд хэнийг ч байсан ярьдаг эрхийг энэ ард түмний төлөөллийн байгууллага чинь өөртөө хадгалах гээд байна шүү дээ. Энд чинь хүн шийдэх асуудлыг л ард түмний нүүрэн дээр гаргаж ирж хэлэлцээд хууль зөрчсөн бол эрх бүхий байгууллагад нь шилжүүлдэг ийм л ердийн логик явж байна шүү дээ. Одоо энэ төсөл санаачилж байгаа хүмүүс энийгээ нэг ойлгоод, энийгээ дэмж. Би та бүхнээс хичээнгүйлэн хүсэж байна. Энэ 30 жилийн хамгийн зовлонтой юм бол төрийн өндөр албан тушаалтнууд дураараа авирлах явдал бас сонгогдохын өмнө баахан шударга ёс сайхан юм ярьж байгаад гарч ирчхээд бүлэглэл үүсгэдэг бүлэглэлдээ үйлчилдэг. Ингэсээр байгаад өнөөдрийн энэ хүндрэлтэй нөхцөлийг үүсгэсэн нь нууц биш.

Энэ шүүх, прокурорууд чинь бүх насаараа томилогдож авч байгаад дуртай бүхнээ хийж байна. Бүх насны томилгоонд аархаж байна. Хараат бус байдал гэдэгт аархаж байна. Нүдэн дээр харж байхад гэмгүй хүмүүсийг аваачаад хэрэг дээрээ бол бүх насаараа хорих цаазын ялыг дураараа оногдуулж байна. Ийм юмыг чинь Их Хурал дээр хэлэлцэхгүй бол болохгүй нь ээ. Энийгээ нэг ойлгож үзээд энийг дэмжээд өгөөч ээ. Бямбацогт гишүүн та нар үүнээс тэр органик хууль руу битгий түлхээд бай. Органик хууль руу түлхээд хаях юм бол дараагийн үе гарч ирж байгаад энэ өнөөдөр ярьж байгаа юмыг чинь байхгүй болгож хаяад дураараа авирладаг юм аа аваад үлдэнэ. Ийм л зүйл байна. Тэгээд та бүхнийг дэмжээд магадгүй энэ өөрчлөлтийн хамгийн том нэг ач холбогдол юм энэ болж магадгүй шүү. Энэ парламент муу нэртэй нь үнэн. Сайн нэртэй парламент дэлхийд байдаггүй л юм байна лээ. Гэхдээ энэний хамгийн сайн тал нь бол болохгүй байгаа юмаа сонгогчдынхоо өмнө гаргаж ирээд ил яриад асуудлаа ярьдагт л асуудал байгаа. Энд чинь тэр ардчилал гэдэг юмны чинь амин сүнс нь байгаад байгаа юм. Парламент нь өвчин ороод хөдөлж чадахгүй байхын цагт тэр Ерөнхийлөгч, тэр Ерөнхий шүүгч чинь, тэр шүүгч нар чинь яг өнөөдөр.

Г.Занданшатар: Франц, Германы Үндсэн хуулиас авсан санаа шүү дээ. Тэгээд манай гишүүд л гаргасан. Дахиж санал хурааж явуулж болно. Дэгээрээ шаардлагатай бол дахин санал хураалгах эрхтэй. Гурав хүртэл санал хураалт явуулна. Дахин санал хураалт явуулах бол үг хэлнэ.

Даваасүрэн гишүүн горимын санал. Дэгийн хуулиар шүү.

Ц.Даваасүрэн: Манай энэ хууль санаачилсан 62 гишүүн бас энэ дээрээ бодооч дээ. Та нар ингээд ийм ийм гоё гоё юм оруулсны 2-ыг нь татчихлаа шүү дээ. Тэр нөгөө нэг Шүүхийн хяналтын зөвлөлөө бас татчихлаа. Гэтэл одоо энэ чинь чухал юм байхгүй юу даа. Бид нар зөндөө л ярьсан. Лүндээ гишүүн өөрөө мэдэж байгаа. Их Хурал ер нь ингээд хяналтын дээд байгууллага чинь өөрөө Их Хурал байхгүй юу. Хамгийн дээд. Тэгсэн мөртөө өнөөдөр шүүх болоод байна шүү дээ. Шүүх чинь дийлдэхгүй болж байна. Прокурор чинь дийлдэхгүй болж байна. Алтан Дорнодын 45 тэрбумыг Ерөнхий прокурор шууд байхгүй болгож байсан. Үнэн үнэн. Өнөөдөр прокурор дээр, шүүх дээр шударга ёс тогтооё гэсэн мөртөө бид нар одоо ингээд энийгээ энэ зүйлийг хийж чадахгүй байгаад байна шүү дээ.

Ер нь бол энийг хэрвээ тэрийг жирийн хуулиар зохицуулдаг маягаар энүүгээр орчих юм бол энэ чинь хуулийн гэрч болоод явна. Үндсэн хуульдаа бид нар энийг суулгаад өгчих юм бол бусад хуулиуд нь дагаад явна тийм биз. Одоо бол ингээд хуулиар тогтооно гэж. Тэгэхээр чинь дараа нь хууль гарахаар яах вэ. Үндсэн хуулийн зөрчилтэй байна гэдэг чинь ингээд хууль хоорондын зөрчил үүсэж байна гээд ингээд энэ чинь явж өгөхгүй. Ер нь төрийн өндөр албан тушаалтнуудыг ялангуяа тэр Ерөнхий шүүгчийг, Ерөнхий прокурорыг дуудаж ирж тэр үйлдсэн гэмт хэргийг нь асуудаг байх хэрэгтэй. Тайлбар авдаг байх хэрэгтэй. Бид нар чинь өөрсдөө ингээд нэг хэлэлцүүлэг хийж байна гээд үнэхээр нэг хүчин чадал мөхөс юм хийгээд л байдаг биз дээ. Нээлттэй хэлэлцүүлэг хийж байна гээд Хурцыг дуудаж ирээд тэрийг чинь өнөөдөр ингээд хуулийн дагуу жинхэнэ бодитой эрх мэдэлтэй хэрэгжүүлдэг болчихъё гэдэг заалт дээрээ бид нар буцаад байна шүү дээ. Би бол саяын Нямдорж гишүүний хэлсэнтэй санал нэг байна. Энэ орж өгөх юм бол харин энэ хуулийг цаашаа ард түмэн дунд аваад явна шүү. Бид нар үүнээс айгаад ингээд үлдэх юм бол өөрсдөө эд нар бол хулгай хийх гээд айгаад ингээд үлдэж байна гэж ард түмэн ойлгоно шүү.

Г.Занданшатар: Шаардлагатай бол гурав хүртэл санал хураана. Гар өргөж үг хэлдэг дэг байхгүй. Кноп дараад орсон нь үг хэлж байгаа, кноп дараад үг хэлнэ.

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Төслийн 8 дахь заалтыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулж байна. Энэ бол бүлгээр бол яригдаагүй асуудал шүү. Санал дэмжигдээгүй учраас цаашаа явъя.

8.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу Хорин наймдугаар зүйлийн 3 дахь хэсгийг хасах. Саяын заалтыг хасах санал Ш.Раднаасэд, Г.Тэмүүлэн нар гаргасан. Ажлын хэсэг гаргасан. Энэ санал дэмжигдээгүй учраас санал хураагдахгүй биз дээ. Энэ санал хураагдахгүй. Төслийг хамтатган хэлэлцэнэ гэдэг энэ зарчим чинь ингээд үйлчилж байгаа юм.

9-ийн бүлэг заалт бол Нямбаатар гишүүний. Саяын заалтыг тэр 3 дахь хэлэлцүүлэг дээр 7.1 дэх, 1.4 дэх заалтын хүрээнд найруулгаар оруулах боломжийг ажлын хэсэг судалж, яагаад 1.4 хөндөгдсөн, 1.4 дээр нэмээд найруулах бололцоог судалж дахин орж ирэх хэрэгтэй. Ингээд дэмжихгүй гээд ажлын хэсгээс ороод ирсэн учраас гишүүд дэмжихгүй байна. Гэхдээ ажлын хэсэг ахин үзээд 1.4 дээр сууж үз. Энэ санал хураалт дууссан учраас эргэж буцах арга байхгүй.

10.Төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын “нийгмийн хөгжлийн” гэсний дараа “бодлого” гэж, мөн заалтын “батлах” гэсний дараа “Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа Засгийн газрын зөвшөөрөлгүй зардлын шинэ төрөл үүсгэж, зарлага нэмэгдүүлэхгүй, төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэсэн хоёр, гурав дахь өгүүлбэр тус тусад нь нэмэх.

Төслийн заалт, 62 гишүүний.

10. Есдүгээр бүлэг заалт Нямбаатар гишүүний гаргасан горимын саналын дагуу хойшилж байгаа, баялгийн заалт байгаа. Хойшлуулсан, энэ аравдугаар заалт шүү, есийг хойшлуулаад арав руу шууд очиж байгаа гэж.

Арвын бүлэг заалтыг бүгдийг уншиж танилцуулаад хэлэлцүүлэг дээр нэгдсэн журмаар анхаараад явъя гэсэн саналтай байна. Гишүүд анхаарч үзээрэй. Энэ төслийн заалт. Төслийн заалтыг, 10.1-ийг ингэж өөрчилъё гэж ажлын хэсэг, Төрийн байгуулалтын Байнгын хороо дэмжсэн. Дараагийн санал байна.

10.1. Төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын “нийгмийн хөгжлийн” гэсний дараа “бодлого” гэж, мөн заалтын “батлах” гэсний дараа “Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа Засгийн газрын зөвшөөрөлгүй шинэ зардлын төрөл үүсгэж, зарлага нэмэгдүүлэхгүй, төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэсэн 2, 3 дахь өгүүлбэр гэснийг хасаж төслийн 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 16 дахь заалт буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт нэмэх.

16/Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт. “Төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах, улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно, ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно. Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна. Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” Санал гаргасан ажлын хэсэг, Төрийн байгуулалтын Байнгын хороо дэмжсэн санал байна.

10. Аравдугаар бүлэг асуудлыг хэлэлцэж байна. Түрүүн хэлсэн, есдүгээр бүлэг заалт хойшлуулсан, өчигдрийн горимын саналаар. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын дараалал, санал хураалтын талаар горимын санал оруулж болно, Улсын Их Хурлын дэг, журмын тухай хуулиар.

За. 10.2. Төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын “батлах” гэсний дараа “Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн урт, дунд хугацааны хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлнэ. Энэхүү бодлого төлөвлөлтийг тогтвортой, залгамж чанартай хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллагатай байна” гэж нэмэх гэж. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, Д.Дамба-Очир, Б.Жавхлан, М.Оюунчимэг, Д.Тэрбишдагва, Б.Ундармаа гишүүн.

Би аравдугаар бүлгийн саналыг бүгдийг уншъя.

Эхлээд уншаад танилцсаныхаа дараа үгээ авна шүү дээ. Баасанхүү гишүүн ээ, тайван бай даа. Би уншиж танилцуулсны дараа юуны талаар ярихаа эхлээд сонсоод дараа нь үгээ ав. Би уншиж танилцуулж байна. Тэрний дараа үгээ ав аа, айлын эрх хүүхэд шиг битгий ингээд чарлаад, тийчлээд байцгаа.

Аравдугаар зүйлд орсон зүйлийг уншиж танилцууллаа. 10-ын гурав, дөрөв дээр материал тараагдсан байгаа шүү. Ийм багц асуудлууд байгаа шүү. Хамтатган хэлэлцэнэ гэж журмын тухай хуульд заасан байгаа. Хамтатган хэлэлцэнэ, гэхдээ саналаа зүйл, заалт дээрээ хэлж болно, ярьцгаа. Дэг нь хамтатган хэлэлцэнэ гэж байгаа шүү, хамтатгаад бүгдэд нь саналаа хэлбэл сайн. Дэг нь тийм, дэг нь тийм байна, Ингээд төслийн 2 дугаар зүйлийг санал хураалаа. Үг хэлэх хүн байна уу. Байхгүй бол санал хураалт явууллаа шүү. Цогзолмаа гишүүнээр тасаллаа.

Эрхэм гишүүн Октябрийн Баасанхүү үг хэлнэ.

О.Баасанхүү: Үндсэн хуулийг хэлэлцүүлж байгаа бол дэгээ, журмаа, хэрвээ горимын санал гаргасан юм бол горимын саналаа дагаад явмаар байна. Арай дээрэлхэж байгаа юм биш үү, доромжилж байгаа юм биш үү. Гутааж байгаа юм биш үү. Та нар намайг доромжилж, гутааж болно, Монголын ард түмнийг...

Г.Занданшатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж үг хэлнэ. Та 2 цаг, 3 цаг хоцорч ирээд хэлэлцэж байгаа асуудлын, төслийн хоёрдугаар зүйлийн талаар л үг хэлнэ. Төслийн заалтын талаар үг хэл. Тэгвэл дараагийнх дээр оруулна. Эхлээд Ганзоригийн Тэмүүлэн гишүүн үг хэлнэ.

Ганзоригийн Тэмүүлэнгийн дараа Баасанхүү гишүүн үг хэлнэ.

Г.Тэмүүлэн: За баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Бид нар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд бас нэг амин сүнс болж ирж байгаа гол чухал заалтын нэг бол үүнийг гэж харж байгаа. Ер нь төсвийг хэлэлцэхдээ төсвийн орлого зарлагыг бид нар цаашид алдагдлыг нэмэгдүүлэхгүй байх үүднээс энэ заалт орж ирж байгаа.

Үүнийг ажлын хэсэг гаргасан, Төрийн байгуулалтын Байнгын хороон дээр дэмжигдээд явсан бас ийм заалт байгаа. Тэгэхээр үүн дээр өнөөгийн монгол улсын маань өнөөгийн хүчин төгөлдөр хууль, төсөв санхүү, эрх зүйн орчны зохицуулалтаар улсын төсвийн өмнө хүлээх хариуцлагын тогтолцоо үнэхээр байхгүй. Бид нар ямар ч бай, эхний ээлжид Улсын Их Хурал болоод Улсын Их Хурлын гишүүд бол хариуцлагатай байх энэ тогтолцоог оруулж ирж байгаа юм. Харин бид нар үүнийг цааш нь бэхжүүлж, болж өгвөл найруулгын явцад өөрчлөлт хийх нэмж өөрчлөх асуудлууд байна.

Энэ нь юу гэхээр зөвхөн Улсын Их Хурал, Улсын Их Хурлын гишүүд төсвийн зарлага зарцуулалт дээр хариуцлагагүй хандаж, хэлэлцүүлгийн явцад нэмэгдүүлдэг асуудал биш. Төсвийг эхнээс нь төлөвлөж, оруулж ирдэг байгууллага маань Засгийн газар, Ерөнхий сайд, сангийн яам, Сангийн сайд байгаад байгаа. Өнөөдөр Засгийн газар ямар нэг байдлаар улсын төсвийн өмнө хүлээх үүрэг, хариуцлага бол хуулийн хүрээнд байхгүй. Эрх зүйн зохицуулалтын хүрээнд. Тэгэхээр бид нар үүнийг бүх нийтээрээ Улсын Их Хурал нь ч тэр, Засгийн газар нь ч тэр төсвийн байнгын хороо нь ч тэр, Сангийн сайд нь ч тэр улсын төсвийнхөө өмнө нийтийн төсвийнхөө өмнө хариуцлага хүлээдэг энэ тогтолцоог илүү бэхжүүлж, найруулгаар явцад засаж залруулах ийм шаардлага байна гэж хараад байгаа.

Энэ асуудал байхгүй учраас төсвийн хөрөнгийг үр ашиггүй захиран зарцуулдаг олон төслүүд сүүлийн жилүүдэд гарч ирснийг бүгдээрээ мэдэж байгаа. Бид нар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг зүйлийг жилдээ бараг хоёр удаа хэлэлцэж байгаа. Билэг тэмдэг төдий энэ асуудлыг байнга ярьдаг, үүн дээр ямар нэг ард нь хариуцлага тооцдог, энэ дээрээс хариуцлагын санкц асуудал тусдаг асуудал байхгүй.

Тэгэхээр бид нар ерөөсөө төсвийг дунд хугацаандаа тогтвортой байлгах гол энэ төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь өөрөө ач холбогдолгүй болж байгаа асуудал байгаа. Хариуцлагын санкц байхгүй, хариуцлага хүлээдэг этгээд байхгүй. Тэгэхээр бид нар зөвхөн Улсын Их Хурал биш, Улсын Их Хурлын гишүүд нь хариуцлага хүлээдэг биш, төсвийг ямар нэг байдлаар үр ашиггүй зарцуулсан, төсвийн төлөвлөлт дээрээ алдаа гаргасан, зөрчсөн тохиолдолд Сангийн сайд нь огцордог, Ерөнхий сайд нь сануулга авдаг, бүр болж өгвөл Төсвийн байнгын Хорооны дарга нь өөрчлөгддөг энэ санкцуудыг хуулийн хүрээнд оруулж өгөх ёстой.

Үндсэн хууль дээр бид нар цогцоор нь хийж чадахгүй бол органик хуулиудаар үүнийг хийж, оруулж өгөх шаардлагатай гэдэг асуудлыг би протоколд тусгах гээд байгаа. Тэгэхээр бид нар цаашдаа энэ тогтолцоог өөрчлөхгүйгээр бид нар цааш явах боломж бололцоо байхгүй, Улсын төсвийн маань алдагдал хэчнээн

хувьд хүрч байгаа билээ, бид нар үүнийг бууруулах гэж ямар нөхцөл байдалд ороод байгаа билээ, үүнийг хүн болгон мэдэж байгаа.

Тэгэхээр цааш цаашдаа бид нар нэгэнтээ төсвийг боловсруулахдаа ч тэр ямар нэг зөрчил гаргадаггүй, зарцуулалт дээрээ ч алдаа гаргадаггүй энэ тогтолцоог хийх зайлшгүй шаардлага байна. Засгийн газар, Сангийн яам, төсөв, Төсвийн байнгын хороо, Их Хурал өөрөө давхар хариуцлага хүлээдэг тогтолцоог оруулж өгөх саналтай байгаа.

Тэгээд энэ заалтыг дэмжиж байгаа гэдгээ Та бүхэнд хэлэх байна.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Октябрийн Баасанхүү үг хэлнэ.

О.Баасанхүү: Энэ заалт ямар хэрэгтэй юм. Ямар ч хэрэггүй заалт оруулаад ирсэн. Хэрэггүй шүү дээ. Ерөнхий сайдыг томилоод, Ерөнхий сайд нь бусад сайдаа томилно гээд Үндсэн хуулийн чинь өөрчлөлт явж байгаа. Тэгээд Ерөнхий сайд хүсвэл тэр сайдууд аа чөлөөлнө, тэр орж ирж байгаа сайдыг нэгийг нь ч өнөөдөр юу гэдэг юм, хэлэлцүүлэгт оруулж та сайн ажиллаарай, Тэмүүлэнгийн хэлдгээр.

Та нар төсвөө оруулахдаа ийм заалт байгаа шүү гэж ярих эрх байхгүй. Ямар ч эрх байхгүй. Монгол улсын Дээд шүүхээр ярих юм бол одоогийн хуулиар үйлчилж байгаа Дээд шүүхийн шүүгч нарыг орж ирэхэд нь бид томилдоггүй ч гэсэн сонсдог, худлаа ч гэсэн “та битгий авлига аваарай, албан тушаалын хэрэгт холбогдов оо, та ер нь Элбэгдоржийн хүн байна шүү,” энээ тэрээ шүү гэж хэлээд сонслоо гээд Ерөнхийлөгч рүү явуулдаг байсан. Одоо түүнийг чинь болиод Ерөнхий сайдаа томилъё, Ерөнхий сайд нь бусад сайдаа томилдог, Улсын Их Хурлын гишүүд санхүүгийн ямар ч, төсөв санхүүгийн ямар ч шийдвэр бие даан гаргах эрхгүй гэж байгаа. Тэгээд тунхгийн шинжтэй юм яриад яах юм, гоё бичсэн байна, гоё бичсэн байна, гоё бичсэн байна гээд унших юм уу, сайдуудын тухай яриад байгаа юм.

Сайдуудын тухай ярихдаа өнөөдөр бид нарын маргаад байдаг зүйл чинь Ерөнхий сайдаа томилж чадахгүй бол Парламент тарна, Ерөнхий сайдыг огцруулъя гэвэл бушуухан орных нь Ерөнхий сайдыг оруулж ирнэ гээд, одоо Ерөнхий сайд болох хүнээ олоогүй цагт тэр хүн хулгайгаа хийгээд, дээрмээ хийгээд, төсвөөрөө дураараа зарцуулаад, дунд чөмгөөрөө жиргээд яв гээд парламентын засаглалаасаа Ерөнхийлөгч Ерөнхий сайд болж байгаатай адил, нэртэйгээр нь ерөөсөө Ерөнхийлөгчийгөө Ерөнхий сайдаа хийе гээд хэлчихмээр байгаа юм л даа.

Хоёрдугаарт, хуйвалдаанаар хийхээ болиоч гэж өчигдрөөс хойш хэлээд байгаа юм. Төслийн заалт гээд 62 хүн гарын үсэг зураад, тэр төслийн заалтаар би ийм байна гэж үгээ хэлээд дэмжиж байна, дэмжихгүйгээ хэлээд дараа нь одоо ажлын хэсгийн заалт буюу та нарын хуйвалдагчдын одоо 11 дүгээр сарын 26-нд та нар сонгууль явуулах гэж байсан хуйвалдаан чинь илэрсэн байгаа шүү. 108 гэдэг үгийн дараа би бодоход төрийн тусгаар тогтнолын баяраар сонгууль хийе гээд яаравчлаад, ингээд явж байсныг чинь хэвлэл мэдээллийнхэн бүгд мэдэж байгаа. Ийм хуйвалдааны байдлаар Үндсэн хуулиа хийгээд байна, ядаж энэ хуйвалдсан ажлын хэсгийн чинь талаар ороогүй учраас би ийм учиртай юм гээд өөрийнхөө санаачилсан төслөө юуг нь дэмжээд, яагаад гарын үсэг зурсан юм бэ. Яагаад энэ дээр дэмжээгүй, зарим нь бас бүгдийг нь санаачилж оруулаагүй учраас ийм байна гээд ярих эрхийг минь хаасаар өнөөдөр хүрлээ. Одоо энэ санал хураалтаа хар л даа.

Бөөн төмсөгдүүлсэн хүмүүс. 49 ЖДҮ-чин, үүнийг нь ярихаар ерөөсөө болдоггүй, санал хураалтыг чинь доошоо лайв хийхээр, хэвлэл мэдээллийнхэнд хэвлэлийн хурал зарлаад ч ирэхгүй. Ийм дарангуйлал өнөөдөр бий болгоод Үндсэн хуулийг өөрчлөх замаар төрийн эрх мэдлийг барихгүй. Та нарт 4 жилийн эрх өгсөн болохоос биш 40 жилийн эрх өгөөгүй. 65 байна гэдэг чинь өнөөдөр юу гэдэг юм, өнөөдөр дарангуйллыг тогтоогоорой та нар гээд гаргаагүй. Тийм учраас төрийн санхүү, төсвийн асуудал, өрийн асуудал чухал нь чухал, гэхдээ хэн хэрэгжүүлэх юм бэ. Яаж хэрэгжүүлэх вэ, хэзээ хэрэгжүүлэх вэ, энэ болгоныг ярьж гэхээр нөгөө Засгийн газрын бүтэц нь энэ ярьсан заалтынхаа эсрэг байгаа. Ийм замбараагүй байж болохгүй л дээ.

Тэгээд дээрээс нь жагсаалтын гишүүдийг дандаа доромжилно, тойрогтоо, энд тэндгүй тойрогтоо дурдаагүй байхад сургууль цэцэрлэг авчирлаа гэдэг. Манайд цэцэрлэг байхгүй байна гээд тойргийнхоо гишүүнд хэлэхгүй өөр хэнд хэлэх юм. Нөгөөдхийг нь төсөвт нь оруулаад За, энд хийе гээд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүддээ тусалъя гээд хэлж байгаа болохоос би хувьдаа сургууль байгуулаад, та нар шиг тендерийн 10 хувийг нь авах гээд явж байгаа юу. Та нар мэдэж л байгаа шүү дээ, гишүүн болгон 8 тэрбум гэж хэлээд зарим нь юу гэдэг юм, Засаг дарга руугаа утасдсан, манай компанийг шалгаруулаарай гээд, 10 хувийг зувчаад явж байгаа шүү дээ. Ийм зүйлийг нь өнөөдөр хийгээд хавтгайраад байгаад байгаа бол хууль хяналтын байгууллага ажиллаад, харин Улсын Их Хурлын гишүүн, одоо 76, 23 гээд тойргийн зовлонгоо яаж хийх юм, нэг их тунхгийн шинжтэй, ямар ч Их Хурлын гишүүн төсөв, санхүүтэй холбоотой хууль санаачлахгүй, санал оруулахгүй, хяналт тавих эрх байхгүй, огцруулах эрх байхгүй, сайдыг огцруулах эрх байхгүй, өнөөдөр огцруулмаар өчнөөн олон сайдууд байна шүү дээ. Хар тамхины хэрэгт холбогдлоо гээд л хэвлэлээр шуугиад байгаа сайд л байж л байна, есөн шидийн хэл аманд ороод байгаа сайдууд байж байна, оймс гутлаас нь мөнгө олдсон асуудал байж байна, үүнийг нь хариуцлага ярина гэхээр өмнөх хариуцлагын хуулиа байхгүй болгосон, хяналт тавих хуульгүй болгосон, тэгээд дээрээс нь төсвийн асуудал гээд ингээд ордог, үүнийгээ боль, одоо зүгээр хуучнаараа байлгая, хуучнаараа байлгаж байж өнөөдөр юу гэдэг юм, явахгүй бол нөхцөл байдлыг ингэж дарангуйллын байдлаар шийдэж болохгүй ээ.

20 онд би дэвшихгүй ч байсан болно, надад айх юм алга. Миний ар талд ард түмэн байна. Харин дэвшихгүй бол баларлаа гэдэг 49 ЖДҮ- чид хэцүү байна шүү дээ, 60 тэрбум хэцүү байна шүү дээ, концесс хэцүү байна шүү дээ, хүн амины хэрэгтэй хүмүүс хэцүү байна шүү дээ. Үүнийг чинь манай намын дарга хэлсэн шүү дээ, Хүрэлсүх. Би тэрийг чинь хэлээгүй. Манай дарга хэлсэн, ойлгосон. Та нар сайн бод. Тийм учраас өнөөдөр энэ хэлэлцүүлэгтээ үгээ авмаар байна. Өчигдрөөс хойш үгээ авъя гээд байхаар нийтэд нь бөөнд нь уншаад, одоо ганцхан зарчмын зөрүүтэй горимын санал оруулчихъя, яршиг.

Бүгдийг нь уншаад нэг кнопоор дарчих, ядаргаа, ард түмэн энэ Үндсэн хуулийг чинь сонирхохгүй байх шиг байна. Тэртээ тэргүй авлигач дээр байгаа, бидэнд ямар хамаатай юм гээд өнөөдөр сургуулийн хүүхдийн формын үнэ өсөөд байна, наад байгаа түгжрэл чинь балраад байна, одоо 2020 оны утаа яан аа гээд иймэрхүү, санаа зоволтод байгаа болохоос биш энд өнөөдөр ярьж байна, Та нар хэвлэл мэдээлэлд асар их мөнгө төлсөн, одоо энэ Үндсэн хуулийн хэлэлцүүлэгт гаргасан төсвийн тайланг шилэн дансаар гаргаж ирээч ээ, хэлэлцүүлэг нэрээр хэчнээн тэрбум төгрөгийг гаргаснаа гаргаж ирээч. Бүх хүний аманд нь мөнгө чихчихсэн байна шүү дээ. Одоо энэ яриад байгаа төсөл чинь парламентын сайт дээр байхгүй байна. Та нар хуйвалдааныхаа юмыг парламентын сайт дээр тавиач.

Парламентын сайт дээр тавихгүй байж ийм утгагүй байж болохгүй шүү дээ. Би 3 цаг та нарыг харлаа. Яаж хэлэлцүүлэг хийдэг юм, Баасанхүүгээс болоод болохгүй байна гээд, өчигдрөөс хойш яриад байхаар нь бүтэн 3 цаг өрөөндөө суугаад та нарыг ажиглалаа.

Өнөөдөр Үндсэн хуулийг 400 гаруй иргэд батлахдаа 10:10 минутаар яриад заалт болгоноор 10:10 минутаар яриад 3-4 сар хэлэлцэж байж баталдаг байхад 3 хоногийн дотор батална гээд бүх төслийн заалтуудаа, 150 заалтаа нэгмөсөн уншаад үг өгөхгүй байна. Тэгээд хошин шогийн нам зам тавьчихсан, бүртгэлгүй нам хийх нь хүртэл Их Хурал зөвшөөрчихсэн, хошин шогийн гурав дахь хүчнээ гаргачихсан, та нар ичээч. Шившгүүд ээ. Гурав дахь хүчин байж болох бүх хүмүүс дээр нь очоод янз бүрийн байдлаар аманд нь мөнгө чихчхээд, хэн та нарт барьцаалагдах юм, шоронгоор айлгах юм уу, эсвэл үхлээр айлгах юм уу, би айхгүй, төгс хүн гэж байхгүй, зөв хүн гэж байгаа, зөв байхын төлөө явж болно, төгс төгөлдөр болчихсон хүн алга. Гэхдээ өнөөдөр гэмт хэрэг хийж, төрийн мөнгө идчихээд өнөөдөр та нар Үндсэн хуулийг өөрчлөх нэрээр хэлэлцүүлэг хийж өгөхгүй байна шүү дээ. Хэлэлцүүлэг гэдэг чинь яг 10 минут, яг заалтынхаа тухай ярина шүү дээ. Одоо тэгэхээр бүгдийг нь уншсан, би яаж ярих юм. Эсвэл юу гэдэг юм, Бямбацогт даргаа би төсөл гэдэг заалтаа эхлээд ярьж байгаа шүү, та тэмдэглээрэй, дараа нь энэ заалтыг ярьж байгаа шүү, та тэмдэглээрэй гээд ярих уу, тэгвэл яршиг баруун талын байшингийн буланд хоёулаа суугаад, эсвэл Новотелд очоод хоёулаа хэлэлцүүлэг хийе за, тэгж явсан нь дээр, тэгж өнөөдөр явсан нь дээр.

Түүнээс биш 49, концесс бүх юмаараа та нар барьцаалагдаж байгаа, одоо Монголын ард түмнийг доромжилж суухаа больцгоо, одоо үүнийгээ зогсоо.

Л.Энх-Амгалан: Баасанхүү гишүүн ээ, өчигдөр Тэрбишдагва гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргаад түүнийгээ татсан шүү дээ. Одоо тийм учраас заалт бүрээр гишүүн бүр өөрийн байр сууриа илэрхийлэх бололцоо нь нээлттэй байгаа шүү дээ. Баасанхүү гишүүн ээ. Тэрбишдагва гишүүн.

Д.Тэрбишдагва: За баярлалаа, За энэ одоо уг нь Их Хурлын гишүүд бүгдээрээ суугаад хэлэлцэх л ёстой маш чухал заалт байгаа юм. Хөгжлийн бодлогын асуудал, Лүндээжанцан, та зөв, зааландаа сууж бай, битгий хэрүүл хийгээд бай. Заалаа хар л даа, Заалаа хар. Би ярья. Хөгжлийн бодлогын юм ярих гэж байна, сууж бай гэж хэлж байна шүү дээ, Битгий хэрэлдээд бай, Лүндээжанцан дарга аа.

Энэ заалт өөрөө маш чухал хөгжлийн бодлоготой холбоотой заалт. Монгол улсын өнөөдрийн хөгжлийн гол шалтгаан бол эдийн засгийн хөгжил, тусгаар тогтнол, аюулгүй байдлын гол суурь нь эдийн засгийн хөгжил. Эдийн засаг өөрөө хөгжиж чадахгүй байх юм бол ажилгүйдэл, ядуурал асар их болж байна.

Ажилгүйдэл ядуурлаас улс төрийн тэмцэл их болж байна. Сонгууль өөрөө зөв зүйтэй явагдаж өгөхгүй байна. Одоо ч гэсэн Үндсэн хуулийн асуудал ч гэсэн өөрчлөх шатан дээр бол бид Үндсэн хуулийнхаа гол асуудал руу биш янз янзын нийгэмд үүссэн бухимдалтай асуудал руу их яриад байгаа нь их харамсалтай байгаа юм.

Бид ардчилал, зах зээлд оронгуутаа энэ либерал ардчилал буюу өөрөө өөрийгөө авч яв, өөрсдөө хөгж, барууны загварыг авсан л даа. Төрийн өмчийг устгаж хаяад, хувьчлал нэрийн дор ажилгүйдэл, ядуурлаа бий болгочоод, хэдхэн хүмүүс, тэр ч байтугай Их Хурлын танхим дотор олон хүмүүс хувьчлал нэрийн дор асар их хэмжээний үйлдвэр, аж ахуйн газрыг авчхаад, олон жилийн

мэдлэг мэргэжлээрээ, ажлынхаа чадвараар одоо ажиллаж байсан тэр хүмүүсийг гудамжинд гаргаж хаяснаас л энэ ажилгүйдэл ядуурал эхэлсэн шүү дээ. Ямар нэгэн хөгжлийн бодлогын төлөвлөлтгүй явсан. Энэ барууны либералууд бол урд өмнө нь байгуулсан бүх юмнуудаа устгаж хая. Одоо бүгдийг шинээр байгуулъя гэж бидэнд зааж өгсөн. Тэрний дагуу л бид яг одоо сургуультай нохой шиг хачин янзаар явсаар байгаад эцсийн эцэст энэ улс орны хөгжил бол ийм байдалтай хүрсэн. Өнөөдөр энэ ажилгүйдлээр ядуурал асар их болчихсон ийм үед бол энэ ерөөсөө суурь нь эндээс эхэлсэн юм. Ямар нэгэн хөгжлийн бодлого байхгүй. Энийг одоо хэсэг гишүүд энэ заалтад оруулаад энэ хөгж, Монгол Улсын эдийн засаг нийгмийн урт дунд хугацааны хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтөө хөгжүүлнэ. Энэхүү бодлого, төлөвлөлтийг тогтвортой, залгамж чанартай хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллагатай больё л гэж энийг одоо олон жил ярьж багаа. Төрийн захиргааны төв байгууллагатай больё.

Төрийн захиргааны төв байгууллага гэж одоо бид төлөвлөлтийн асуудлаар, төлөвлөгөөний комиссоос хойш 10 хэдэн удаа төрийнхөө байгууллагыг төрийн төлөвлөлтийн байгууллагыг сольчихсон. Тэгээд энэ төлөвлөлтийн байгуулга сольсноос болоод тэгээд одоо энийг хариуцдаг эзэн байхгүй. Эцсийн эцэст Монгол Улсын эдийн засгийг иж бүрнээр нь харж ингэж хөгжүүлэхгүй бол тэгээд төлөвлөлтийн байгууллагатай болж явахгүй бол энэ улс орон чинь ерөөсөө болихоо. Өнөөдөр биднийг одоо 1990-ээд оны эхээр энэ ардчилал зах зээлийнхээ үед та нар бүгдийн замбараагүй болго, задгай болго бүгдийг нь хулгай хий, тэр 70 жил байгуулсан үйлдвэр аж ахуйн газраа бүгдийг нь сөнөө, 70 жил бий болгосон мэргэжилтэй боловсон хүчнээ бүгдийг нь гудамжинд гаргаж хая гэснийхэн дагуу гудамжинд гаргаж хаяад хэсэг хүмүүс өмч хувьчлалын нэрээр баяжицгаасан. Хэсэг хүмүүсийг гудамжинд гаргаж хаясан.

Тэгээд одоо ийм төлөвлөлтгүй явснаас болоод энэ улс орны чинь эдийн засгийн байдал хүндрээд, эдийн засгийн байдал хүндрэхээр нийгмийн байдал хүндэрдэг, нийгмийн байдал хүндрэхээр энэ улс төрийн намуудын авлига, мөнгө төгрөгөөр Улсын Их Хуралд гарч ирж суух, албан тушаал авах, дарга нарыгаа дагалдаж явах, байгалийн баялгийг хулгайлж авах ийм юмнууд чинь үүсчхээд байгаа шүү дээ. Тэгэхээр ийм нэг төлөвлөлтийн байгууллагатай больё гэж одоо яриад байгаа юм. Гэтэл эхлээд бидэнд энэ замбараагүй байдлыг зааж өгсөн нөхөд маань эргэж хүрч ирээд, Монгол Улс чинь одоо төлөвлөлтгүй явж байна. Одоо төлөвлөгөөтэй ажиллаа гэж, бодлоготой ажил гэж, төлөвлөгөөний тусгай байгууллагатай бол гэж ингэж яриад байгаа л даа.

Тэгээд энэ нэг заалтыг оруулахгүй бол энэ юу чинь, энэ эхний заалт явахгүй. Сүүлийнх нь энэ төслийн энэ ажлын хэсгийн буюу Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал ч явахгүй шүү. Явахгүй шүү. Энийг яагаад эндээс ингээд зугтаагаад байгааг би ерөөсөө ойлгохгүй байгаад байгаа юм. Монгол, би дахиад хэлчихье. Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт, дунд хугацааны хөгжлийн нэгдсэн бодлоготой, төлөвлөлтэй хөгжүүлнэ гэж ямар ч төлөвлөлт байхгүй байна шүү дээ. Дураар нь загнаж байна шүү дээ. Нэг Засгийн газар орж ирээд л нэг төсөл хэрэгжүүлдэг.

Засгийн газрын мөрийн хөтөлбөр гээд нэг юм байгуулдаг. Тэр мөрийн хөтөлбөрийнх нь нэг 50, 60 хувь биелдэг юм уу, биелдэггүй юм уу. Ингэж яваад байгаа байхгүй юу даа. Тэгэхээр энэ чинь бодлого төлөвлөлтөө явуулъя. Системтэй байгууллагатай больё. Монгол Улсын Шадар сайдаар ахлуулсан ч юм уу ийм байгууллагатай болоод ингээд явах юм бол энэ улс орон чинь хөгжинө шүү дээ. Хэрвээ ард түмэн маань ажилгүйдэл ядууралгүй, орлоготой, төлөвлөгөөтэй, би нэг 10 жилийн дараа ийм мэргэжлээр сурвал ийм ажилтай болох юм байна. Би

нэг ийм ажил хийх юм бол ирээдүй баттай болох юм байна гээд ингээд бодоод явах юм бол энэ хүмүүс чинь ажил төрөл, мэргэжил, мэргэжлээ хүртэл сонгохдоо одоо чухал байж байна шүү дээ. Гэтэл тийм юм байхгүйгээсээ болоод өнөөдөр нэг уул уурхай гэнгүүт л уул уурхай дээр очиж, Оюу толгой дээр очиж бөөнөөрөө нэг ачигдаж очдог. Эсвэл нэг ноолуурын сезон болонгуут нь ноолуур луу явдаг ийм төлөвлөгөөгүйгээр энэ улс орон чинь хөгжиж чадахгүй байгаагийн гол үүсвэр.

Хэрвээ ийм төлөвлөгөөтэйгээр, бодлоготойгоор эдийн засгийн хөгжил нь сайжруулах юм бол ард түмний бухимдалгүй болгоно. Ажил орлоготой болно. Ажилтай болно, орлоготой болно, ажилгүйдэл ядууралгүй болно. Хэрвээ ажилтай орлоготой байх юм бол энэ улс төрждөг. Бүгдээрээ улс төрч болсон. 3.2 сая хүмүүс бүгдээрээ улс төрждөг болсон. Одоо нам сонгууль дөхөөд ирэнгүүт нь өөрөө за намын харьяалагддаг. Эсвэл дагаж гүйдэг, хэдэн төгрөг олох гэсэн ийм хүмүүс бий болдог энийг нь ингэж одоо тэжээдэг улс төрчид бий болчихсон. Ийм учраас бол энэ бодлоготой төлөвлөгөөтэй явъя гэдгийг одоо мөн ч олон жил ярьж байгаа.

Гаднын нөгөө хэлдэг, ярьдаг, нөгөө дагадаг хүмүүс чинь манайхыг алдаа дутагдлыг маань олчхоод одоо энэ та нар төлөвлөгөөтэй яв гэдгийг буцаад одоо бидэндээ зөвлөөд эхэллээ. Өөрсдийнхөө үгийг сонсдоггүй бидний олон жилийн ярьсныг сонсдоггүй юм бол тэр гадаадынхаа зөвлөхүүдийн үгнүүдийг сонсоод бид нарын ярьж хэлсэнтэй нь хамтатгаад энэ төлөвлөлттэй, бодлоготой ийм газартай болоод явъя л даа. Ингэхгүй бол Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, цэрэг дайны асуудал гэж байхгүй. Би тусгаар тогтнолоо зөвхөн эдийн засгаа сайн хөгжүүлж, баян тансаг чинээлэг ард түмэн болж байж энэ их баялагтай, энэ их түүхтэй, энэ их боломжийн улсыг хөгжүүлчих юм бол болно.

Одоо хөгжүүлчих юм бол бид улс орон маань өөдрөг, өнгөтэй ийм хэрүүл, уруулгүй болно. Сингапурыг хараад үз л дээ. Жижигхэн орон өнөөдөр хөгжлөөрөө тэргүүлээд л явж байна. Хонконгийг хараад үз л дээ. Английн колони байж байгаад Англид бол тусгай хугацаанд өгчхөөд одоо эргээд Хятадад нь буцаагаад өгчихсөн байж байгаад өнөөдөр тэр жижигхэн, Хятадын нэг жижигхэн одоо хэдхэн сая хүнтэй хүн Хонконг дэлхийн эдийн засгийг ганхуулж байна шүү дээ. Дэлхий Хонконгийг одоо харж байна шүү дээ. БНХАУ бусад өөр улс, орнуудыг байсан бол өнөөдөр Түвдийг, Уйгарыг, Монголчуудыг Хятадууд яаж байна. Бүгдээрээ өмнө нь бөхөлзөж байхад Хонконгоос гөлөлзөж байна шүү дээ. Юу ч хийж чадахгүй байна шүү дээ. Яагаад вэ гэвэл эдийн засаг нь хүчтэй хөгжиж байна. Тийм учраас Монгол Улс энэ 2 том хөршийн дунд бол эдийн засгийн хөгжилтэй, төв байгууллагатай ингэж явж байж Монгол Улс хүчирхэг болж байж дэлхийн олон улсад хүлээн зөвшөөрнө.

Зөвхөн Ардчилал, зах зээл гэсэн хоёрхон үгээр, шударга ёс гэсэн үгээр Монгол Улс хөгжиж чадахгүй байгаагийн жишээ энэ шүү. Ийм учраас бол би энэ эдийн засгийн хөгжилтэй холбоотой асуудлыг эдийн засгийн төв байгууллагатай байх асуудлыг бол үнэхээрийн гарцаа байхгүй авч үзэх асуудал гэдгийг олон жил ярьж байгаа. Дүлий юм шиг явж байгаа. Энийгээ бол замбараагүй байдалд байж байгаад эндээс нь бол байгалийн баялгаа замбараагүй болгодог, хулгай хийж байгаа, байгалиа сөнөөж байгаа, ард түмнийгээ доромжилж байгаа юмнууд явж байгаа шүү. Тийм учраас энийг бол цэгцтэй хөгжүүлэх асуудал бол гарцаа байхгүй хэрэгтэй. Тийм учраас төслийн юуг одоо Байнгын хороогоор орж ирсэн энэ саналыг дэмжих ямар ч боломж байхгүй. Энэ бодлого төлөвлөлтийг урт, дунд хугацаатай хэрэгжүүлдэг энэ байгууллага, төрийн захиргааны төв байгууллагыг нэг юундаа зөвшөөрөхгүй байгаа юм бэ. Энийг заавал ч үгүй оруулмаар байна. Энэ саналыг гишүүд дэмжиж өгөөрэй гэж хүсэж байна. Баярлалаа.

Л.Энх-Амгалан: Батболд гишүүн. С.Батболд гишүүн.

С.Батболд: Тэгэхээр нэмэлт, өөрчлөлтийн энэ 16 дугаар зүйл дээр Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтыг Төрийн байгуулалтын байнгын хорооноос дэмжиж орж ирсэн байгаа. Тэгээд ерөнхийдөө бол дэмжиж байгаа юм. Гэхдээ энд бас нэг, хоёр зүйлийг анхаарах ёстой гэж бодоод санал хэлье гэж бодлоо.

Нэгдүгээрт нь бол яах вэ ер нь энэ Улсын Их Хурлын хувьд бол бид олон жилийн туршид Засгийн газраас оруулж ирсэн төсвийг батлахдаа зүгээр нэг бүтцийг нь өөрчлөх биш, зарлагыг бол их нэмдэг, алдагдлыг нэмэгдүүлдэг ийм практик бол бүүр тийм уламжлал болчихсон явж ирсэн. Тэгээд гишүүн болгон мэдээж тойрог болгон дээрээ ажлаа хийх энэ замаар бол төсвийг өөрчилдөг. Үүнээс болж төсвийн бодлого алдагддаг. Зардал өсдөг, төсвийн алдагдал нэмэгддэг ийм зүйл одоо байнга байж ирсэн. Тэгэхээр зарлага болон алдагдлын хэмжээг өөрчилж болохгүй гэж ингэж одоо зааж оруулж ирж байгаа нь зөв гэж бодож байгаа юм. Энэ өөрчлөлт орсноор Улсын Их Хурлын аль нэг одоо гишүүнээс зарлага нэмэх санал гарах юм бол заавал орлогын эх үүсвэрээ заавал тусгах ёстой болж байна гэсэн үг. Нэг үгээр хэлэх юм бол төсвийн сахилга бат нэмэгдээд төсвийн алдагдал бууруулахад нэмэртэй болно гэсэн.

Тийм учраас энэ бол зүйтэй юм гэж байгаа юм. Зүгээр нэг энд байгаа нэг ойлгомжгүй гэх юм уу, тодотгох ёстой зүйлийг бас анхаарна, анхаарах хэрэгтэй. Энэ төрийн санхүү төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гээд гэдэг өгүүлбэр дотор хяналтыг гэсэн үг байгаа юм. Тэгэхээр уг нь төрийн санхүү төсвийг хэрэгжүүлдэг байгууллага нь Сангийн яам л даа. Төрийн төсөв, төрийн санхүү, төсвийн хяналтыг тэр хэрэгжүүлэх гэхээр энэ Үндэсний аудитын газрыг хэлээд байгаа юм шиг байгаа юм. Гэхдээ Үндэсний аудитын газар маань бол ер нь төрийн хяналтыг, төрийн аудитыг бүхэлд нь хийдэг газар шүү дээ. Тэгэхээр зөвхөн энэ санхүү, төсөв гэдэг дээр тусгайлж одоо нэмэлт үүрэг яригдаад байна уу, тусдаа байгууллага яригдаад байна уу энэ дотроо тодотгож байгаа асуудал юм уу гэдэг зүйл бол бас энэ тодорхой байвал зүйтэй байх гэж. Ингэж ойлгогдож байгаа юм. Би хоёрдугаарт нь, түрүүн Тэрбишдагва гишүүн нэлээн анхаарал тавьж ярилаа. Энэнтэй би бас санал нэг байгаа юм. Олон жил ер нь энэ Монгол Улсын хөгжлийн төлөвлөлт, хөгжлийн бодлого маань нэг тийм сонгуулийн улс төрийн циклтэй холбоотой юм шиг. Сайхан баримт бичгүүд их байдаг ч гэсэн тэр нь уриа лоозон маягтай ингээд яваад ирсэн.

Тэгээд энэний гол одоо дутагдал алдаа нь юундаа байна вэ гэхээр хөгжлийн төлөвлөлт хариуцсан энэ төрийн захиргааны төв байгууллага ерөөсөө тогтвортой бөгөөд тодорхой байхгүй байгаа юм. Яг энэ утгаараа бол би Тэрбишдагва гишүүнтэй санал нэг байгаа юм. Бид энийг бас олон жил энэ эдийн засаг, бизнес энэ талаас нь тогтвортой орчин байх ёстой. Өрсөлдөх чадвартай орчин, бодлого байх ёстой гэдэг талаас нь би зөв гэж байгаа юм. Жишээлбэл, энэ Японыг ярьж байна. Түрүүн олон жишээ ярьсан энийг. Бид Японыг тогтвортой хөгжилтэй орон гэж үздэг, энд бол ямар байгууллага байдаг гэхээр Японы эдийн засаг, худалдааны яам гээд энэ хөгжлийн бодлогыг нь олон 10 жил маш ойлгомжтой, бодлоготой, тогтвортой авч явдаг ийм төрийн захиргааны байгууллагатай. Энийгээ заагаад өгчихсэн.

Эдийн засаг, худалдааны яам гээд. Бидэнд тийм байгууллага байхгүй. ингээд солигдоод явагдаад байдаг. Түрүүн бас Тэрбишдагва гишүүн хэлсэн шүү дээ. Сонгуулиас сонгуульд засаг болгон гарч ирэхэд нэг засаг нь болохоор одоо

хөнгөн үйлдвэр, ноос ноолуурын бодлого яриад явдаг дараагийн засаг нь гарч ирээд инноваци яриад эхлэх жишээтэй. Тэрний дараагийн засаг нь гарч ирээд бас нэг өөр бодлого яриад ингээд ерөөсөө тогтвортой хөгжлийн бодлого гэж ерөөсөө байхгүй. Түүнийг хэрэгжүүлдэг байгууллага байхгүй. Цаасан дээр бол байгаад байдаг. Тэгэхдээ тэрийг ерөөсөө хэрэгжүүлдэг, тэр нь төсвийн одоо хөрөнгө оруулалтын урт хугацааны бодлогыг тодорхойлж өгдөггүй, хувийн хөрөнгө оруулалтыг татах тийм тогтсон бодлого гаргаж өгдөггүй. Ийм одоо бодлогын чанартай ингэж зангидаж хийдэг ийм төрийн захиргааны төв байгууллага байхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энийг бид нар бол дэмжих ёстой. Энийг болж өгвөл энэ Үндсэн суурь хуульдаа бол заагаад өгөх нь уг нь зөв зүйтэй байгаа юм. Энийг бид нар ярьдаг л даа. Бидний одоо сууж ирсэн, би бол 4 парламент дамжаад сууж байгаа. Ер нь байнга л ярьдаг юм. Байнга л ярьдаг.

Тэгэхээр байнга л одоо баримт бичиг гаргадаг. 20 шахам бодлогын баримт бичиг батлагдсан гэж байгаа юм. Би энэ тоог нь аваад үзэхэд, тэгээд тэр батлагдсан энэ хөгжлийн чанартай, бодлогын чанартай энэ баримт бичиг уриа лоозон болоод л тэгээд цаас болоод л дуусчхаад байгаа юм. Тэгээд яагаад гэвэл нөгөө хэрэгжүүлдэг мөн зангидаж бодлого болгодог энэ төрийн захиргааны төв байгууллага нь байнга өөрчлөгдөөд явчихдаг. Жишээ нь худалдааны бодлого гэдэг дээр байхгүй л байгаа шүү дээ. Байнга яам дамжаад Эдийн засгийн яам болоод, Үйлдвэр худалдааны яам болоод, Гадаад харилцааны яам гээд ингээд хэд хэдэн яамнуудаар сонгууль болгоноор солигдоод явдаг учраас нэг тийм тогтвортой нэгдсэн бодлого гэж ерөөсөө байхгүй. Тийм учраас энэ зүйлийг бол бид нар уг нь тусгаад авах нь зүйтэй байгаа юм.

Улс хөгжилд төлөвлөлтийг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын энд тодорхойлоод заагаад өгөх нь зүйтэй. Жишээ нь бид бол төрийн захиргааны байгууллагуудыг бол бүр одоо хуулиудаар агентлагуудын тухай би түрүүн ярьж байсан. Хуультай. Агентлаг байгуулагдахдаа хуультай тийм учраас агентлагуудын бодлого бол харьцангуй тодорхой, үйл ажиллагаа нь тогтвортой, бүүр боловсон хүчний чадавх нь ч гэсэн илүү боломжтой байдаг. Гэтэл төрийн яамнууд дээр ирэхээр бол яам болгон дээр тийм хууль байхгүй. Тийм учраас энэ дээр яам болгон дээр нэр нь солигдоно, боловсон хүчин нь солигдоно, бодлого нь солигдоно. Бүх юм нь солигдож байдаг болохоор маш ойлгомжгүй, тогтворгүй зүйл яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр бол цаашдаа болбол яам тус бүрээр бүр одоо хууль гаргаад тэр дотоод энэ төрийн захиргааны хөгжлийн төлөвлөлт, бодлого хариуцсан ийм одоо яамыг болбол хуульчилж байгуулж өгөх ийм асуудлыг бас анхаарч өгөх нь зүйтэй гэсэн ийм одоо саналыг хэлье гэж бодоод байгаа юм. Баярлалаа.

Л.Энх-Амгалан: Баярлалаа. Гишүүд энэ үүдэнд үдийн цай ирсэн байгаа юм байна. Ажлын хэсгийнхэн тэгээд гишүүдийг үг хэлж байх хооронд бас нэг, нэгээрээ гараад ингээд цайгаа уучих уу. Ингээд Нарантуяа гишүүн.

3.Нарантуяа: За, энэ Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд өөрчлөлт оруулах тухай одоо төслөөс, анхны төсөлд байсан санал ажлын хэсгийн гаргасан санал, гишүүдийн гаргасан саналыг ярьж байна л даа. Тэгэхээр энэ яг одоогийн бид нарын санал хураах гэж байгаа энэ томъёоллууд аль, аль нь нөгөө байрлалаа олоогүй, Үндсэн хуулийнхаа бүтцийг алдагдуулсан ийм саналын томъёоллууд байна гэж хэлэх гэж байгаа юм. Үндсэн хуулийн 25 дугаар зүйл өөрөө Улсын Их Хурлын онцгой эрхийг тодорхойлж өгч байгаа заалт. Хуучин бол энэ заалт дээр Улсын Их Хурал төсөв, санхүү энэ эдийн засагтай холбоотой үндсэн чиглэлийг тодорхойлж Засгийн газрын үйл ажиллагааны төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг

батлах гээд эрхийг нь хийж өгсөн юм. Одоо энэ заалт дээр нэмэх гэж байгаа зүйл нь юу вэ гэхээр нөгөө зарчимтайгаа холиод байгаа байхгүй юу.

Их Хурал төсөв, санхүү, үндсэн чиглэл бодлогын баримт бичгүүдийг батлахдаа ч тодорхойлохдоо ч, Засгийн газар нь боловсруулж оруулж ирэхдээ ч баримтлах ёстой үндсэн зарчим нь энэ төслийн зарлага алдагдлын хэмжээг нэмэгдүүлэхгүй, төсвийн ер нь бол орлогодоо суурилсан энэ зарлагын хүлээгдэж байгаа орлогын хэмжээ, эдийн засгийн нөхцөл байдалдаа тулгуурласан ийм зарлагын дээд хэмжээг тавьж байх ийм үндсэн шаардлагыг оруулмаар байгаа юм. Одоо бид нар Санхүүгийн тогтвортой байдлын тухай хууль гээд энэ хууль байгаа. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, энэ хуулиар хэчнээн одоо бид нар дээд таазнуудыг өрийн тааз, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн алдагдлын хэмжээг тавьсан ч гэсэн Үндсэн хуульд заагдаагүй учраас тухай тухайн үед нь өөрчлөөд өнөөдрийн манай эдийн засаг, төсөв санхүүгийн бодлого маань ийм замбараагүй, сахилга хариуцлагагүй болчихоод байгаа юм. Тэгэхээр би бол одоо зарчмын санал гаргах гээд байгаа нь хоёрдугаар хэлэлцүүлгийн дараа энэ томъёоллыг дахиж авч яг Үндсэн хуулийнхаа 5 дугаар зүйл буюу эдийн засгийн үндсэн харилцаагаа тодорхойлж байгаа тэр 5 дугаар зүйл дээрээ 5-ынхаа 4-ийн ард энэ өгүүлбэрүүдийг оруулаад 5¹-ээр шинэ заалт нэмэх ийм санал байгаад байгаа юм.

Энэ төр нь 5 дугаар зүйлийн 4 дээр төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангахад зорилгод нийцүүлэн эдийн засгаа зохицуулна гээд. Тэгээд араас нь тэр хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байх, төрийн санхүү, төсвийн одоо хяналтыг чинь хараат бусаар хэрэгжүүлэх байгуулга байх тэр нь хуулиар тогтоогдох гэсэн энэ Үндсэн зарчмуудаа тавынхаа 4-т аваачиж өгвөл одоогийн энэ санал хураах гээд байгаа 10.2 чинь зөв байрлалаа олоод тэгээд сайн томъёологдох гээд байна гэж. Ер нь бол 5¹ дээр бол Улсын төсөв, санхүү гэсэн шинэ зүйлийг нэе, бий болгоё. Нэгдүгээр шаардлага бол улсын төслийг батлахдаа орлого, зарлагын тэнцвэртэй байдлаа хангана. Төсвийн нийт зарлагын таазыг хүлээгдэж байгаа орлогын хэмжээ эдийн засгийн нөхцөл байдлыгаа харгалзаж тогтооно.

Улсын төсвийн алдагдлын дээд хэмжээ бол дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 2 хувиас илүүгүй байх бөгөөд зарлагын дээд хэмжээг нэмэгдүүлэх, хуульд заасан зайлшгүй шаардлага үүсэн тохиолдолд хуульд заасны дагуу Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ гэдэг ийм томъёоллоор хийхгүй бол одоо ерөөсөө Засгийн газар зөвшөөрөхгүй бол нэмж болохгүй. Ерөөсөө алдагдал зарлагыг нэмж болохгүй гэсэн ийм юм хийгээд байна шүү дээ. Амьдрал баян, энэ улсад чинь төлөвлөөгүй, төсөвлөөгүй одоо муугаар ярихад эрсдэлтэй ямар ч байдлууд бий болж болно шүү дээ. Энэ Засгийн газар чинь яах аргагүй нөхцөл байдал, онцгой нөхцөл байдал бий болоод зарлагыг нэмэх тийм тохиолдол гарна гэвэл ямар тохиолдол байх юм гэдгээ хатуу энэ хуульд хийчихсэн байх тохиолдолд зөвшөөрсөн зарчмыг Үндсэн хуульдаа хийж өгөхгүй бол энэ чинь хөл, гараа барьчихаж байгаа. Нэг талаасаа нэг шударга сайн заалт, хариуцлага чангатгаж байгаа заалт хийж байгаа юм шиг, нөгөө талаасаа Засгийн газраа маш их боомилсон ийм нөхцөл байдалд орохоор томъёоллууд болчихоод байна.

Дээр нь бол хамгийн хатуу хийж өгөх асуудал бол энэ Засгийн газрын өрийн тааз дээд хэмжээ байгаа юм. Ихэнх улсуудад бол дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 60%-аас илүүгүй байна гэдэг ийм хатуу шаардлагыг бол Үндсэн хуульдаа хийж өгсөн байна. Бид нар бол одоо энэ Төсвийн тогтвортой байдлын хуульдаа хийгээд энийгээ хэд өөрчилчихсэн явж байгаа. Тэгэхээр энэ сахилга

хариуцлагаа үнэхээр одоо чангатгая гэдэг ийм шаардлагыг ярьж л байгаа бол одоо бид нар дахиж энэ томьёоллуудаа нухацтай авч үзэх хэрэгтэй байна.

Гуравдугаарт, төсвийн хөрөнгийн хуваарилалтын зарчмыг суулгаж өгөх хэрэгтэй байна. Одоо бид нар тогтолцоогоо өөрчилж чадахгүй, тэртэй тэргүй ингээд 66 жижиг, 76 жижиг мажоритараараа явна гэвэл одоогийн төсвийн нийт гуравны хоёр хувь чинь хөдөө орон нутаг руу, тойрог болгон руу яваад байгаа ч гэсэн хөдөө хотын чинь хөгжлийн ялгаа арилахгүй байгаа энэ хуваарилалтын буруу бодлого чинь үргэлжлээд явах гээд байна. Тийм учраас би бол төсвийн хөрөнгө оруулалтын хуваарилалт, төсвийн хөрөнгийн хуваарилалт нь эдийн засгийн үр ашигтай нийгмийн ач холбогдолтой байх бөгөөд хөгжлийн бодлого, зорилго бодлого төлөвлөлтдөө нийцсэн урт хугацааны өсөлтийг дэмжихүйц байна ийм зарчмыг энд оруулмаар байна гэсэн ийм бодлууд байгаа юм.

Тэгээд одоо энэ 25.1.7 буюу Улсын Их Хурлын зүгээр онцгой бүрэн эрхийг энэ зарчимтай нь холиод байгаагаа болиод энд оруулсан тэр төсөв, зарлагын алдагдлын дээд хэмжээг нэмэгдүүлж үл болно гэсэн хатуу зүйлээ ямар тохиолдолд, ямар хувь хэмжээнээс нэмэхгүй, нэмэгдүүлэхгүй, дахиж хэлэлцэх тухай зарчмаа оруулаад, төсвийн бодлого төлөвлөлт бол тогтвортой байна гэдэг юмаа нэлээн сайн одоо тодорхойлчихмоор байгаа юм. 5.4 дээр тухайлах юм бол эдийн засгийн одоо манай 5.4 бол саяны, түрүүний миний уншсан эдийн засгаа яаж хөгжүүлэх үү гэдэг үндсэн зарчим байгаа юм. Тэрний ард эдийн засгийн эрх чөлөөг эрхэмлэсэн тогтвортой хөгжлийн загвар үзэл баримтлалыг хуулиар тодорхойлно гэдгээ хэлээд энэ хөгжлийн үзэл баримтлал нь эдийн засгийн бие даасан байдлыг хангах нэгдмэл цогц харилцан уялдаатай, судалгаанд суурилсан төрийн бодлогын залгамж чанарыг хангасан, хэрэгжихүйц байна гэдэг энэ өгүүлбэрийг тавьж байгаад тэгээд энэ 10.2 буюу санал хураалгах гэж байгаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт, дунд хугацааны нэгдсэн бодлого төлөвлөлтэйгөөр хэрэгжүүлнэ.

Энийг хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллагатай байна гэдэг энэ юмаа хийх юм бол бид яг энэ Үндсэн хуульд эдийн засгийн суурь харилцаануудынхаа нэлээн гол зарчмуудаа суулгаж чадсан ийм амжилттай өөрчлөлт болох юмаа гэж бодож байгаа юм. Бас нэг санал байгаа. Ер нь одоо улс орныхоо хөгжлийг цааш нь 10, 20 жилээр, 30 жилээр ингэж харж тэрнийхээ суурь зарчмуудыг Үндсэн хуульдаа хийж өгье гэж бодож байгаа бол энэ эдийн засаг, нийгмийнхээ хөгжлийг дэмжсэн санхүүгийн салбарын хөгжлийн цоо шинэ энэ хэлбэр хувилбарыг бид нар хөгжүүлж эхлэх зайлшгүй шаардлага байгаа юм.

Өнөөдөр одоо улс оронд томоохон төслүүд, томоохон эдийн засгийн ач холбогдол бүхий арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх гэхээр дандаа төсөв мөнгөний гачлантай, тэгээд гаднаас зээл хууль гуйж явдаг. Бид нар энэ санхүүгийн зах зээл дээрээсээ өөрсдөө хөрөнгөө босгодог, энэ чөлөөт санхүүгийн орчныг бий болгох хэрэгтэй. Би юу гээд, жишээ болгож ярихад одоо энэ Хонконг дээр үүсэж байгаа нөхцөл байдал бол энэ Азид оруулж ирж байгаа том том санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн урсгалыг энэ үргээж байгаа яг энэ нөхцөлд бид нар санхүүгийн чөлөөт бүс гэдэг юмыг улс орондоо, Монголдоо хүлээн зөвшөөрч байгуулах хэрэгтэй байна.

Энэ хуулийг гаргаад явах гэхээр энд чөлөөт бүс дээр хөрөнгөө оруулах гэсэн санхүүгийн байгууллагууд энэ хөрөнгө оруулагч нар чинь юунаас эмээдэг вэ гэвэл манай дотоодын шүүх, хуулийн байгууллагын энэ нөхцөл байдлаас л үргээд байдаг. Тэгэхээр аль ч улсад олон улсын шүүхийн хэлбэрийг энэ санхүүгийн чөлөөт бүс дотроо зөвшөөрөх юм бол энэ хөрөнгө оруулагч нар чинь итгэлтэйгээр

орж ирдэг ийм хөгжлийн нэг шинэ боломж байна шүү дээ. Тэгээд нэгэнт л Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулж байгаа дараагийн сая би хэлсэн 20, 30 жилийнхээ хөгжлийг харж байгаа бол яагаад бид нар олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн шүүхийг энэ санхүүгийн чөлөөт бүс дотор байхыг зөвшөөрөөд, энэ санхүүгийн чөлөөт бүсийнх нь хуулийг гаргаад бусад улс 10-хан жилийн дотор бий болгож байгаа энэ юмыг бий болгож болохгүй юм бэ. Иймэрхүү байдлаар харж сэтгэж Үндсэн хуулиа өөрчлөх асуудалд хандмаар байгаа юм гэж. Ингэж чадах юм бол бид нарт маш их боломж байна.

Дотоодын нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн зах зээл чинь өөрөө хүссэн хүсээгүй өдөр тутам тэр хийж байгаа үйлдлээрээ энэ дэлхийн хэмжээний стандартыг чинь өөрөө авчраад суулгаад өгчихдөг. Энэ бүс нутагт эргэлдэж байгаа бүх хөрөнгийн урсгалыг чинь энэ төв дээр авчраад өгчих ийм боломж байгаа байхгүй юу. Тэгээд энэ саналуудаа хэлсэн. Тэгээд хоёрдугаар хэлэлцүүлгийн дараа үнэхээр дахиж энэ саналуудын томъёоллыг зарчмын бодлогын шинж чанартай зүйлүүдийг нухацтай дахиад нэг авч үзээч ээ гэдэг энэ хүсэлтийг л хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Л.Энх-Амгалан: 8 гишүүн үг хэлэх юм байна. Одоо цаг 1 цаг 23 минут. 8 гишүүнээр үг хэлтэл энэ чуулганыг үргэлжлүүлье. За Лүндээжанцан гишүүн.

Д.Лүндээжанцан: Баярлалаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцүүлэг явагдаж байна. Тэгэхээр энэ төслийн 2 дугаар зүйл буюу Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1.7 дахь заалт дээр бол маш их саналууд гарсан. Гишүүдээс, иргэдээс, эрдэмтэн судлаачдаас. Энэ дээр бол одоо бид бүтэн хоёр, гурван жил ажилласан. Тэгээд Үндсэн хууль гэдэг уг чанараа бас одоо бид ойлгох ёстой болоод байгаа юм. Үндсэн хуулийг бол хөтөлбөр Үндсэн хууль, тунхаг Үндсэн хууль, хууль Үндсэн хууль гэж ангилдаг.

Манай Үндсэн хууль бол хууль Үндсэн хууль байх ёстой. Тунхаг байж болохгүй, хөтөлбөр байж болохгүй. Манай гишүүдийн гаргаад байгаа санал дотор бол бүгдэнд нь хүндэтгэлтэй хандаж, үзэж байгаа. Үндсэн хууль дотор бол заавал төрийн захиргааны төв байгууллага гэдгийг бол яамыг хэлдэг. Тэгэхээр тийм тийм бид бүхэн бол 9 яамтай байя, 4-ийг нь, 3-ыг нь бол одоо нэмж байгуулж болъё гэдэг заалт олон нийтээр хэлэлцэгдэж ингээд дэмжлэг авсан ч байсан тэгээд харамсалтай нь бол одоо энэ яамандаа бол багтаахгүй юм байна лээ. Ганцхан Эдийн засгийн хөгжлийн яам гэдгийг бол ганцаарыг нь томъёолох бол тун төвөгтэй байгаа юм.

Хоёрдугаарт, зөвшилцөөний ажлын хэсэг бол энэ байгууллага байгуулахыг аль болохоор одоо хязгаарлах ийм асуудлыг ярьсан. Тийм ч учраас энэ одоо Тэрбишдагва гишүүн ээ, та миний яриаг та сонсохгүй байж болно. Гадаа үүдэнд хүмүүс сонсож байна, өрөө өрөөндөө хүмүүс сонсож байна. Иргэд телевизээр сонсож байна.

Л.Энх-Амгалан: Тэрбишдагва гишүүн ээ, та дэгээ сахъя. Дэгээ сахъя.

Д.Лүндээжанцан: Хоёрдугаарт, энэ асуудалд туйлын хүндэтгэлтэй хандаж бид бүхэн бол хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэдэг үг бол цаад утгаараа хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тогтвортой явуулах байгууллагатай байна гэсэн санаа байгаа юм. Чимид багш мөн олон удаа энэ Үндсэн хуулийн хэлэлцүүлэг дээр тайлбар хийж байсан. Юманд чинь байна шүү дээ Дорж бол Дорж гэж заадаггүй, хүн гэдэг бол ийм одоо эрхтнүүдээс бүрдэнэ гэвэл харин бол тэр Дорж гэдэг санаагаа илэрхийлдэг байхгүй юу. Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэдэг үг бол хангалттай гэж бид бол ойлгож байгаа.

Монгол Улс тэр хөгжлийн бодлого, төлөвлөлтгүй явж ирснийг маш их олон хүн шүүмжилж, саяын үг хэлсэн хүн болгон шүүмжилж байна. Энийг одоо оруулж ирээд санал хураалгах гэж байна шүү дээ. Харин тэр төрийн санхүү, төсвийн хяналт хараат бус байна гэдэг нь бол тэр Засгийн газартай холбогдолгүйгээр энэ бол яг төсөв, санхүүгээ хянадаг тогтолцоог нь оруулж ирье гээд ингээд оруулаад ирсэн. Энэ дээр байгууллага гэж нэг үг оруулж ирчхээд бас будилаан хутгаад байгаа юм.

Хоёрдугаарт, төрийн хөгжлийн бодлого бол урт удаан хугацаанд хэрэгжинэ гэдгийг энэ дотроо бас хэлээд өгчхөж байгаа юм. Дээр нь байгалийн баялгийн асуудлыг урт удаан хугацаанд тогтвортой хөгжлийн бодлогод нийцүүлэн явуулна гэдгийг хэлээд өгсөн. Засгийн газрын хэсэг дээр бас байж байгаа юм. Тэгээд юмыг бол өөрсдийнхөө зөв болгож тайлбарлахын тулд юм болгоныг одоо харлуулж, эсвэл мушгин гуйвуулж тайлбарладаг явдал их байна.

Сая одоо Баасанхүү гишүүн Ерөнхий сайд сайд нарыг томилно гэдэг асуудлыг бол ярихдаа Их Хуралд ор хамаагүй, ядахдаа Улсын дээд шүүхийн шүүгчдийг Их Хурал танилцаад үгээ хэлээд гардаг тиймийг байхгүй болгосон гэж яриад. Гэтэл цагаан дээр хараар төсөл дотор Улсын Их Хурал Ерөнхийлөгчид танилцуулж томилж, чөлөөлнө. Сайд нар нь Засгийн газрын гишүүд нь Их Хуралд тангараг өргөнө гээд энд биччихсэн байж байгаа байхгүй юу. Яахаараа тэгэхээр тэрийг сонсож байгаа олон түмэн бол нээрээ л эд нар баллах гээд байгаа юм байна. Тийм юмгүй болгосон юм байна гээд. Энэ чинь байгаа юмыг ингэж одоо гуйвуулж одоо ингэж тайлбарлаад байгаа одоо манай гишүүд болиоч ээ гэж би хэлмээр байгаа юм.

Өөрөөр хэлбэл өөрийн л юмыг оруулж байвал тэр бусад юмыг бол яаж ч гуйвуулсан хамаа байхгүй. Энэ дотор ороогүй зүйл байхгүй. Төсвийн сахилга баттай холбоотой Их Хурлын гишүүдийн юун дээр бол бид ингэсэн шүү дээ. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлсэн, боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах. Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Их Хурлын эрхэнд халдаагүй, бид өөрчилж болно. Харин тэгэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно гээд. Энэнээс илүү одоо ер нь яаж заалгах гээд байгаа юм.

Бид төсвийг одоо хариуцлагатай баталдаг больё. Тэр өргөн мэдүүлсэн нь үнэхээр буруу байх юм бол батлахгүй байх эрх бас Их Хуралд байна. Их Хурал төсөв батлахгүй бол Ерөнхий сайд бараг огцрохдоо хүрнэ. Гэх мэтчилэн шат шатанд хариуцлагыг нь дээшлүүлээд өгсөн ийм заалт байж байгаа. Тэгээд би энэ Үндсэн хууль одоо миний дараа Эрдэнэбат дарга үг хэлнэ. Энэ Үндсэн хууль бол Ардын намын асуудал биш. Энэ бол монголын ард түмний асуудал. Хамтын бүтээл. Тэгээд энэ асуудал болгон дээр манай Ардын намын бишээ АН-ын гишүүд оролцсон, бүлгийн гишүүд. Бүр одоо анхнаас нь оролцоод явсан. Тэгээд хамтарч одоо энэ цагаан дээр хараар бичигцгээсэн. Тийм учраас бол би АН-ын энэ Ардын нам муухай харагдаж байвал болно. Тийм учраас бол одоо энэ унах юм бол ард түмний эрх ашиг унах гээд байгаа байхгүй юу. Тийм учраас АН-ын гишүүд маань дэмжих юман дээрээ дэмжээд, үнэхээр саналын зөрүүтэй юман дээрээ бол үгээ хэлээд эсэргүүцэх юман дээрээ эсэргүүцээд явна байх аа гэж би итгэж улс төрийн соёлыг бол одоо та бүхнээсээ хүсэж байгаа юмаа гэдгээ бас нэг хэлчихье.

Л.Энх-Амгалан: За Д.Эрдэнэбат гишүүн.

Д.Эрдэнэбат: Баярлалаа. Би 7 жил энд парламентад сууж байна. Анх удаа ингээд гурвуулхнаа өөд өөдөөсөө хараад хичээл заагаад байгаа юм шиг Үндсэн хууль хэлэлцэж байх.

Л.Энх-Амгалан: Үгүй ээ Эрдэнэбат гишүүн ээ. Гишүүд энэ коридорт байна, үдийн цай.

Д.Эрдэнэбат: Үгүй ээ, гишүүд гэх юм байхгүй. Би танд зарчмын нэг юм хэлье. Ингэж хэлэлцүүлээд яах юм бэ. Наадахаа завсарлуул. Би зурагтаар гарах гэж үг хэлмээргүй байгаа юм л даа. Өнөөдөр энэ төрийн санхүү, эдийн засаг төсөвтэй холбоотой яг энэ заалт орж ирж байгаа мөртөө энэ 76 байж байгаа даа уг нь. Ирц нь 63 шүү дээ. Тэгээд би одоо ингээд Лүндээ гишүүн над руу лекц уншсан, одоо би ямар Лүндээ гишүүнд лекц уншилтай нь биш дээ, ичиж байна шүү дээ. Баттөмөр гишүүн хоёртоо. Гурвуулхнаа сууж байна шүү дээ. Ингэж болохгүй шүү дээ. Тантай нийлээд 4-лээ сууж байна. Лүндээ гишүүн ээ, тэгэхээр одоо таны үг бол надад зориулж өгсөн үг болоод дуусаж байх шиг байна. Уг нь энэ 60 гишүүн чинь бүгдээрээ сонсож байх ёстой шүү дээ. Одоо тийм учраас би завсарлаад тэгээд гишүүд байж байгаа дээр би энэ төрийн эдийн засаг, санхүүгийн тухай үгээ яримаар байна. Тийм учраас одоо завсарлуулъя. Гуравхан хүнтэй хэлэлцэнэ гэж ямар юм байдаг юм.

Л.Энх-Амгалан: Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Төслийн тэр 10.2-т Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт, дунд хугацааны хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлттэй байна. Бодлого төлөвлөлтийг тогтвортой залгамж чанартай хэрэгжүүлнэ гээд ингээд ийм санал Тэрбишдагва гишүүн бид оруулсан юм л даа. Тэгээд харамсалтай нь бол энэ дэмжигдэж явсангүй.

25.1.7-д хөгжлийн бодлого төлөвлөлттэй байна гэсэн заалт, тогтвортой байна гэсэн энэ заалт бол дэмжигдээд явж байгаа юм байна л даа. Тэгэхээр мөн одоо тэр төслийн 25.1.7 дахь заалтын бодлого гэсний дараа дунд, урт хугацааны бодлого гэж өөрчлөх гээд бас ийм санал оруулсан. Энэ бас Байнгын хороон дээр бол дэмжигдэхгүй байгаа. Гэх мэтээр ингээд юу байна л даа. Ер нь энэ аливаа хөгжил гэдэг бол төлөвлөлтгүй хөгжинө гэж бол байдаггүй. Тэгэхээр Монгол Улс энэ 30 жилийн хугацаанд төлөвлөлтгүй л яваад байна л даа. Социализмын үед бол Улсын төлөвлөгөөний комисс гэж одоо ийм байгууллага байсан. Улсын төлөвлөгөөний комиссын дарга нь Монгол Улсын Шадар сайд байсан. Монгол Улс хөгжиж байсан дээр үед. Тэгээд яагаад ингээд энэ хөгжлийн бодлого төлөвлөлт ингээд энэнээс татгалзаад байдгийг, сая Лүндээжанцан гишүүн хэлж байна. Чимид багш тайлбарлаж байсан. Яах вэ тайлбарлаж л байсан байх. Тэгэхдээ энэ 30 жил Монгол Улс чинь хөгжлийн бодлогогүй яваад байна шүү дээ. Өнөөдөр хөгжлийн бодлогыг хэн хариуцаж байгаа юм. Хэрэг эрхлэх газар хариуцаж байгаа юм уу эсвэл Сангийн яам хариуцаж байгаа юм уу. Сангийн яам хэзээ ч хөгжлийг хариуцдаггүй. Сангийн яам бол тэр орлого, зарлагатай холбоотой харилцаагаа л хариуцна. Нэг ийм юм байгаад байгаа юм л даа. Энэ бол их харамсалтай байна л даа.

Хөгжлийн бодлого байхгүй учраас хөгжлийн тэр төрийн зохицуулалт гэдэг юм байхгүй. Хөгжлийн бодлого төрийн зохицуулалтгүй учраас одоо өнөөдөр манай энэ хөгжлийн мухардал энэнтэй холбоотой байгаад байгаа шүү дээ. Хөгжлийн бодлоготой, төрийн зохицуулалттай улс хөгжиж байна. Одоо сая энд Тэрбишдагва гишүүний ярьж байгаа тэр Хонконгийн асуудал, Хонконгийн хөгжил. Японых, Солонгосынх, Хятадынх. Энэ одоо бид бэлэн туршлага бол байж байна шүү дээ. Тэгээд ийм ийм зүйлүүдийг бид нар одоо бодох ёстой байгаа юм л

даа. Төрийн одоо бодлого төрийн зохицуулалтгүй учраас энэ нийслэл хотын хөгжил, малын тоон өсөлт, чанарын одоо бууралт, авто замын түгжрэл, агаар, газар, ус, үзэгдэх орчны бохирдол, байгаль орчны сүйрэл гээд энэ болгон бүгд төрийн бодлого зохицуулалтаас үүдсэн 30 жил одоо бий болсон ийм гамшиг юм байгаа юм.

Тийм учраас энэ төрийн зохицуулах бодлого гэдэг зүйлийг Үндсэн хуульд бол маш их оновчтой хийх ёстой юм. Аргаа бараад одоо энэ хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан энэ нэг салбарыг одоо бий болгохгүй болохоор нь Үндсэн хуульд нь хийж өгье гэж одоо оролдоод тэгээд одоо барахгүй байна л даа. Сая одоо тэр С.Батболд гишүүний ярьж байгаа бас бодлого төлөвлөлтгүй хөгжсөн юман дээр бас зөв л, би санал нэг байгаа юм. Хөгжлийн бодлого байхгүй учраас дотор талд нь хийгдэх ажлууд нь хаягдаад, эзэнгүй хаягдаад байгаа юм. Тухайлбал одоо хөгжлийн бодлого байхгүй учраас энэ худалдааны бодлого, үйлдвэрлэлийн бодлого гэдэг юм нь Монголд байхгүй байна шүү дээ.

Зах зээл эхэлж байх үед л одоо баахан газар эдийн засгийн чөлөөт бүс байгуулна, худалдааны чөлөөт бүс байгуулна гэсэн. Өнөөдөр хаана байна. Нэг ч тэр бүс нь бий болсонгүй шүү дээ. Монгол Улс одоо дэлхийд газар нутгаараа 18-д орж байна шүү дээ эхлээд. Энэ том газар нутаг, энэ их одоо сайхан боломжийг ашиглаад хэд хэдэн чөлөөт бүсээ байгуулчих боломж байна. Худалдааны бодлого гэж ер нь алга. Уг нь үйлдвэр, худалдааны бодлого хамт явж байх ёстой. Юу үйлдвэрлэж чадах вэ, юу худалдаж авах вэ. Энэ бодлогууд маань одоо ингээд цуг явж байх ёстой. Харамсалтай нь байгуулаад ингээд дараа нь татан буулгачихсан. Шинэ Засгийн газар байгуулагдахдаа энийгээ цааш нь үргэлжлүүлж авч яваагүй.

Одоо өчигдөр тэр телевизээр гарч байна шүү дээ. Одоо Монголд үйлдвэрлэдэг, монголын одоо тэр зурагтай, тогтсон стандарттай тэр хүүхдийн формыг бол Эрээнд үйлдвэрлээд наашаа зөөж байна шүү дээ. Энэ болгоны цаана одоо дандаа валют урсаж байгаа юм. Монгол төгрөг яагаад одоо тогтвортой одоо ханш нь чангарахгүй байна гэхээр ерөөсөө энэ худалдааны бодлого байдаггүй. Валютын эрэлт бол өдөр тутам нэмэгдэж байна. Монгол төгрөгийн ханш өдөр тутам унаж байна. Ийм хөгжлийн одоо гаж хөгжил явж байгаа. Энийг л одоо засах гэсэн ийм л зүйл яваад байгаа юм л даа. Энэ хөгжлийн бодлого гээд ингээд ирэхээр бол энэ ер нь хүн төрөлхтний үүссэн цаг үеэс эхлээд хүн амьдрахын тулд одоо бий болсон ийм бодлого. Хамгийн хүчтэй хөгжил нь энэ дэлхийн хоёрдугаар дайны дараа үеэс л энэ дэлхийд бий болгосон ийм хөгжил гэж байгаа. Манайхан хөгжил ярихаар ДНБ-ний өсөлт яриад байгаа. ДНБ-ний өсөлт бол хөгжил бишээ. Хөгжил бол хүний хөгжлийн индексийн одоо өсөлт байхгүй юу. Хүний амьдралын чадварын одоо хүний амьдралын одоо тэр стандарт хэмжээ яаж нэмэгдэж байгаа юм энэний л одоо үзүүлэлтүүд юм. Тэгээд энийг одоо бид ойлгохгүй байгаа нь харамсалтай байгаа юм л даа.

Энэ хөгжил ингээд ярихаар бид нар маш их олон зүйл ярьж болно л доо. Бид нар бол зүгээр нэг өсөлт хөгжил ярих биш энэний чинь цаад талд одоо бид чинь дэлхийд амьдарч байгаа энэ 200 хэдэн улсын нэг. Дэлхийн зах зээл дээр Монгол Улс нэр хүнд, энэ эзлэх байр сууриа дээшлүүлэх бас нэг зорилт бол энэ хөгжлийн бодлого дотор бас л явж байх ёстой юм. Гэх мэтээр ингээд ярих юм бол одоо маш их олон асуудлуудыг ярьж байна л даа. Хөгжлийн бодлогогүй учраас засаглалын хомсдолыг үүсгээд байна. Засаглалын хомсдол маань хөгжлийн бодлогыг л одоо байхгүй болгоод байгаа юм. Ийм учраас энэ хоёрдох хэлэлцүүлгийн дараагаар энэ хөгжлийн бодлого төлөвлөлттэй холбоотой энэ асуудлыг дахиж нэг авч үзэж Үндсэн хуульдаа зөв тусгах нь зүйтэй гэж үзэж байгаа юм.

Л.Энх-Амгалан: Бямбацогт гишүүн алга, Мөнх-Оргил гишүүн алга, Оюунчимэг гишүүн алга, нэрээ татсан байна Батзандан гишүүн. Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт 15 цагаас. Одоо Аюулгүй байдлын байнгын хороо А танхимд 2 цагаас хуралдах юм байна. Аюулгүй байдлын байнгын хорооны гишүүд хуралдаа оръё.

Ингээд үдээс өмнөх хуралдаан завсарлалаа. Чуулганы хуралдаан үдээс хойш 15 цагаас.

ЗАВСАРЛАГА

Г.Занданшатар: Эрхэм гишүүд ээ. 2019 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 30-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Энэ 10 дугаар заалтын талаар гишүүд саналаа хэлсэн. Одоо санал хураалт явуулна. Үг хэлээд дууссан. Энэ заалт дээр үг хэлээд дууссан. Дараагийнх. Энэ төслийн заалтыг дууссаны дараа ахиад дараагийн 10.1 гээд заалт уншаад тэндээ саналаа хэлнэ. Д.Эрдэнэбат гишүүн буруу ойлгоод байгаа юм. Заалт тус бүрээр нь нэгтгэж хамтарч хэлэлцэж танилцуулж байгаа болохоос биш тэр үг хэлэх энэ тэрээ бол тэгээд.

Төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын “нийгмийн хөгжлийн” гэсний дараа “бодлого” гэж. Мөн заалтын “батлах” гэсний дараа “улсын төсвийг хэлэлцэн батлахдаа Засгийн газрын зөвшөөрөлгүй зардлын шинэ төрөл үүсгэж зарлага нэмэгдүүлэхгүй. Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэсэн хоёр, гурав дахь өгүүлбэр тус тус нэмэх. Төслийн заалт.

Төслийн заалтаар санал хураалт явуулъя. Төслийн заалтыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Төслийн заалт дэмжигдсэнгүй.

10.1.Төслийн 2 дугаар зүйлийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын “нийгмийн хөгжлийн” гэсний дараа “бодлого” гэж. Мөн заалтын батлах гэсний дараа “улсын төсвийг хэлэлцэн батлахдаа Засгийн газрын зөвшөөрөлгүй зардлын шинэ төрөл үүсгэж зарлага нэмэгдүүлэхгүй. Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гэсэн 2, 3 дахь өгүүлбэр гэснийг хасаж, төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16 дахь заалт буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт нэмэх.

16. Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт. Төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлого нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах, улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно. Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна. Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх,

зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. Санал гаргасан ажлын хэсэг. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал байна.

Үг хэлэх гишүүд нэрээ л өг. М.Билэгт гишүүнээр тасаллаа. Ц.Даваасүрэн гишүүн үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Би товчхон. Заавал 10 минут гэхгүй.

Энэ Улсын Их Хурал бол ингээд бодлого гаргах байгууллага гээд байгаа юм. Тэгээд өнгөрсөн парламент дээр болохоор бид нар дунд хугацааны хөтөлбөрүүд батлахыг бас Засгийн газарт эрхийг нь өгчихсөн байхгүй юу. Бас л бодлого шүү дээ. Дунд хугацааныхаа одоо хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлогуудаа өгчихсэн. Ингээд бодлогоо өгөөд яваад байгаа байхгүй юу. Тэгсэн мөртөө одоо жишээлбэл бид нар нэг бодлого баталчихъя. Хөрөнгө оруулалтын нэг том хөтөлбөр баталчихъя. Гэтэл одоо тэр дээр чинь мөнгө тавиагүй ороод ирсэн байвал тэгээд бид нар одоо ингээд яаж ч чадахгүй суугаад л байх уу? Аан. Зардлыг хөдөлгөж болохгүй гээд л.

Тэгэхээр энэ дээр бол нэг тийм сонин л юм. Одоо тэгээд нөгөө аягүй бол Төсвийн хуулиар илтгэл үзүүлнэ гээд л Ерөнхий сайдынхаа асуудлыг оруулж ирэх үү? Энэ дээр нэг тийм жаахан сонин л юм болчихоод байгаа юм даа. Ер нь бол бодлогоо гаргачхаад тэгээд хяналтаа тавиад явдаг. Төсвийн бүрэн эрх чинь Их Хуралдаа байгаа. Ер нь бол одоо Их Хурлын онцгой бүрэн эрхийн нэг шүү дээ. Тэгтэл одоо ингээд энийгээ эдэлж чадахгүй өөрсдийнхөө. Яах вэ бид нар төлөвшил муу байсан байх. Өнгөрсөн хугацаанд. Тэгэхдээ бид нарын оруулсан хөрөнгө оруулалт, сургууль, цэцэрлэг, эмнэлэг бол буруудаагүй л байх гэж би ингэж бодож байгаа юм.

Гэтэл одоо ингээд хэрвээ бид нар яг одоо энэ тогтолцоогоороо шууд сонголтоо тойргийн гишүүдтэй байх юм бол тойргийн асуудлаа ярьдаг л байж таарна. Тэрийгээ сайн шүүгээд. Ер нь бид нар бодлогоо гаргаад бодлогоо батлаад явчихдаг, тэр бодлогоо зөрчдөггүй байхад л асуудал байгаа болохоос биш одоо зардал нэмж болдоггүй, тэгж ингэж болдоггүй гэдэгт бол би асуудал байна гэж харахгүй байгаа юм.

Тэгээд ер нь зүгээр хэрэгжүүлдэг байгууллагаа ингээд данхайлгаж, хэтэрхий том эрх мэдэл өгдөг энэ ер нь зөв үү, буруу юу? Дандаа сайн хүн Засгийн газрын тэргүүнээр томилогдоно гэдэг баталгаа байхгүй шүү. Байхгүй. Их дураараа загнадаг хүн гарч ирээд л та нарын баталсан бодлогыг чинь төлөвлөхгүй орж ирээд л. Тэгээд бид нар тэрийг нь төсвийг нь тавьж чаддаггүй. Нөгөө бодлого хэрэгждэггүй. Тийм ээ. Ингээд суугаад байдаг болох ийм юм руу явж байгаа юм биш биз дээ. Зүгээр сайн хараарай. Би бол одоо намын тэргүүн, Ерөнхий сайд байгаа энэ тогтолцоог чинь бол хангалттай эрх мэдэл Засгийн газарт байна гэж ингэж хардаг шүү.

Бид нар өнгөрсөн нэг Засгийн газрыг мэднэ дээ. Эрдэнэтийг өгөөд явуулчхаж чадаж байсан. Дубайг өгөөд явуулчхаж чадаж байсан. Одоо цаашдаа тэгээд ер нь ингээд Эрдэнэт шиг юмнууд одоо ингээд Тавантолгойг маань нэг нөхөр гарч ирээд л ингээд өгөөд тавиад туудаг. Дураараа аашилдаг. Бодсоноо төлөвлөдөг. Бодсон төсвөө баталдаг. Их Хурлаа үл ойшоодог. Ийм байдал руу явах юм биш биз дээ гэж би зүгээр.

Тэр нэг хэтэрхий задгайруулсан юмыг нь бид нар яах вэ жаахан хянах хэрэг байсан л байх. Тэгэхдээ тэр бол бид нарын тэр хуулиа дагадаггүй, төлөвлөгөө, бодлогоо дагадаггүй, урт хугацааны бодлогоо дагадаггүй бид нарын ёс суртахуунд

л байгаа болохоос биш. Ийм юмыг зохицуулах шаардлага байсан уу, үгүй юу гэдгийг бол би мэдэхгүй юм. Зүгээр гишүүд минь сайн анзаараарай. Би бас энэ төсвийн чиглэлээр олон жил ажилласан хүний хувьд хэлж байгаа юм шүү. Энэ бол тодорхой буруу үр дагавартай байж магадгүй. Дураараа Ерөнхий сайд гараад ирэх юм болов уу л гэж би хэлээд байгаа юм шүү.

Г.Занданшатар: Ц.Даваасүрэн гишүүн бас өмнөх заалтыг сайн уншаагүй бололтой. Өмнөх заалт дээр төсвийн зарлага үүсгэхгүй, нэмэхгүй гэсэн байсныг энүүгээр орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно гэж өөрчилж байгаа шүү дээ. Тэгэхээр нөгөө агуулгатай нийцэхгүй болоод байна шүү.

Эрхэм гишүүн Д.Эрдэнэбат үг хэлнэ. Өмнөхийг чинь унагаад энэ өөрчилж болно гэж оруулж байна.

Д.Эрдэнэбат: Баярлалаа. Үндсэн хуулийн гол өөрчлөлтийн цорын ганц өгүүлбэр энд л яваа юм л даа. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн өөрчлөх шаардлагатай гурван зайлшгүй бидний өмнө шаардлага тулгасан. Харамсалтай нь энийг Үндсэн хуульд өнөөдөр хүртэл бид нар тусгаж чадаагүй.

Төрийн эдийн засгийн бодлого гэдэг бол Улсын Их Хурлын бүрэн эрх мэдлийн тухай асуудал байсан. Түүрүүн манай З.Нарантуяа гишүүн ярьсан. Уг нь бол Үндсэн хуулийнхаа 5 дугаар зүйлийн тэр эдийн засагтай холбоотой зүйлээ нэлээн тодорхой болгох байсан юм. Тэгж байж энэ өөрчлөлт явна гэж. Тэгээд манай зөвлөлөөс оруулсан ганц нэг найруулгын чанартай цорын ганц заалтуудын нэг нь энэ л дээ.

Ер нь бол бид нар энэ эдийн засгийн хэт төвлөрөл, санхүү, төсвийн эрх мэдлийн хэт төвлөрлөөс зайлах ганцхан арга нь бид нар төрийн эдийн засгийн бодлогоо тодорхой болгох байсныг энэ Үндсэн хуульд хийж чадаагүй. Одоо манай зарим гишүүд ч гэсэн энэ үг өгүүлбэрийн утга учрыг ойлгохгүй явж байгаа байх.

Ер нь бол орон нутагт энэ эдийн засгийн, төсвийн, татварын зарим нэгэн эрх мэдлийг хуулийн хүрээнд өгөх асуудлыг орон нутгийн тэр заалт дээр зохицуулсан хэдий ч гэсэн төрийн эдийн засгийн үндсэн бодлогыг бид нар тодорхойлж чадаагүй. Яагаад гэвэл 5 дугаар бүлгийг нэмэлт, өөрчлөлтөөр оруулаагүй гэдэг шалтгаанаар. Төр бол эдийн засгийн бодлогыг тодорхойлохдоо Их Хурлын гишүүн ч гэсэн төсөвт өөрчлөлт оруулах эрхтэй байх ёстой. Эрхтэй байх ёстой. Энэ дээр энэ заалт тусаж чадаагүй. Орон нутаг өөрсдийнхөө одоо үйл ажиллагаа явуулж байгаа компаниудыг бүртгэх эрх, татвар хураах эрх, төсвөө бие даан зарцуулах эрхийг олгох энэ нөхцөлийг энэ заалтаар олгох ёстой байсныг өнөөдөр бид нар хийж чадаагүй.

Тийм учраас одоо манай бүлгийн нэг зарчмын байр суурийн хамгийн гол зарчмын байр суурь илэрхийлсэн энэ заалт бол өнөөдөр энэ дээрээс хасагдаж байгаа. Үндсэндээ бид нар гурван төрлийн зүйлийг л Үндсэн хуульд зайлшгүй өөрчлөхөд хэрэгтэй гэж оруулсан шүү дээ. Үнэхээр бид нар сонгодог парламенттай байя гэвэл нэгдүгээрт засаглалын тогтолцоогоо өөрчилж Ерөнхийлөгчийг Их Хурлаас сонгодог байх нь зөв юм гэж.

Хоёрдугаарт, эдийн засаг, төрийн эдийн засгийн бодлогоо тодорхой болгох ёстой. Энэ 76 гишүүн чинь одоо үнэхээр энэ төсвийг үр ашиггүй зарцуулах юм нь дээр маш их хувь нэмэр оруулж байгаа. Үр ашиггүй хөрөнгө оруулалт энд тэндгүй маш ихээр хийгдэж байгаа. Орон нутагт төсвийн ямар ч эрх мэдэл байхгүй. Дээрээс өгсөн тоог нүдэн балай, чих нь дүлий баталж байгаа. Энэнээс үүсэх хэт төвлөрлөөс үүссэн энэ авлига бол газар авч байгаа. Энэ бүх зүйл чинь энэ зүйлд

тодорхойгүй байгаагаас үүдэж байгаа нь яг хэвээрээ үлдэж байгаа юм. Хэвээрээ үлдэж байгаа. Тийм учраас бидний энэ нэг зарчмын байр суурь бол өнөөдөр энэ Үндсэн хуульд тусгаж чадаагүй гэдгийг би бүр зориуд хэлчихье гэж ингэж бодож байна.

Ер нь бол бид нар цаашдаа энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөд энэ мэтийн гол зүйлээ, зарчмын зүйлээ тусгаж чадаагүй байж ямар өөрчлөлтийг хүлээж байгаа юм бэ гэдэг нь ч үл ойлгогдох байдал руу өнөөдөр орж байгаа. Манай гишүүн ч гэсэн зарим юмаа ойлгохгүй явж байгаа. Өнөөдөр ингээд санал хураалт яваад л ингээд ажиглаад байхад энэ дээр дарах юм уу, дарахгүй юм уу гээд л. Тэндээс С.Бямбацогт дарна, дарахгүй гээд удирдаад л. Түүгээрээ гар хөлөөрөө дохиод л. Ингэж Үндсэн хууль бид нар баталж болохгүй шүү дээ.

Анх одоо Ардын намынхан чинь Ерөнхийлөгчийг одоо ерөөсөө үнэхээр одоо юунаасаа сонговол зөв юм байна. Парламентаасаа. Тэгж байж бид нар чинь нээрээ сонгодог засаглал руугаа орох юм байна гээд ярьсан. Өнөөдөр байхгүй. Бид арга ядаад энэ саналыг оруулсан чинь энийг унагаачихсан. Одоо өчигдөр та нар ярьж байгаад энэ намыг албан ёсны Үндсэн хуулийн эрх бүхий субъект болгочихлоо. Тэгээд тэрийгээ болгосон мөртөө өнөөдөр холимог тогтолцоог дэмждэггүй. Мэдээж холимог тогтолцоо гэж ярихад ард иргэд ойлгохгүй байгаа тэр янз янзын юм явж байгаа гэдгийг бид ойлгож байгаа. Тэгэхдээ сонгодог парламент өөрөө нам, төрд нөлөөлөх бодлого, багийн үйл ажиллагаа гэж байхгүй бол сонгодог парламентын утга нь алдагдаж байна гэдгийг энэ 76 жижиг тойрог нотолчихлоо шүү дээ.

Тийм учраас өнөөдөр Ерөнхийлөгчийн орж ирсэн 108-ыг 99 мажоритар гэнгүүт нь 108-ыг нь аваачаад 54, 54. 50, 50 хувийн мажоритар, пропорциональ болгоё гэхээр одоо ерөөсөө бүх санал унагаасан.

Тэгэхээр бид энэ Үндсэн хуулийг ийм тахир дутуу байдалтай баталж болохгүй. Энэ бол маш буруу жишиг юм. Тэгэхээр би гишүүдийг ингэж хүсэх юм байна. Энэ Үндсэн хуулийнхаа үндсэн зүйлийг ойлгож өгөөд хэдүүлээ цаашаа явах юм сан гэж.

Одоо яг тулганы гурван чулууны энэ асуудлын Ардчилсан намаас барьсан зарчмын байр суурь.

Нэгдүгээрт, хэрвээ бид нар сонгодог парламенттай, Улсын Их Хурал нь засаглалыг хэрэгжүүлэгч мөн байгаа юм бол нэгдүгээрт Ерөнхийлөгчөө парламентаасаа сонгоно.

Хоёрдугаарт, төр өөрийнхөө эдийн засгийн бодлогыг тодорхойлно.

Гуравдугаарт, сонгуулийн тогтолцоо нь багийн буюу бодлогын хэмжээний Их Хурал байхын тулд үнэхээр холимог тогтолцоо чухал гэдгийг л бид хүлээн зөвшөөрч чадахгүй юм бол өнөөдөр Үндсэн хуулийн энэ өөрчлөлт чинь ямар ч утгагүй боллоо.

Одоо ийм тунхгийн шинжтэй хэчнээн заалт энд орохыг бүү мэд. Зөндөө юмнууд байгаа. Тэглээ гээд маргааш амьдрал сайжрахгүй нь ойлгомжтой болж байгаа. Тийм учраас эрх баригчид энийгээ нэг эргэж нэг харах шаардлага үүсэх байх гэж бодож байна.

Тэгээд өнөөдөр яах вэ цорын ганц энэ заалт байгаа юм байна. Бид нарын оруулж ирж ингээд нэг юм зохицуулалт хийсэн. Энийг бол бид нар дэмжинэ. Дэмжинэ. Харин бусад бидний зарчмын байр суурьтай саналуудыг бол хүлээж

авахгүй бол бид нар одоо бас яах вэ гэдгээ шийдэхээс өөр гарцгүй болно шүү. Тийм учраас манай гишүүд энэ дээр маш онцгой анхаараарай. Одоо яах вэ ирцээ бүрдүүлээд л бүгдээрээ бүлгийнхээ шийдвэрийг дагаад л бие биеэ харж байгаад л кноп дарж л байна л даа. Тэгэхдээ энэ кноп бол дараа нь хэтэрхий үнэ цэнтэй тусах вий гэдгээс би их болгоомжилж байгаа. Ийм байдалтай бид нар өнөөдөр энэ Үндсэн хуулийн хандлагад, Үндсэн хуульдаа ингэж хандаж болохгүй.

Түрүүн би үг авах гээд ярьсан чинь гурвуулхнаа сууж байгаа байхгүй юу. Д.Лүндээжанцан дарга, Б.Баттөмөр гишүүн бид гурав. Д.Лүндээжанцан дарга над руу яриад энэ 76-гийн заал дотор над руу яриад, зориулаад яриад байгаа байхгүй юу. Д.Тэрбишдагва дарга байж байгаад гараад явсан. Би энэ зааланд ярьж байна.

Тэгэхээр Үндсэн хуульд ийм байдлаар бид нар хандаж болохгүй шүү дээ. Одоо зурагтаар гаръя гэвэл юуг ч ярьж болно. Өнөөдөр намайг одоо зурагтаар харуулж байгааг бид ойлгож байна. Тэгэхдээ асуудал нь зурагтаар гаргахдаа биш байхгүй юу даа. Асуудал нь бид нар далан зургуулаа эхлээд энэ Үндсэн хуулийнхаа мөн чанарыг ойлгохдоо байгаа юм. Энэ мөн чанарыг ойлгоогүйгээрээ бид нарт бүгдээрээ бие биеэ дагаж кноп дарах юм бол эцсийн хариуцах үр дүн ямар байх вэ гэдгээ бүгдээрээ хаа хаанаа зайлшгүй анхаарах ёстой шүү гэдгийг би анхааруулж хэлмээр байна. Баярлалаа. Би тэртээ тэргүй дууслаа, Х.Нямбаатар аа. Чи битгий санаа зов.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Октябрийн Баасанхүү. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж.

О.Баасанхүү: Уг нь та бүхэн хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой үг хэл гэхээсээ өмнө ерөнхийгөөс тодорхой, тодорхойгоос цаашаагаа одоо юу гэдэг юм дүгнэлт гээд явдаг учраас ерөнхий ярингуут нь хэлэлцэж байгаа асуудал биш байна гээд ингээд дарамтлан шахдагаа болих хэрэгтэй.

Мэдээж энэ хэлэлцэж байгаа асуудлаа ярихын тулд оршил ярихаас өөр арга байхгүй шүү дээ. Жишээлбэл, сая Ц.Даваасүрэн гишүүн хэлж байна л даа. Одоо энэ зарлага нэмэгдүүлэхгүй гэж болохгүй шүү дээ гээд. Тэгсэн манай Г.Занданшатар дарга юу гэж хэлж байгаа вэ гэвэл наадахыг чинь өөрчилсөн шүү дээ гээд. Хөндлөнгөөс харах юм бол Ц.Даваасүрэн гишүүн уншаагүй юм шиг. Бодитоор аваад үзэхээр хуульчид зөрчсөн учраас Ц.Даваасүрэн гишүүнийг эвгүй байдалд оруулж байгаа байхгүй юу. Хуулиараа ямар байгаа вэ гэхээр хоёр асуудлаа зэрэгцүүлээд хэлэлцэхдээ тус тусад нь үг хэлнэ гэж. Ц.Даваасүрэн гишүүн бол 10.1 дээр үг хэлсэн. Г.Занданшатар гишүүн бол 10.6 буюу тэр нөгөө ажлын хэсгийн санал дээр үг хэлсэн. Ингээд намайг хорлож байгаа юм шиг байдлаар энэ хэлэлцүүлгийг ёстой жонхуу болгож байна. Яаран сандран хэлэлцүүлээд байна.

Миний хэлээд байгаа хамгийн энгийн зарчим бол юу вэ гэх юм бол яагаад 400 гаруй иргэд энэ 1992 оны Үндсэн хуулийг баталсан бэ гэвэл 10, 10 минутаар суугаад олон сар ярилаа ч гэсэн ард түмэн ийшээ чинь анхаараад. Энэ асуудал нь ийм юм байна гэж утга утгаар нь тайлбарлаад ойлгож байсан. Одоо бол юу вэ гэх юм бол эд нар нөгөө ердийн хууль хэлэлцэж байна гэсэн байдлаар ямар ч сонирхолгүй, ямар ч анхааралгүй. Нөгөө талаасаа хуйвалдааны байдлаар явж байгааг чинь ойлгож байгаа.

Одоо наад зах нь энэ төсөл дээр л байна л даа. Одоо жишээлбэл анхны төслөөр бол зардлын шинэ төрөл үүсэхэд зарлага нэмэгдүүлэхгүй гэхээсээ гадна Засгийн газар зөвшөөрөх гэж үг байсан. Одоо дараагийн юм нь дээр нь ингээд нөгөө хоёуланг зэрэг ярих аягүй зовлонтой болчихоод байгаа байхгүй юу. Засгийн

газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, гүйцэтгэлийн тайланг батлах гээд. Нөгөө зөвшөөрөл алга болсон. Зөвшөөрөх гэдэг нь уг нь хоёр талтай л даа. Жишээлбэл манай гишүүд ингээд татварын хөнгөлөлтийн хууль санаачлаад гүйгээд байдаг. Одоо юу гэдэг юм НӨАТ-аас чөлөөлье. Компанийн лоббид ороод. Тэрний компанийн, энэний компанийн, эсвэл тийм юмыг өршөөе, ийм юмыг чөлөөлье гээд өчнөөн хэдэн зуугаар нь. Тэгснээ жирийн ардын нөгөө нэг зөрчлийн хуулийн. Тэр дундаа нөгөө нэг 50 мянган төгрөгийн торгуулийг бол тоохгүй. Хөөрхий тэгээд л өдөр болгон нөхрүүд нь замын торгууль, энэний зөрчил, тэрний зөрчил гээд бөөн дотацид байдаг. Энийг нь өршөөе, чөлөөлье гээд одоо хууль санаачилбал энэ хуулиар бол болохгүй юм байна л даа. Засгийн газар мөнгө төгрөгтэй холбоотой асуудлаар болохгүй гээд.

Ингээд Үндсэн хуулиар нэг талаасаа мөнгөний асуудал яриад байгаа юм шиг боловч Монголд өнөөдөр дарамт болж байгаа хоёр хууль байгаа шүү дээ. Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль. Зөрчлийн хууль гэдэг бол бүр ёстой зөрчилтэй хууль. Юм алхаад л ингээд байдаг. Тэгэхээр одоо миний энэ яриад байгаа нөгөө 10.1. Юугаар ярихаар. За Засгийн газрын одоо нөгөө төсөв, санхүүгийн юмандаа нөлөөлнө. Өөрчлөх гэж байна. Одоо энийг хасах юм бол орлого, зарлага оруулдаг юмыг одоо хасах гээд байна гэх мэт байдлаар энэ хуулийн чинь заалт бүтэхээ больчихож байгаа байхгүй юу. Хууль өргөн барих боломжгүй болж байгаа.

Ийм өнөөдөр юу гэдэг юм утгагүй юм орж ирж байгаа юм. Тэгээд одоо ерөөсөө нэг юмаа ерөөсөө тохирчихъё доо. Монгол Улс парламентын засагтай юм уу, Ерөнхийлөгчийн засагтай юм уу, Ерөнхий сайдын Засгийн газар бүхий, Ерөнхий сайд бүхий парламентыг гэдэг юм уу, юу гэдэг юм нэг тийм нэр томъёо олж Ерөнхий сайдын засагтай юм уу гэж. Ингээд тодорхой болгох юм бол засаглал нь өөрөө тодорхой болох юм бол одоо ингээд л тэрнийх нь эрх мэдлийг нь булааж авах гээд байна, энэний эрх мэдлийг авах гээд байна гэж хэрэггүй шүү дээ.

Тойрогт өнөөдөр юу гэдэг юм нэг сургууль, цэцэрлэг гээд. Ц.Даваасүрэн гишүүний хэлж байгааг би бас дэмжиж байгаа. Хүүхэд бүрийг хоёр ээлжээр байлгана. Хүүхэд бүр цэцэрлэгтэй байна гэсэн сугалаа энэ жил байж л байгаа. Тэгээд цэцэрлэгтэй болъё гээд тойргоос өчнөөн өргөдөл ирээд 76 хүн болгонд өргөдөл ирэхээр бүгд л одоо тэрний цэцэрлэгийг бариад өгөөч гэдэг болохоос. Бид төсөв дээр нь ажиллаж л юмаа хийнэ шүү дээ. Тэрнээс биш очоод ямар цэцэрлэг барих юм, хэзээ барих юм. Энэ чинь орон нутаг нь шийднэ шүү дээ. Ямар тендер нь шалгаруулах юм, ямар компани хийх юм хамаагүй шүү дээ.

Улсын Их Хурлын гишүүн ээ, та манай тойргийн зовлонг шийдсэн үү гэж асуухаар шийдсэн. Замыг чинь шийдсэн. Яагаад гэвэл төсвийг чинь батлуулсан. Цэцэрлэгийг чинь шийдсэн гээд. Бүгд л одоо 2020 онд тэгж л ярина шүү дээ. Зарим нь тэр юмнуудынхаа байшинг нь барьсан юм шиг нээлт дээр ордог биз дээ. Тэгээд одоо ингээд өөрсдийнхөө эрх мэдлийг хязгаарлая. Эрх мэдлээ одоо, эрх мэдэл гэдэг нь бол миний ойлгож байгаагаар Улсын Их Хурлын гишүүний эрхийн тухай яриад байгаа шүү дээ. Тэрнээс биш одоо юу гэдэг юм ажил хий гэдэг одоо тэр эрхийн тухай яриад байгаа юм.

Тэгэхээр энэ эрхээ ингээд хасъя, бооё гэсэн байдлаар яваад байдаг. Тэгээд би түрүүнээс хойш энэ Г.Занданшатар даргыг харахаар л өөрийн эрхгүй эр хүн шиг байгаач гэж хэлмээр санагдаад байх юм. Тус бүр дээр яримаар байна шүү дээ. Үгийг минь хасчхаад. Одоо өчигдрөөс хойш ингээд нэг төсөл дээр 5 минут ярих болчихоод байна. Дарга аа. Энийг одоо ингээд та нар 65-уулаа. Ардчилсан нам бол түрүүн хэлж байна шүү дээ. Бид нар холимог гэдгийг хэлэх байх. Ерөнхийлөгчийг сонгох байх. Тэгвэл бид орж байгаа. Бусад нь бол хамаагүй гээд байна шүү дээ.

Хамаагүй. Бусад нь. Тэр хоёр дээр л гол нь гээд байдаг. Надад бол бүх юм нь хамаатай байна. Монголын ард түмэн тэр бүх юмыг чинь хараад суугаад өнөө өглөөнөөс хойш над руу мессеж бичээд байна шүү дээ. Юу болов гишүүн ээ. Гарах уу, очих уу, уулзах уу. Үгийг чинь хаагаад байгаа юм уу, боогоод байгаа юм уу гээд. Яагаад хаагаад боогоод байна вэ гэхээр одоо төсөл дээр байгаа заалтыг яагаад оруулснаа яримаар байна. Ажлын хэсэг дээр та нар юу тохирсныг чинь одоо өөрийнхөө байдлаар асууж тайлбарлаж наадахаа дэмжинэ, дэмжихгүй гэж яримаар байна. Ингээд тус тусад нь санал хураалт явмаар байна. Бөөнд нь санал хураалт аваад, бөөнд нь ингэж явахаа болиоч ээ.

Би бол ийм байдлаар ингээд хэлэлцүүлээд, дургүйд хүчгүй гэдэг шиг дахиад л нөгөө нөхрүүдээ одоо та нар кнопдоорой гээд. Манайхан өнөөдөр мэдэж байгаа шүү дээ. Хоёр ажил хийнэ гэж л та нар ард түмнээс мандат авсан. Нэг нь Үндсэн хуулийг өөрчилнө. Нэг нь ард түмний амьдралыг сайжруулна. Хоёр дахь амьдрал будаа болсон. Хар тамхи, есөн шидийн юм дуулдаад эхэлсэн. Тэгэхээр одоо Үндсэн хууль өөрчилсөн гэдэг нэр зүүх гэж ингэж явахаа боль. Тийм учраас өнөөдрийн энэ одоо яг яриад байгаа наад төсөл. Ялангуяа төсөв, санхүүтэй холбоотой, тэр дундаа Засгийн газар, Улсын Их Хуралтай холбоотой энэ асуудлаар хэлэлцүүлгийг өргөн хиймээр байна. Өргөн гэдэг нь тус тусад нь үг хэлэх эрхийг өгөөч ээ. Эрхээ авмаар байна.

Г.Занданшатар: О.Баасанхүү гишүүн ээ. Таны үг хэлэх чинхүү хүсэл эрмэлзлийг ойлгож байна. Тэгэхдээ нэгдүгээрт юмаа уншчихмаар байна. Та сая 10 дугаар заалтаар түрүүн хоёрхон цагийн өмнө үг хэлээд гарсан. Завсарлаад орж ирээд 10.1-ийн заалт. Заалт тус бүрээр та үг хэлж байгаа. Одоо жаахан эрүүл ухаантай бодож наад үгнүүдээ хэлж байхгүй бол энэ буруу зөрүү ойлголт нийгэмд тараадгаа болимоор байна. Попорч болно. Тодорч болно. Тэгэхдээ энд үг болгоноор хамгийн их үг хэлж байгаа, тань шиг хэдэн цаг үг хэлж байгаа хүн байхгүй. Тийм учраас асуудалдаа хариуцлагатай ханд. Унш. Наад дээр чинь тийм заалт байхгүй. Ерөөсөө энэ хоёр заалтаа ялгаж уншаа ч үгүй байна шүү дээ та. Наадахаа уншаад сайн ярь гэдгийг сануулъя.

Эрхэм гишүүн Содномын Чинзориг үг хэлнэ.

С.Чинзориг: Энэ Байнгын хороо дэмжсэн энэ заалтыг дэмжээд явъя гэхээр бас нэг дотор нь хоёр гурван зүйл тодруулмаар. Дараагийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ бас жаахан ядаж найруулгын хувьд жаахан өөрчилж авч үзмээр асуудлууд байгаа юм.

Бид одоо олон жил ярьж байгаа. Энэ улс орон бас тогтвортой хөгжихгүй байна. Ард иргэдийн амьжиргаа сайжрахгүй байна гээд яриад байгаа. Энэ чинь ерөөсөө явж явж энэ хөгжлийн бодлого тодорхой бус, хөгжлийн бодлого тогтворгүй байгаатай холбоотой гэж боддог хүний нэг бий л дээ. Тийм учраас болдог бол энэ заалтыг Улсын Их Хурал улс орны хөгжлийн дунд болоод урт хугацааны хөгжлийн бодлогыг тодорхойлно. Энэ бодлого нь тогтвортой байна гэсэн нэг заалт болгоод. Хоёр дахь асуудал нь яг төсөв батлахтай холбоотой тэр зардал мөнгө хэтрүүлэхгүй гэсэн ийм нэг заалт болгоод ингээд аваад явчихвал бол одоо их болмоор байх юм. Энийг чинь ингээд хараад үзэхээр баахан төсөв батална гээд төсвийн зардлыг нэмэгдүүлж үл болно гэсэн атлаа дотор нь хөгжлийн бодлого төлөвлөлт тогтвортой байна гээд нөгөө тоон дотор үсэг цохиж явна гэдэг шиг ийм нэг ганцхан өгүүлбэр дунд нь орчхоод байгаа юм.

Болдог бол энэ заалтыг хоёр болгоод. Хөгжлийн бодлоготой холбоотой асуулт, төлөвлөлттэй холбоотой асуудал, хөгжлийн бодлого нь урт хугацаанд тогтвортой байна гэдэг асуудал нэг заалт болоод ингээд явчихмаар байх юм.

Хэрэв ийм одоо явах, хоёр заалт болох боломжгүй гэвэл ядаж тэр хөгжлийн бодлого, төлөвлөлт, тогтвортой байна гэсэн тэр өгүүлбэр дээш нь хамгийн эхэнд аваачаад. Тэгээд энэ улс орны хөгжлийн дунд, урт хугацааны хөгжлийн бодлогыг Их Хурал тодорхойлно. Тэр нь тогтвортой байна гэсэн асуудлыг оруулж өгмөөр байгаа юм. Нэг дэх асуудал.

Хоёр дахь асуудал. Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх чинь төсөв батлах асуудал. Тэгэхээр одоо бид нар энэ Байнгын хорооны саналыг дэмжье гэхээр гишүүдийн өргөн барьсан төслөөс би бол дордуулсан байна гэж л бодох гээд байгаа юм л даа. Гишүүдийн өргөн барьсан төсөл дотор чинь төсвийн зарлагатай холбоотой асуудлыг нэмэгдүүлэхгүй. Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр одоо нэмэгдүүлэхгүй гэсэн ийм заалт байсан. Одоо бол ерөөсөө нэмэгдүүлж үл болно гээд ингээд ороод ирчихээр чинь төсвийн онцгой эрх, Их Хуралд олгогдсон онцгой эрх маань одоо алдагдах юм уу. Засгийн газар чинь бол тодорхой хэмжээгээр эх үүсвэрээ шахаж орлого олох ийм үндсэн үүрэгтэй. Орлого дээр нь одоо шахалт үзүүлж байгаа юм байхгүй. Тэгээд ерөөсөө байгаа мөнгө нь ингээд одоо төсөв оруулаад ирэх юм бол Их Хурал зарлага болоод алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно гээд ингээд заахаар чинь төсвийн бодлого бол тодорхойлоход бол үнэхээр хэцүү болно. Нөгөө тахиа анхдагч уу, өндөг анхдагч уу гэдэг шиг хөгжлийн бодлого анхдагч байх юм уу, төсөв анхдагч байх юм уу гэдгээ бас бид одоо бас ярих ёстой болов уу гэсэн ийм бодолтой байна.

Тийм учраас энэ заалтыг ингээд энэ Байнгын хорооны дэмжсэн төслийг дэмжээд явна гэвэл дараа нь цаашдаа С.Бямбацогт дарга аа. Тэр хөгжлийн бодлоготой холбоотой асуудлыг тусад нь заалт болгоод явах боломж байна уу? Хэрвээ боломжгүй бол ядаж найруулгаар хөгжлийн бодлогыг нь Их Хурал тодорхойлно. Хөгжлийн бодлого нь урт хугацаанд тогтвортой байна гэдэг юмыг бас нэг оруулж өгөөд. Тэр Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр зардал нэмэгдүүлэхгүй гэдгийг одоо бас найруулгаар авч болохгүй юу.

Засгийн газар тодорхой хэмжээгээр орлого нэмэгдүүлэхгүй, дайчлахгүй, шахахгүй. Байгаа мөнгө нь энэ, боломж нь энэ гээд ингээд оруулаад ирэх юм бол бид чинь одоо тэгээд ёс төдий л ёсчлоод явдаг ийм боломжтой болох. Ерөөсөө зарлагыг нэмэгдүүлж үл болно гэж томъёолох юм уу, эсвэл тодорхой хэмжээгээр хязгаар тогтоох юм уу? Их Хуралд оруулж ирсэн төсвийн зарлагаа тэдэн хувиас дээш хэмжээгээр нэмэгдүүлж болно гэж хязгаар тогтоох юм уу? Их Хурлаас баталсан төсвийн хүрээний мэдэгдлээс хэтрүүлж одоо бас төсөв батлахыг хориглоно ч гэдэг юм уу. Ийм нэг тодорхой нэг заалт бас уян хатан. Төсөв батлах онцгой эрхээ Их Хурал эдлэх энэ боломжийг нь бүрдүүлж өгсөн асуудлыг найруулгаар авахгүй бол ерөөсөө зардал нэмэгдүүлж үл болно гээд оруулчихаар чинь энэ чинь хөгжлийн бодлоготой холбоотой төсвөө уялдуулах асуудал хүндрээд. Цаашдаа энэ төсвийн батлах Улсын Их Хурлын онцгой эрхийг хэрэгжүүлэх энэ боломж нь хязгаарлагдах юм болов уу гэсэн ийм бодол байгаа юм.

Тэгэхээр энийг одоо цаашдаа гурав дахь. Энэ заалтаа дэмжигдсэн нөхцөлд ч гэсэн тэр хөгжлийн бодлоготой холбоотой асуудлыг нь жаахан ялгаж өгөөд. Зардал нэмэгдүүлэхдээ бас тодорхой хэмжээний хязгаартайгаар нэмэгдүүлэх тэр боломжийг нь Их Хуралд одоо нээсэн ийм байдлаар найруулга хийгээд аваад явбал одоо энийг дэмжих боломжтой гэсэн ийм байр сууриа илэрхийлж байна.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Хавдислам Баделхан гишүүн үг хэлнэ.

Х.Баделхан: Баярлалаа. Энэ бол их чухал заалт ороод ирсэн байна л даа. Энэ урьд өмнө нь бол Засгийн газраас өргөн барьсан улсын төсөв. Тэр дотроо

хөрөнгө оруулалтыг бол Их Хурлаар хэлэлцэх явцдаа ер нь нэмэгдүүлж байсан. Эндээс болоод тэр баталсан төсөв нь амьдрал дээр хэрэгжихгүй дутагдал маш их байгаа. Тухайлбал, Барилгын тухай хуулиар бол зураг төсөв нь бэлэн, газар нь бэлэн барилга бол улсын төсөвт орох ёстой. Бэлэн биш байвал улсын төсөвт оруулахыг хориглоно гэсэн заалттай.

Гэтэл өнөөдөр бол энэ заалт зөрчигдөж байгаа. Энд ороод ирсний дараа гишүүдийн саналаар бас амьдралын шаардлагын дагуу янз бүрийн хөрөнгө оруулалтын асуудал орж байгаа л даа. Гэхдээ ч ямар ч зураг төсөвгүй, батлагдаагүй газар олголт байхгүй учраас тэр дараа нь батлагдлаа ч гэсэн хэрэгжихгүй. Яг өнөөдрийн байдлаар бол амьдрал тийм байгаа.

Одоо зарим нэг сургуулиуд бол улсын төлөвлөгөөнд орсон боловч газрын асуудал шийдэгдээгүйгээс болоод одоог хүртэл баригдахгүй байгаа. Зарим зураг төсөв нь бэлэн бус учраас тендер зарлагдахгүй тэр жилдээ ингээд дуусаж байгаа юм л даа. Тийм учраас энэ асуудал дээр онцгой анхаарах нь зүйтэй.

Энэ дотроо батлагдсан төсөв. Засгийн газрын өргөн барьсан төсөв дотроо орлого зарлагаа өөрчилж болно гэсэн саналыг бол дэмжиж байгаа. Энэ бол маш зүйтэй. Ерөнхий дүнг нь бол нэмж болохгүйгээс нь санал зөв. Гэхдээ энийг бол бас хатуу биш. Энийг бол Засгийн газрын зөвшөөрөлтэйгөөр дахиад нэмж болно, хасаж болно. Би ч бас жаахан уян хатан оруулмаар байна. Энэ бас их чухал заалт учраас энэ заалтыг дэмжиж байна.

Сая одоо зарим гишүүдийн хэлснээр энэ өгүүлбэр дотроо тэр хөгжлийн бодлого тогтвортой байна гэсэн нэг өгүүлбэр ороод ирсэн байна. Ямар ч авцалдаагүй, холбоогүй. Тэгээд хөгжлийн бодлого нь нэг тусдаа. Тэр улсын төсөвтэй орлого, зарлагатай холбоотой заалтыг нь нэг тусдаа оруулаасай гэсэн ийм санал байна. Баярлалаа.

Г.Занданшатар: За баярлалаа. Я.Содбаатар гишүүн. Эрхэм гишүүн Янгугийн Содбаатар.

Я.Содбаатар: Тэгэхээр энэ заалт бас нэлээн чухал заалт байгаа. Олон жил бас парламентын түвшинд ч, судлаачдын түвшинд ч гэсэн нэлээн ярьж байсан. Хэд хэдэн чухал чухал зүйл энэ дотор явж байгаа. Нэг том юм бол энэ хөгжлийн бодлоготой холбоотой асуудал. Үе үеийн сонгуульд ялж байгаа улс төрийн нам, хүчнүүд аюулгүй байдал, хөгжлийн бодлоготой уялдуулсан Засгийн газрын бодлогоо явуулдаг энэ асуудлыг хөндөж энд оруулж ирж байгаа. Үндсэн хуулийн түвшинд энэ орно гэдэг бол өөрөө бас их чухал гэж харж байна.

Ер нь тэгээд юу яахаар л 10 жилийн, 20 жилийн бодлого гараад ирдэг. Тэр бодлого нь хэрэгждэггүй цаас болж үлдээд байдаг гэдэг ийм хандлага, ийм зүйл байдаг. Тийм учраас энийг бол хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр гэдэг томъёоллоор орж байгаа. Тэр утгаараа энэ заалтыг дэмжиж байгаа юм. Мэдээж одоо энэ хэлэлцүүлгийн явцад гишүүд бас янз янзын санал онолууд энэ дээр нэлээн гаргаж хамгийн их тойрч ярьсан, хамгийн олон санал гарч байсан ийм санал байгаа юм. Тэгэхээр энийг дэмжээд яваач ээ гэж.

Хоёрт, Үндсэн хуулийн хэлэлцүүлгийн явцыг харахад бас амаргүй байх шиг байна. 57 заалт дэмждэг. 57 гишүүн дэмжиж байж босдог. Яг энэ хоёрдугаар хэлэлцүүлэг дээр бол асуудал болгон дээр хоёроос гурван заалт орж ирж байгаа. Эндээс бусад төрийн институтууд, бусад улс төрийн хүчнүүд, иргэд, хэлэлцүүлгүүдийн дунд гарсан зүйлээр бид нар ажлын хэсгийн санал гэж босгож

ирж. Энэ ажлын хэсгийн саналынхаа хүрээнд бас асуудлаа авч ингэж ярилцаж байгаа учраас бас манай иргэд бол зарим асуудал нь унаад байх шиг санагдах ийм зүйл биш ээ гэдгийг бас тодотгож хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Гуравт, энэ улсын төсвийг хэлэлцэхтэй холбоотой, Засгийн газрын зөвшөөрөлгүй зардлын шинэ төрөл үүсэхгүй, зарлага нэмэгдүүлэхгүй гэсэн заалт бол яг парламентын гишүүдийн бүрэн эрхэд халдаад байгаа зүйл бол биш байгаа гэж бодож байгаа. Эхний томьёолол бол яг шууд тэгж халдаж байна гэж байсныг нь сая бас зөөлчлөөд Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно гэсэн нийт дүнгээр нь авч өгч ингэж оруулж байгаа. Тэгээд энэ бол өөрөө бас нэлээн нарийвчилж явахгүй бол яг төсөв хэлэлцэх хүрээнд бид нарын бас алдагдлыг нэмэгдүүлчихдэг. Ялангуяа сонгуулийн урд жил бол ийм улс төрчдийн нөлөөлөл, улс төрийн намуудын нөлөөллийн юугаар улсын төсвөө бид нар эвдээд хаячихдаг. Эргээд төсвийн алдагдлаа огцом нэмэгдүүлдэг. Зураг төсөлгүй олон юмнууд орж ирдэг. Энэ нь эргээд ажил хэрэг болдоггүй ийм байдал анзаарагддаг.

Тийм учраас энэ зүйлүүдийг ч гэсэн энд оруулж хөгжлийн бодлоготой холбоотой, улсын төсөвтэй холбоотой, төсөв санхүүгийн хяналтыг сайжруулахтай холбоотой ийм заалтууд байгаа. Тэгээд иргэдтэй уулзаж байхад бол бас яг одоо бид нарын амьдралд хэрэгцээтэй, яг улс орны эдийн засгийн талаасаа юм орохгүй байна гэдэг ийм шүүмжлэл бас нэлээн байсан. Энэ заалт бол тэрэнд бас нэлээн хариулт өгч байгаа ийм заалт.

Мэдээж Үндсэн хууль учраас төрийн байгууламжтай холбоотой, төрийн эрх мэдлийн хуваарилалттай холбоотой зүйлүүд нь бол илүү яригддаг. Аль ч орны Үндсэн хуульд. Тэгэхдээ Үндсэн хуулийн эдийн засаг гэж байдаг. Үндсэн хуулийн эдийн засгийн тэр агуулгатайгаа нэг гол орж ирж байгаа заалт учраас манай гишүүд энийг бас дэмжээсэй гэж хүсэж байгаагаа бас хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Сандагийн Бямбацогт үг хэлнэ.

С.Бямбацогт: Энэ хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал Улсын Их Хурлын 62 гишүүний төсөл, ажлын хэсэг дээр бас нэлээн сайн яригдаад аль аль дээр нь орж ирсэн асуудал.

Тэгээд 1992 онд Үндсэн хууль баталж байх үед тухайн үеийн бас нийгмийн уур амьсгал, мөн нөгөө төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээлд шилжих, нэг намын тогтолцооноос олон намын тогтолцоонд шилжих гээд одоо ийм уур амьсгалын үед болж байсан. Тэр үедээ бид нар үндсэндээ зах зээл бүгдийг зохицуулна. Одоо үнэ нөгөө эрэлт нийлүүлэлт дээр тогтоно. Ерөөсөө л үл үзэгдэгч гар бүгдийг зохицуулдаг болно. Тийм болохоор эдийн засгийн харилцаанд нэг их айхтар оролцоод яах вэ гэдэг агуулгаар. Тийм уур амьсгалаар бас энэ Үндсэн хуульдаа эдийн засгийн бодлогын асуудлыг, хөгжлийн бодлогын асуудлыг бас нэг сайн томьёолж төлөвлөж бас оруулж чадаагүй юм болов уу гэж бас ярьдаг. Энэ үүднээсээ 62 гишүүн энэ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг Үндсэн хуульдаа тусгаж өгье. Урт хугацааны бодлого нь дунд хугацаатайгаа уялдаатай. Дунд хугацаанд богино хугацааныхаа бодлоготой уялдаатай байх энэ асуудлыг бас тусгая гэдгээ агуулгаар яригдсан. Маш олон гишүүд одоо санал гаргасан. 62 гишүүний төсөлд ч бас энэ орсон.

Өөрөөр хэлэх юм бол 1992 оны Үндсэн хуульд ерөөсөө Улсын Их Хурлын бүрэн эрх нь төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэлийг тодорхойлох, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах гэсэн ийм бүрэн

эрхтэй байсан. Энэ нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр гэдэг маань үндсэндээ 4 жилийн хугацаатай дунд хугацааны бодлого. Үндсэн чиглэл, улсын төсөв маань бол жилийн хугацаатай батлагддаг богино хугацааны бодлого.

Гэтэл одоо үйлчилж байгаа хуульд маань урт хугацааны бодлогын асуудал байдаггүй. Тийм учраас нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого гэдэг байдлаар одоо урт хугацааныхаа бодлогыг тодорхойлж ирж байгаа. Одоо урт хугацаа гэсэн үг одоо орсонгүй гэж манай гишүүд бас ярьж байгаа. Энэ нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого гэдэг маань өөрөө урт хугацааг одоо илэрхийлж байгаа. Ийм агуулгаар оруулж ирсэн. Тэгээд энэ урт хугацааны бодлого, төлөвлөлт нь тогтвортой байна гэдэг маань урт хугацааны бодлого нь дунд хугацаатайгаа, дунд хугацааны бодлого нь богино хугацаатайгаа харилцан уялдаатай байх. Мөн одоо бас бүс нутаг, орон нутаг, төв, салбар, салбар хоорондын бодлого нь уялдаатай байх асуудлыг энэ “хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна” гэсэн үгний цаана бас бид ойлгож авч явах нь зөв байх. Ийм байдлаар томъёолж өгч байгаа.

Хөгжлийн бодлого, урт хугацааны бодлого байсан уу, байгаагүй юу. Одоо төрийн хар хайрцгийн бодлого байсан уу, байгаагүй юу гэж бас ярьдаг. Уг нь бол байсан. 1996 онд одоо Ерөнхий сайд П.Жасрай гуайн үед Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал гэдэг зүйлийг бас баталж байсан. Түүнийг нь 1998 онд М.Энхсайханы Засгийн газрын үед Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал болгоод өөрчилж байсан. Дараад нь 2006 онд одоо Миеэгомбын Энхболд гишүүнийг одоо бас Ерөнхий сайд байх үед бас Мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогыг бид баталж байсан. 2016 онд Улсын Их Хурлаар бид нар бас тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ыг баталсан. 2030-ыг.

Ингээд урт хугацааны бодлогоо тодорхойлдог боловч бодлого маань хамгийн гол нь үе үеийн Засгийн газар, Улсын Их Хурал нь түүнийг өөрчилдөг. Түүнийгээ баримталдаггүй ийм асуудалтай байгаад байгаа юм. Тийм болохоор бид нар энэ хөгжлийн бодлого, төлөвлөлт нь тогтвортой байна гэсэн үг оруулж ирээд үүндээ нийцүүлж органик хууль буюу Үндсэн хуульчилсан хуулийг батлах ёстой. Одоо бас батлагдсан хууль байгаа. Энэ бас учир дутагдалтай байгаа. Өөрөөр хэлэх юм бол Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг бид нар бас батлаад энэ урт, дунд, богино хугацааны бодлого, салбар, салбар хоорондын бодлого, бүс нутгийн бодлого, төвийн бодлого, орон нутгийн бодлого гэдгээ үүндээ нийцүүлж яг энэ хуульчилсны дагуу бас хэрэгжүүлдэг байх ёстой болж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол нэг Засгийн газар гарч ирэхээрээ өөрийн бодлого явуулна. Нэг нам ялахаараа өмнөх намын явуулж байсан бодлого, үйл ажиллагаа бидэнд хамаагүй гэдэг байдлыг л зогсоёе. Аль үед одоо төрийн бодлого залгамж чанартай. Урт, дунд, богино хугацаандаа уялдаатай байх гэдэг асуудлыг Үндсэн хуульдаа томъёолж өгснөөрөө цаашдаа одоо юу гэдэг юм Монгол Улсын төрийн хар хайрцгийн бодлого, энэ урт хугацааны бодлого гэдэг маань бас тогтвортой байх. Тогтвортой байснаар бодлого маань бас амжилттай хэрэгжээд үр дүнгээ өгдөг ийм бололцоо боломжийг бүрдүүлэх гэдэг үүднээс энэ асуудлыг бас оруулж ирсэн байгаа.

Энэ дээр тэгээд төсвийн хүрээний мэдэгдэл одоо Их Хурлын бүрэн эрхэд байгаад байгаа. Бодлогын асуудал маань. Бодлогоо бид нар батална. Бодлогыг хэрэгжүүлэх нь Засгийн газрын ажил. Хэрэгжилтэд хяналт тавих нь Улсын Их Хурлын ажил. Тийм болохоор бид нар Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийнхөө бодлогоороо Засгийн газрынхаа үйл ажиллагааны хөтөлбөрөөрөө, урт хугацааны хөгжлийн бодлогоороо үндсэндээ Засгийн газрын хийх, хэрэгжүүлэх ажлын үндсэн чиглэлийг тодорхойлж өгнө. Үүнийг л хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар үйл

ажиллагаа явуулах ёстой. Үүндээ тааруулж Засгийн газрынхаа үйл ажиллагааны хөтөлбөрийг дунд хугацаандаа. Богино хугацаандаа улсын төсвөө батлах ёстой.

Тийм болохоор одоо төсвийн зарлагыг нэмэгдүүлж үл болно гэдэг асуудал маань үндсэндээ Засгийн газар хэт эрх мэдэлтэй болчихоод байна гэж шүүмжилж байгаа.

Бид нар хавар нь төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг Улсын Их Хурал баталж өгдөг. Тэр хүрээндээ намар нь Улсын Их Хуралд Засгийн газар төсвөө өргөн барьдаг. Төсвийг нь бид нар баталдаг. Ийм болохоор бид нар үндсэндээ энэ хүрээ хязгаар дотор, энэ урт, дунд хугацааны бодлогын бичиг баримтыг баримталж, үүнийг хэрэгжүүлэхийн тулд төсвөө өргөн мэдүүлээрэй. Өргөн мэдүүлсэн төсвийг нь харин Их Хурал батлахдаа зарлага нэмэгдүүлэхгүй байх ёстой шүү гэж томъёолж өгсөн.

Ардчилсан намын саналаар бас төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно гэж орж ирж байгаа. Өөрөөр хэлэх юм бол бас тодорхой, Их Хурлын тодорхойлсон бодлого маань хэрэгжих бололцоо боломж бүрдээгүй байна гэж үзэх юм бол орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Гэхдээ хөнгөлийнхөө хэрээр хөлөө жийдэг байя. Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх тал дээр бас анхаарах ёстой шүү гэсэн томъёоллыг оруулж өгсөн юм. Ийм байдлаар одоо асуудлыг бид нар бас харах ёстой байх. Энэ дээр юу гэдэг юм бас Ардчилсан намын нөхрүүд маань ярьж байгаа. Татварын асуудлыг энд оруулж ирэх ёстой. Энэ одоо бас хөндөгдөөгүй асуудлыг хөндөөч ээ гэсэн саналыг бас тавьж байсан. Харамсалтай нь одоо хөндөгдөөгүй болохоор бид бас хөндөх бололцоо байхгүй. Тэртээ тэргүй Улсын Их Хурал татвар тогтоох онцгой бүрэн эрхээ хадгалж байгаа. Энэ нь одоо бас өөрчлөгдөөгүй байгаа. Тийм болохоор бид нар татвар хураамжийг Улсын Их Хурал тогтооно гэж нэмж оруулах шаардлагагүй. Татвар, хураамж, төлбөр гэсэн гурван хэлбэрээс татвар маань бүрддэг учраас үүнийг бас хөндөөгүй учраас цаашдаа хөндөх шаардлагагүй гэж үзсэн.

Ингээд Их Хурлын гишүүдийн гаргасан тэр урт хугацааны, дунд хугацааны гэж оруулах ёстой үгүүд бол тодорхой хэмжээгээр хөгжлийн бодлого, нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого гэдгийн цаад талд бол урт, дунд хугацаа агуулагдаж байгаа гэж та бүхэн бас ойлгоорой. Хөгжлийн бодлого, төлөвлөлт маань тогтвортой байна гэдэг үгний цаад бол мэдээж одоо энэ тогтвортой байлгахын тулд үүнийг хэрэгжүүлдэг, хяналт тавьдаг бас тодорхой бүтэц бий болно. Үүнийг заавал одоо байгууллагыг заавал Үндсэн хуульдаа ингэж тусгаж оруулаад яах вэ гэдэг агуулгаар Д.Тэрбишдагва гишүүн үдээс өмнө асууж байсан. Тийм болохоор ийм байдлаар хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэдэг үгийн цаад талд үүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих ийм бүтэц байна. Энэ нь одоо юу гэдэг юм Шадар сайдын мэдэлд байх юм уу, одоо бусад улс орнуудын жишиг, туршлагыг харж байгаад бид нар цаашдаа бас тодорхой болгоод явах ёстой байхаа гэж бодож байгаа.

Энэ дээр бас дахиад нэг орж ирж байгаа асуудал бол төрийн санхүү, төсвийн хяналтыг одоо хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг энэ хуулиар тогтооно гэж бас орж ирж байгаа. Энэ бол үндсэндээ аудит гэж ойлгох хэрэгтэй байх. Улсын Их Хурлын харьяа байгууллага Үндэсний аудитын газар ажилладаг. Үндсэндээ энэ байгууллага бол энэ төрийн санхүү, төсвийн хяналтыг бол бас гүйцэтгэх ёстой гэдгийг Үндсэн хуульдаа бас тодорхой томъёолж бас оруулж өгч байгаа. Тийм болохоор гишүүдийн хэлж байгаа саналууд ерөнхийдөө бол ажлын хэсэг болон Төрийн

байгуулалтын байнгын хороо дэмжигдсэн саналд агуулгаараа туссан. Энэ дотроос Монгол Улсын Ерөнхийлөгчийн гаргасан санал ч бас орсон байгаа.

Хөгжлийн болон Үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах гэдэг байдлаар орж ирсэн байгаа. Өөрөөр хэлэх юм бол ажлын хэсэг маань ажиллахдаа аль болох гишүүдийн гаргасан саналуудыг, мөн одоо бас Ерөнхийлөгчийн гаргасан санал, мөн 62 гишүүний өргөсөн, өргөн мэдүүлсэн төслийг одоо бас харилцан хооронд нь уялдуулах, гол агуулгыг нь авч үлдэх байдлаар үндсэндээ одоо Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн нэг орхигдож байгаа асуудал гэж одоо Ардчилсан намын гаргаж байгаа энэ эдийн засгийн асуудалдаа бид анхаарах ёстой гэдэг бол энэ зүйл, заалтад нэлээд тодорхой томъёологдож өгсөн байгаа. Энэ заалтыг одоо бас гишүүд маань нэлээн анхааралтай бас уншиж үзээсэй гэж хүсэж байна.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Цэндийн Мөнх-Оргил үг хэлнэ.

Ц.Мөнх-Оргил: За баярлалаа. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг өргөн барьсан 62 гишүүний тоонд би бол ороогүй байгаа юм. Яагаад ороогүй юм бэ гэхээр энэ дотор Үндсэн хуульд заавал тусгалаа олоод байх шаардлагагүй, органик болон бусад хуулиар зохицуулагдах ёстой. Нэг талаас. Нөгөө талаас улс төрийн соёлоороо, хариуцлагаараа зүгээр өөрийнхөө төрийн тогтвортой бодлогоороо, ёс зүйгээрээ шийдэгдээд явах ёстой олон асуудлыг бид нар Үндсэн хуульчилж байж заавал хэрэгжүүлэх ёстой мэтээр ойлгож тулгаж оруулаад байгаа зүйл их байгаа юм.

Гэхдээ энэ гишүүдийн өргөн барьсан санал дотор миний одоо ололттой гэж үзэж байгаа Үндсэн хуульд заавал тусгагдах ёстой гэж бодож байгаа заалт бол энэ 25.1 дэх хэсгийн 7 дахь заалтад нэмж оруулж байгаа Улсын Их Хурал, Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр төсвийн зарлага нэмэгдүүлдэггүй байх тухай Үндсэн хуулийн заалт байгаа юм. Энийг бол нэг талаас цагаа олсон. Бид нарын одоо туулж өнгөрүүлсэн 30 жилийн туршлагаас харахад заавал Үндсэн хуульчилж, Үндсэн хуулиар үүрэгдүүлэх ёстой заалт мөн юм байна гэж ойлгоно. Нэг талаас. Нөгөө талаас энэ онолоороо ч гэсэн ийм байх ёстой. Бусад орны туршлага ч гэсэн ийм байгаа.

Өргөн барьсан төслийг ажлын хэсэг яг энэ хэсэг дээр нь би бас сайжруулчхаж гэж бодоод байгаа юм. Өргөн барихдаа юу гэж өргөн барьсан бэ гэхээр Засгийн газрын зөвшөөрөлгүй зардлын шинэ төрөл үүсгэж зарлага нэмэгдүүлэхгүй гэсэн байгаа. Өөрөөр хэлбэл Засгийн газар нь зөвшөөрчихвөл зардлын шинэ төрөл нэмээд байдаг, зарлагаа нэмэгдүүлээд байж болохоор заалт оруулаад ирсэн байгаа байхгүй юу. Бодит амьдрал дээр энэ заалт хэрэгжихээр юу болох вэ гэвэл Улсын Их Хурал, Засгийн газрыгаа шантажилж байгаад, Ерөнхий сайдыгаа шантажилж байгаад дуртай цагтаа өнөөдөр бид нар зарлага нэмдэг шиг зарлагыг нь нэмэгдүүлээд явчих аюул байсан юм.

Харин ажлын хэсэг сайн ажиллаад. Миний ойлгож байгаагаар бол зардлын шинэ төрөл үүсгэж зарлага нэмэгдүүлэхгүй гэдэг заалтаа оруулаад харин төрийн санхүү. Тэрийгээ хасаад харин ийм заалт оруулаад ирчхэж байгаа юм. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно. Харин төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно гээд. Өөрөөр хэлбэл өргөн барьсан хэмжээ дотор нь, зарлагын хэмжээ дотор нь бүтцийг нь өөрчилж болно.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүд яах вэ гэвэл би 2 сургууль нэмж бариулмаар байна гэдэг асуудал оруулаад ирэх юм бол тэрэндээ таарсан зарлага өөр газраас хэмнэж байж тэр хэмнэсэн мөнгөөрөө энэ талдаа зарлага үүсгэх ёстой болж байгаа байхгүй юу. Энэ бол би зөв гэж бодож байгаа юм. Тэгэхгүй бол бид нарын энэ сүүлийн 27 жил төсөв баталж ирсэн практик маш ойлгомжтой шүү дээ. Засгийн газар хуруу хумсаа хугалан байж за энэ жилийн орлого бол яг бодитоор тооцохоор дараа жилийн орлого бодитоор тооцоход тэдэн төгрөг байх юм байна гээд оруулаад ирдэг. Гишүүд нь барьж аваад л чи ерөөсөө орлогоо дутуу тооцсон байна нөхөр. Зэсийн үнэ чинь юун 5800. Наадах чинь 8500 хүрэх гээд. 9000 хүрэх гээд байна. Цаана чинь The Wall Street Journal дээр тэгээд биччихсэн байна гэж байгаад л зэсийнхээ үнийг хоёр дахин нугалж өгөөд л, баахан хоосон орлого нэмэгдүүлж өгөөд, тэрэндээ таарсан зарлага хийж өгөөд, тэгээд тэрэндээ таарсан амлалтуудаа тойрог дээрээ аваачиж өгөөд. Бодит амьдрал дээр нөгөө орлого нь байхгүй болчихдог. Орлого нь байхгүй болчихоор амласан юм нь биелдэггүй. Ингээд Засгийн газраа буруутгаад яваад байдаг ийм буруу практик байгаа юм.

Тийм учраас энэ нэг талаас Улсын Их Хурлын эрхийг хязгаарлаж байгаа юм шиг мөртөө нөгөө талаас энэ Үндсэн хуульд бид нарын одоо гарч хүрч байгаа үндсэн санаа чинь бол тэр шүү дээ. Энэ засаглалын тэнцвэртэй байдлыг нь хадгалъя. Бие биедээ хараат байдлыг нь, одоо хяналт тавьдаг байдлыг нь нэмэгдүүлж л гэж байгаа бол Улсын Их Хурал энэ эрхээсээ, зарлага нэмдэг эрхээсээ татгалзаад бүтцэд нь өөрчлөлт хийдэг эрхээ авч үлдэх нь чухал гэж би харж байгаа юм. Тийм учраас энийг Улсын Их Хурлын гишүүд дэмжих байх. Энэ манай Үндсэн хуульд оруулж байгаа одоогийн бид нарын оруулах гэж байгаа өөрчлөлт дотор жинхэнээсээ гялтайж үлдэж байгаа, олон жил энэ улсын төсвийг нэг сахилгатай, хариуцлагатай, Засгийн газар нь нэг орлого, зарлага мэддэг, олон жилийн дунджаараа харж байгаад баталдаг. Улсын Их Хурлын гишүүд нь олсон хэдэн төгрөгийг нь тойрог тойрог руугаа хуваагаад чирээд аваад явчихдаггүй ийм боломжийг бүрдүүлж байгаа юм.

Тэгтэл энэ заалт дотор бас ийм хэд хэдэн зүйл нэмж оруулж ирээд ёстой нөгөө гуяа дагаж хүзүү гэдэг шиг байдлыг энэ Үндсэн хуулийн заалтыг дордуулсан юмнууд оруулаад ирж байна гэж би харж байна. Жишээ нь, Үндсэн хуульд бол маш ойлгомжтой тодорхой заачхаад байгаа байхгүй юу. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг Улсын Их Хурал батална гээд л ерөөсөө одоогийн Үндсэн хууль дээр маш тодорхой. Засгийн газрын хөтөлбөрийг батална. Өөр үг байхгүй.

Тэгтэл ажлын хэсэг юу гэж нэмээд оруулаад ирж байна вэ гэхээр “Хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” гээд тодотгол оруулаад ирж байгаа юм.

Мэдээж Засгийн газрын хөтөлбөр чинь тэр хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлоготой нийцэж л орж ирнэ шүү дээ. Тэрэндээ нийцээгүй байх юм бол Улсын Их Хурал энэ дээр нь хүлээж аваад хэлэлцээд энэ чинь болохгүй байна гэж хэлээд хөтөлбөрийг нь батална. Одоо Үндсэн хуулиараа Засгийн газрын Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулах ёстой хөтөлбөрт ийм тодотгол оруулаад ирэхээр ямар аюул үүсэх вэ гэхээр Засгийн газрын өргөн барьж Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулах гэж байгаа хөтөлбөр чинь хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцээгүй байна. Үндсэн хуулиар үүрэгжүүлсэн үүргээ Засгийн газар биелүүлээгүй байна гээд л маргаан үүснэ. Их Хурал дээр ч үүснэ. Цэц дээр ч үүснэ. Иргэд Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргана. Тэрийг цэц хэлэлцэнэ. Яагаад гэвэл энэ чинь Үндсэн хуулийн заалт байхгүй юу.

Тэгэхээр энэ хэрэггүй тодотголууд эргээд бид нарыг толгой орооно. Гуравдугаар хэлэлцүүлэг дээр жишээ нь энэнээс бол би татгалзах ёстой гэж бодоод байгаа юм. Улсын Их Хурал Засгийн газрынхаа үйл ажиллагааны хөтөлбөрийг л баталъя л даа. Тэрийгээ заавал Үндсэн хуулиар ингэж тодотгож байх шаардлагагүй.

Дараа нь нэг ийм заалт оруулаад ирж байгаа юм. Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэж. Тогтвортой л байх ёстой шүү дээ. Бид нар чинь олон хөтөлбөр баталсан. Яагаад тогтворгүй байгаад байгаа юм. Үндсэн хуульд ийм заалт байхгүйгээс болоод бид нарын бодлого тогтворгүй байгаад байгаа юм уу. Үгүй байхгүй юу. Энэ төр, засгийн эрхэнд байгаа улс төрчдөөс, Улсын Их Хурлын гишүүдээсээ, Засгийн газраасаа, хувь хүмүүсээсээ, хувь улс төрчдөөсөө шалтгаалаад энэ бодлого, төлөвлөлт чинь тогтворгүй байгаад байгаа байхгүй юу.

Энэ Засгийн газар олон солигдож байгаагаасаа болоод бодлого, төлөвлөлт тогтворгүй байгаад байгаа байхгүй юу. Тэрнээс биш Үндсэн хуульд ийм үг үсэг байсан бол бодлого тогтвортой байх юм шиг. Одоо ийм өгүүлбэр оруулчихаар бодлого тогтвортой болох юм шиг бид нар ярьж болохгүй шүү дээ. Үндсэн хуулийн үг, үсэг болгоны чинь цаана дагаад маш олон хууль тогтоомж гарна, тушаал, заавар гарна. Бүгд эрх зүйн хэм хэмжээ болж хувирна.

Өнөөдөр Үндсэн хуулиас эх аваагүй Монголд нэг ч хууль байхгүй, нэг ч тогтоол байхгүй, нэг ч Засгийн газрын шийдвэр байхгүй. Бүгдээрээ Үндсэн хуулиас эхтэй. Тэгээд Үндсэн хуулийнхаа энэ эх үүсвэрийг нь ингээд бид нар тунхаглалын шинжтэй ч юм уу, эсвэл сайн санаанаас бодож, өөрсдийнхөө хариуцлагагүй байсан юмаа Үндсэн хууль руугаа чихэж одоо л ингээд Үндсэн хуульдаа бид нар ерөөсөө хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гээд оруулчихсан шүү. Одоо энэнээс хойш ингээд л тогтвортой байх юм шиг бодоод л оруулаад байх юм бол эх үүсвэрийг нь бид нар булингартуулаад байна шүү дээ. Энийг гуравдугаар хэлэлцүүлгийн үеэр. Энэ саналыг нь бол би бүхэлд нь дэмжиж байгаа. Энэ хоёр булингартуулаад байгаа, хэрэггүй тодотгол оруулаад байгаа, яваандаа Үндсэн хуулийн цэц болон Улсын Их Хурал дээр маргаан дагуулах энэ заалтуудаа хасмаар байна.

Одоогийн бид нарын амьдралыг удирдаад залаад явж байгаа 1992 оны Үндсэн хууль бол би хувьдаа боддог юм. Маш сайн Үндсэн хууль. Илүү үггүй. Нэг ч илүү үггүй. За магадгүй одоо энэ Улсын Их Хурлаас өөрийнхөө эрхийг хязгаарлаад тэр төсвийн зарлага нэмэгдүүлдэг заалтаа хязгаарлаад явчих юм, зарлага нэмэгдүүлэх эрхгүй болоод хязгаарлаад явчих юм бол энүүгээрээ ингээд явж байхад хангалттай.

Тэр дордуулсан 7 нэмэлт, өөрчлөлт гээд байгаа. Тэр бол миний бодлоор бол дордуулаагүй. Давхар дээлтэй болгосон нь бол дордуулсан байж магадгүй. Бусад нь бол яг амьдралаас ургаад гараад ирсэн төрийн ажлыг гацаагаад байсан гацаануудыг нь бүгдийг нь гаргасан шүү дээ. 1996-2000 онд Ардчилсан нам олонх болчихоод, засгийн эрхийг авчхаад Ерөнхий сайдаа томилж чадахгүй ажиллана гэж тийм юм байж болохгүй шүү дээ. Ардчилсан нам нь ч байна уу, Ардын нам нь ч байна уу өөр ямар ч нам нь байна вэ. Тэр гацаанаас гаргасан. Ирц хэтэрхий өндөр тавьчхаад Улсын Их Хурлын үйл ажиллагааг бойкотлоод байсан. Тэрийг нь хассан. Нууцаар санал өгч байгаа нэрээр хуйвалдаад байдгийг нь. Тэрийг нь хассан. Улсын Их Хурлын гишүүн хуулиар л нууцаар санал өгнө гэсэн. Эсвэл олонхоороо шийдээд хувь хүний холбоотой асуудлаар л нууцаар санал өгөхгүй бол бусдыг нь юунаас нь хүнээсээ ичээд, ард иргэдээсээ, сонгогчдоосоо нуугаад

байгаа юм бэ. Санал ил тод байх ёстой шүү дээ. Тэрийг засаж өгсөн. Маш олон гацаануудыг гаргасан байхгүй юу.

Зүгээр тэрийг дагасан улс төр нь явсаар байгаад зөв өөрчлөлтүүдээ бид нар дордуулсан 7 болгож хувиргаад. Тэрнээсээ үндэслээд Улсын Их Хурлынхаа нэр хүндийг унагаагаад, Үндсэн хуулийнхаа нэр хүндийг унагаагаад явчихсан ийм аюултай байгаа юм. Тэрэнтэй адилхан ийм юм битгий давтагдаасай гэж бодож байгаагийн хувьд энд оруулж байгаа өөрчлөлтүүдээ Их Хурлын дарга аа гуравдугаар хэлэлцүүлгээрээ жаахан чамбайруулаад илүү дутуу тодотголудаа хасаад ирээдүйд хэл ам дагуулах, толгой, хүзүү ороох заалтуудаа хасаад явчихмаар байна. Тодорхой жишээ бол энэ байна. За баярлалаа.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Магваны Билэгт үг хэлнэ.

М.Билэгт: Гишүүдийнхээ амрыг эрье.

Ард иргэд маань энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс их л одоо чухал өөрсдийнх нь амьдралд нөлөөлөх, үр дүн өгөх ийм л одоо өөрчлөлт ирээсэй гэж горьдож харж байгаа.

Гэтэл энэ сүүлийн 20-иод жилд ерөөсөө үндэсний онцлогтоо зохицсон эдийн засгийн бодлогоо боловсруулдаг тийм төр засаг байхгүй болжээ гэдгийг л бодитоор бид харлаа.

Өндөр хөгжилтэй оронд, гадаадад төгссөн өндөр боловсролтой залуучууд маань Монголынхоо үндэсний онцлогийг мэдэхгүй болоод одоо бүр энүүгээрээ дуусах гээд байх шиг байна л даа. Мэддэггүйд нь одоо тэгээд мэдээж нас нь ахиад гараад явж байгаа.

Энэ юу гэсэн үг вэ гэхээр зэрэг хамгийн нэгдүгээрт гэхэд одоо зах зээлийн эдийн засгийн нийгэмд шилжсэн энэ 20 гаруй жилд манай төрийн, салбарын яамдын аппаратын тухайн салбарын менежментийг өндөр хөгжилтэй орны хэмжээнд хүргэхээр туршлага судлахаар татвар төлөгчдийн мөнгөөр хэдэн их наядаар гадаадад туршлага судалсан. Тэглээ гээд энэ салбарууд өндөр хөгжилтэй орны хэмжээнд очсон, иргэдийн итгэлийг хүлээх хэмжээнд очсон юм ховорхон л байна.

Эсрэгээрээ ард иргэд маань төрийн минь сүлд өршөө гэж цайныхаа дээжийг өргөдөг байсан энэ ард иргэд маань Монголынхоо төрд итгэх итгэл жилээс жилд буурсаар одоо яаж байна вэ 76 мангаа гэсэн ийм нэр хочийг бид авах хэмжээнд очлоо.

Ер нь бол иргэн баян бол төр баян гэдэг. Уг нь 30-аад жилийн өмнө хөдөө аж ахуй, үйлдвэрийн орноос аж ахуй, хөдөө аж ахуйн орон болох зорилт тавиад Монголын төр энэ зорилтдоо хүрч байсан юм. Хүрч байсан юм. 360 үйлдвэр, комбинаттай. Эндээ 6 мянга гаруй нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Дотоодынхоо хэрэгцээг хангадаг. Валютынхаа эх үүсвэрийг эндээс бүрдүүлэх, нөхцөлийг бүрдүүлэх. Гадаадад бас эндээсээ гаргадаг ийм л байсан.

Өнөөдөр хүчний байгууллагуудын тэр форум, хувцас. Энийг бүгдийг дотооддоо үйлдвэрлэж байсан. Энэ болгоныг зах зээл эхлэнгүүт яасан бэ гэхээр зэрэг ерөөсөө 1996 оноос хойш ямар байдалд хүрсэн бэ гэхээр нөгөө үйлдвэрүүдийг чинь бүгдийг нь хувьчлал нэрээр төрийн өндөр эрх мэдэл, албан тушаалтнууд аваад тэр үйлдвэрүүдийг хамгийн гол нь бүгдийг нь дампууруулсан. Доторх тоног төхөөрөмжүүдийг нь бүгдийг нь төмрийн хог болгоод Хятад руу гаргаад. Ингээд тэнд иргэд 100 гаруй мянган иргэд ажилтай, орлоготой байдаг

байсан бол өнөөдөр байхгүй. Гэтэл эсрэгээрээ дотоодынхоо үйлдвэрлэлийг ерөөсөө дэмждэггүй. Гадаадаас бараа, бүтээгдэхүүнээ оруулдаг. Хэрэгцээнийхээ бүх бараа, бүтээгдэхүүнийг оруулдаг. Хилээ задгай тавиад ингээд иргэд маань ажилгүй, орлогогүй л болсон.

Нөгөөтээгүүр үндэсний мөнгөн тэмдэгт байна. Үндэсний мөнгөн тэмдэгт. За яах вэ, 1992 онд зах зээлд шилжээд бас мэдээж ороо бусгаа үе байлгүй л яах вэ гэж бодоход 1998 оноос хойш зүгээр 20 жилээр харьцуулахад үндэсний мөнгөн тэмдэгт 300 хувиар унасан. 1998 онд монгол төгрөг 1 доллар нь 800 төгрөгтэй тэнцэж байсан бол өнөөдөр 2700 хүрчхээд байж байна. Гэтэл тэгвэл хөгжингүй орнуудын туршлагыг нэвтрүүлж байгаа бол энэ хамгийн гол юм шүү дээ.

Жишээ нь, Хятадад 1998 онд 1 доллар 8.3 юань байсан. Өнөөдөр яаж байна вэ. Сүүлийн арван хэдэн жил, хорин жил зургаа аравны хэд дээр л Хятад барьж байна. Ингэж үндэсний мөнгөн тэмдэгтээ барьж чадаж байна. Японы хар. 1998 онд 1 доллар 130 иен байсан бол бүр 2013 онд 97 болгоод. Одоо бүр 110 дээр л ингээд бариад байж байна. Ингэж байж л иргэдийн амьдрал хэвийн явах нөхцөл нь бүрдэнэ. Хамгийн гол нь энэ үндэсний мөнгөн тэмдэгтийг тогтвортой барих. Үндэсний мөнгөн тэмдэгт унаснаар иргэдийн хэрэглээний зардал тэр хэмжээгээр өсөж өрхийн орлого, зарлага хасах түвшинд очиж зээлээс зээлийн хооронд амьжиргаагаа залгуулах ийм л нөхцөлийг бүрдүүлсэн шүү дээ.

Энийг жинхэнэ зохицуулж чадах юмыг энэ Үндсэн хуульд уг нь энэ заалтыг оруулж өгмөөр байна. Үндэсний мөнгөн тэмдэгтэйгээ холбогдуулж. Өндөр хөгжилтэй орны бусад орнуудын туршлага ийм л байна шүү дээ. Дээр нь Монголчууд одоо яадаг болсон. Ганц гайгүй шиг жаахан ажил хийдэг, юманд авхаалжтай, самбаатай ийм залуучууд нь гадаад руу явж ажилладаг болчихлоо.

Тэгэхээр цаашдаа яах юм болж байна. Ажиллах хүч гадаадад гаргах гэж байна. Тэдийг гаргах гэж байна. Очерлоод байгаарай л гэж байна. Ийм байж болохгүй шүү дээ. Монголдоо гэр бүлтэйгээ, үр хүүхэдтэйгээ энэ залуучууд маань ажиллаж, айл өрх ч гэсэн элэг бүтэн амьдрах энэ нөхцөлийг бид нар бүрдүүлэх. Монголдоо үйлдвэрлэж, Монголдоо ажилладаг ийм улс болгомоор байна шүү дээ буцаагаад.

Тэгэхээр энийг яг энэ талаар дорвитой оруулах юм бол энд орж ирэхгүй л байж харагдаад байна л даа. Яах вэ энэ бага ч гэсэн бас энэ сүүлийн одоо энэ орж ирж байгаа заалт бол уг нь болж байна. Тэгэхдээ үндэсний мөнгөн тэмдэгтийг энэ дээр бүр онцгой анхаармаар байна. Энэ чинь иргэдийн амьдралтай холбоотой шүү дээ. Тэгээд үйлдвэрлэгч болгохын тулд жижиг, дундаас нь эхлээд. Үйлдвэрлэгч болгохын тулд импортын татвараар энийгээ хамгаалж өгөх ёстой. Дотооддоо хийж чаддаг байсан юмаа эд нарыгаа үйлдвэрлэдэг болгох нөхцөлийг бид нар импортын татвараар л хамгаална шүү дээ. Гадаадын улс орнууд бүгд л тийм байна шүү дээ.

Одоо улс орнуудын хоорондох худалдааны дайн л гэж байна. Тухайн улс орон өөрийнхөө үйлдвэрлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг гадаадад экспортлох энэ зах зээлээ хамгаалахын тулд худалдааны дайны хэмжээнд очиж байна. Манайд байхгүй. Импортоор орж ирж байгаа бараа бүтээгдэхүүнийг ерөөсөө зохицуулж өгөхгүй. Тэгээд Хятадуудыг буруутгах арга байхгүй. Одоо яаж байна вэ. Хятадууд л ерөөсөө Монголын зах зээлийг ялгаагүй энэ мөнгөний уналтыг, үндэсний мөнгөн тэмдэгтийн уналтыг.

Дээр нь Монголд одоо энэ үндэсний нөхөн сэргээгддэг баялаг энэ мал ахуйн салбараас гарч байгаа энэ баялгийг үнийн өсөлт бууралтыг Хятадууд л барьж

байна. Тэгтэл өнөөдөр манай Монголын төр энэ дээрээ анхаарч өгмөөр байна шүү дээ. Иргэд ажилтай, орлоготой болох юм бол хамгийн гол юм л тэр. Хэрэглээний зардал нь өсдөггүй болох юм бол. Өндөр хөгжилтэй орон бүгдээрээ ийм байна шүү дээ. Тэгээд ямар туршлагаа судлаад байгаа юм бэ. Хамаг үйлдвэрээ дампууруулаад. Ялгаагүй. Бид нартай зэрэг зах зээлд шилжсэн. Зэргэлдээ байж байгаа Хятад байж байна. Орос байж байна. Энэ улсууд маань хуучин байсан үйлдвэрээ улам сайжруулаад орчин үеийн технологийг нэвтрүүлээд ингээд хөгжөөд байж болно. Манайх байхгүй.

Тэгэхээр энэ дээрээ л гол юмаа бодмоор байна. Энэ хооронд л төсөл хөтөлбөр хангалттай баталсан л даа. Тогтвортой хөгжлийн, бүсчилсэн гээд л ингээд. Даан ч энэ нь уламжлагдаж явдаггүй. Дараагийн Засгийн газар орж ирэнгүүт урд талын Засгийн газрынхаа сайн төсөл, хөтөлбөрийг үргэлжлүүлээд аваад явахыг боддоггүй ийм л болсон шүү дээ. Тэгээд энийг яаж энэ Үндсэн хуулиараа хамгаалж өгөх юм бэ. Органик хуулиараа бол худлаа. Тэр доор нь л нэг нэмэлт, өөрчлөлт оруулж байна гэж хэлээд л хэн нэгний эрх ашиг тэнд орж ирээд нэг үгээр, нэг өгүүлбэрээр ингээд хэн нэгний эрх ашгийн тийм өөрчлөлт ордог юм. Энийгээ яаж засах юм бэ гэдгийг л би хэлэх гээд байна л даа.

Г.Занданшатар: Гишүүд чуулганы танхимдаа орж ирээрэй. 5 минутын дараа санал хураалт явуулна. Одоо эрхэм гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ үг хэлнэ.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ заалтыг нэлээн анхаарал хандуулах эрхтэй болж байгаа юм. Ер нь бол.

Монгол Улсын өнөөдрийн хөгжлийн бодлого, төлөвлөлт бол нэлээн замбараагүй явж байгаа. Та бүхэн мэдэж байгаа. Нэг Засгийн газар гарч ирдэг. Нэг Улсын Их Хурал бүрэлдэн тогтдог. Тэндээс гарсан бодлого урд урьдынхаа бодлогыг бол үгүйсгэдэг. Ингээд өөрсдийнхөө бодлогыг бариад явдаг. Тэгж байтал дараагийнх нь гарч ирээд дахиад нөгөөдхөө өөрчлөөд явчихдаг.

Тэгээд өнөөдрийг хүртэл тогтвортой ийм ирсэн бодлого бол үндсэндээ байхгүй байгаа шүү дээ. Тэгэхээр бид хэдэн гишүүн нийлээд энэ Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн урт, дунд хугацааны хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлттэй байна гэсэн ийм үг, үсгийг оруулсан. Энэ орсон үг, үсэг маань бол энд орж ирэхдээ төсвийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд төлөвлөлт тогтвортой байна гэдэг зөвхөн ийм дан үгээр ороод ирж байгаа. Тогтвортой байна.

Тогтвортой байна гэдэг маань бол үндсэндээ бол зүгээр л энгийн томъёолол гэж хараад байгаа байхгүй юу даа. Энгийн томъёолол. Бүх зүйл тогтвортой байх ёстой. Бүх зүйл зөв байх ёстой. Бодлого одоо нэгдсэн бодлоготой байх ёстой гээд бид нарын ярьдаг л зүйл шүү дээ. Өнөөдрийг хүртэл зах зээлд орчхоод бид нар 20, 30 жил ярьсан энэ зүйлийг ярьсаар л ирсэн шүү дээ. Яг үндсэндээ амьдрал дээр бол хэрэгжиж байгаа юм байхгүй.

Тийм болохоор Үндсэн хуульдаа Монгол Улсын одоо үндсэн эцэг болсон энэ том хуульдаа бол хаашаа ч гарахгүйгээр үг, үсгээр нь тодорхой оруулъя гэж байгаа. Үндсэн хуулийг ерөнхий үг, үсэгтэй байна гэсэн нэг ийм зүйл бид одоо өнөөдөр хүртэл дахиад л яриад байгаа. Энэ дотор хэрвээ ийм байгаад зөв явдаг байсан бол өнөөдрийн энэ Үндсэн хууль бол буруутаагүй. Энэ Үндсэн хууль бол маш сайхан хууль байгаа. Энэнээс одоо улбаалаад органик хуульдаа бид нар энэ зүйлүүдийг тусгаж хэрэгжүүлж чадахгүй болчихоод байна. Тэрийг нь эвдээд байна. Нэг Улсын Их Хурал гарч ирэнгүүтээ шууд органик хуульд өөрчлөлт оруулж байгаад дараагийн өөрсдийнхөө бодлогыг шилжүүлээд ингээд явчхаж байгаа шүү

дээ. Тэр битгий хэл одоо хууль ямар хамаатай юм гэсэн асуудал ч хүртэл үе үеийн зарим зарим Засгийн газарт гараад ирж байдаг.

Тэгэхээр мэдээж Улсын Их Хурлаас бодлого гарна. Тодорхой хэмжээний тухайн 4 жилдээ хийгдэх мөрийн хөтөлбөрүүд гарна. Энэ мөрийн хөтөлбөр нь тэр эцэг том бодлогын төлөвлөлтийнхөө хүрээнд ажилладаг. Тэр хүрээнээсээ гаждаггүй ийм хуультай болмоор байна. Ямар ч Ерөнхий сайд хүрч ирсэн энэ хуулийнхаа дагуу энэ бодлогынхоо хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Ямар ч сайд, ямар ч төрийн байгууллага байна тэр бол үндсэндээ тээврийн байна уу, одоо юу байдаг юм. Уул уурхайн бодлого гэвэл энэ бодлого бол тэр үндсэн том бодлогынхоо хүрээнд л урт хугацаанд харж байдаг.

Тэгэхээр энд урт хугацааны буюу дунд хугацааны гэсэн ийм тодорхой үг, үсгийг оруулъя гэсэн юм. Одоо өнөөдөр ингээд орсонгүй ингээд хүрч ирлээ. Ажлын хэсэг бол нэлээн энэ дээр гүрийнэ гэдэг шиг болж гүрийж байгаад л гарах шиг боллоо.

Тэгвэл эндээс үндсэндээ органик хуульдаа бид яг ийм бодлоготойгоор гарна. Урт дунд хугацааны. Тэр урт, дунд хугацааных нь ямар хугацаатай байх юм. Бүр тодорхой баймаар байна. Нэг 4 жил биш. 8 жил. 12 жил, 16 жил. Одоо хэдээр байж болох юм. Энийг бүр тодорхой заамаар байгаа байхгүй юу даа. Тэгж байж бид нар энэ бодлого дотроо орж явах ёстой.

Хоёрдугаарт, энд бас нэг орлого зарлагын бүтцээ өөрчилж болно. Тэгээд одоо зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж болно л гээд байгаа юм. Нэг талдаа бол энэ бас Засгийн газар бүрэн өөрсдийнхөө мөрийн хөтөлбөрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах бүрэн бололцоог нь одоо нэг талаас олгож байгаа тал дээрээ бол зөв зүйтэй үг, үсэг орж ирж байна. Нөгөө талаасаа Улсын Их Хурал тодорхой бодлогоо хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээний цаг үетэй холбогдсон өөрчлөлтүүдийг хийх боломж бол байх ёстой бид нарт. Олдох ёстой. Өнөөдрийн хувьд бол яах вэ энэ Улсын Их Хурал янз янзын нэр ус зүүгээд л бас нэг тодорхой үнэлгээ авахгүй гадаад талдаа тодорхой үнэлгээ авахгүй ингээд л яригдаад хэлэгдээд явж л байх шиг байна. Гэхдээ дандаа ийм байхгүй. Энэ Улсын Их Хурал чинь одоо цэвэр цэмцгэр байх ёстой. Зөв байх ёстой. Бодлогоо одоо зөв тууштай барьдаг байх ёстой. Тэгээд энэ нь улсын бодлого дээр уян хатан байх ийм боломж бололцоог бол бид нар бас нээх ёстой юм л даа. Энүүгээр бол хэтэрхий хатуу тийм зарчмын асуудлыг бол суулгаад явах гээд байх шиг байна.

Тэгэхээр гурав дахь хэлэлцүүлэг дээр энд одоо тэр дагалдах хуулиуд дээр одоо ямархуу байдлаар заагдсан байж байгаа юм. Тэр дагалдах хуультайгаа уялдаад үг, үсэг засах ийм боломж бололцоо бас байдаг юм уу, яадаг юм. Ямар ч байсан энэ бодлогын, урт хугацааны гэсэн энэ бодлогоо цаашаа барих. Тэгээд энэ төлөвлөлтөд тодорхой хэмжээний өөрчлөлт орох ийм боломж бололцоог бол бид нар нээсэн ийм өөрчлөлтийг хийх боломж бололцоо бол хийгээд явах нь зүйтэй байгаа юм гэж. За баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Түрүүн төслийн 10 дугаар заалтаар санал хураалт явуулаад унасан. Одоо 10.1.

10.1 бол төслийн 2 дугаар зүйлийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын “нийгмийн хөгжлийн” гэсний дараа “бодлого” гэж, мөн заалтын “батлах” гэсний дараа “улсын төсвийг хэлэлцэн батлахдаа Засгийн газрын зөвшөөрөлгүй зардлын шинэ төрөл үүсгэж, зарлага нэмэгдүүлэхгүй, төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэсэн 2, 3 дахь

өгүүлбэрийг хасаад, /дээр унасан учраас хасаж байна шүү дээ/ төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16 дахь заалт буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт нэмэх:

16. Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

Төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах.

Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын нийт хэмжээг нэмэгдүүлж үл болно. Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна. Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

Санал хураалт явуулна. Санал хураалт явуулахдаа 3 дахь хэлэлцүүлэгт гишүүдийн хэлсэн саналыг Мөнх-Оргил гишүүн, Чинзориг сайд, Даваасүрэн гишүүдийн хэлсэн саналыг найруулга, хэлэлцүүлэгтээ анхаарах чиглэлийг өгч байна.

Санал хураалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулж байна.

Протоколд тэмдэглүүлчих. Элдэв-Очир гишүүн.

Л.Элдэв-Очир: Саяны санал дээр дэмжсэн санал техникийн саатлаас болоод орсонгүй. Манай техникийн хүмүүс бас хажууд байлаа, яах аргагүй орохгүй байх юм. Өглөө би бас засуулсан юм, дахиад засвар хийх хэрэгтэй болох юм шиг байна. Миний саналыг протоколд оруулж өгнө үү.

Г.Занданшатар: Тэрбишдагва, Элдэв-Очир гишүүдийн саналыг дэмжсэнд тооцохоор, 63 гишүүн санал хураалтад оролцсоноос 59 гишүүн дэмжиж энэ санал дэмжигдлээ.

10.2. Төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын “батлах” гэсний дараа “Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт, дунд хугацааны хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлттэй хэрэгжүүлнэ. Энэхүү бодлого, төлөвлөлтийг тогтвортой, залгамж чанартай хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллагатай байна” гэж нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, Д.Дамба-Очир, Б.Жавхлан, М.Оюунчимэг, Д.Тэрбишдагва, Б.Ундармаа.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй.

Эрхэм гишүүн Дэндэвийн Тэрбишдагва.

Олонх нь татвал татвал татаж болно, 1 гишүүн татахгүй шүү дээ. 1 гишүүн төлөөлөөд татах юм уу? Баттөмөр гишүүн.

Д.Тэрбишдагва: Баярлалаа. Түрүүний 10.1 дээр би эсрэг санал өгсөн л дөө. Тэгэхдээ олонхоороо дэмжээд гарчихлаа. 10.1 дээр түрүүн манай олон гишүүд санал хэлсэн. 10.1-ийн 16. Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт дээр үүнийг засвартайгаар оруулахаар олон гишүүд хэлчихлээ. Даваасүрэн, Мөнх-Оргил гишүүд хэллээ. Энэ дээр Монгол Улсын хөгжлийн гол цөм болсон эдийн засгийн хөгжил маш чухал байгаа юм. Үүнийг олон жил ярьж байгаа юм. Тэгээд

эдийн засгийн хөгжлийн, нийгмийн хөгжлийг урт, дунд хугацааны хөгжлийн нэгдсэн бодлоготой. Сая бол нэгдсэн бодлоготой, төлөвлөгөөтэй гэж яриад байгаа. Тэгэхдээ урт, дунд, богино хугацааны хөгжилтэй. Бодлого, төлөвлөлтийг тогтвортой, залгамж чанартай хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллагатай болъё гэж. Ерөөсөө энэ төрийн захиргааны төв байгууллагыг Үндсэн хуульд оруулж болохгүй гэж яриад байгаа юм. Гэхдээ Монгол Улсын аюулгүй байдал, тусгаар тогтнолын гол судас нь эдийн засгийн хөгжил, ажилгүйдэл, ядуурал өнөөдрийн байдал ямар байгаа билээ.

Тэгэхээр эдийн засгийн хөгжилгүйгээр улс орны хөгжлийг өнөөдөр ардчилал, шударга ёс гээд юуг ч яриад хэрэггүй л дээ. Өнөөдөр ямар ч авторитар дэглэмтэй ч байна уу, дэглэмгүй ч байна уу улс орон хөгжлийн бодлоготой, төлөвлөлттэй явж байж дэлхий нийт хүлээн зөвшөөрч байна шүү дээ. БНХАУ-ыг нэг хэсэг коммунист орон, төлөвлөгөөтэй орон гээд баахан шүүмжлээд, ардчилал байхгүй л гээд байсан. Одоо дэлхий нийтээрээ Хятадын өмнө бөхийж байна шүү дээ. Өнөөдөр Сингапур гээд жижигхэн улс байж байна. Сингапур хөгжилтэй улс учраас бүгдээрээ дэлхийн өмнө хүлээн зөвшөөрч байна шүү дээ. Бүгдээрээ бодлого, төлөвлөлттэй явж байгаа шүү дээ. Тэгээд Япон, Солонгос гээд ярих юм бол зөндөө улс орон байна шүү дээ. Тэр ч байтугай Хонконг гээд БНХАУ-ын дотор нь жижигхэн өөрийнх нь улсын 1 хот байгаа шүү дээ. Англид тодорхой хэмжээгээр түрээслүүлж байгаад буцаад Хятадаа ирчихсэн, Хятадын нэг хэсэг мөртлөө өнөөдөр тэдний хөгжил дэлхий нийтийн санхүү, эдийн засагт нөлөөтэй байгаа учраас БНХАУ Хонконгтой юу ч ярьж чадахгүй л байна шүү дээ.

Тэгэхээр тусгаар тогтносон Монгол Улсын хөгжлийн дэлхий нийтэд хүлээн зөвшөөрүүлэх гол үндсийн үндэс нь эдийн засгийн хөгжил байх ёстой. Тэгэхгүй бид дэлхийн бусад улс орнуудтай харьцдаг, ярьдаг. Бидний ганц хийж, ярьж чаддаг юм бол ардчилал гэж ярьдаг. Ардчиллаар нь хөөрөгдөж, хөөрөгдөж байгаад бид өнөөдөр чинь ямар улс болов? 1990 оноос хойш Монгол Улсын өнөөдрийн хөгжил, өнөөдрийн хүн амын нөхцөл байдал, энэ хар тамхи, халдварт өвчин, утаа энэ бүх юм чинь эдийн засгийн хөгжилтэй холбоотой юм биш үү. Тэгээд жижигхэн тусгаар улсын эдийн засгийн хөгжлийн асуудлыг тусгай байгууллагатай болъё гэж ярихаар Үндсэн хуульд ийм юм байдаггүй гээд энэ Лүндээжанцан гишүүн нар эсэргүүцээд, хүн загнаад байх юм. Энэ чинь бас ордог юм, ордоггүй юм гэж бас байна шүү дээ. Монгол Улсын ялангуяа 2 том хөршийн дунд байж байгаа улс бол биднийг аврах ганц юм бол эдийн засгийн хөгжил. Бид эдийн засгийн хөгжлийн нөхцөл байна уу, байна. Баялаг байна уу, баялаг байна. Оюунлаг ард түмэн мөн үү, оюунлаг ард түмэн. Бид түүхтэй, шастиртай гэх юм бол өнөөдөр бид түүх, шастираараа манлайлж байгаа орон шүү дээ. Жеймс Бейкер хүрч ирээд . . . /хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Үг хэлэх гишүүд кнопоо дарчих. Баасанхүү гишүүнээр тасаллаа. Тэрбишдагва гишүүн сая үг хэлчихсэн, дахиж үг хэлэхгүй. Татъя гэж хэлээд үг хэлээд байна.

Эрхэм гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ төслийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт дээр өөрчлөлт оруулсан ийм саналыг хэдэн гишүүн гаргасан юм. Тэгээд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлнэ, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэхүү бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанартай хөгжүүлэх төрийн захиргааны төв байгууллага байна гэсэн, төв байгууллагатай байлгая гэсэн юм. Ер нь Монгол Улсын хөгжил өнөөдрийг хүртэл явж ирсэн хөгжил дээр харж байхад тодорхой хэмжээний байгууллага байгаад энэ бодлого

дээр урт хугацааны төлөвлөлт барьсан, урт хугацааны төлөвлөлтийг хийдэг, хөгжүүлдэг, үүний дагуу хардаг, хянадаг ийм байгууллага зайлшгүй байх ёстой. Тэгээд сүүлд саяны саналаар бол тогтвортой байна гэсэн ганц үг орж ирээд байна, тогтвортой байна гээд. Угаасаа тогтвортой байна гэдэг чинь 1 жилийн хугацаанд тогтвортой байх юм уу, 3 жилийн хугацаанд тогтвортой байх юм уу? 10 жилийн хугацаанд тогтвортой байх юм уу? Зүгээр байдаг л үг шүү дээ. Тэгэхээр энэ урт хугацаанд эсхүл дунд хугацаанд гэсэн ийм тодорхой үг оруулж өгөөч ээ гэсэн ийм бодлогыг бид нарын энэ хэдэн гишүүд Эдийн засгийн байнгын хороонд оруулж ирээд байгаа юм.

Нөгөөтээгүүр энэ бодлогыг барьдаг байгууллага ямар байгууллага байх юм. Эсхүл Улсын Их Хурлаасаа тодорхойлъё. Эсхүл үүнийг барьдаг Хөгжил шинэтгэлийн хороотой адилхан тиймэрхүү том байгууллага үндсэн бүх нийгэм, эдийн засгийн хэмжээний бодлогыг гаргадаг, бүх салбарын хэмжээнд бодлого гаргадаг, ямар хугацаанд, ямар эдийн засаг, ямар хөгжлийн бодлогын хүрээнд, ямар салбарыг илүү түлхүү хөгжүүлэх вэ гэдэг юм уу, ийм тэнцвэржүүлсэн бодлого гаргаж, барьдаг ийм байгууллага зайлшгүй байх ёстой гэсэн энэ бодлогыг гаргаад байгаа юм.

Одоо энэ ерөнхийдөө цөөнх болоод явах шинжтэй болоод явж байна. Тийм болохоор одоо ажлын хэсэг дээр анхаараад, үүнийг цаашдаа органик хуульд бүр тодорхой оруулмаар байна.

Хоёрдугаарт, хугацааг нь тодорхой оруулмаар байна. Хэрвээ бид ингээд 4 жилээрээ цаашаа явна гэж байгаа бол ядаж 12 жилийн хугацааны бодлого энд байх хэрэгтэй байна, 12 жилээр. Үүнийг бид протоколд заагаад, цаашаагаа энд заасан протоколдоо өнөөдрийн ярьсан протоколын дагуу органик хуульдаа яг ийм байдлаар тусгана шүү гэж ойлгож явж байгаа гэж ойлгож байгаа, энэ протоколд бүртгэгдэнэ тийм үү, зөв. Тэгвэл тэр байгууллага бас ямар хэмжээний байгууллага байх юм, ямар бодлого гаргах юм, төлөвлөлт гаргах юм, хаанаа харьяалагдах юм, хэний дэргэд харьяалагдах юм. Ерөнхийлөгчийн дэргэд байх юм уу? Доороо эсхүл Ерөнхий сайдын дэргэд байх юм уу? Эсхүл Их Хурлынхаа дэргэд байх юм уу? Үүнийг тодорхой ярилцаж, хэлэлцээд явах нь зүйтэй байх аа. Ингэж байж бидний бодлого тогтвортой болно, ингэж байж бодлого тасрахгүй, жигд сайхан хөгжлийн гол тулгуур нь болох асуудал гэж үзэж байгаа шүү.

Тийм болохоор үүнийг цаашдаа органик хуульдаа яг ийм бодлогоор, яг ийм ойлголтоор суулгаарай гэж хэлэх байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Эрхэм гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Сая би өдрийн зоог Японы элчинд барьсан юм. Тэднийх 45 оноос хойш нэг ч өөрчлөлт ороогүй юм байна. Бид нар бол маш том өөрчлөлтүүд хийх гээд байна. Яг одоо төрийн тогтолцоогоо өөрчилдөг ч юм уу, хувьсгал явбал ийм өөрчлөлтүүд ордог. Тэгэхээр нэгэнт ийм том өөрчлөлт хийе гэж байгаа бол сайн ярьсан нь дээр ээ. 500 гаруй ярьж байсан хуулийг бид нар 76-уулаа суучаад, залхуурдаг ч юм уу? Нэгнийгээ ярихаар төвөгшөөх ийм байдал гаргаж болохгүй ээ. Энэ бол улс орон, ард түмний хэдэн арван жилийн хувь заяаг шийдэх гэж байгаа шүү, бид нар. Түүнийгээ маш сайн бодох хэрэгтэй. Би түрүүн Мөнх-Оргил гишүүний хэлсэнтэй санал нэг байгаа юм. Бүх юмыг Үндсэн хуульд хийчихвэл ингээд яг мөрдөгдөөд явна гэдэг бол ёстой худлаа шүү. Би энэ заалтыг бараг хасахад болохгүй юм байхгүй байх гэж дэмжиж байгаа юм. Бид нар төлөвлөгөө, бодлоготой байна гээд хуульчилсан баримт бичгүүд бий юу, бий. Хөгжлийн яамтай байсан уу, байсан. Үндэсний хөгжлийн газартай байсан,

Хөгжлийн яамтай байсан. Тэглээ гээд болоогүй. Тийм учраас заавал Үндсэн хуульд туссанаар болчихгүй гэж бодож байна.

Ер нь энэ төлөвлөгөө, бодлогыг үймүүлж байгаа ганц л юм байгаа, намын мөрийн хөтөлбөр. Намын мөрийн хөтөлбөрөө намууд боловсруулахдаа хачин юм хийж байгаа шүү дээ. Хаана ч тэр урт хугацааны бодлогод байхгүй юмыг оруулаад ирж байгаа шүү дээ. Тэгээд тэр нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болоод хэрэгжиж байгаа шүү дээ. Тэгвэл өнөөдөр бид нар үүнийг энд хөндсөн үү. Хөндөөд юу ч болохгүй. Хөндье, Үндсэн хуульд аваачаад жишээлбэл намын мөрийн хөтөлбөр урт хугацааны хөтөлбөртэй нийцсэн байна гээд хийчихье. Тэгвэл жижигхэн намыг бүртгэхдээ Үндсэн хуультай зөрчилдөж байна гээд хасчихна. Энэ чинь өнөөдрийн бидний байгаа байдал. Ямар ч хууль, ямар ч тогтолцоо руу явдаггүй. Бидэнтэй холбоотой. Тийм учраас одоо ингээд энэ дээр нэг юм орсон нь, бүх юмыг сайхан шийдчихнэ гэж бодож болохгүй. Оруулж байгаа бол гай болохгүй талаас нь маш сайн ярилц, залхуурахгүй ярилц. Ийм юм болно, тийм юм болно, ингэнэ, тэгнэ гэж. Энэ чинь хувь заяа шийдээд гол суурь хууль шүү дээ.

Тийм учраас би энэ заалтууд дээрээ, хасаж байгаа, нэмж байгаа юмнууд дээрээ анхаараарай. Ер нь бол ийм олон зүйл, заалтаар Үндсэн хуульдаа өөрчлөлт хийдэг орон, би сая ойрын хэд хоног харлаа байдаггүй юм байна. Тогтолцоо нь өөрчлөгдвөл, томоохон хувьсгал гарвал нэг иймэрхүү юм явдаг юм байна. Тийм учраас маш том өөрчлөлт хийж байна, энэ дээрээ маш хариуцлагатай байхыг бид нар анхаарах ёстой юм байна гэж бодоод байна. Тийм учраас энэ ялангуяа төлөвлөгөөний асуудал дээр бид нар тал талаасаа маш сайн ярих хэрэгтэй шүү. Ерөөсөө бид нар ингээд төлөвлөлтгүй явж байна, бодлогогүй явж байна гээд яриад л байдаг шүү дээ. Одоо үүнийгээ яаж засах юм? Гол үймүүлж байгаа юм намын мөрийн хөтөлбөр шүү. Үүнийг яах ёстой юм. Намын мөрийн хөтөлбөр дээр л хаа хамаагүй юм ороод ирдэг шүү дээ, тэгээд л үймүүлээд хаячихдаг. Тэгээд тэр нь мөрддөггүй, тэр нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болдог. Үүнийг шийдээгүй байхад хэчнээн гоё юм суулгаж өгөөд, Үндсэн хуульд хийж өглөө ч тэр энэ төлөвлөгөө, бодлого хэрэгждэггүй юм чинь засрахгүй.

Г.Занданшатар: Японы Үндсэн хуулийг 47 онд үйлчилж эхэлсэн, Америкууд зохиож өгсөн гэдэг. Одоо өөрчлөх гээд ярьж л байгаа байх, тийм үү.

Одоо Октябрийн Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: Үндсэн хууль гэдэг бол нийгмийн суурь буюу язгуур харилцаа зохицуулах гэж байдаг хууль. Эдийн засгийн, улс төрийн, оюун санааны харилцааг нийгмийн суурь харилцаанд нь оруулж шийдэх гэдэг. Тийм учраас Үндсэн хууль гэдэг бол нийгмийн суурь харилцаа өөрчлөгдөхөөр Үндсэн хууль өөрчлөгдөнө. Нийгмийн суурь харилцаа өөрчлөгдөхгүй бол Үндсэн хууль өөрчлөгддөггүй. Би энд онол ярихаас өөр аргагүй болж байна. Жишээлбэл, өнөөдөр юу гэдэг юм, тухайн үед манайх төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас, зах зээлийн эдийн засаг уруу орсон, нийгмийн суурь харилцаа өөрчлөгдсөн. Тийм учраас Үндсэн хуулийг бичихээс өөр аргагүй. Улс төрийн дэглэм нь нэг намын засаглалтай коммунист дэглэмээс, олон намын тогтолцоотой, ардчилсан дэглэм руу оръё гээд Үндсэн хууль өөрчлөгдсөн.

Одоо үүнийг өөрчлөх гээд байгаа санаа нь манай Ардын намын л хүсэлт шүү дээ, 65 хүнээ яаж багтаах уу, нөгөө Ерөнхийлөгчийн хүсэлт шүү дээ, нөгөө хурууныхаа үзүүрт явдаг хэдэн хүүхдүүддээ яаж авч үлдэх вэ, өөр ямар хүсэлт байгаа юм. Одоо энэ урт хугацааны тогтвортой бодлого гээд миний мэдэж байгаагаар энэ чинь 2000 оноос хойш ингээд баталдаг юм, зөндөө баталдаг. Хамгийн сүүлд миний дуулснаар алсын хараа 25 гэнэ үү, Засгийн газар нь 25

жилээр юмаа баталж байна гээд. Тэгэхээр хэрвээ Үндсэн хуулиараа энэ урт хугацааны хөтөлбөрөө батална гэж байгаа бол эрх нь хэнд байгаа юм, Засгийн газарт байдаг юм уу, Их Хуралд байдаг юм уу. Хэрвээ Их Хуралд байгаа юм бол үүнийг хариуцах байгууллага хэрэгтэй гээд явахаар бол энэ чинь юу болох юм. Төв байгууллага хариуцах юм уу, төв биш байгууллага хариуцах юм уу. Эсхүл одоо нэг хувь хүн хариуцах юм уу. Бид нар Монгол Улсын сайд гээд нэг сайд томилж үзсэн шүү дээ. Юун Монгол Улсын сайд вэ, Хятад Улсын сайд биш шүү дээ гэсэн. Энэ Мега төслийг хариуцах юмаа гээд Мэндсайханы Энхсайхан гээд. Тэгээд тэр нь Мега төслийг хариуцаж байгаа гэдгээр бид нар урт хугацааны юм уу гэсэн чинь, сүүлдээ Таван толгойг 100 жилээр үнэгүй өгөх гэж байсан гээд нөгөө 37 он шиг нөгөө хүнээ одоо ад үзээд сууж байгаа биз дээ.

Тэгэхээр иймэрхүү байдлаар өөрчлөхгүй ээ. Хошин шог болохоо боль одоо. Үндсэн хууль хийнэ гэж байгаа бол нийгмийн суурь, язгуур харилцааны өөрчлөлтүүд нь юу байгаа юм, эдийн засгийн өнөөдөр, цаашдын асуудлууд нь ямар байгаа юм. Жишээ нь төрийн албан дээр аваад үзэхэд чинь мерит зарчим гээд, тэгсэн хэрнэ ярихаараа юу гэж хэлээд байгаа вэ гэхээр, одоо шаталснаар явна. Одоо мэргэжилтэн, дээрээс нь хэлтсийн дарга, газрын дарга сүүлдээ юу, юу ч гэдэг юм, төрийн нарийн гээд. Түүнийгээ мерит гээд байдаг. Гэтэл мерит гэдэг үгийг орчуулаад, судлаад үзэхээр чадамжтай хүнийг жил, нас харгалзахгүйгээр тухайн газар нь оруулж ажиллуулахыг хэлдэг юм байна. Тэгээд ингээд ярьж байгаа юм нь, хийж байгаа үгнийхээ эсрэг яваад, мэддэггүй мөртөө мэддэг царайлаад мэдэж байгаа юм шиг онолдоод ингээд баахан юм оруулчихсан. Түүнийгээ зөвшилцөл гээд нэрлэчихсэн. Дамба-Очир, Жавхлан, Оюунчимэг, Тэрбишдагва, Ундармаа, Баттөмөр гишүүд маань санал гаргасан гээд. Тэгээд санал гаргахдаа мэдээж Монголоо гоё болгоё гээд энд 76 хүн бүгд л бодож байгаа байлгүй дээ, сайхан болгоё, гоё болгоё гээд.

Одоо байгаа Үндсэн хууль дээр тодорхой байгаа шүү дээ. Улсын Их Хурал нь Монгол Улсын гадаад, дотоод бодлого, эдийн засгийн цаашдын чиг хандлагыг тодорхойлно гээд ингээд тодорхой заачихсан. Урт, богино, тактикийн гээд энэ чинь намын мөрийн хөтөлбөр л гэсэн үг шүү дээ. Тэр түрүүний хэлдэг бас үнэн л дээ. Сонгуульд орох үед бараг бүх хүн жинхэнэ утгаараа попордог, оноо авахын тулд, лайк цуглуулахын тулд нам нь хүртэл. Трамп хүртэл Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихэд Америкт харж байхад нэлээн хүчтэй, хүчтэй амлалтууд өгч байсан, гарч ирээд улс орныхоо эдийн засаг, нөгөө нөхцөл байдалтайгаа тааруулдаг. Одоо ийм тунхгийн шинжтэй юм хийвэл энэ амлалтын юм чинь бүр 10 дахин нэмэгдэнэ гэсэн үг, 100 дахин. Манайд чинь одоо хагас галзуу гэх нь хаашаа юм, хүн байгаад байгаа шүү дээ. Хүн болгонд үнэгүй байр, үнэгүй сургууль, үнэгүй цэцэрлэг, бүх юмыг үнэгүй өгнө гээд ингээд ярьж байгаа бас нэг нөхрүүд байгаа.

Нөгөө талаасаа аваад үзэхээр саран дээр байшин барина гэх нь холгүй бүх хүний гэрэл цахилгааныг нарны энергиэр шийднэ ч гэдэг юм уу. Хүнд таалагдсан үгийг хэлэх гэж Үндсэн хуулийг бичдэггүй. Хүнд таарсан зүйлийг нь бичих гэж л явж байгаа гэж би ойлгож байгаа. Энэ заавал онол дээр суурилдаг юм биш. Суурь харилцаан дээр бид нар өнөөдөр дутагдаад байгаа нь юу юм бэ. Жишээлбэл бид яагаад өртэй байгаа юм. Оюу толгой гээд л ярьдаг, Оюу толгойн хувьцааг яагаад Монголын Хөрөнгийн биржээр зарж болдоггүй юм бэ. Тавантолгой гээд л ярьж байна. Тавантолгойн хувьцааг яагаад Монголын Хөрөнгийн биржээр зарж болдоггүй юм. Монголын Хөрөнгийн бирж, олон улсын хөрөнгийн бирж хоёр юугаараа ялгаатай юм. Хөрөнгийн бирж зах зээлийн өнөөдрийн зарчмаар өнөөдөр банк үргэлж мөнгө олохгүй, хадгаламж эзэмшигчийн мөнгө дээр дандаа суурилахгүй.

Хөрөнгийн хувьцаа зарсан нэрээр тэр банкнууд чинь хөрөнгө оруулалт, мөнгө босгоод цаашаа явдаг. Гэтэл ийм байдлаар өнөөдөр бодлого ярьж болно л доо. Бодлого гэдгийг юу гэж ойлгож байгаа вэ гэвэл, энэ бол санал. Гоё байж магадгүй. Тооцоололтой, судалгаатай. Майдар хот баръя гээд бодлоготой бид нар. Сайншандын парк баръя гэдэг бодлоготой. Тэгээд бид нарын энэ бодлого хөгжсөн бол арьс ширээ өнөөдөр аль хэдийн боловсруулчихсан, гангын үйлдвэр барьчихсан, зэсийн үйлдвэр барьчихсан, шатахууны үйлдвэр барьчихсан. Тэгээд юу бүтээд байгаа юм. Бодлого дутаад байгаа юм бишээ, бодлого дутаад байгаа юм биш. Энэ бол ерөөсөө бололцоо, боломжийг өгөхгүй байгаа. Гадна, дотнын гар, хөл, эх орноо бодохгүй байгаа. Дээрээс нь юу чухал вэ гэдгийг ерөөсөө хэн ч тооцохгүй, олон түмэнд таалагдах гэсэн л үг байвал чухал болоод байгаа юм.

Тийм учраас энэ 10.2 шиг иймэрхүү үгнүүд нэлээн олон газар байна л даа. Өөрөөр хэлбэл, одоо үүний дараа ч гэсэн богино хугацааны болгоё, дунд хугацааны болгоё. Бодлогыг ярьж болно л доо. Байгаа юм чинь. Одоо энэ Үндсэн хуулийг одоо жишээлбэл засахаас өмнө урт хугацааны бодлого гээд энээ тэрээ хийсэн юмыг юу гэж үзэх юм бэ, бүгд хүчингүй. Шинэ Үндсэн хууль баталсан. Шинэ Үндсэн хуулийн дагуу шинэ бодлогоо дахиад тодорхойлно, улсаа гоё хөгжүүлнэ гээд суух уу. Миний ойлгож байгаагаар төрийн алба тасралтгүй, нам харгалзахгүйгээр тухайн бодлого нь үргэлжлээд л явах ёстой. Зам тавина гэж хэлээд Мянганы зам гэсэн бол тэр Мянганы замыгаа, одоо тэр нь үнэхээр мянганы бодлого байсан бол түүнийгээ үргэлжлүүлээд явах ёстой. Одоо утаан дээр гэхэд чинь 10-20 янзаар ингээд шийдэл хайгаад, янз бүрийн юм яриад яваад байгаа. Хөшигтийн хөндийн иргэний нисэхийн нээлтэд очоод надад нэг зүйл бодогдож байсан. Хэдэн Ерөнхий сайдын нүүрийг үзэж, хэдэн бодлого тодорхойлж, одоо цахилгаан, эрчим хүч гэхээр хэдэн хүн үүнийг ярих бол гэж. Тэгэхээр энэ болгон чинь Үндсэн хууль дээрээ тодорхой байвал Үндсэн хуулийг давсан, хэн ч ярих ёсгүй, Үндсэн хуулийг давсан, ярьсан нь ёстой жинхэнэ утгаараа попорол. Поп гэдгийг би тэгж ойлгоод байгаа шүү дээ, хийрхэл гэж монголоор орчуулаад байгаа шүү дээ. Хийрхэх, хоосон шүүмжлэх. Санал нь өөрөө тодорхой байвал шүүмжилж болно. Би жишээлбэл түрүүнээс хойш үг авъя гэдэг санал чинь, санал нь тодорхой байгаад байгаа юм. 10, 10-аар 20 минут ярьж гэдэг санал яриад байгаа юм. Тэгээд Их Хурлын дарга бид хоёр ерөөсөө энэ байдлаасаа болоод. Харин нэг зүйл дээр онолоо. Өчигдөр танай Ардын намын бүлэг үг хэлүүлэхгүй гэсэн үгнээсээ өөрчлөгдөөд, овоо хүмүүс маань чөлөөтэй боллоо. Одоо энэ үг хэлж байгаа хүмүүс надад баярлалаа гэж хэлэх ёстой. Тэгэхгүй бол өчигдөр ганцхан би 10 минут хэлнэ гээд, ингээд тэмцлийн хэлбэр руу явж байж үг хэлүүлсэн шүү дээ.

Тийм учраас өнөөдөр энэ төрийн захиргааны төв байгууллагатай байтугай, өнөөдөр энэ гадаад, дотоод бодлогыг тодорхойлж болно. Түүнээс эдийн засгийн урт, богино, өргөн, нарийн гэдэг энэ бодлого гээд байгаа зүйлүүдээ маш ойлгомжтойгоор бөгөөд социализмын лоозон шиг юм хийж болохгүй ээ. Хүн бүр бага балчраасаа эхлэн социализмын өмчийн эс ширхэг бүрийг нандигнан хамгаална гэдэг. Эс ширхэг гэдэг үг байсан шүү дээ. Түүн шиг өнөөдөр Үндсэн хуульдаа ингэж аймшигтай үг, өгүүлбэр оруулаад түүгээрээ дараа нь хойч үеэ шоолуулж суухгүй байхыг та бүхнээс уриалан хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Энэ төслийн заалтын талаар нэг ч үг ярьсангүй. Дараагийнх нь Дэндэвийн Тэрбишдагва гишүүн.

Д.Тэрбишдагва: Баярлалаа. Би түрүүн үндэслэлүүдээ нэлээн ярьсан. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн яамтай улс орон хөгжөөд байгаа юм. Үүнийг чинь олон газраас туршлага судалж, уншиж харсны үндсэн дээр л энэ саналуудыг хэлээд байгаа юм. Энэ дээр попорсон юм бол байхгүй. Ер нь эдийн засгийн

хөгжлийн суурь, иж бүрнээр нь харах болчихсон юм. Сая манай хүмүүсийн ярьж байгаатай их олон зүйл дээр санал нэг байгаа юм. Тэгэхээр энэ болгоныг чинь приоритероор нь алиныг нь нэгдүгээрт хийх вэ, алиныг нь хоёрдугаарт хийх вэ гээд ингээд урт, дунд хугацаагаар нь төлөвлөөд, түүнийг нь яг хариуцсан байгууллагатай больё гэж яриад байгаа юм.

Одоо бол Үндэсний хөгжлийн газар гээд нэг байгууллага байгаа. Тэр бол яамны доор нэг агентлаг. Үндэсний хөгжлийн бодлогыг нэг агентлаг авч явахгүй л дээ. Үүнийг Шадар сайдын хэмжээнд авч явах ёстой. Улс орнууд, ямар улс орон ямар бодлоготой вэ гэдгээсээ шалтгаалаад энэ Шадар сайд гэдэг хүн бол гадаад бодлого нь чухал байдаг юм бол Шадар сайд бөгөөд Гадаад хэргийн сайд, эдийн засгийн бодлого маш чухал байдаг юм бол Шадар сайд бөгөөд эдийн засгийн хөгжлийн асуудал хариуцсан Шадар сайд ч гэдэг юм ийм маягаар явдаг. Тэгэхгүй нэг агентлаг, нэг яам гээд Төлөвлөгөөний комиссоос хойш бид ямар ч төлөвлөлтгүй явсан. Төлөвлөлтгүй яв гэдгийг чинь бид нарт барууныхан орж ирж зааж өгсөн шүү дээ. Монгол Улс төлөвлөгөөт эдийн засаг гэдэг юмнаасаа боль, чөлөөт эдийн засаг гэдэг руу яв. Дураараа дургиж, дунд чөмгөөрөө жиргэ гэдэг юмыг чинь эргээд бид ийм замбараагүй байдалд орчхоод байгаа юм. Тэгээд үүнээс чинь болоод өнөөдөр ажилгүйдэл, ядуурал их болж байна. Үйлдвэр, аж ахуйн газрууд хэн дуртай нь дураараа үйлдвэр, аж ахуйн газар байгуулж байна. Баялгаа бол хэн дуртай нь эзэмшиж байна. Хаа дуртай газраа ухаж байна. Түүнээс чинь болоод байгаль орчин чинь сүйрч байна. Энэ эндээс нь ингээд аваад үзэх юм бол өнөөдөр энэ нийгмийн суурь асуудал бол өнөөдөр ард түмэн ажилтай, орлоготой байх ёстой. Ард түмэн барилгатай, орон сууцтай байх ёстой, ард түмэн утаагүй нөхцөлд ажиллах ёстой гээд ингээд үзэх юм бол ямар үйлдвэр, аж ахуйн газар байгаа юм, ямар чиглэлээр, яаж бүсчилж хөгжүүлэх вэ гээд энэ иж бүрнээр нь төлөвлөөд үзэх юм бол тэр намын мөрийн хөтөлбөр, яг энэ том төлөвлөлт дээрээ тулгуурлаж хийж, Үндсэн хууль дээр заасан том бодлогынх нь бичиг баримтаар гарч ирсэн, яам, Тамгын газрын боловсруулсан бодлого дээр нь тулгуурлаж, жижиг байна уу, том байна уу аль нэгэн нам энэ бодлого дээр тулгуурлаж эдийн засгаа хөгжүүлэхгүй бол бид ерөөсөө замбараагаа алдлаа.

Хамгийн гол нь эдийн засгийн хөгжил нь ийм биш байгаа учраас бид нарын амьдрал сайжрахгүй байгаа. Энэ бол ямар нэгэн попорсон, ямар нэгэн ийм асуудал байхгүй. Энэ эдийн засгийн асуудлыг энэ Үндсэн хуульд оруулж байгаа ганц тулгуур заалт энэ юм байгаа. Монгол Улсын хувьд би түрүүн хэлсэн, 2 хөршийн дунд байдаг улс. Үнэхээрийн бид эдийн засгаа хөгжүүлж, эдийн засгийн бодлоготой хөгжиж чадахгүй бол энэ улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнол энэ дээр л тулгуурлана. Монгол Улс түүх шастираараа гайхамшигтай орон. Бид нарыг эхлээд ардчилал, зах зээлд орж байхад, либерал ардчилал байдаг Японы зөвлөхүүд ирж байсан. Дараа нь саяхан бид нарыг чөлөөтэй та нар либерал ардчиллаар яв, зах зээлээр явж гэж зааж байсан. Өнөөдөр төлөвлөгөөт ажил гээд бидэнд эргээд ном уншаад явж байна билээ. Жеймс Бейкер ирээд та нар ардчиллын баян бүрд гэсэн. Яг нарийндаа ярих юм бол бид Монгол Улс баялгийн баян бүрдтэй улс. Баялгаа ухаад, баян бүрдээ ашиглаж чадахгүй гадна, дотнынхонд өгч байна. Бид археологийн баян бүрдтэй улс. Археологийнхоо баян бүрдийг ухаж төнхөөд дэлхийд гаргаад үзүүлэхийн оронд замбараагүй ийш, тийш нь худалдаж, замбараагүй болж байна.

Бид динозаврын баян бүрдтэй улс. Бид түүхийн баян бүрдтэй улс. Өнөөдөр бид оюунлагийн баян бүрдтэй улс. Энэ болгоныгоо ашиглаад эдийн засгийн хөгжлийнхөө бодлогыг явуулахгүй бол болохгүй. Одоо 10 гаруй байгууллага 1990 оноос хойш байгуулагдсан байна. Тэгээд сольчихдог. Тийм учраас тогтвортой, дунд, удаан хугацааны хөгжлийн нэгдсэн бодлогыг төлөвлөгөөтэй хөгжүүлнэ.

Энэхүү бодлого, төлөвлөлтийг тогтвортой, залгамж шинж чанартай хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллага гээд. Тэгээд ийм том байгууллага ийм зөв бодлоготой гаргаж ирэх юм бол энэ чинь хэрэгжүүлэх бүрэн боломж байна шүү дээ.

Социализмыг сайн, муу гэж хэлж байгаа. 1980-аад оны сүүлчээр одоогийн энэ бичиг баримт нь байна. Монгол Улсыг 50 жил хөгжүүлэх бодлогын бичиг баримт гаргаж байсан. Хаана ямар үйлдвэр, аж ахуйн газар барих вэ, хаана ямар баялаг байна вэ гэдгийг чинь аль хэдийн гаргаж ирж байгаад бодлогоор төлөвлөсөн байна. Гэтэл үүнээс хойш ардчилал, зах зээлд ороод хэн дуртай нь газраа ухаж байна. Хэн дуртай нь голоо ширгээж байна. Хэн дуртай нь дураараа ноос, ноолуурын үйлдвэр байгуулаад Туул голоо бохирдуулж байна. Ингэж улс орон хөгждөг юм уу. Тэгэхээр өнөөдөр улс орны гол цөм нь эдийн засгийн хөгжил орох оронтой баймаар байна, өмсөх хувцастай баймаар байна, идэх хоолтой баймаар байна. Тэгээд улс орон маань орлоготой баймаар байна. Ингэхгүйгээр болохгүй байна шүү дээ. Би түрүүн хэд хэдэн жишээнүүдийг хэлсэн. Өнөөдөр дэлхий нийт аль олон ардчилсан орон, аль орон тоталитар дэглэмтэй гэж ярихаасаа илүү аль орны эдийн засаг илүү байна, тэр орон руу л өнөөдөр хөрөнгө оруулж байна шүү дээ. Арабын орнуудыг шейхтэй, тэгээд тэнд хүний эрх зөрчдөг гэдэг, тэнд хамгийн их хөрөнгө оруулж байгаа шүү дээ. Коммунист орон гээд Хятадыг хэлдэг, хамгийн их хөрөнгө оруулж байгаа шүү дээ. Гэтэл Монголд өнөөдөр эдийн засгийн нөхцөл байдал ийм байгаа нөхцөлд ерөөсөө хөрөнгө оруулагч байхгүй байна.

Эдийн засгийн нөхцөл байдал сайжраад ирэх юм бол энэ улс төрчид дахин, дахин энэ ард түмнийгээ худалдан авч, Монголын баялгаар хулгай хийж баяжсан, 70 жил бүтээн байгуулсан улсын үйлдвэрийн газруудыг хувьчилж аваад, баяжаад улс төрд ороод ирж байгаа. Өнөөдөр оффшор дансанд мөнгө, төгрөгтэй хүмүүс энэ ард түмэнд чинь нөлөөлж улс төржүүлдэг, мөнгөөр жагсуулдаг, хооронд нь үзэлцүүлдэг. Гурав аравны хоёрхон сая хүмүүсийг хооронд нь үзэлцүүлж, талцуулж, задралыг бий болгож байна, зааг, ялгааг бий болгож байна шүү дээ. Тэгэхээр энэ эдийн засгийн хөгжлийн төв байгууллагатай болъё гэдгийг яагаад Үндсэн хуульд оруулна гэвэл Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын үндсэн баталгаа нь Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, ард түмний аюулгүй амьдрах нөхцөл байдал нь хүн сайн амьдрах нөхцөл байдал учраас энэ Үндсэн хуульд оруулъя. Ингэж байх юм бол энэ тусгаар тогтносон Монгол Улс эдийн засгаараа хүчирхэг байж чадах юм бол дэлхийн улс орон хөгжиж чадна. Түүн дээр нь тулгуурлаад бид хөгжил дэвшлийг, ардчиллыг, зах зээлийг ярих болохоос биш хүний эрх чөлөө юу ч хийж болно гэж, хар тамхи татаж болно, хүн алж болно, байгалиа ухаж болно гээд ардчилал, зах зээл, хүний эрх гэдгийн дор дураараа загнахыг хэлдэггүй байлгүй. Тийм учраас үүнийг эсэргүүцээд байхыг ойлгохгүй байгаа юм.

Тэгэхээр энэ заалтыг би түрүүн баахан гишүүд 10.1 дүгээр заалт дээр жаахан өөрчлөлт оруулъя гэсэн. Тэгэхээр энэ заалтыг хөгжлийн бодлогыг төлөвлөж, тогтвортой байна гэсний оронд ийм үг оруулмаар байгаа юм. Үүнийг үргэлжлүүлэн Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт, дунд хугацааны хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлнэ. Энэхүү бодлого, төлөвлөлтийг тогтвортой, залгамж чанартай хэрэгжүүлж төрийн захиргааны төв байгууллагатай байна гэсэн үгийг л тэр тогтвортой, төлөвлөлттэй гэсэн үгний оронд дэлгэрүүлээд оруулаад өгчих юм бол бид төлөвлөгөөтэй хөгжих нь ээ.

Одоо бол урт хугацааны төлөвлөгөө гэж ярьж байгаа. Тэр төлөвлөгөө байгаа мөртөө баахан юм ярьдаг. Яг бодит амьдралд үүнийг чинь зохион

байгуулаад, аваад явчих байгууллага байхгүй байна шүү дээ. Хамгийн том байгууллага нь гэж байгаа Үндэсний хөгжлийн газар нь агентлагийн хэмжээнд байдаг. Агентлагийн даргадаа удирдагддаг сайдууд гэж байдаг юм уу. Тийм учраас Шадар сайдын хэмжээнд удирдаж, энэ болгоныгоо сайд нарыгаа зангидаж, хөгжлийнхөө бодлогыг зангидаж, тэр хэлсэн, ярьсан үг нь жинхэнэ хэрэгжиж явдаг ийм байгууллагатай болох үүднээс үүнийг чинь оруулъя, ийм захиргааны байгууллагатай болчихъё гэдгийг эсэргүүцээд, тэгээд энэ хэдэн хуульчид чинь хуулийн юм яриад байдаг болохоос биш, хууль чухал ч гэсэн эдийн засгийн нөхцөл байдалгүйгээр хэчнээн хууль, хэчнээн гоё юм яриад ард түмний амьдрал сайн биш байх юм бол юу яриад, ямар ч хэрэг байхгүй байна шүү дээ. Тэгэхээр хүмүүсийн амьдралыг сайжруулахын тулд ийм захиргаатай болгоё, зангидаж өгье гэж юм яриад байхад үүнийг ойлгохгүй, ойлгосон ч буруугаар ярина. Энэ заалтыг дараагийн гуравдугаар хэлэлцүүлэгт оруулж ирээч гэж би гуйгаад байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Баагаагийн Баттөмөр үг хэлнэ.

Б.Баттөмөр: Энэ ийм санал оруулаад байгаа нь сая Тэрбишдагва гишүүн тодорхой хэлчихлээ. Аргаа бараад л ийм юм бид энэ Үндсэн хуульд оруулъя гээд яваад байгаа шүү дээ. 30 жилийн хугацаанд энэ Монголын хөгжлийн асуудлыг зангидаж явдаг байгууллага байсангүй. Ийм учраас хөгжсөнгүй. Энэ хөгжлийн асуудал гэхээр их хялбар юм бодоод байгаа юм. Энэ чинь маш их том өргөн хүрээтэй ойлголт. Өнгөрсөн хугацаанд 3 удаа ийм хөгжлийн хөтөлбөр боловсруулсан байгаа. Мянганы зорилтод суурилсан эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөр дараа нь хамгийн сүүлд Тогтвортой хөгжил-2030 гээд. Ер нь хэрэгжиж байгаа юм бол байхгүй байгаа юм. Тухайлбал энэ 2030 гэхэд, хамгийн сүүлийн хөтөлбөр гэхэд л нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээг 17500 болгоно гэж байгаа. ДНБ-ний хэмжээ өсөөд байдаг, долларт нь шилжүүлэхээр өсдөггүй. Яагаад гэхээр монгол төгрөгийн ханш байнга унаж байдаг. Ийм л гаж гэхээр юм уу? Ийм байдал ингэж ажиглагдаж байгаа юм Монголын нийгэм, улс төрийн амьдралд.

Тэгэхээр энэ хөгжлийн асуудал гэдэг бол их том өргөн хүрээтэй ийм асуудал. Ийм учраас үүнийг бид их олон талаас бодох ёстой. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог л Монголд бий болгоё. Тэр бүтэц, тэр хариуцсан сайд маань нэгдсэн тогтолцоог бий болгох ийм л агуулгыг энд бид ярьж, хэлж байгаа шүү дээ. Нөгөө коммунизм гэж байдаггүй гэдэгтэй адилхан энэ чөлөөт зах зээл гэж юм байдаггүй юм байна. Үүнийг их олон эрдэмтэд тогтоочихсон байдаг юм байна. Харин төрийн бодлоготой, төрийн зохицуулалттай, үндэснийхээ онцлогт тохирсон хөгжлийн бодлого л байдаг юм байна. Ийм учраас энэ хөгжлийн асуудлыг авч үзэх ийм шаардлага байна.

Монгол Улсад түрүүн би хэлсэн, дэлхийд газар нутгаараа 18-д орж байна. Менделеевийн үелэх системд байдаг тэр элементүүдийн 90 хувь нь, газар нутгийн 30 хувь нь судлагдсан байдаг. Гэтэл 90 хувь нь тэнд байна. Газар дор байж байгаа баялгаараа дэлхийд эхний 10-т орохоор ийм том баялаг байна. Монгол хүний оюун ухаан, ой чадамж бусад хүмүүсээс давуу талтай. Яагаад Монгол Улс хөгжихгүй байна. Энэ 30 жилийн хугацаанд яагаад хөгжсөнгүй вэ гэхээр төрийн бодлого алга. Нэгтгэж, зангидаж байгаа юм алга, энд л байгаа юм. Ийм учраас бид нар энэ хөгжлийн асуудал дээрээ Монголын төр, монголчууд онцгой анхаарах ийм шаардлага үүсээд байгаа юм.

Чөлөөт зах зээл гэж байхгүй ээ. 1990 оноос хойш гаднынхан орж ирээд бүх зүйлээ хувьчил, төрд банк байх хэрэггүй, төрд одоо юу ч байх хэрэггүй. Зах зээл бүгдийг нь аваад явдаг юм. Эрэлт, нийлүүлэлтээр зохицуулдаг юм. Тэр

ифнляцитайгаа битгий хөөцөлд, тэр зах зээл өөрөө зохицуулна. Ханштай битгий хөөцөлд, зах зээл өөрөө зохицуулна, бүгд худлаа. Энэ дэлхийд ийм практик ерөөсөө хаана ч байдаггүй. Үүнийг төрийн бодлогоор л төлүүлэе, төрийн бодлогоор энэ гүйцэтгэлийг нь хянаж байя гэсэн ийм л юм яваад байгаа юм. Бүгдийн зах зээлээ нээчихсэн. Нээгээгүй улсууд нь өнөөдөр хөгжөөд байна шүү дээ, ОХУ, БНХАУ. Дэлхийн хоёр дахь эдийн засаг болчихлоо. Вьетнам бидэнтэй адилхан социалист улс, Казакстан, эд нар манайхан шиг зах зээлээ 100 хувь нээгээгүй. Тодорхой үе шаттай нээсэн. Үе шаттай нээсэн нь хөгжөөд байдаг. Задгай тавьсан нь хөгжлийн мухардалд орсон. Энэ юутай холбоотой вэ гэхээр, хөгжлийн бодлого алга. Ийм учраас ийм болсон юмаа гэдгийг л хэлэх гээд байгаа юм.

Ер нь цаашдаа энэ хөгжлийн бодлого монгол хүний үндэсний эрх ашигт нийцсэн байх ёстой. Нэгдмэл цогц харилцан уялдаатай байх ёстой. Төрийн бодлогын залгамж чанарууд одоо энэ хөгжлийн бодлогод явж байх ёстой. Судалгаанд суурилсан. Монголчууд аливаа зүйлд шийдвэр гаргахдаа ерөөсөө судалгаанд суурилсан юм байдаггүй. Цээжний пангаар тэгэх ёстой гэнэ билээ, ингэх ёстой юм гэнэ билээ гэж ингэж явдаг. Нөөц бололцоондоо тулгуурласан байх ёстой. Энэ их ашигт малтмал, энэ баялаг дээрээ ил тод байх ёстой. Ийм шаардлагууд одоо энэ хөгжлийн бодлогод тавигдана. Тэгээд одоо манайд байхгүй. Тэгээд урт, богино хугацааны олон зүйлүүд байна. Энэ хөгжлийн бодлогоос гадна хөгжлийн загвар гэж юм байна. Монгол Улсыг яаж, ямар хөгжлийн загвар, Монголын хөгжлийн загвар юу байх вэ. Хөгжлийн бодлого, хөгжлийн загвартайгаа харилцан уялдаатай нийцсэн байх ёстой. Энэ юм бол бас алга. Ийм учраас энэ болгоныг л ажил болгоё, энэ болгоныг төрийн бодлого болгож энэ улс орноо хөгжүүлэе гэдэг юм энд яваад байгаа юм.

Энэ төрийн хөгжлийн бодлого дотор маш их олон асуудлууд байгаа. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр байна, үндэсний хөтөлбөрүүд байна, хөрөнгө оруулалтын хөтөлбөр гэж байна. Улс орон нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн төлөвлөгөө, хөтөлбөр гэж байна. Бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр гэж байна. Аймаг, нийслэлийг хөгжүүлэх төлөвлөгөө гэж байна. Санхүүжилтийн эх үүсвэр дээрээ суурилсан байх ёстой энэ бодлогууд маань. Тэгээд хийгдэж байгаа бодлого маань үе, үе шатандаа хяналт шинжилгээ, үнэлгээтэй. Түүндээ суурилж цаашаа хөгжих ёстой гэх мэтийн олон асуудлууд байна. Тэгээд энэ маань одоо ингээд хөгжлийн бодлого маань тогтвортой байна гээд Үндсэн хуульд ийм үг оруулснаараа шийдэгдэх үү, үгүй юу. 1992 оны Үндсэн хуульд энэ бас л ажил хэрэг болговол болгохоор л боллоо, одоо байхгүй байна шүү дээ. Тэгээд үүнийг л Тэрбишдагва гишүүн бид нар яриад байгаа юм. Үүнийг та бүгд бодоорой. Энэ бол гурав дахь хэлэлцүүлгийн үед үүнийг яаж оруулж ирэх ёстой юм. Олон талаас нь бодох ийм шаардлага үүссэн учраас ингэж яриад байгаа юм.

Г.Занданшатар: Одоо Жалбасүрэнгийн Батзандан үг хэлнэ.

Ж.Батзандан: Шударга иргэдийн нэгдсэн эвслээ төлөөлж миний бие Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх хэлэлцүүлэгт оролцож байна. Энэ оны 6 сарын 6-нд Монголын 60 гаруй мянган шударга эх орончид нийлж, Шударга иргэдийн нэгдсэн эвслийг байгуулсан юм.

Шударга иргэдийн нэгдсэн эвслийг улсын бүртгэлд 1 сарын дотор бүртгэх ёстой байсан боловч өнөөдрийг хүртэл МАНАН-гийн шүүх Шударга иргэдийн нэгдсэн эвслийг бүртгэхгүй цаг хожиж байгааг Монголын ард түмэн анхааралтай ажиглаж байгаа. Улсын Их Хурал хуулийн хэрэгжилтэд хяналт тавьдаг байгууллага байгаа. Монгол төр шударга ёсыг тогтооё гэвэл шүүхийг МАНАН

мафийн савраас салгах ёстой гэдэг байр суурин дээрээ бид хатуу байгаа гэдгийг энэ ялдамд хэлэхийг хүсэж байна.

Хоёр зүйлийг хэлэхийг хүсэж байна. Шударга иргэдийн нэгдсэн эвслийг Баасанхүү гишүүн элдвээр доромжлохыг би бас харлаа. Аргагүй ээ, Эрдэнэтээс сонгогдсон Баасанхүү Эрдэнэтийн 49 хувийг хулгай хийх гэж сахал Эрдэнэбилэг, Хурц хоёртой явж байгаад баригдсан юм. Баасанхүү Шударга иргэдийн нэгдсэн эвслийг хараад уур нь хүрч байгаа байх. Баасанхүүгийн хулгайг зогсоосон учраас. Энэ Баасанхүүг Монгол Улсын Их сургуульд сурч байхад нь оюутнуудаас нь би асуусан юм, энэ ямар нөхөр вэ гэж. Хярс Баасанхүү гэдэг нэртэй байсан юм. Хярс Баасанхүү. Одоо бол Их Хурал дотор Хурцын хонины хонхорт явдаг, Хурцын захиалгаар ажилладаг хоргол Баасанхүү гэдэг нэртэй ийм хүн байгаа. Өнөөдөр Үндсэн хуулийн хэлэлцүүлгийн явцад Монголчуудад хэрэгтэй заалт болгоныг Баасанхүү эсэргүүцэж, унагахын төлөө явж байна. Би энэ Их Хурлын танхимд байгаа гишүүд та бүхэндээ хандаж хэлье. Баасанхүүгийн эсэргүүцсэн баас болгоны эсрэг, заалт болгоны эсрэг бид бүгдээрээ хамтдаа зогсож, Монголоо аврах ёстой гэж бид бодож байна.

Өнөөдөр хөгжлийн төлөвлөлт, бодлогын тухай Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад оруулж ирсэн санал Бат-Эрдэнэ гишүүн, Тэрбишдагва гишүүний энэ саналыг би дэмжиж байгаа гэдгээ илэрхийлэхийг хүсэж байна.

Ер нь 1992 оны Үндсэн хууль дотор Үндсэн хуулийн эдийн засаг гэдэг бүлгийг хийж өгье гэж энэ том өөрчлөлтийг бид нар ярьж байгаа. Үндсэн хуулийн эдийн засаг гэдэг бүлэг бол 3 үндсэн том бүлгээс бүрдэх ёстой юм.

Нэгдүгээрт, баялгийн асуудлаа, стратегийн ордуудынхаа 51-ээс доошгүй хувийг Монголын ард түмэнд өмчлүүлэх асуудлыг бид Үндсэн хуулийн эдийн засгийн хүрээнд шийдвэрлэх ёстой гэж бид харж байгаа.

Хоёрдугаарт, өр, зээлийн асуудал. Монгол Улсын өр, зээлийн хэмжээ ДНБ-ний 50 хувиас хэтрэхгүй байхаар бид Үндсэн хуульдаа зааж өгөх ёстой гэдэг ийм бодолтой байгаа.

Гуравдугаарт, төсвийн орлого, зарлагын асуудлыг Үндсэн хуульд оруулж өгснийг би дэмжиж байгаа. Ингэж Үндсэн хуулийн эдийн засагтай, бие даасан бүлэгтэй болж байж Монгол Улсын эдийн засаг хөгжлийн зөв замдаа орно гэдэг ийм байр суурьтай байна.

Хууль зүйн сайдад хандаж би нэг зүйлийг хэлэхийг хүсэж байна. Сүүлийн үед энэ Баасанхүү гэдэг хүн Улсын Их Хурлын гишүүдийг гэмт хэрэгт гүтгэдэг боллоо. Би Улсын Прокурор руу ярилаа. Батзандан дээр эрүүгийн хэрэг үүссэн байна уу гэж. Баасанхүү худал мэдээлэл хийж байна гэж Улсын Прокурор надад сая хэлж байна. Энэ худал яриад байгаа Баасанхүү гэдэг гишүүнийхээ асуудлыг яах юм бэ. Тагнуул руу ярилаа. Нямдорж, Батзандан, Нямбаатар 3 дээр эрүүгийн хэрэг үүссэн гэж энэ Баасанхүү гэдэг гишүүн чинь мэдээлэл хийсэн. Би сая Тагнуулын даргатай ярилаа, тийм зүйл байхгүй гэж ярьж байна. Өдөр болгон худал ярьдаг энэ баас шиг нялцганасан гишүүнийхээ учрыг олоорой Хууль зүйн сайд аа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Гишүүд чухал санал гаргасан. Гэхдээ энэ 5 эрх мэдлийн Үндсэн хуультай Хонконг, Сингапур зэрэг улсуудад энэ байгууллага байдаг. Органик хуулиар үүнийг байгуулах бололцоотой болохоос биш Үндсэн хуулийн байгууллага болгох бололцоогүй гэж ажлын хэсэг үзсэн юм байна.

Ийм учраас органик хууль бусад салбарлан гарах хуулиуд дээрээ сайн анхаарах нь зүйтэй байхаа. Энэ санаануудыг тусгах талаар анхаарч ажиллах нь зүйтэй байхаа.

Ингээд санал хураалт явуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй санал.

Энэ санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал.

10.3. Төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын “бодлого” гэснийг “дунд, урт хугацааны бодлого” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй санал байна.

Эрхэм гишүүн Баагаагийн Баттөмөр санал татах саналаа хэлнэ.

Б.Баттөмөр: Энэ 10.3 дахь заалт түрүүн яригдсан учраас энэ “бодлого” гэсний дараа “дунд, урт хугацааны бодлого” гэж өөрчлөх саналыг татаж байна.

Г.Занданшатар: Санал гаргасан гишүүн саналаа татсан учраас саналыг татсанд тооцлоо.

10.4. Төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад Засгийн газрын өрийн дээд хэмжээ ДНБ-ний 60 хувиас илүүгүй байна. Төрийн татвар хураамжийг зөвхөн хуулиар тогтооно гэсэн өгүүлбэр нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй.

Эрхэм гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Би товчхон үг хэлнэ. Энэ заалтыг дэмжээгүй юм байна тийм үү. Тэгэхээр би бол энэ дэмжээгүйгээрээ байсан нь дээр гэж бодож байгаа юм. Ялангуяа одоо иймэрхүү төсөв, санхүүтэй холбоотой юм бүрийг ингэж хуульд оруулж болохгүй ээ. Амьдрал баян. Хямралтай үе тохиолдож болно, зээл аваад гарах үе гарч болно, зөвхөн Үндсэн хуульдаа баригдаад суугаад байж болохгүй. Өөр нэг асуудал бол энэ ДНБ-ний нэрлэсэн үнээр юм уу, өнөөгийн үнэ цэнээр юм уу гэдэг нь бас тодорхой биш юм билээ. Энэ чинь одоо нэрлэсэн үнээр ийм байх юм бол угаасаа энэ чинь бүтэхгүй юм болно. Тийм учраас хэрвээ үүнийгээ шийдэх дээрээ тулбал энэ нь маш нарийн, өнөөгийн үнэ цэнээр юм уу гэдгээ шийдэж байж явахгүй бол энэ бас осолтой заалт. Яагаад гэвэл эдийн засгийн хямралтай хүнд үе гарах үед зээл авахад Үндсэн хуулиа зөрчих тухай асуудал гарч магадгүй шүү.

Г.Занданшатар: Баярлалаа. Эрхэм гишүүн Дондогдоржийн Эрдэнэбат үг хэлнэ.

Д.Эрдэнэбат: Баярлалаа. Энэ манай намын зөвлөлийн санал. Ялангуяа төрийн эдийн засгийн бодлоготой чухал холбоотой гарсан ийм санал юм байгаа. Түрүүн би хэлсэн шүү дээ. Бид нар түрүүн энэ төрийн эдийн засгийн бодлоготой холбоотой асуудлаар би түрүүн тодорхой тайлбар хийсэн. Үндсэн хуульд ямар ач холбогдолтой юм бэ гэж. Тэгээд ч түрүүний заалтыг манай зөвлөлийнхөн бүгд дэмжсэн. Ганц гялтайж байгаа заалт нь энэ байна аа гээд. Бид энэ асуудал дээр нэлээн өөрийнхөө санал бодлоор, үзэл бодлоороо хандах хэрэгтэй. Хамгийн гол

нь бидний явж ирсэн амьдралд, төсөв, эдийн засгийн нөхцөл байдалд ямар зүйл их садаа болсон бэ. Манайх шиг жижиг эдийн засагтай орон юугаа хязгаарлаж болох вэ, юугаа хязгаарлаж болохгүй вэ гэдгээ тал талаасаа бодох хэрэгтэй. Өнгөрсөн 2 парламентын хувьд би өөрөө сууж байсны хувьд Төсвийн тогтвортой байдлын хууль гэж нэг гаргаад, Засгийн газрын өр болон улсын өрийн хэмжээг жил болгоноор тогтоогоод, түүнийгээ гуравны хоёроор хуулиа өөрчилнө гэсэн ийм заалттай ийм хууль байсан юм. Одоо өнөөдөр бол олонхоороо баталдаг ийм хууль байгаа. Үүнийг ямар нам гарна вэ, өөрийнхөө үзэмжээр өөрчилдөг байсан нь бол тодорхой болсон зүйл ээ. Ялангуяа манайх жижиг эдийн засагтай улс орон бол ДНБ-ээсээ илүү давсан өрөнд хэзээ ч орж болохгүй. Ялангуяа ийм хоёр том хөршийн дунд байгаа. Нэг улсаас эдийн засгийн бас гол нь хараат нөхцөл үүссэн, экспортын хувьд ч тэр, импортын хувьд ч тэр. Тийм учраас энэ бол бидний хувьд эдийн засгийн онцлогоосоо, газар зүйн байрлалаасаа хамаараад үнэхээр үүнийг Үндсэн хуульд зайлшгүй тусгаж өгөх шаардлагатай гэж үзэж байгаа.

Олон орны Үндсэн хуульд энэ асуудлаар туссан байдаг юм билээ. Тэгэхдээ тусгахдаа үнэхээр жижиг улс орнууд тусгасан байдаг нь нэг онцлог байдгаа гэдгийг би та бүхэнд сануулж хэлмээр байна.

Засгийн газрын өрийн дээд хэмжээ ДНБ-ний 60 хувиас илүүгүй байна гэдгийг заасан. Энэ Засгийн газрын өр. Улсын өр гэвэл бас нэг өөр хэрэг. Улсын өрөнд хувийн компаниудын үйл ажиллагаануудын зээлүүд бас ордог. Яагаад Засгийн газар гэж онцолсон юм бэ гэхээр Засгийн газар ихэнхдээ дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хийдэг. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн үр ашгийн хувьд нөхөн төлөгдөх бололцоо муутай, ард иргэдийн татвараас үүнийг буцаан төлдөг, төсвөөс төлдөг ийм өр үүсэх юмаа. Үүнийг үүсдэг гэдгийг манайхан бүгдээрээ мэдэж байгаа. Тийм учраас энэ хүрээндээ тодорхой хэмжээний хязгаартай байхгүй бол ямар нам гарч ирнэ вэ, тэр нь мөнгө дутахаараа мөнгө зээлдэг, өрийн хэмжээ жилийн жилд нэмэгддэг. Өнөөдөр ч гэсэн Засгийн газрын өрийн хэмжээ нэмэгдээд л явж байгаа. Тэгэхээр энд жижиг эдийн засагтай манай орны хувьд Засгийн газрын өрийн дээд хэмжээг тогтоож өгөх нь зөв гэж бид ингэж үзсэн. Тэгэхээр манай гишүүд үүнийг жаахан өөр өөрсдийнхөө өнцгөөс маш сайн бодож үзээрэй.

Сая ч гэсэн Ардын нам олонх болонгуутаа гуравны хоёрыг нь цуцлуулаад олонхоороо баталдаг болсон. Энэ бол дахиад л өөрчлөгдсөн шүү дээ. Миний бодож байгаагаар би эндүү бодоогүй бол 2 ч удаа Төсвийн тогтвортой байдлын хуулийг өөрчиллөө, өрийн өсөлтөөс хамаараад. Тэгэхээр цаашдаа бол ингэж явж болохгүй гэдгийг би та бүхэнд хэлье.

Төрийн татвар хураамжийг зөвхөн хуулиар тогтооно гэдэг өгүүлбэрийг бид оруулсан. Энэ бол бусад орны би дахиад онцолж хэлье. Жижиг эдийн засагтай бусад орны бүх Үндсэн хуульд ойлгомжтой туссан зүйл байдаг. Өнөөдөр бид нар хураамж хүртэл хэн дуртай нь, бараг байгууллага болгон хураамж тогтоож байна даа. Замын хураамжаас эхлээд иргэдийн хармааг суйлдаг юм бүр хавтгай болсон шүү дээ. Үүнийг бид нар хуульчилж өгөх ёстой. Төр өөрийнхөө татварын болон хураамжийг тодорхой хатуу хуулиар хязгаарлаж өгөх ёстой гэж бид ингэж үзэж байгаа. Тийм учраас энэ заалтыг оруулсан. Би энэ саналаа татахгүй ээ. Тэгээд манай гишүүд өөрсдөө өөр өөрийнхөөрөө дүгнэж үзнэ биз. Энэ саналыг дэмжээд цаашаа явах юм бол их зөв заалт болно гэж би ингэж харж байгаа шүү. Баярлалаа.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Магваны Билэгт үг хэлнэ.

М.Билэгт: Энэ Засгийн газрын өрийн дээд хэмжээ ДНБ-ний 60 хувиас илүүгүй байна гэдэг энэ уг нь бид нар энэ талаар тодорхой ийм заалт, цензур хийж

өгөх ёстой юм байна гэж бодогддог юм. Одоо яаж байна вэ гэхээр гадаадын баахан хөнгөлөлттэй зээлээр гэдэг төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг юм. Гэтэл өнөөдөр үндэсний мөнгөн тэмдэгт жилээс жилд унасаар байгаад одоо 30-40 жилийн хугацаатай тэр зээлийг бидний хойч ирээдүй нөгөө үндэсний мөнгөн тэмдэгт нь одоо энэ сүүлийн 20 жилийн хугацаанд 300 хувь унасан шиг ийм хэмжээнд унах юм бол яах юм болж байна. Тэгэхээр энэ дээр анхаарахгүй бол болохгүй болчхоод байгаа юм. Жишээ нь, 2012 онд гаднын Азийн хөгжлийн банк, Солонгосын Экзим банк гээд эд нараас гэхэд л 50 хэдэн сая, 50 хэдэн сая долларын зээлийг 30-40 жилийн хугацаатай төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр жилийн 0.5 хувийн хүүтэй авсан. Гэтэл тухайн үед доллар 1200-1300-гийн хооронд байсан. 71 тэрбум төгрөг төлөхөөр байна гэсэн үг, тэр үеийнхээр бол. Гэтэл яг өнөөдрийн ханшаар харахад энэ ингээд 140 тэрбум болчихсон. Тэгтэл 30 жилийн дараа, 40 жилийн дараа 140 тэрбум биш бүр хэдэн их наяд болох юм уу, ийм л байдлаар бид үндэсний мөнгөн тэмдэгтээ унагаагаад байх юм бол энэ гадаадын банкнуудыг мөнгийг нь өсгөх, мөнгийг нь хүүлэх энэ дэмжлэгийг манайх энэ урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл гэдэг нэрийн дор ийм бодлого яваад байна, манай төрийн бодлого үүгээр яваад байна. Энэ болмооргүй санагдаж байна. Тийм учраас энэ дээр анхаарах хэрэгтэй.

Үндэсний мөнгөн тэмдэгт бол ингээд жилээс жилд унаад байх юм бол бидний хойч ирээдүйд ямар амьдрал, ямар эрсдэл бий болох вэ гэдгийг бид энэ Үндсэн хууль хэлэлцэж байх явцдаа нэг удаа энэ өөрчлөлт оруулах явцдаа, энэ дээр тодорхой цензур тавьж, дээр нь энэ өр зээл дээрээ, энэ чинь дандаа гадаадын зээл бол валютын зээл байгаа. Тэгээд үндэсний мөнгөн тэмдэгт унаад байхаар ямар хэмжээнд очиж хойч ирээдүйд маань эрсдэл үүсэх билээ гэдгийг бодох ёстой.

Мөн валютын эх үүсвэрээ бүрдүүлж байна гэж хэлээд одоо ерөөсөө ганц тооны машин дээр боддог нөгөө бодлого боловсруулдаг юм нь юу болчихсон бэ гэхээр Сангийн яаман дээр, ерөөсөө газрын доорх баялгаа ухаж, байгалиа сүйтгэж, алт олборлохыг дэмжинэ. Тэгснээ нүүрс төчнөөн тонныг гаргана гэж ингэж л ярьдаг болсон. Үүнээс өөр юм бодохоо больсон. Гэтэл валютын эх үүсвэрээ бүрдүүлэхийн тулд гадагшаа гарч байгаа валютаа зогсоох, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, дотооддоо үйлдвэрлэдэг юмнуудаа дэмжих үүнийг төр бодлогоор, татварын бодлогоор зохицуулах юмыг бусад улс орон хийдэг байх, манайх хийхгүй байгаа. Одоо нүүрсийг жишээ нь өмнөх жилд 22 мянган тонн нүүрс гаргалаа гээд хэлж байгаа юм. Гэтэл нөгөө 22 мянган тонн нүүрс чинь 75 аравны хэдэн доллароор явж байгаа гээд. Тэгээд тухайн үеийнх нь төсөвт баталсан 2560-аар нь бодохоор 200 хэдэн мянган төгрөг 1 тонн нь. Тэгэхдээ бодит амьдрал дээр яг улсын төсөвт орж ирж байгаа нь ноднин яасан 720 тэрбум л орж ирж байна. Тэгвэл 22 мянган тонн-доо хуваах юм бол 1 тонн нүүрс 32 мянган төгрөгөөр улсын төсөвт мөнгө нь орж ирж байгаа юм. Тэр байгалийг сүйтгэж, сүйтгэж. Дээр нь нүүрсийг сорчилж авч байгаа. Гэтэл өнөөдөр бидний, манай Монголчуудын үндэсний нөхөн сэргээгдэх баялаг зүгээр л ямааны арьс нь 30 хэдэн мянган төгрөг, өвөл 40 мянган төгрөг хүрч байгаа шүү дээ, зөвхөн арьс нь шүү дээ. Тэгэхэд энэ дээр үндэсний онцлогт зохицсон эдийн засгийн бодлогоо боловсруулаач ээ. Ийм бодлого боловсруулах талаас нь одоо энэ хойч ирээдүй, энэ ирээдүй залуучуудаа бид тэр талаас нь төлөвшүүлэх хэрэгтэй болж байна гэдгийг л би дахин дахин хэлмээр байна.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Загдхүүгийн Нарантуяа үг хэлнэ.

З.Нарантуяа: Төслийн 2 дугаар зүйл буюу 25 дугаар зүйлийн 1.7-д, Засгийн газрын өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн өрийн дээд хэмжээг ДНБ-ний 60

хувиас илүүгүй байна гэдэг энэ заалтыг үнэхээр оруулах шаардлага байгаа юм. Ер нь төсвийн сахилга хариуцлагыг сайжруулъя гэж 2010 онд анх Төсвийн тогтвортой байдлын тухай хууль баталсан. Энэ хуулийн 6.1.4-т Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл бол тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-нийхээ 40 хувиас хэтрэхгүй байна гэж анх тэгж суулгаж байсан. Дараа нь 2015 онд 60 болгосон. Энэ өөрчилдөг асуудал үргэлжилсээр байгаад энэ Тогтвортой байдлынхаа хуулийн 19.3-т 2016 онд 88 хувь, 2017 онд 85 хувь, 2018 онд 80 хувь, 2019 онд 75 хувь гээд энэ хэмжээнүүд бол төсөв батлагдах болгонд, Төсвийн хүрээний мэдэгдэл батлагдах бүрд ингэж өөрчлөгдөж байгаа. Энэ өөрөө бол төсвийн сахилга хариуцлагыг муутгаж байгаа гол үндсэн үзүүлэлт шүү дээ.

Өнөөдрийн Засгийн газрын өр тэгвэл хэд байгаа юм бэ гэж. 2016 оны 6 сард Улсын Их Хурлын сонгуулийн дараа энэ Улсын Их Хурлыг үйл ажиллагаагаа эхлэх тэр мөчид 16 их наяд 612 тэрбум төгрөгийн Засгийн газрын өр байсан. Өнөөдөр 2019 оны 8 сарын байдлаар 22 их наяд 361 тэрбум буюу даруй бараг 6 их наяд төгрөгийн өр нэмэгдсэн байгаа. Энэ бол яг бодит бид нарын байж байгаа төсөвтөө яаж ханддаг, ямар сахилга хариуцлагагүй байдгийг, Үндсэн хуульд хийж өгөхгүй бол наад органик гэж бид нарын яриад байгаа тусгай зохицуулалтын хуулиа яаж дураараа өөрчилдгийн илрэл шүү дээ. Үнэхээр л бид нар үүнийгээ хаая гэж байгаа бол Үндсэн хуульд энэ заалтыг оруулах дотоод хэрэгцээ шаардлага аль хэзээ бий болчихсон байна. Иргэдийн хүсэлт ч энэ байна.

Хоёрдугаарт, энэ бол Үндсэн хуульд байж болдоггүй заалт биш, байдаг. Маш олон улсууд бас л бид нарын энэ зовлонг эдлээд Үндсэн хуульдаа ийм заалтыг оруулсан байна. Хэд хэдэн орнууд, 10 гаруй орнуудын Үндсэн хуульд ийм байгаа гэдгийг энэ Үндсэн хуулийн ажлын хэсэгт одоо ороод ажиллаж байгаа энэ хүмүүсийн хийсэн судалгаа өөрөө харуулж байгаа шүү дээ. 60 байх уу, 70 байх уу, 75 байх уу гэдэг нь манай өөрийн өнөөдрийн хүлээгдэж байгаа өрийн хэмжээ, ирээдүйдээ бид нар баялгаа хэрхэн зөв удирдаж, эдийн засгаа бэхжүүлж чадах энэ тооцоон дээр суурилагдаж гарах ёстой юм байгаа. Тэгэхээр энэ заалтыг оруулахгүй бол бид нарын нөгөө гоё яриад байгаа сахилга хариуцлага, зарчим Үндсэн хуулиар тунхаглагдана гэдэг худлаа шүү. Гишүүд минь энэ заалтыг оруулж өгөөч ээ гэж би зөвхөн сая Засгийн газрын өрийн хэмжээн дээр ярилаа. Алдагдлаа бас яаж дураараа дургиж энэ хуулиа өөрчилж байсны жишээ бас энд байна. Алдагдлаа бид нар 2016, 2017, 2018, 2019 онуудад бид нар 18.5 хувь хүртэл тухайн жилийн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг тухайн оны тооцсон ДНБ-нд эзлэх хувь хэмжээг 18.5 хувь хүртэл нэмж л байлаа. Үүнийг л засах гэж Үндсэн хуулийн өөрчлөлтийг хийх гэж байгаа гэж би бол харж байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Эрхэм гишүүн Намсрайн Цэрэнбат.

Н.Цэрэнбат: Энэ Үндсэн хуулийн өөрчлөлт бол сүүлийн 20 гаруй жил Монгол Улсын нийгэмд чөдөр тушаа болсон, хүндрэл үүсгэсэн зүйл заалтад бид өөрчлөлт оруулах гэж байгаа. Тэгээд энэ заалтыг дэмжихгүй байгаа. Яагаад вэ гэвэл, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаагийн 2-т, Монгол Улсын иргэний эдлэх эрх чөлөөг баталгаатай эдэлнэ гэж зааж өгөөд, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн, эдийн засаг алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж байгаа.

Мөн Үндсэн хуулийн Гучин хоёрын 8-д болохоор Засгийн газрын бүрэн эрх байгаа. Засгийн газар нь нийгэм, эдийн засгийн дагуу хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх гэж байгаа. Сүүлийн 20 гаруй жил яагаад ийм болоогүй вэ

гэхээр, өнөөдөр миний яриад, хэлээд байгаа сая эрүүл, аюулгүй орчинд амьдрах баталгаатай эрх, энэ төсвийн хязгаар, өрийн хязгаар гэдгээс болоод хөрөнгө оруулалт хийж чадаагүйгээс болсон. Ийм учраас Засгийн газрын өр дээр бид нар аль болох хурдхан бидэнд нэн шаардлагатай байгаа эрүүл мэнд, боловсрол, ажилгүйдэл гэдэг салбарт томоохон хөрөнгө оруулалтаа хийгээд, тэгээд дараа нь өрөө төлөх ажил уруу оруулмаар байна. Тэгэхгүй бол байгаа мөнгөндөө тааруулж хийж байгаа хөрөнгө оруулалт маань эрүүл мэнд, боловсрол, энэ ажлын байр бий болгох салбарт дутагдсанаас бидний хойч үе бүтэн үеэрээ, хэдэн үеэрээ хохирох гээд байгаа юм. Тийм учраас энэ дээр ийм хязгаарлалтуудыг бид нар хөгжлийн тодорхой түвшинд хүртлээ үүнийг хийх нь зохимжгүй гэж үзэж байгаа.

Хоёрдугаарт нь, төрийн татвар хураамжийг зөвхөн хуулиар тогтооно гэсэн өгүүлбэрийг хэрэгжүүлнэ гээд Улаанбаатар хотод шилжин суурьшиж байгаа хүмүүс дээрх татвар хураамжийг шүүхээс зогсоосноос болж бидэнд байгаа Улаанбаатар хотод бий болсон бөөгнөрөл, ажилгүйдэл, орлогогүй байгаа байдал, эмх замбараагүй байдал өнөөдөр бид нарын бодит үнэн дүр төрх болсон. Тийм учраас энэ дээр бид анхаарах ёстой. Тийм учраас нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжүүд өөрсдийн нутаг дэвсгэр дээр зөв зүйтэй, эдийн засгийн зөв харилцаатай байхын тулд энэ татвар хураамжаа өөрсдөө тогтоодог байх ёстой гэж бодож байгаа.

Тийм учраас бид энэ өөрчлөлтүүдийг хийхийн тулд Засгийн газрын өр дээр тодорхой хувь тогтоохыг дэмжихгүй байна. Мөн төрийн татвар хураамжийг зөвхөн хуулиар тогтооно гэдэг нь хөгжих гэж байгаа, шинээр бий болох хотуудад хамааралтай учраас үүнийг гишүүний хувьд дэмжихгүй байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ үг хэлнэ.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би зарчмын зөрүүтэй маягийн санал хэлэх гээд байна. Ялангуяа энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг энэ хэлэлцүүлгийн явцтай холбоотойгоор. Би үдээс өмнөх чуулган дээр тодорхой саналаа хэлсэн. Тэгээд энд би зарчмын зөрүүтэй саналаа хэлээгүй учраас ач холбогдол өгөхгүй байх шиг байна. Тэгтэл үдээс хойших хуралдаан дээр бол Ардчилсан намын зөвлөлийн дарга бол сая тодорхой байр суурь хэлж байна шүү дээ. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийх хэрэгцээ шаардлага энэ ач холбогдол алга болчихлоо гэж. Тэгэхээр ийм нийгмийн зөвшилцлийн хэмжээнд батлагдах ёстой энэ Үндсэн хуулийн хэлэлцүүлэг чинь ер нь хаашаа болж байна. Би үдээс өмнө хэлсэн. Одоо цөөнх сөрөг хүчний асуудлыг бол ойлгож байгаа. Гэтэл бол одоо эрх барьж байгаа улс төрийн намын, тэгээд Засгийн газрын гишүүн тэгээд одоо олон удаа сонгогдсон манай Даваасүрэн нөхөр бол юу гэж хэлээд байна шүү дээ.

Энэ Үндсэн хуулийн хэлэлцүүлгийг оролцож байгаа та нөхдүүд бол төр ард түмний эсрэг гэмт хэрэгтнүүд шүү. Энэ ч бол би нөхөртөө итгэж байгаа. Ямар нэгэн байдлаар цаад талд нь үндэслэлтэй асуудлыг л тавьж байгаа гэж би ойлгож байгаа шүү дээ. Тэгээд энийг одоо мухарлаач ээ гэсэн үдийн цайны завсарлагаар бол та нарыг ямар нэгэн одоо ажил зохион байгуулсангүй л дээ. Тэгэхээр энэ асуудлууд Ардчилсан намын өөрсдийн байж байгаа, хүмүүсийн илэрхийлж байгаа санал байр суурь.

Дээрээс нь Баасанхүүгийн одоо хэлээд байгаа санал байр суурь энэ юмнуудыг нэг талд нь гаргахгүй бол энэ чинь би Ардчилсан намын зөвлөл хаяж гараад алга болчихож байгаа бол энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх бололцоогүй гэж би анх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг Их Хурал дээр хэлэлцэхээс эхлээд ярьсан шүү дээ. Гэтэл одоо ингээд зөвшилцөл, ойлголцолд хүрсэн ингээд хэлэлцүүлээд эхлээд явж байгаад өнөөдөр Ардчилсан

намын зөвлөлийн дарга Эрдэнэбат даргын хэлж байгаа байр суурь бол ер нь анхаарах ёстой ийм саналуудыг хэлж байна. Тэгээд энийг одоо бүхэлд нь та бүхэн маань нэг анхаарч үзэхгүй бол болохгүй байна.

Өнөөдөр ингээд эрх барьж байгаа энэ 65 суудалтай намын бүлгийн гишүүдээс чинь энд эрүүл мэндийн шалтгаантай аргагүй хүндэтгэн үзэх шалтгаантай хүмүүсийг бол ойлгож байна. Гэтэл ирэх ёстой улсууд чинь ирэхгүй байгаад байна шүү дээ. Өмнөх 7 хоногоос эхлээд огт ирэхгүй байгаад байгаа.

Дээр нь өнөөдөр энэ чинь яг эрх барьж байгаа намын энэ засаг барьж байгаа Засгийн газрын кабинетын гишүүд чинь энэ хуралдаа оролцох ёстой шүү дээ. Тэгтэл одоо бүтэн 7 хоног энэ хэлэлцүүлэг явж байхад хүн ирэхгүй. Зарим нь хоцорч ирнэ. Тэгээд хамгийн түрүүнд гараад алга болно. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс илүү чухал асуудал гэж баймааргүй санагдаад байх юм. Тэгээд энэ асуудлаа Их Хурлын дарга минь анхаарахгүй бол энэ чинь явахааргүй ийм нөхцөл байдалтай байна шүү. Засгийн газрын гишүүд чинь орж ирэнгүүтээ зарим нөхрүүд бол цөөнх рүүгээ жаал дайрч агсарч байгаад гараад явдаг. Энэ цөөнх чинь бид нарт шаардлага тавих бүрэн эрх нь тэр шүү дээ. Эрх баригчид ирцээ бүрдүүл. Асуудалдаа хариуцлагатай оролц. Идэвхтэй оролц гэдэг шаардлагыг тавих ёстой шүү дээ. Тэгээд Засгийн газрын гишүүд орж ирээд цөөнх рүү дайрч байгаад ингээд гараад явдаг. Ийм байж бол таарахгүй байх гэж.

Хоёрдугаарт бол энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал хэрвээ яг ийм маягаараа байх юм бол энэ чинь явахааргүй шинжтэй байна шүү дээ. Яг энэ бол энэ хууль тогтолцоо руу бүх юмыг чихээд байдаг бол болохгүй асуудал шүү дээ. Эргээд сонгогчидтой уулзаж байхад хэлж байгаа шүү дээ. Хууль тогтолцоотой холбоотой юмыг 100 хувь гэж үзэх юм бол 20 хувь нь л одоо хууль тогтолцоотой холбоотой л асуудал байгаа шүү. 80 хувь нь бол хүний хүчин зүйл, хүнтэй холбоотой асуудал байгаа шүү. Энэ ажил хариуцаж байгаа улсуудын хариуцлага үзэл ухамсар эрх ашгийн эрэмбэ энэ бүх юмтай шууд холбогдоно шүү л гэж ингэж хэлээд байна. Бодит амьдрал дээр ч гэсэн яг л ийм байдалтай байгаа шүү. Тэгээд хамгийн сүүлд нь хэлэхэд бол энэ өрийн асуудал байна. Засгийн газрын өрийн асуудал. Өмнө нь яригдсан тэр 2 зүйл, заалт дээр бол би энэ цаг хэмнэх үүднээс үг аваагүй л дээ.

Түүн дээр бол энэ улс орны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх энэ урт дунд хугацааны бодлого, төлөвлөлт энэ бол энийг хариуцсан байгууллага байх ёстой. Тэгтэл энэ дотор бол судалгаа гэдэг үгийг би эрээд олохгүй байгаа байхгүй юу. Ер нь судалгаан дээр тулгуурлахгүй бол ерөөсөө явж болохгүй байна шүү дээ. Хятад одоо энэ дэлхийн эдийн засгийг тодорхойлж байгаа гэж байгаа боловч яг бодит байдал дээр бол энэ Үндэстэн дамнасан компаниуд энэ томоохон одоо эдийн засгийн хүчирхэг энэ улс орнууд чинь бол бүрэн хэмжээний судалгаатай байгаад энэ судалгаан дээрээ тулгуурлаад хааш нь ч хөдөлгөхгүй зах зээлийн үнийг нь ингээд бариад байгаа тухай асуудал бол бодитой ийм асуудал шүү дээ. Тэгтэл бид нар бол цээжнийхээ пангаар ямар ч одоо судалгаа байхгүйгээр ингэж явж байгаа ийм асуудал шүү.

Баярлалаа. Би 5 минутандаа арай багтаасангүй. 5 минут 10 секунд боллоо.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Дэндэвийн Тэрбишдагва.

Д.Тэрбишдагва: Эрхэм гишүүн Дэндэвийн Тэрбишдагва энэ асуудлыг зарчмын хувьд нэгийг нь дэмжээд, нэгийг нь дэмжихгүй байгаа юм. Ардчилсан намыг оруулж ирж байгаад нэг талаасаа баярлаж байгаа. Нөгөө талаасаа бол

Ардчилсан нам алдаагаа ингэж засаж байгаа юм уу, аль эсвэл өөрсдөдөө тохируулж үе үе ингэж өөрчлөгдөөд байдаг юм уу, ийм л болоод байгаа юм.

Ардчилсан намын үед Засгийн үед бол гадаад өрийн дээд хэмжээг гуравны хоёроор Улсын Их Хурлаар шийддэг байсныг эсэргүүцсээр байгаад 50+1 ээр баталдаг болсон. Өнөөдөр болохоор 60 гэж оруулаад ирж байгаа юм. Энэ бол яг одоо сөрөг хүчний үүднээс ингэж оруулж ирж байгаа юм уу. Аль эсвэл үнэхээрийн урд өмнөх алдаа дутагдал дээрээ засаж залруулаад орж ирж байгаа юм уу гэдэг дээр би жоохон гайхаад байгаа юм.

Зарчмын хувьд бол энэ буруу зүйл биш. Ер нь бол жижиг орнуудын эдийн засаг хамааралтай, гадаадаас хамааралтай байдаг жишээ олон бий л дээ. Хамгийн сүүлийн жишээ бол Киргиз байна. Африкийн орнууд өрөнд орчихсон. Ингээд одоо ДНБ-ээсээ 60-аас дээш хувьтай болчих юм бол тэгээд л ер нь бол гаднын л хамааралтай болно шүү дээ. Ялангуяа манайх шиг манай улсын хувьд бол их онцлог орон л доо. 2 том хөрштэй. Гурав дахь хөрш гэж нэрлэгдэх улсууд бол шууд дэмжлэг туслалцаа үзүүлээд, хил хязгаараараа худалдаа наймаа арилжаа хийгээд хөрөнгө оруулахаасаа илүү, ардчилал зах зээлийг нь дэмжээд энэ бусад одоо эдийн засгийг нь либералчлахад дэмжинэ ч гэдэг юм уу ийм маягаар яваад байдаг учраас яг бодит хөрөнгө оруулалт бол орж ирж дэмжиж эдийн засагт нь дэмжиж чаддаггүй юм.

Тийм учраас бид бол гаднын хамааралтай байх нөлөөлөл асар их учраас энэ заалтыг бол ер нь оруулаад өгөхөд бол буруудах юм байхгүй ээ. Энэ аливаа нэгэн сөрөг хүчнийхээ алдаа дутагдлаа засаад зөв зүйтэй оруулж ирж байгаа зүйлийг бол дэмжих ёстой л доо. Зүгээр энэ төрийн татвар хураамжийг зөвхөн хуулиар тогтооно гэдэг бол ер нь бол хуулиар тогтоогоод өгч байгаа органик хуулиудаар тогтоогоод өгч байгаа л даа. Тэрийгээ л засаад залруулаад явахгүй л бол Үндсэн хууль дээр төрийн татвар хураамжийг зөвхөн хуулиар тогтооно гэсэн заалт бол орох нь яагаад ч гэсэн ойлгомжгүй их заалт байна. Энэ бол ойлгомжгүй заалт.

Харин дээд талын Засгийн газрын өрийн дээд хэмжээ ДНБ-ний 60 хувиас илүүгүй байна гэдэг бол Засгийн газрын өр нийт манай өр чинь 30 тэрбум доллар гараад байгаа шүү дээ. Энэ дотроос Засгийн газрын өр нь хэд вэ гэдгийг бодох хэрэгтэй. Ер нь Засгийн газар бол өр тавиад тэтгэвэр, тэтгэмжээ цалин хөлсөө өгч байгаа юм чинь бий шүү дээ. Ийм маягаар бол хөгжихгүй л дээ. Тэгэхээр би түрүүний нөгөө заалтуудыг энэ Үндсэн хуульд оруулаад нэг тогтвортой хөгжлийн бодлоготой төлөвлөгөөтэй, алс ирээдүйгээ харсан 10 жилийн дараа яг ийм болох юм байна. Таван жилийн дараа ийм болох юм байна гээд их тодорхой байдлаар оруулаад өгөөд энийг нь бол төрийн захиргааны төв байгууллагатай удирдаад явсан бол зүгээр байсан юм. Органик хууль руу л хийлээ л дээ. Би дахин дахин хэлж байхад энэ энэ эдийн засгийн тусгаар тогтнол гэдэг бол Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тулгуурын тулгуур шүү.

Эдийн засгийн хүнд байдалд орж байгаа хүмүүс бол ямар байдаг юм бэ гэхээр Солонгос руу л очерлоод л яаж явж байна. Бид өнөөдөр БНХАУ-д миллиард 300 тэрбум хүнтэй, 1.3 тэрбум хүнтэй улсад очиж ажил хийж байна шүү дээ. Манайхан гадагшаа гарч. Яагаад гэвэл энд чинь цалин хөлс нь байхгүй. Эдийн засгийн бодлого нь тогтвортой биш. Яг ямар үйлдвэрлэл явах нь ойлгомжтой биш. Тэрнээс биш манайх бол эдийн засгийн бодлогыг нь явуулаад эхлэх юм бол дэлхийн 7 миллиард хүний хэрэглэж байгаа ноолуурын 40-45 хувь нь Монголд гарч байна. Зөвхөн ноолуураараа бизнес хийхэд бол гуравхан тэрбум хүнээ тэжээж болж байна. Бид ганцхан Эрдэнэтээ саалийн үнээ гэж явж байсан

бол Оюу толгой, Эрдэнэт өөр хэчнээн ч юм байна. 3.2 сая, тэрбум хүнтэй мөртөө 80 сая малтай байж байна.

Энэ бүрийг чинь эдийн засгийн бодлогоор нь зөв тийш нь харуулаад чиглүүлээд ингээд явах юм бол энэ Монгол улс чинь богино хугацаанд хөгжих боломж байгаа учраас энийг одоо Үндсэн хуульдаа ийм юм оруулж өгөөч гээд байхад л органик хууль руу л явуулаад байгаа юм л даа. Тэгэхээр одоо ингэж явах юм бол бид тэр 60 хувь гэдэг заалт оруулах шаардлага ч үгүй. Бид өөрийнхөө эдийн засгийг аваад явчих боломжтой улс байгаа юм л даа. Тэгээд одоо аргаа барагдаад, зах зээлийн үед асар их хэмжээний өр зээлд ороод өр зээл бидэнд өгч байгаа хүмүүс бол сайхан сэтгэлтэй юм шиг ОУВС л гэнэ. Дэлхийн банк л гэнэ. Ерөөсөө бидэнд өгөхөөр нь алгаа тосоод авдаг аав уу даа гэдэг дуу хүртэл байдаг. Түүн шиг алгаа тосож авчхаад баярлаад, хормойгоо дэвсэж авчхаад баярлаад ингээд авдаг. Эргээд төлөх бодлого байхгүй.

Энийг чинь авч байгаа бол төлдөг. Авах уу, үгүй юу гэдгийг төлөвлөдөг тийм газар байхгүй байгаагаас л асуудал ингээд байна шүү дээ. Тэгээд одоо манай зарим гишүүд бол янз янзын мессежээр шантаажлаад нэг үгийг битгий олон дахин хэлээд байгаач ээ гэж янз янзын мессеж бичээд байх юм. Та нар энэ ирэхгүй байгаа хүмүүстэйгээ хариуцлага ярь. Үг хэлж байгаа хүмүүстэй ийм хачин хачин мессеж бичээд бай. Би энэ удаа нэрийг нь хэлэхгүй. Энэ чинь түрүүний 7 хоногийн 4 дэх, 5 дахь өдрөөс авхуулаад ирцэд ирээгүй хүмүүс байж л байгаа шүү дээ. Өнөөдөр Нямдорж гишүүн бол өнөөдөр сүүлийн хэдэн хүмүүсийн нэрийг бичсэн. Өнгөрсөн 7 хоног энэ хүмүүс ирээгүй биш ирсэн бол. Ийм учраас бид нар хөгжлийн бодлоготой холбоотой ярьж байгаа юмыг хажуу талаас нь яриулахгүйгээр янз янзын мессеж бичээд.

Энд ирээд суусан хүмүүс бол үгээ хэлэх ёстой. Бид сэтгэл зүрхээрээ сууж байгаа. Үндсэн хуулийг өөрчлөхийн төлөө сууж байгаа. Сайжруулахын төлөө сууж байгаа. Батлахын төлөө сууж байгаа. Энэ ялангуяа Монгол Улсын хөгжлийн цөмийн цөм болсон эдийн засгийн хөгжлийн асуудалтай холбогдуулаад үг хэлж байгаа. Үг хэлэхээр нь ийм ийм янз янзын юм хэлээд байх шаардлагагүй учраас би дахиад энийг чинь холбож ярьж байна. Одоо бид нарыг өөр үг ярилаа гээд микрофон хаачих гээд байх юм бол тэгвэл болиод явчихъя л даа. Нөгөөдүүлийг нь болохоор шөнийн 1, 2 болтол очоод гуйгаад л түүгээд л хадаг бариад шахуу явж байдаг. Энд байгаа хүмүүсээ үг хэлэхээр нь янз янзаар ингээд байж бас болохгүй шүү дээ. Бүтэн 7 хоног барилаа шүү дээ. Одоо өнөөдөр, өчигдөр дуусах ёстой юмыг маргааш үргэлжлүүлээд хуралдана. Нөгөөдөр хүүхдүүдийн хичээл сургуулийн асуудал гээд зөндөө асуудлууд байна шүү дээ. Ийм учраас бол хэлэх үгээ хэлнэ ээ. Хэлэх гэж энд ирсэн. Хэлэхгүйгээр зугтаагаад, зугтаж явж ирж байгаад одоо орж ирэнгүүтэй ирц гэж яриад байх нь бол зохимжгүй асуудал шүү.

Тийм учраас би бол энэнтэй холбогдуулаад энд ялангуяа эдийн засгийн хөгжлийн асуудал дээр та бүгд хариуцлагатай хандаач ээ. Орж ирж үгээ хэлээч гэж өглөөнөөс хойш хэлээд байгаа нь ийм учиртай. Тэгэхээр бол энэ өрийн дээд хэмжээ ДНБ-ний 60 хувиас дээш гэдэг дээр бол энийг эргэж бодох ёстой.

Уг нь бол ийм юм орохооргүй л улс байгаа юм л даа. Харамсалтай байна. Энэ эдийн засгийн өгөгдөл нь байгалийнх нь баялгийн өгөгдөл нь малынх нь .../минут дуусав/.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Сандагийн Бямбацогт үг хэлнэ. Бямбацогт гишүүн байхгүй байна. Октябрийн Баасанхүү гишүүн үг хэлнэ.

О.Баасанхүү: Бид нар түүхэнд үлдэх том хурал хийж байна л даа. Тэгэхээр энэ бид нарын ярьж байгаа үг өгүүлбэр, эргээд өнөөдөр архивд хадгалагдаад үнэхээр сайн Үндсэн хууль хийсэн бол Үндсэн хуулийн судлаач нар тэр архивыг унших байх. Тэгээд оюутан байж болно, эрдэмтэн доктор гээд 20 жил, 30 жилийн дараа бид нарын ярьж байсан үгийг ишлээд заримыг нь шоолоод, заримыг нь дооглоод, заримыг нь ухаантай мэргэнийг нь гайхаад ингээд явах байх. Түүхийг бид бичдэг. 2012-2016 онд бид нар байхад миний санаж байгаагаар энэ босгыг нэмэх тухай асуудал бол Ардын намын шаардлага битгий нэмээч, 50 хувь ч билүү дээшээ байхгүй бол Монгол Улс сөнөх гээд байна, ингэх гээд байна гээд аймшигтай юм боллоо гэсээр байгаад тэгээд ний нуугүй хэлэхэд бол тухайн үеийн Ардчилсан нам одоо манай Батзандан би хамтдаа засаг барьж байсан учраас мөнгөгүй байна, амьдрал ядуу байна хэцүү байна, яах юм бэ одоо доллар чинь аймшигтай өсөх гээд байна шүү дээ гээд ингээд босго нэмээд Чингис, Самуурай бонд авсан л даа. Есөн шидийн юмнууд авсан. Үүний дараа ерөөсөө энэ босгыг тоодоггүй болсон. Тэгсэн өнөөдөр 30 тэрбум долларын өртэй болчихлоо.

Одоо өнөөдөр хэрвээ Хятадууд магадгүй своп хэлцэл дээр орсон 2 тэрбум доллараа нэхэх ч юм уу. Эсвэл одоо Чингис, Самуурай бондоо бушуухан өгч гэх юм уу. Одоо бид Оюу толгойгоос жижгэрээд байдаг шалтгаан чинь энэ шүү дээ. Ингэвэл бид нар жинхэнэ чацга царайлна. Бид одоо баас гэж ярьсан болохоор чинь баастай чинь холбож жишээ аваад яриад байна шүү дээ.

Тийм учраас миний үндсэн зарчим бол улсаараа тоглохоо боль. Тийм учраас нэг баримжаатай болохгүй бол Монгол бол Орос биш, Америк биш. Америкийн өрийн босго гээд Сангийн яамандаа тавьсан өр нь бол аймшигтай байдаг юм билээ. Өөрөө өөрийнхөө орондоо өчнөөн өртэй. Бараг бид нар сонсвол ухаан алдаж унамаар. Тэгээд яг ингээд цагаа тулахаар тэд нар яах ч үгүй. Таджекстан Монгол хоёр ойролцоо юм шиг байгаа юм. Аль аль нь чанга дуугарвал тэгээд баларна гэдэг шиг. Бид нарын бүх өрийг Парисын бүлэг дээр аваачиж хэлэлцээд, ямар нэгэн улс нь очоод энэ өрийг нь худалдаад авчихъя. 34-ийг нь 20-оор авчихъя ч гэдэг юм уу. Ингэж аваад хамгийн түрүүнд бид нарыг юу вэ гэвэл нэг номерт юу хийх вэ. Онгоцнуудыг нь барьцаална. Бид нар санаж байгаа биз дээ.

Жишээлбэл, нөгөө нэг Канадын Хан Ресурсоос болоод бид онгоцоо барьцаалуулж байсан шүү дээ. 300 сая долларын өрөө төл, үгүй бол онгоцыг чинь барьцааллаа шүү гээд. Германд барьцаалангуут бид нар сандраад бушуухан хэлэлцээрт оръё гээд 70 сая доллар төлөөд гарч байсан. Яг түүн шиг өнөөдөр 3 тэрбум доллароо төл гэвэл өнөөдөр жижигхэн зах зээлийн эдийн засаг бол савлана. Хүнд байдалд орно. Тийм учраас өнөөдөр юу вэ гэх юм бол энэ босгыг 60-аас босгохгүй байя гэдэг юм уу. 60 биш гэвэл хэд байх юм бэ. Нэг баримжаатай болж авахгүй бол дараагийнх нь эдийн засгаа тэлж байна. Өр хамаагүй гэсээр байгаад юмаа алдах вий дээ. Улсаа алдах вий дээ.

Яагаад гэвэл хэдэн гадаадад байгаа валютыг нь аваад эсвэл одоо юу гэх юм бэ вагоныг нь аваад, онгоцыг нь аваад бүтэн юу гэдэг юм Элчин сайдын яамны байрыг аваад тэр өрөнд чинь юу ч болохгүй шүү дээ. Энэ олон улсын хууль гэж байна. Тийм учраас энэ өрийн босгыг тодорхой болгоё гэдэг энэ зарчим бол зөв байх аа гэж би бодож байгаа. Би дандаа эсэргүүцдэггүй. Юуны өмнө хэрвээ та нар протокол дээр харах юм бол би 25 дугаар зүйлийн 1.7 дахь хэсгийг дэмжээд 60 хувийн саналаар бид нар юу яасан байгаа. Дэмжигдээд явсан байгаа. Тийм учраас попроод хэрэггүй л дээ. Бид нар өнөөдөр попорч болохгүй. Улсаа бодох ёстой. Манай Эрдэнэтэд нэг Чибиш гэдэг нэртэй хүн байсан. Одоо ч байгаа. Мундаг хүн л дээ. Их Хурлын гишүүн болоод миний аав ээж надад Чибиш гээд нэр өгсөн бол юу гэж ярих байсан юм байгаа юм. Гэмтлийн эмнэлэгт одоо бурхан болчихсон

болохоос биш Хүнбиш гэдэг нэртэй мундаг гавьяат эмч байсан юу гэж хэлэх юм байгаа юм.

Одоо би зарим нэгэн зүйлийг маш хууль ч хүний хувьд нотолгоотой хэлэх гээд байгаа юм. Би Ардын намынхаа Их Хурлын гишүүдийг доромжлоогүй ээ. ЖДҮ-чин, 60 тэрбумтан, концессчин, одоо хүн амины хэрэгтэн гэж би доромжлоогүй. Намын даргын хэлсэн үгийг л давтаж хэлж байгаа юм.

Би Хууль зүйн сайд Нямдоржийг доромжлоогүй ээ. Тэр хүн шалгагдаж байгаа гэж өөрөө хэлсэн. Надад 5 хэрэг шалгаж байгаа, эрүүгийн хэрэг үүссэн гэж өөрөө хэлсэн. Тийм учраас миний муу найзыг та нар яасан юм бэ дээ. Энэ 17 шүүгчийн Манан мафийг зогсоо гээд жагсаал хийгээд шүүгчгүй болгосон шүү дээ. Энэ шүүгчгүй болсноос болоод Монгол Ардын хувьсгалт нам Их Хурлаа хийж намын даргаа дахин сонгох боломжгүй болчхоод байгаа юм. Би хоосон хурал хийгээд шүүгчгүй байшин нүдээд яах вэ дээ гээд ингээд байж байна. Би энэ дээр яах вэ та өмнөх хүн дээр бас тэгсэн шүү дээ. Надад одоо яах вэ, надад олон ах бий, одоо энэ Занданшатар миний ах байна. Би, Хүрэлсүх миний ах байна. Одоо Халтмаагийн Баттулга миний ах байна. Одоо Энх-Амгалан гишүүн та бол мэдэж байгаа. Чи муу Женкогийн хүн, машин жийп авсан гээд л гүтгээд байсан. Гэтэл зарчимтай юман дээр бол нийлээд л. Зарчимтай юман дээр бол бид нар ахыгаа бол дэмжинэ. Ах нараа дэмжинэ. Тавантолгойг ард улсад, ард түмэндээ авъя гэдэг дээр дэмжинэ. Хүрэлсүхийг өнөөдөр байгалийн баялгийг зохистой хэрэглэе гэдгийг нь дэмжинэ. Дарга боллоо гэж дэмжиж болохгүй.

Ерөнхийлөгч байхад нь бөгсийг нь долоож яваад шоронд орохоор нь юу гэдэг юм шог царайлаад ингээд муулаад явдаг. Би ийм зарчимгүй. Энхбаяр даргыг би Хаан байхад нь очиж уулзаж бөгсийг нь долоож амьдраагүй. Шоронгоос нь гаргаад, намтай болгоод л явсан. Тийм учраас Манкурт боол шиг ингэж явахаа больцгооё. Хэн рүү ч утсаар ярьж болно л доо. Ярьдаг чинь өөрөө хууль зөрчиж байгаа. Хамгийн гол нь нэг зүйлийг бид нар шийдэх ёстой. Бичгээр л ярья л даа. Бичгээр л аваад ир. Тэр 49 гэдэг тоо чинь өдрийн сонин дээр л гарсан тоо. Тийм учраас би 49 гэдэг тоог хэлсэн шүү. Энийг бас ерөнхийдөө хаалт дотор тайлбар хэлэхгүй бол манай тойргийн гишүүд уурлаад байх юм.

Манай Эрдэнэтэд энэ 49-ийг чинь Ардчилсан нам авсан шүү дээ. Манай хувьсгалт намтай нийлээд тэр утгаараа би хувьсгалт намд байгаа гэдгээрээ 49-тэй холбоотой юм шиг байгаа юм. Би хэлдэг юм. Энэ Эрдэнэтийнхээ Худалдаа хөгжлийн банкиг очиж өмчөө олж авах юм сан. Харамсалтай нь нөгөө баян хүний нэрэн дээр одоо юу гэдэг юм доромжлуулаад суух бас хэцүү юм.

Г.Занданшатар: Баасанхүү гишүүн төслийн заалтын талаар үг хэлье. Энэ чинь улс төрийн индэр биш.

О.Баасанхүү: За ойлголоо. Энэ дээр 60 хувийн босгыг та бүхэн ерөнхийдөө 60 биш гэвэл хэд гэх юм бэ. Тэр босго дээр бүгдээрээ яриач ээ. Ямар нэгэн багцаа байхгүйгээр ингээд явбал дараагийн Засгийн газар нь дахиад л хэлнэ шүү дээ. Энэ Засгийн газрын үед өр аймшигтай болсон гээд. Миний санаж байгаагаар бол яг 16 онд өр хэд байлаа. Одоо тэр тоо чинь замбараагүй өссөн юм биш үү. Би тухайн үедээ энэ өр дараад байна гээд нөгөө Хүрэлбаатар сайд яриад байхаар нь ямар ч байсан овоо доо гээд байсан чинь зүгээр урд хормойгоо аваад ард хормойндоо хийгээд өнөөдөр юу гэдэг юм ОУВС-ийн өр чинь бидний л өр шүү дээ. Энэ өр нэмэгдэхээр өрийн босго чинь үндэсний ДНБ-ээ даваад 60 гаруй хувьтай болоод байгаа юм. Тийм болохоор Ардчилсан нам байна уу, Ардын нам байна уу, Хувьсгалт нам байна уу ямар ч байсан улсаа бодъё гэвэл багцаатай болж аваад энийг бид давахгүй гэдгээ хатуу зааж өгөхгүй бол нөгөө нэг юуны органик хуульд

оруулъя гэвэл органик хуулийг ямар л бол ямраар засна шүү дээ. Засаад л байхгүй. Дахиад л нөгөөдөх нь өсөөд явна. Эцэст нь Монгол Улсын тусгаар тогтнол бүрэн эрхт байдал үндэсний аюулгүй байдлаараа бид нар одоо юу гэдэг юм зай тавьж өгнө. Тийм учраас бид нар энийг дэмжсэн нь зөв байх гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Лувсаннамсрайн Энх-Амгалан.

Л.Энх-Амгалан: Зөв хэлээрэй овог. Лувсанцэрэн.

Г.Занданшатар: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан.

Л.Энх-Амгалан: Ер нь бол мэдээж Монголчууд өртэй хүн өөдөлдөггүй, өттэй мал таргалдаггүй гэж ярьдаг л даа. Тэгээд энэ өрийг одоо өнөөдөр Ардчилсан намын өр, Ардын намын өр гэж ярих нь юу юм бэ Монголын л өр гэж би бодож байгаа. Тэгээд мэдээж өргүй улс орон гэж бол байхгүй. Өр бол үнэхээр хэцүү. Өртэй байхын зовлон гэдэг бол үнэхээр зовлон. Манай Монголчууд бол зээлгүй хүн гэж байхгүй. Өргүй хүн гэж байхгүй. Тэгээд өрийн хэмжээг бол үнэхээр үргэлж харж явж байх ёстой. Улс орны хамгийн том харж явж байх ёстой зүйл бол энэ өрийн хэмжээ байгаа юм. Ер нь бол өрөө, бид нар яаж энэ тавьсан өрөө буцааж яаж төлөх вэ гэдэг том асуудал байгаа байхгүй юу. Өрийн дарамт гэж бид нар ярьж байна.

Ерөөсөө улс орнуудын өрийг өрийн дарамтад орсон байна уу, ороогүй байна уу гэдэг ганц томъёолол бол энэ улс орон нийт хэдий хэмжээний өр тавьсан юм, тэрийгээ буцаан төлөх чадвар нь хир байгаа юм бэ гэдэг энэ үзүүлэлтээр л бид нар энэ томъёоллоор энэ улс өрийн дарамтад байна уу, үгүй юу гэдгээ ярьдаг байхгүй юу. Бид нар ер нь яах гэж энэ ОУВС-гийн хөтөлбөрт 2016 онд орсон бэ гэдгийг эргэж санамаар байгаа юм. Гуравхан жилийн өмнө манай улсын эдийн засгийн нөхцөл байдал, эдийн засгийн өсөлт бол 0 хувь болсон. 1-ээс доошоо орсон, хасах хувь руу орсон. -1.4 болсон. Төсвийн алдагдал хоёр оронтой тоо руу 10 хувь руу дөхсөн. Бүс нутагтаа хамгийн өндөр төсвийн алдагдалтай ийм улс орон болчихсон. Маш их өрийн дарамтад орчихсон байсан. 2016 оны Монголын ард түмний Монгол Ардын намд өгсөн хамгийн том итгэл бол энэ улс орны эдийн засгийн буруу бодлогыг засаад өгөөч. Төрөө хямралаас, ард түмнээ ядуурлаас, ард түмнээ, энэ улс орноо өрийн дарамтаас гаргаад өгөөч гэж бид нарт энэ их том итгэлийг өгсөн гэж би ойлгоод байгаа шүү дээ.

Тэгэхээр одоо яг энэ Ардчилсан нам маань ингэж ойлгож яг Үндсэн хуулиндаа одоо энэ өрийнхөө хэмжээг ДНБ-ний 60 хувиас хэтрүүлэхгүй байя гэдэг энэ санал бол их ажил хэрэгч санал аа. Уг нь дэмжигдэх ёстой юм. Гэхдээ өнөөдөр яг энэ Өрийн менежментийн хуультай, тусгай менежментийн хуультай, Өрийн удирдлагын тухай хуультай улс орон, Төсвийн тогтвортой байдлын хуультай улс орон маань яг энэ Үндсэн хуульдаа ингээд тодорхой үзүүлэлтүүд заах бол ямар байдаг юм бол. Би тэрийг хэлж мэдэхгүй байна. Саяхан хүртэл одоо зөвхөн нэг жил гэхэд бид нар авсан зээлийнхээ үндсэн зээл биш зээлийнхээ хүүнд бараг 1 их наядтай тэнцэх хэмжээний энэ мөнгийг бид нар төлж байсан шүү дээ. Нэг ч төгрөгийн хөрөнгө оруулалт оруулж чадахгүйгээр бид нар зөвхөн авсан зээлийнхээ хүүг төлж байсан цаг үе саяхан шүү шүү дээ. Гуравхан жилийн өмнө, дөрөвхөн жилийн өмнө. Тийм учраас бол бид нарт бол маш их гашуун туршлага байгаа юм.

Хэрэв бид нар энэ Оросод тавьсан 10 тэрбум доллартой тэнцэх алтан рублийн өр гэж ярьдаг байсан, социализмын үед. Энэ өрийг бид нар хэрэв үнэхээр төлөөгүй байсан бол өнөөдөр бид нар толгой мэдэж Оюу толгойгоо шийдэх, толгой мэдэж Тавантолгойгоо шийдэх ийм боломжгүй байсан гэж би бодож

ойлгодог юм. Тийм учраас өрийн асуудал бол үнэхээр тусгаар тогтнол, улс орны аюулгүй байдлын асуудал. Тэгэхээр бид нар одоо цаашдаа ер нь энэ тавьсан өрийг, өрийг ер нь яах гэж авсан юм. Яах гэж өрөнд ордог юм бэ гэдэг асуудал. Хамгийн гол нь энэ улс орныхоо эдийн засгийг бид нар өрсөлдөх чадвартай л болгох ёстой гэж би ойлгоод байгаа юм.

Тэгэхээр ер бол гурван янз байдаг л даа. Хувийн хэвшлийнхний тавьсан өр. Төв банкны тавьсан өр. Монгол Улсын Засгийн газраас гаргаж байгаа бондуудын өр гээд гурван хэлбэртэй байж байгаа. Одоо бид нарын хамгийн цаашдаа харж явах үзүүлэлт бол Монгол Улсын Засгийн газрын тавьсан өр нь ДНБ-ийхээ хэдэн хувьтай тэнцэж байна вэ гэдэг энэ үзүүлэлтүүдийг л бид нар харж байх ёстой байхгүй юу. Сая Дэлхийн банкнаас гаргасан судалгаагаар энэ бага орлоготой 20 улсын өрийн хэмжээ, өрийн дарамтыг харьцуулсан ийм судалгаа миний өмнө байж байна л даа. Тэгэхээр бага орлоготой улсуудын Засгийн газрын тавьсан өр нь 50 хувиасаа дээшээ, ДНБ-тэй харьцуулахад 50 хувиасаа дээшээ гарахад энэ бол маш том өрийн дарамтад орсон ийм эрсдэлтэй улс орнуудын тоонд ордог юм байна. Энэ тоонд бид нар бас орох нь ойрхон байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар энэ эдийн засгийнхаа өмнө нь явуулж байсан алдаатай бодлогыг засаж, залруулж аль болохоор өрийн дарамтгүй улс орон болох энэ чиглэл рүү бид нар анхаарч ажиллах ёстой гэж ойлгож байна.

Нөгөө талаасаа бид нар хувийн хэвшлийн тавьж байгаа өрнүүдийг аль болохоор бид нар дэмжих ёстой гэж ойлгож байна. Яагаад гэвэл энэ бол шууд хөрөнгө оруулалтууд болдог. Гадаадын хөрөнгө оруулалтууд, хувийн хөрөнгө оруулалтууд болдог. Ерөөсөө нэгэнт одоо бид нарын сонгож авсан нийгэм зах зээлийн нийгэм учраас өнөөдөр энэ хувийн хэвшлээ л бид нар дэмжих ёстой. Өнөөдөр хувийн хэвшил бол ДНБ-ний 80 орчим хувийг бид нар бүтээж байгаа шүү дээ. Ажлын байрыг хэн бий болгодог юм бэ. Төсвийн орлогыг хэн бий болгодог юм бэ. Татвар хэн төлдөг юм бэ.

Тийм учраас цаашдаа энэ хувийн хэвшлээ, хувийн хэвшилтэйгээ төр өрсөлдөөд байх биш, эдийн засгийн өрсөлдөх чадвараа дээшлүүлж эдийн засгийн өсөлтийг бий болгох, төсвийн алдагдлыг аль болохоор багасгах, улс орныхоо зээлжих зэрэглэлийг дээшлүүлэх энэ чиглэл рүү л бид нар явах ёстой гэж ойлгож байна. Тийм учраас энэ Ардчилсан намаас гаргаж байгаа ер нь бол энэ өрийн дээд хэмжээг ДНБ-ний 60 хувиас илүүгүй байна гэдэг энэ заалтыг Үндсэн хуульдаа оруулдаггүй юм гэхэд ямар ч байсан энэ Үндсэн хуулийг дагаж гарах органик хуулиуд, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн өрийн удирдлагын тухай хуулиуд дээр энэ заалтууд бол зайлшгүй байх ёстой гэсэн би ийм саналтай байгаа юм.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Дамдингийн Хаянхярваа үг хэлнэ.

Д.Хаянхярваа: Тэгэхээр бид нар одоо энэ 10.4 дэх заалтыг яриад байна. ДНБ-ний 60 хувиас илүүгүй байна гэж өрийн дээд хэмжээ. Зүгээр одоо энийг манай гишүүд бол дэлгэрэнгүй тодорхой ярьж байна л даа. Ингээд миний Улсын Их Хуралд ирж суусан энэ хугацаанд харахад бол Монгол Улс хоёр удаа эдийн засаг нь хасах руу орж байна лээ. Нэг удаа -1.2, нэг удаа бүр 0 хүртэл ингэж унаж байсан. Буцаагаад бид нар энийгээ 14, 15 хувь хүртэл өсгөж чадаж байсан. Өнөөдрийн байдлаар зургаа аравны хэдэн хувь хүртэл өсгөж чадаж байсан. Эцсийн дүндээ бид нар яг одоо эдийн засгийн ийм эрс тэс өөрчлөлтүүдийг энэ богино хугацаанд хийж чадаж байсан гэсэн мөртөө энийгээ бид нар эргээгээд яг ард түмнийхээ амьдрал руу чиглүүлж чадсан уу гэвэл бид нар чадаагүй. Энэ өсөлтийг зарим нэг нь эдийн засгийн өсөлт ч гэж ярьдаг. Зарим нэг нь үнийн өсөлт

ч гэж ярьдаг. Мэдээж энд бол аль аль нь байсан. Үнийн өсөлт ч байсан. Эдийн засгийн чадавч ч сайжирсан. Энд ганц юунаас болоод энийг ашиглаж чадаагүй вэ гэж.

Юунаас болоод, бодлогын алдаанаасаа болоод л бид нар энийг ашиглаж чадаагүй. Үнэхээр өнөөдөр бид нар бодлогын алдаа гэдэг нэг юман дээр юуг яг зааж хэлэх гээд байна вэ гэхээр бид зөв төлөвлөж, эдийн засгийнхаа байгаа бодит байдал юманд бол анализ дүгнэлт хийдэг эдийн засгийн төвлөрсөн төв байгууллага байхгүйгээс болоод тэрэнд судалгаа шинжилгээ хийдэг, ийм одоо судалгаа, шинжилгээ дээр тулгуурлаж Засгийн газар бодлогоо явуулдаггүйгээс болоод бид нар бол энэ дээр маш том алдаа гаргасан.

Тухайлбал Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль гээд хоёр том хуулийг 2008-2012 оны хооронд, одоо заримыг нь ажлын хэсгийг нь Улаан сайд ахалж байсныг би санаж байна. Ингээд маш сайн хууль гаргалаа. Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкныхан одоо бид нарыг ер нь үндсэндээ энэ үнэхээр маш сайн хууль боллоо гээд энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар төсвийн тусгай заалтуудыг бий болгож өгсөн. Тусгай нөхцөлүүдийг бий болгосон. Ингээд тусгай нөхцөлүүдээ бий болгосны дараагаар Баасанхүү гишүүн түрүүн дурдаж байна лээ. Бүр Үндсэн хуулийн цэцэд өгч байгаад, бүр Үндсэн хуулийн цэцэд өгч байгаад шиг санаж байна шүү. Үндсэн хуулийн цэцэд өгч байгаад төсвийн тусгай шаардлагуудаа хүчингүй болгож байгаад, өрийн дээд хязгаараа нэмэгдүүлээд бид нар ингээд өрнийхөө хэмжээг нэмэгдүүлээд цаашаа явсан гашуун түүх бий.

Өрийн дээд хязгаараа нэмэгдүүлээд, өрнийхөө хэмжээг нэмэгдүүлээд, түүгээрээ бид нар эргээгээд одоо нөгөө валютаа олдог, эдийн засгаа өсгөдөг буцаагаад нэмүү өртөг шингэсэн юмаа бий болгодог тийм зүйл рүү тэр хөрөнгө санхүүгээ зарцуулж чадсан уу гэвэл бид нар тэрийгээ чадаагүй. Тэрийгээ хийж чадаагүй. Зам харгуй гээд урт, удаан хугацаанд өгөх маягийн юмнууд руу зарсан болоод тэгээд тэр нь хэрүүл, уруул болоод одоо ингээд Хөгжлийн банк, Төрийн банк тойрсон хэрүүл, уруул болоод өнөөдөр тэр нь бол энэ Монголын улс төрийн хэрүүлтийн хамгийн том алим. Тэр дотроо хамгийн том будилаантай асуудлын нэг болгож хувиргаж чадсан. Энэ бол хэний гавьяа вэ гэж. Энэ гавьяа бол яг ний нуугүй хэлэхэд бол улс төрчид бид нарын гавьяа.

Яагаад гэвэл улс төрчид бид нар бол ийм бодлого авч хэрэгжүүлж, Улсын Их Хурал харин бодлогоо баталж гаргаж ирсэн. Ийм учраас л бид нар бол өнөөдөр өртэй холбоотой асуудал эмзэг сэдэв болчиход яригдаад байгаагийн нэг нь энэ юм. Ер нь бол бид нар яах вэ гэхээр хэрвээ үнэхээр энийг Үндсэн хуульдаа заахдаа биш бид тодорхой органик хуулиудад энийг зааж өгч болно. Тухайлбал бид нар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заагаад тусгай шаардлагуудыг заачхаад 2-3 жил маш сайн мөрдөж явсан. Төсвийн тусгай шаардлагад нийцүүлээд өрнийхөө хэмжээг хязгаарлаад тэр хуулиа дагаж мөрдөөд явж чадсан бол өнөөдөр магадгүй бид нар бол ийм их хэмжээний өр зээл тавьчихсан явахгүй байх тийм боломж бидэнд байсан. Олсон хөрөнгөө өөр эрүүл саруул харин улсынхаа эдийн засгийг тэтгэж чадах тийм чиглэлийн юм руу хөрөнгөө зарцуулаад явах боломж байсан. Харамсалтай нь өнөөдөр бид нар тэгж чадаагүй ээ.

Тэгэхээр би энэ дээр юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр ерөөсөө энд бичиж, ингэж хязгаар тоо зааж өгөхөөс илүүтэйгээр ерөөсөө төрийн бодлого залгамж чанар, хууль хэрэгжүүлэх, сахилга бат, хариуцлагатай холбоотой асуудлыг л хамгийн чухлаар тавих ёстой. Сахилга бат, хариуцлагатай холбоотой асуудлуудыг. Энэ үеийн үед Улсын Их Хуралд мэдээж өнөөдөр энэ Улсын Их Хуралд сууж

байгаа өнөөдрийн 76 гишүүн үргэлжийн мөнхөд суухгүй. Энэ Улсын Их Хурал чинь өөрөө дахиад сонгууль болно. Дахиад өөрчлөгдөнө. Гэтэл бид нар яг энэ Улсын Их Хурлаар батлаад гаргасан эдийн засгийн ач холбогдолтой чухал чухал хуулиудынхаа гол гол зүйлүүдийг бол дагаж мөрддөг байх хэрэгтэй. Цагийн аяс, улс төрийн бодлого, сэтгэлийн хөөрөлдөө автагдаж энэ бүх зүйлүүдээ өөрчилж давхиад байх юм бол эдийн засгийн тогтвортой бодлогыг бид нар явуулж чадахгүй юм байна гэж ингэж өнөөдөр олон хүн энэ жишээн дээр ярьж байгааг бид бас ойлгох хэрэгтэй.

Өнөөдөр бид нар түрүүн тэр 10.1 дээр 10 дээр яриад ийм ийм зүйлүүдийг хуульчилж өгье. Ийм ийм зүйлийг оруулж өгье гээд ярьж байхад Мөнх-Оргил гишүүн маш тодорхой ярьсан шүү дээ. Манай энэ хуулийн 25 дугаар зүйлийн 7 дээр бол маш тодорхой заасан байна гэж. Тэр нь юу вэ гэхээр төрийн санхүү зээл албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв түүний гүйцэтгэлийн тайланг батлах гээд ингээд л заачихсан. Маш тодорхой заасан. Гэтэл бид нар өнөөдөр энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр юу хийх гээд байна вэ гэхээр бол энэ ингээд маш тодорхой илүү дутуу үгүйгээр энэ хуульд заагаад өгсөн юмыг дунд хугацааны хөтөлбөр л гэнэ. Энэ хөтөлбөрийг өөрчлөхгүй л гэнэ. Ийм байдлаар хийнэ гээд ингээд задлаад бараг худалч хүнд бол тайлбар тавих гэж байгаа маягаар оруулж ирээд байгаа нь бол Үндсэн хуульд тусгах баримт бичиг биш болоод байна гэдгийг бас манай энэ юм үзэж, судалж, харж байгаа энэ хүмүүс маань бол хэлээд байна. Энийг бид нар үнэхээр бас анхааралдаа авах ёстой гэж ингэж хэлмээр байна. Одоо бид нар яагаад би энэ 60-ыг зөвшөөрөхгүй байна вэ гэж. Түрүүн энэ Даваасүрэн гишүүн миний хажууд сууж байгаад бас үг хэлэхдээ хэлж байна лээ.

Энийг жишээлбэл ингээд тусгалаа гэхэд нэрлэсэн үнээр авах юм уу. Өнөөгийн үнэ цэнээр авах юм уу. Эдийн засгийн тодорхой одоо дээш доош “бүүм”, янз бүрийн юм болох юм бол бид энийг яаж тооцох юм бэ. Тэгвэл Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулна гээд дахиад суух уу гэж. Тийм учраас Үндсэн хуульд бол энэ гишүүдийн хэлээд байгаа тодорхой тоон хязгаартай зүйлүүдийг ингэж бодлогогүйгээр суулгаж өгөх нь цаашдаа буруу юм гэж би хувьдаа бодож байна.

Тийм учраас үүнийг бол тэр Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гэх мэт ийм эдийн засгийн маш их чухал хуулиудаараа бид нар төсвийн тусгай шаардлага гэдэг юм уу тийм юмандаа зааж өгөөд харин Үндсэн хуульд бол төсвийн тусгай шаардлагад заасан зүйл, заалтуудыг зөрчсөн тохиолдолд Засгийн газар гэдэг юм уу, Улсын Их Хурал нь ийм ийм хариуцлага үүрнэ гэх маягаар байдаг юм уу. Ингэж суулгаж өгч хариуцлагуулах юм бол арай илүү ийм амьдралд дөхөм болох болов уу даа гэж би ингэж бодож байна. Эцэст нь би дахин давтан нэг зүйлийг хэлэхэд ерөөсөө эцсийн дүндээ бид нар энд сууж байгаа 76 хүний тоо цөөн, их, багадаа биш.

Ерөөсөө энд сууж байгаа хүмүүсийн хариуцлага, энд сууж байгаа хүмүүсийн энэ улс эх орны эдийн засгийг харж авч хэрэгжүүлэх гэж байгаа бодлогын нарийн залгамж чанарыг хадгалж үлдэх, цааш цаашдаа Монголын эдийн засгийн гол зангилаа асуудлуудыг яг бодлогоор тодорхойлж өгөөд ямар ч Засаг гарсан тэрийг мөрдөж ажилладаг ийм төрийн залгамж чанартай болж чадах юм бол магадгүй энэ улсын эдийн засагт бол маш чухал хэрэг болно гэж энийг одоо бас бодож байх ёстой юм гэж хэлмээр байна. Тийм учраас энэ 60-ыг бол би энд зааж өгөх нь хэрэггүй гэж үзэж байна.

Г.Занданшатар: Одоо Батзандан гишүүн. Эрхэм гишүүн Жалбасүрэнгийн Батзандан үг хэлнэ.

Ж.Батзандан: Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн 10.4-т Засгийн газрын өрийн дээд хэмжээ ДНБ-ний 60 хувиас илүүгүй байна гэдэг заалтыг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтийн хэлбэрээр оруулья гэдэг саналыг хэлэлцэж байгаа юм.

Ер нь дэлхийн олон улс орнуудын Үндсэн хуулийг харахад ДНБ-ний 50 хувиас хэтрэхгүй байхаар Засгийн газрын өрийн хэмжээгээ хуульчилсан байгаа. Монгол Улс ч гэсэн Төсвийн тогтвортой байдлын хуулиараа Засгийн газрын өрийн хэмжээг ДНБ-ний 40, 50, 60 хувь гэж хуульчилсан байсан. Хоёр, гуравхан жилийн өмнө. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг гуравны хоёроор өөрчилдөг органик хууль гэж бид нар үзэж ингэж хамгаалж байсан. Гэтэл хэсэг Улсын Их Хурлын гишүүд энэ хуулийг Үндсэн хуулийн цэцэд өгөөд гуравны хоёрын хамгаалсан босгыг нь хүчингүй болгож байгаад улсын өрийг үндэслэлгүйгээр нэмсэн. Түүх хуучраагүй байна. Ердийн хуульд өндөр гуравны хоёрын хамгаалалттай хуульд оруулаад бид өрийн босгыг, өрийн хэмжээгээ барьж чадалгүйгээр хулгайч нарын саварт алдаад дууссан юм. Аргаа бараад одоо Засгийн газрын өрийн дээд хэмжээг ДНБ-ний 60 хувьд нь барих ийм заалтыг Үндсэн хуульд оруулья гээд Улсын Их Хурлын зарим гишүүд аргаа бараад оруулж ирж байна. Би хувьдаа дэмжиж байгаа 60 хувь биш 50 хувиар хязгаарлаж оруулах нь зүйтэй гэдэг ийм байр суурьтай байна.

Өнөөдөр Монгол Улсын нийт өрийн хэмжээ 28 тэрбум долларт хүрсэн гэдэг мэдээ миний өмнө байна. Өнгөрсөн 30 жил Монголчууд жил болгон нэг тэрбум доллартой тэнцэхүйц өр үйлдвэрлэсэн байна. Өнгөрсөн 30 жил бол өр үйлдвэрлэсэн эдийн засгийн бодлого явуулсан 30 жил байсан. Бүх том орд баялгуудыг нь хэдэн дарга олигархууд нь хулгай хийсэн. Хулгай хийсэн мөнгөө оффшорт нуусан 30 жил байсан. Улсын төсөв, Монголын ард түмэн ядуурсан шалтгаан бол эрх мэдэлтнүүдийн хулгай байсан. 33-хан км-ийг 30 тэрбумаар барьсан төмөр замаа 200 тэрбумаар улсын төсөвт шахдаг, 30 жил байсан. Дарга нарын хулгайгаас болж Монгол дампуурсан. Дарга нарын эрх мэдэлтнүүдийн хулгайгаас болж Монгол Улс өрөнд орсон гэж бид харж байгаа. Ийм учраас энэ заалтыг Үндсэн хуульд зайлшгүй оруулах шаардлагатай гэж үзэж, дэмжиж байгаагаа илэрхийлье. ДНБ ойролцоогоор 15 тэрбум доллар гэж үзэх юм бол ДНБ-ний 50 хувиас хэтрүүлэхгүйгээр Засгийн газрын өрийг барья гэдэг бол Монгол Улс 7 тэрбумын өр зээлтэй байхад хэвийн хэмжээ гэж үзэж болохоор байгаа юм. Өнөөдрийн байдлаар Засгийн газрын өр 15 тэрбум долларт хүрээд байна. Энэ бол улаан гэрэл ассан гэсэн үг.

Монгол Улсын өрийн хэмжээ аюултай түвшинд хүрсэн гэсэн үг. Монгол Улс дампуурлын ирмэг дээр ирсэн гэсэн үг. Ийм учраас Улсын Их Хурлын эрхэм гишүүд энэ заалтыг дэмжиж өгөөч гэж хүсэж байна. Монголын өвгөд буурлууд хэлдэг юм. Адууныхаа хэрээр исгэрч бай. Хөнжлийнхөө хэрээр хөлөө жийж бай гэж буурлууд бидэнд захисан билээ. Ийм учраас Засгийн газрын өрийн хэмжээг ДНБ-ний 50-60 хувиас хэтрүүлэхгүй байх энэ заалтыг Үндсэн хуульд оруулахыг дэмжиж өгөөч гэж эрхэм гишүүдээс хичээнгүйлэн хүсэж байна.

Г.Занданшатар: Эрхэм гишүүд ээ, 6 цаг, ажлын цаг өнгөрсөн байгаа учраас өнөөдөр сунгаж хуралдана. 10, 11 цаг хүртэл нэлээн сунгаж хуралдъя.

Маргааш хагас, бүтэн сайнд бас гишүүдийн саналаар завсарлаад нэг дэх өдөр, хичээлийн шинэ жилийн нээлт учраас намын бүлэг, зөвлөлийн хурлууд болно.

Хоёр дахь өдөр амралтын өдөр болсон учраас ирэх 3 дахь өдөр нэгдсэн чуулганд гишүүд яс цуглацгаах ёстой. Нэг дэх өдөр бүлэг, зөвлөлийнхөө хуралд орох ёстой. Тэгээд ирэх гурав дахь, дөрөв дэх, тав дахь, хагас сайн өдрүүдэд яс хуралдаж хоёр дахь хэлэлцүүлгээ дуусгана гэдгийг анхаарч, ажлаа зохицуулаад гурав дахь өдөр чуулганд 100 хувийн ирцтэй оролцоно шүү гэдгийг урьдчилан анхааруулж байна.

Одоо өнөөдөр сунгаж хуралдана. Тэгээд гишүүд 40 минутын дараа чуулганы танхимд орж ирж санал хураалтад оролцоно.

Одоо эрхэм гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг үг хэлнэ.

М.Оюунчимэг: Оройн мэнд хүргэе. Сая бид нар ер нь Үндсэн хуульд эдийн засгийн чиглэлтэй ялангуяа тогтвортой хөгжлийн асуудлыг урт, дунд хугацааны стратегитай холбоотой тийм нэг хариуцдаг байгууллага байх гээд маш тодорхой бас зааж өгөх зайлшгүй шаардлага байна гэдгийг миний бие бас хэсэг гишүүдийн хамт санаачилж энэ төсөлд уг нь тусгуулсан юм. Үүний гол зорилго нь яг энд яригдаад байгаа санаанаас би Батзандан гишүүнтэй нэг зүйлд бол санал нэг байна л даа. Өнгөрсөн 30 жил бол өр үйлдвэрлэсэн 30 жил байлаа гэдэг бол үнэн тодорхойлолт болж л байна л даа. Одоо бид нар ганцхан жишээ сая Эрдэнэбат гишүүний оруулж ирсэн энэ Засгийн газрын өрийн дээд хэмжээ ДНБ-ний 60 хувиас илүүгүй байна гэсэн санал уг нь бол үнэхээр ажил хэрэгч бас чухал. Дэлхийн улс орнуудынх 50 хувиас хэтэрдэггүй байдаг. Манай улсынх ч гэсэн ийм байсан. Гэтэл статистикаас харахад манай улсын Засгийн газрын өрийн байдал 2016 оны төгсгөлд гэхэд бүр 78.8 хувь болж өссөн байсныг та бид нар мэднэ.

Харин өнгөрсөн оны сүүлээр энэ үзүүлэлт маань овоо буурч 58.9 хувь болж ингэж буурсан байгаа юм. Тэгэхээр энэ дээр юу байна вэ гэхээр нөгөө л төсвийн хариуцлага, сахилга баттай холбоотой асуудлыг бид хөндөж тавьсан. Энэ Улсын Их Хурал бүрэлдсэнийхээ дараахан Сангийн сайдад ч хэлж байсан. Энэ төсвийн сахилга батыг маш өндөржүүлсэн байдалд авч үзье. Бараг байгууллага бүхэн төсөвтэй, сайд бүхэн төсөвтэй, улс хоёр гурван төсөвтэй юм шиг явж ирсний алдаа нь өнөөдөр бид энэ асар өндөр гадаад өр төлөхөд хүрчхээд байгааг бол бид нар мэдэж байгаа шүү дээ. Ер нь ингээд статистикаас харахад өнөөдөр нийт өр 29.7 тэрбум Америк долларт хүрч, 171 сая доллароор өссөн үзүүлэлттэй байгаа. Үүний юу юм бэ гэхээр хөнжлийнхөө хэрээр хөлөө жийх энэ асуудлыг орхигдуулж, эдийн засгийн тооцоо судалгаагүйгээр маш өндөр бизнесийн зээлүүд авсны бас сөрөг үр дагаврууд өнөөдөр манай эдийн засаг, нийгмийн бүх салбарт маш ноцтой нөлөөлснийг бид нар мэдэж байгаа. Одоо ингээд үзэхэд бид нар 21 оноос эхлээд өр төлж эхэлнэ. Эндээс л бид энэ гадаад өрийг төлөх тэр стратегийг маш сайн боловсруулж хатуу мөрдөх асуудал бол өнөөдөр энэ Их Хурлын хамгийн тулгамдсан чухал асуудал гэж би харж байгаа.

Тийм учраас бид Үндсэн хуульдаа ч гэсэн цаашид гаргасан энэ өмнөх алдааг давтахгүйн тулд бас нэг тодорхой зүйлүүдийг сайн тусгаж өгөх нь зөв гэсэн байр сууринаас би хандаж байгаа юм. Одоо бид нарын хэлж байгаа энэ 2021 онд гэхэд 600 сая ам.долларын нөгөө Мазаалай бондын өр, 2022 онд Чингис бондын 1 тэрбум ам.доллар, 2023 онд Гэрэгэ бондын 800 сая ам. доллар, 2024 онд Хуралдай бондын 600 сая ам.доллар гээд нийтдээ 2.9 тэрбум ам.долларын өрийг төлөх байгаа. Энэ бол аймшигтай тоо шүү дээ. Гэтэл өнөөдөр бид үйлдвэрүүдээ барих, бензин, газрын тос, нефть боловсруулах, цэвэрлэх байгууламж гээд асар том ажлуудыг хийх ёстой. Энэ бол улс орны хөгжил, иргэдийн маань амьдрал ахуйтай холбоотой энэ чухал асуудал байгаа учраас бид одоо энэ өрнүүдийг төлөх нь бол зайлшгүй. Гэхдээ эдийн засаг, нийгмийнхээ амьдралд дарамт учруулахгүй

байдлаар маш сайн стратеги боловсруулж мөрдөх учраас бид нар энийг органик хуулиараа маш сайн зохицуулж өгөх зайлшгүй шаардлага байгаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа ч гэсэн маш сайн дагаж мөрдөх энэ зүйлүүдийг хатуу хариуцлага тогтоодог байдлуудыг ч гэсэн гаргах нь зөв байгаад байгаа юм. Тийм ч учраас тэр эдийн засгийн хөгжлийн дунд, урт хугацааны хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй хөгжүүлэх тэрийг нь чанд ингэж мөрдүүлж ажилладаг тодорхой ийм байгууллагатай байя гэдэг саналуудыг уг нь бид нар гаргаж тавиад байгаа юм.

Тэгэхээр энэ байдлууд дээр бид нар маш сайн дүгнэлт хийх хэрэг гарч байгаа. Өнөөдөр бас бид нар ингээд харж байна л даа. Ямар ч байсан өнөөдөр гадаад актив 6.8 тэрбум ам.доллар байна. Манай Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц бол сөрөг байдалтай байгаад байгаа шүү дээ. Өнөөдөр гадаад активын нөөцийг валютын нөөц бүрдүүлээд байна. Гэтэл бид нар одоо энэ их өр төлөхөд юу болох вэ гэдэг асуудал бас гарч ирнэ. Өнөөдөр бид нар ингээд харж байхад манай улсын экспортын бүтээгдэхүүний хувьд гадаад зах зээл харьцангуй бас тогтвортой байгаа. Алт, төмрийн үнэ ханш өссөн. Харин зэс 6 мянга байж байгаад 5600 руу орж буурсан ийм үзүүлэлттэй байгаа. Эндээс харахад бид нар уг нь нийт гадаад төлөх өрөө маш сайн стратеги боловсруулбал бас гайгүй ингээд дарамт учруулахгүйгээр даваад гарах бололцоо харагдаж байгаа юм.

Тиймээс би бас энэ асуудал манай энэ Улсын Их Хурал, Засгийн газар одоо энэ хэрэгжүүлэх байгууллагууд маш анхааралтай, хариуцлагатай хандах ёстой гэж хэлмээр байна. Эд юу юм бэ гэхээр өмнө нь нэг Ерөнхий прокурор асан хүн чуулганы танхимд хэлж байсан шүү дээ. Төсөвт бүр зохион байгуулалттайгаар мөнгө суулгаад тэрийгээ хувийн буруу замаар ашигладаг бүхэл бүтэн ийм систем бүлэглэл байгаа гэж хүртэл хэлж байсан. Энэ байдалд цэг тавихын тулд би хариуцлагын асуудлуудыг маш өндөр гаргаж тавьж байгаа. Ийм юм дахиж давтахгүйн тулд төсвийн энэ хариуцлага сахилга батын асуудлыг улсын Их Хурал ер нь сайн хуульчлаад өгөх нь бол буруугүй гэж би хардаг.

Тиймээс энэ асуудалд Их Хурал анхаарлаа хандуулах ёстой. Үндсэн хуульд бид бас тодорхой нэг болохгүй юм байна энийг л дагаж мөрдөх ёстой гэсэн заалт тусгах нь бас зөв гэж бодож байгаа. Гэхдээ өнөөдрийн энэ оруулж ирсэн шиг шууд 60 хувиас илүүгүй байна гээд заагаад өгвөл бид 21 оноос эхлээд ийм их гадаад нөгөө бондуудын өр төлөхөд энэ нь өөрөө авцалдаагүй болох гээд байгаа учраас энэ дээр бас сэтгэлийн хөдөлгөөнөөр биш эдийн засгийн тооцоо судалгаатай хандах ёстой гэж хэлмээр байна.

Ямар ч байсан тэр сахилга батын тухайд бид нар харин төсвийн тогтвортой байдлын тухай хуулийнхаа тухай ийм зүйлийг л төсөв хэлэлцэх үедээ төсөв батлаад хэрэгжүүлэх үедээ мөрдөнө гэдгийг маш хатуу зааж өгөх ёстой гэсэн байр суурийг би хэлж байгаа. Энэ дээр бид нар органик хуулиараа зохицуулах заалтуудыг бас оруулах нь зүйтэй болов уу гэсэн байр сууринаас хандаж байна. Харин энэ 10.4-т тэр төрийн татвар, хураамжийг хуулиар тогтооно гэдгийг бол би зөв гэж харж байна.

Өнөөдөр нээрэн хэн дуртай нь татвар хураамж тогтоож байна. Энэ нь өөрөө цалин ч нэмэгдээгүй баахан цалингийн, тэтгэврийн өртэй байгаа ард иргэд дээр энэ хураамж энэ татвар асар их дарамт болж байгааг бол өнөөдөр уулзсан иргэн бүхэн ярьж байгаа юм. Хэн дуртай нь тогтоож байна шүү дээ. Харин хатуу тогтоогоод өгвөл яг гадаадын улс орнууд өндөр хөгжсөн улс орнууд тэр замын татвар нь, тэр хурдны зам нь ийм л татвар хураамжтай байдаг. Энийгээ зайлшгүй авах ёстой. Үүнээс бусад татвар иргэдээс авахгүй гэдэг юм уу ийм зүйлийг нь бас

тодорхой болгоод өгөх нь зөв болов уу гэсэн байр суурьтай байгаагаа илэрхийлэхийг хүсэж байна.

Баярлалаа.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Баагаагийн Баттөмөр үг хэлнэ.

Б.Баттөмөр: Энэ Ардчилсан намын энэ санал бол их судалж үзэх ёстой асуудлын нэг гэж үзэж байна. Ер нь бол Монголчууд үе үедээ их өр тавьж ирсэн. ОХУ-д ЗХУ гэж байх үед 1990 онд тавьсан өр 12 тэрбум шилжих рубль, 250 сая доллар төлж энийг тэглэсэн. Тэр үеэс хойш 1990 оноос хойших өнөөдрийн Монгол Улсын нийт өр 30 тэрбум доллар болсон. Үүнээс Засгийн газрынх нь өр 15 тэрбум доллар болсон байна.

Тэр хувьсгалын өмнө ч гэсэн тэр Хятадын пүүс энд тавьсан өр гээд түүхийн ном сурвалжид зөндөө л байдаг. Тэгээд бид нар их өр тавьдаг хүмүүс юм, Монголчууд. Энэ дотоод нөөц бололцоогоо ашигладаггүй ийм улс орон гэж бас байдаг юм байна л даа. Тэрний нэг нь Монголчууд бид нар. Өөрсдөө болох юмаа, дотоод нөөц бололцоогоо ашиглаад хийчих юмаа өр тавьж гаднаас авдаг. Энэ өнөөдөр түрүүн ярьсан тэр хөгжлийн бодлого байхгүй байна гэж. Энэ өрийн удирдлагын бодлого гэдэг чинь хөгжлийн бодлогын нэг хэсэг. Хөгжлийн бодлого байхгүй учраас өрийн удирдлага, өрийн бодлого гэдэг юм Монголд байхгүй байна. Ийм явж байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр бид нар их анхаарах ёстой юм байгаа юм. Энийг одоо Үндсэн хуульд зааж өгөх ёстой юм уу. Эсвэл одоо тэр органик хууль дээрээ зааж өгөх маш хатуу байх ёстой.

Өнөөдрийн мөрдөх гэж байгаа хуулиар бол энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуульд жил бүрийн өрийн дээд хэмжээг Сангийн яам тодорхойлоод Засгийн газар оруулаад Засгийн газар Их Хуралд оруулж батлуулдаг. Ийм эрх зүйн орчин бол байна. Өрийн удирдлагын тухай хуулиар. Тэгэхээр манай энэ Өрийн удирдлагын хууль 2015 онд батлагдсан хууль. Их сайн хууль болсон гэж үздэг. Хэрэгжилт нь ямар байгааг бол мэдэх юм алга байна. Яг өнөөдрийн энэ дэлхийн хэмжээнд гаргасан судалгаагаар дэлхийн нийт өрийн хэмжээ гээд ингээд үзэхээр 1980 оны өрийн хямралын хэмжээнд хүрсэн байна гэж. Дэлхийн улс орнуудын 40 хувь нь өрийн өндөр дарамтад байна. Ялангуяа хөгжиж байгаа орнуудын. Ийм судалгаанууд байна л даа. Эдийн засгийн муруй гээд хэмждэг гол үзүүлэлтээрээ бол өрийн хямрал үүсэх магадлал их өндөр байна гэж үзэж байгаа. Ингээд үзэхээр энэ өрийн асуудлаа удирдах асуудлыг орхигдуулж ерөөсөө болохгүй. Монгол Улсад энэ өрийн асуудал ханш, инфляц гэсэн гурван үзүүлэлтийг бол үндсэндээ бид хянахгүй байна шүү дээ. Яах вэ зүгээр инфляцыг бол Монголбанк дээр тодорхой гаргах хэмжээнд одоо авч байна. Ханшин дээр бол авч байгаа байх.

Нөгөө бодлогууд нь байхгүй, хөгжлийн бодлого байхгүй, худалдааны бодлого байхгүй болохоороо энэ удаа ханш бол байнга өсдөг ийм л нөхцөлд бид нар амьдарч байна шүү дээ. Тэгэхээр энэ бүрийг бол бодлогоор зохицуулах ийм шаардлага үүсэж байна. Өргүй улс гэж дэлхийд алга. АНУ гэхэд л үндэсний орлогоосоо бараг хоёр дахин илүү өртэй гэж үздэг. Бүх улс өртэй. Гэхдээ өрөө яаж удирдаж байна гэдэг нь бол өөр байна л даа. Манай нийт Монгол Улсын нийт гадаад өр 30 тэрбум доллар болсон. 30 тэрбум доллар бол сая үнэхээр тэр зарим хүмүүсийн ярьж байгаа жилд 1 тэрбум долларын өрийг үйлдвэрлэжээ гэж. Өрийн удирдлагыг Монголын төрийг Үндэсний аюулгүй байдлын хэмжээнд хүртэл энийг авч үзэж байх ёстой. Жил бүр энэ дээр холбогдох арга хэмжээг авч байх ёстой. Гаднаас өр зээл тавьж хийж байгаа хөрөнгө оруулалт энэ ялангуяа энэ төсвийн орлогыг нөхдөг, төсвийн алдагдлыг нөхдөг, төсвийн орлогын дутууг гүйцээхийн

тулд гаднаас өр зээл авдаг юмыг бол бүрмөсөн зогсоох ёстой. Байж байгаа юмандаа тохирч бид нар ажиллаж, амьдрах ийм шаардлага байна шүү дээ. Энэ бүрийг бодмоор байна.

Энэ Засгийн газрын гадаад зээлийн талаар баримтлах бодлого гэж байгаа. Энийг шинэчлэх шаардлага байгаа. Тэр гадаад зээлийг бол зөвхөн тэр өөрөөр хэлбэл нэмүү өртгийг бий болгодог тэр хэсэгтээ л зээлийг авах ийм шаардлагатай. Өр үүсгэж бий болгосон хөрөнгө оруулалт, өр үүсгэж байгуулагдсан объектоос бол тэр үр ашгийг нь заавал авдаг байх ёстой. Эрсдэлийг нь тооцдог байх ёстой. Мэдээллийг нь сайжруулах ёстой. Шинжилгээ хийх ёстой гээд маш их олон асуудлууд энд үүсэж хуримтлагдсан байгаа юм л даа. Тэгэхээр энийг бид нар цаашдаа бодож ингэж хийх ёстой юм. Тэгэхээр энэ заалт бол их чухал заалт. Тэгэхдээ Ардчилсан намын бүлгээс ирсэн тооцоо нь 60 гэдэг бол ямар ч тооцоон дээр хийгдэж үндэслэсэн юм бол энийгээ дараа дараагийн хэлэлцүүлгийн явцад тодорхой тайлбарлах нь зүйтэй байх гэж ингэж бодож байна. Ямар ч байсан энэ бол анхаарах ёстой асуудал. Ямар орчинд нь энийг нь хийж өгөх юм, эрх зүйн орчин бүрдүүлэх юм. Үндсэн хуульдаа юу, эсвэл тэр органик хуулиуддаа хийж өгөх ёстой юу гэдгээ тогтох шаардлага байна гэж үзэж байна.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Цэндийн Мөнх-Оргил үг хэлнэ.

Ц.Мөнх-Оргил: Үндсэн хуульд яаж ийж байгаад л тулгамдаад байгаа асуудлаа нэг тусгаад өгчихвөл, үүрэгжүүлээд өгчихвөл. Эсвэл энэ өрийн асуудал дээр босго тогтоогоод л өгчихвөл тэр асуудал өөрөө аяндаа шийдэгдэх юм шиг бид нар ойлгож, хүсэж мөрөөддөг энэ хандлагаасаа салмаар байна. Үндсэн хуульд чинь орох ёстой юм гэж байна. Орох ёсгүй юм гэж байна. Энэ өрийн дээд хэмжээ бол миний бодлоор яагаад ч орох ёсгүй асуудал байгаа юм. Ардчилсан нам магадгүй, аягүй нарийн тооцоо хийгээд 60 хувь гэдэг тэр тооцоог гаргаад ирсэн байж магадгүй юм. ДНБ-ний 60 хувиас хэтрэхгүй гээд. Тэгэхдээ Үндсэн хуульд бид нар энэ өрийн тоо хэмжээ тогтооно гэдэг бол өөрөө нэг талаас хууль дээдлээгүй явдал. Яагаад вэ гэхээр өнөөдөр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4 дээр Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ний 60 хувиас хэтрэхгүй байна гээд цагаан дээр хараар бичсэн байгаа байхгүй юу. Угаасаа хуультай. Зүгээр байгаа хуулиа л бид нар хэрэгжүүлээд л биелүүлээд л сахилга баттай төсөв батлаад л, сахилга баттай баталсан төсвөө хэрэгжүүлээд явах л тухай асуудал байгаа байхгүй юу.

Нэгэнт хуульд заасан, Монгол Улсын Их Хурлаар баталсан хууль шүү дээ. Баталсан хуулийг заавал Үндсэн хуульд тоо хэмжээ тусгах гээд байх ямар ач холбогдол байна.

Яагаад би энийг хууль дээдлэхгүй байгаагийн тод жишээ болгож хэлээд байгаа юм бэ гэхээр Үндсэн хуульд л зааж байж тэр нь хууль болдог. Тэр нь үүрэгждэг, тэр нь биелдэг болох гээд байна шүү дээ. Бусад хуульд заасан байгаа бол тэр хамаагүй. Яагаад гэвэл Үндсэн хуульд зааж байж л хэрэгжинэ.

Ийм хуулийг үгүйсгэсэн, өөрөө өөрсдийнхөө ажлыг үгүйсгэсэн Монгол төрийг доош нь хийсэн юмыг бид нар оруулж ирээд хэлэлцээд явж байж болохгүй ээ. Би Ардчилсан намын энэ саналыг оруулсан гишүүдэд хүндэтгэлтэй хандаж байна. Өргүй амьдаръя. Өрийн босгоо хэтрүүлэхгүй байя гэсэн сайхан санааны үүднээс энэ санааг оруулсан байх. Тэгэхдээ Үндсэн хуульдаа хүндэтгэлтэй хандах хэрэгтэй байна. Бусад хууль тогтоомждоо хүндэтгэлтэй хандах хэрэгтэй байна. Байгаа хуулиа хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Тэрнийхээ дараа Үндсэн хууль руугаа буруугаа чихэх хэрэгтэй байна.

Өнөөдөр бид нар энэ 60 хувийг дэмжээд явах юм бол, бид нар Монголын ард түмэнд юу гэж хэлэх гээд байна вэ гэвэл бид нар ингээд өр баларчихлаа. Яагаад гэвэл Үндсэн хуульд өмнө нь ийм заалт байгаагүй байхгүй юу. Одоо харин бид нар ёстой энэ Үндсэн хуульдаа зааж авч байгаад энэ өрийг чинь нэгмөсөн болгоод өгөх гэж байна гэж хэлэх гээд байгаа юм уу. Хүн үнэмших юм уу тэрэнд, үнэмшихгүй байхгүй юу. Тийм учраас байгаа хуулийнхаа, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийнхаа 6.1.3 гэсэн заалтаа хэрэгжүүлээд л явъя. Хангалттай. Бидний гол проблем бол байгаа хуулиа хэрэгжүүлдэггүй байхгүй юу.

Одоо хамгийн тод жишээ нь 2010 онд баталсан, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль. Тухайн үедээ Баярцогт Сангийн сайд байж байгаад Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкныхантай хамтраад Чил-ээс төлөөлөгчид явуулж туршлага судалж байгаад Азид байхгүй чухал хууль баталлаа гээд л. Засгийн газрын өр ДНБ-ний 40 хувиас хэтрэхгүй байна гээд маш чухал заалт оруулаад, юмыг яаж мэдэх вэ, дараа дараагийн Их Хурлын гишүүд сахилгагүйтээд энийг хамаагүй өөрчлөөд байж магадгүй гэж бодоод гуравны хоёроор энийг өөрчилнэ гэж бодоод том босго тавьсан. Тэгсэн яасан гэхээр өрнийнх нь хэмжээ хэтрээд ирэхээр 2015 онд Үндсэн хуулийн цэцээр Улсын Их Хурал гуравны хоёрын босгоор хууль баталж болохгүй. Энэ Үндсэн хуулийн зөрчил гэдэг хууль бус, илт улс төрийн захиалгаар шийдвэр гаргуулж байгаад энэ Төсвийн тогтвортой байдлынхаа хуульд өөрчлөлт хийж байгаад өрөө зад тавьсан. Яаж тавьсан бэ гэхээр төмөр зам, дэд бүтэц, төрийн өмчит үйлдвэрүүдийн компаниудын өр Засгийн газрын өрөнд орохгүй гэж нэмэлт, өөрчлөлт оруулж байгаад л нөгөө 40 хувиасаа гараад явчихсан. Хэтрээд явчихсан. Дараа нь Ардын нам 2016 онд төрийн эрхийг аваад 40 хувиасаа хэтэрсэн байна гэдгийг нь хүлээн зөвшөөрөөд Улсын Их Хуралд оруулж ирээд энийг 60 хувь дээр барьж байна. Өнөөдөр нэг 58, 59 хувьтай байж байна. Тэгэхээр хуульд юу гэж бичих нь бол нэг хэрэг. Хэрэгжүүлэх нь өөр асуудал байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ буруугаа бид нар өөрсдөөсөө хайх ёстой юм. Үндсэн хуулиасаа юм уу, бусад хуулиасаа биш. Тэгээд энэнтэй яг агаар нэг заалтыг түрүүн бид нар хэлэлцээд дэмжихгүй явчихлаа. Энэ нь одоо хөгжлийн бодлогыг тодорхойлдог заавал яам байх ёстой гэж манай гишүүд бодоод байгаа юм. Хөгжлийн бодлого тогтвортой яваагүй нь ерөөсөө яамгүйгээс л боллоо гэдэг л ойлголтыг л бид нар одоо өгөх гээд байна шүүдээ. Яамтай байсан бол бид нар ерөөсөө бодлого аягүй тогтвортой байх, байгаад явчих юм яриад л байна. Өнөөдөр агентлаг байж л байна шүү дээ. Тогтвортой байгаа бодлого байна уу, байхгүй л байна шүү дээ. Яагаад гэвэл Засгийн газар тогтвортой ажиллахгүй байна шүү дээ. Энэ 27 жил 16 Засгийн газраа сольчихлоо шүү дээ.

Өнөөдөр бид нар харин энэ Үндсэн хуульд өөрчлөлт хийж байгаад Засгийн газар тогтвортой ажилладаг нөхцөлийг бүрдүүлж байна. Энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр батлагдаад явах юм бол. Жил зургаан сар ажилладаг Засгийн газаргүй болох гэж байна. Болдог бол бүрэн эрхийнхээ хугацааг хэрэгжүүлээд явдаг Засгийн газартай болох гэж байна. Дураараа Ерөнхий сайдаа солиод байдаг тогтолцоогоо бид нар солих гэж байна, нэг талаас. Нөгөөтээгүүр энэ Үндсэн хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтөөрөө бид нар Улсын Их Хурал, Засгийн газрын өргөн барьсан төсвийг дураараа зад тавиад зарлагыг нэмэгдүүлээд байдаг тэр эрхийг нь бид нар хязгаарлаж байна. Ингэж байж бид нар энэ төсвийн сахилга бат тогтвортой бодлогын алхам алхмаар очно. Тэрнээс биш хууль дээр ёлкны модон дээр тоглоом өлгөж байгаа юм шиг тэнд нэг заалт нэмээд, энд нэг заалт нэмээд л тэгээд за одоо ингээд Үндсэн хуульдаа тогтвортой бодлоготой гээд орсон, одоо хэдүүлээ тогтвортой болчихлоо гээд бид нар баярлаад байж болохгүй ээ.

Тогтвортой бодлого хэрэгтэй гэдгийг ойлгож байна. Тэгэхдээ энэ бол улс төрийн соёлоороо, улс төрийн хариуцлагаараа манай Их Хурал хяналтаа зөв тавьж байж тэгж хийгдэх болох ёстой биш. Хуульд заалт нэмснээрээ биш. Тэр тусмаа Үндсэн хуульд ийм заалт оруулж байж биш.

Мэдээж өргүй л амьдармаар байна л даа. Аль болохоор бага өртэй амьдармаар байна. Тэгэхдээ дахиад хэлэхэд Үндсэн хуульд ийм хатуу босго тавиад түүгээрээ бид нар энэ өрийн асуудлыг шийдчихлээ гэвэл үгүй ээ. Тогтвортой бодлогоо явуулна, бодлогын залгамж чанар байна. Байгаа хуулиа хэрэгжүүлнэ. Тэгж байж бид нар энэ өрийн дарамтаасаа сална. Тогтвортой бодлоготой улс орон нь хөгжсөн ард иргэд нь сэтгэл тэнүүн амьдарсан ийм улс орон болно. Энэ Үндсэн хуулийн хэлэлцүүлэг эхлэхээс өмнө уг нь бид нар анхаарах ёстой заалт байсан юм. Зүйл байгаа юм. Бид нар өөрөө өөрсдийнхөө алдааг улс төрийн алдаа ч байдаг юм уу, эдийн засгийн алдаагаа ч байдаг юм уу, ерөөсөө хууль руу чихээд байдаг. Одоо энэ 27 жилд 16 Засгийн газар солигдоход яамдын сайд нар бүгд солигдож байгаа. Сайд нар гарч ирээд яадаг вэ гэхээр хууль болохгүй байна.

Нөгөө ажлаа хийх, нөгөө хуулиа хэрэгжүүлэх тухай мартсан. Орж ирээд л хууль бариад л Засгийн газар дээр хэлэлцүүлж байгаад хууль бариад ороод ирнэ. Засгийн газар нь дэмжиж өгөхгүй бол Их Хуралд сууж байгаа гишүүдээр дамжуулаад нэг салбарынхаа хуулийн төслийг бариад ороод ирнэ.

Яасан. Энэ хууль ажил хийлгэхгүй байна. Хууль болохгүй байна. Тэгээд баахан хуульд өөрчлөлт оруулна. Тэрийгээ хэлэлцэж хэлэлцэж хуульдаа өөрчлөлт оруулаад авдаг бүрэн эрхийн хугацаа нь дууссан. Яагаад вэ гэвэл Засгийн газар 1 жил 6 сар л ажиллаж байгаа байхгүй юу. Тэгээд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтүүд нь ерөөсөө л өөрийнхөө яамныхаа юм уу, сайдынхаа эрх мэдлийг л нэмэгдүүлсэн бусад Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, аймаг, Засаг дарга нарын эрх рүү халдсан, хөрөнгө мөнгө, тендер төвлөрүүлсэн ийм нэг нэмэлт, өөрчлөлтүүд л оруулж ирнэ. Тэгээд хууль руугаа чихнэ.

Ажил яасан бэ? Хууль болохгүй. Жоохон дээшээгээ болох юм бол Үндсэн хууль болохгүй байна. Би ажил хийх гэсэн чинь Үндсэн хууль болохгүй байна. Зөв зүгээр байгаа Үндсэн хууль руугаа хамаг юмаа чихсээр байгаад л өнөөдөр бид нар өөрсдөө хуулиа хэрэгжүүлдэггүй. Өөрсдөө хариуцлагагүй байдаг буруугаа Үндсэн хууль руугаа чихээд сууж байгаа байхгүй юу. Одоо энэ ажлыг бид нар 27 жил хийж байна.

Батлагдсанаас нь л хойш хийж байна. Тэгээд олон нийтэд бол ямар хүлээлт үүсгэсэн бэ гэхээр болохгүй байгаа юм нь Үндсэн хуульд жаахан өөрчлөлт оруулчихвал цэгцрэх юм байна гэсэн л ойлголттой болчихсон. Тийм амархан цэгцрэхгүй шүү дээ. Үндсэн хуульд бид нар өнөөдөр асар их тийм дорвитой том өөрчлөлтүүдийг үнэндээ хийж чадахгүй. Энэ өөрчлөлтүүд нь бол улс орныг илүү тогтвортой, Засгийн газрыг тогтвортой бодлоготой болгох дэм тус болно. Гэхдээ бид нарын ярьж хэлээд байгаа шиг хүмүүсийн хүсэн хүлээгээд байгаа шиг өргөс авчихсан юм шиг ийм олон өөрчлөлтүүд хүмүүсийн амьдралд шууд мэдэгдээд явахгүй. Энийг бид нар олон нийтэд ойлгуулж хэлэх ёстой. Харин өнөөдрөөс эхлээд энэ Үндсэн хууль батлагдсанаас эхлээд нэмэлт, өөрчлөлт батлагдсанаас эхлээд доороосоо авхуулаад хамгийн дээд түвшиндээ хүртэл энэ төр засгийнхан маань байгаа хуулиа хэрэгжүүлдэг дээр анхаармаар байгаа юм. Улсын Их Хурал өдөр шөнөгүй хууль хэлэлцээд хуулийн нэмэлт, өөрчлөлт болтол ярьж байхаасаа илүү хуулийн хэрэгжилтийг шалгадаг болмоор байна. Тэгээд магадгүй одоо энэ хянан шалгах түр хороо байгуулагдаад ороод ирэх юм бол түүгээрээ хуулийн

хэрэгжилттэйгээ бид нар хянах бололцоо нэмэгдэх байх л даа. Тэрэн дээрээ илүү анхаарлаа хандуулмаар байна.

Г.Занданшатар: Цэдэнгийн Гарамжав гишүүн.

Ц.Гарамжав: Засгийн газрын өрийн дээд хэмжээг 60 хувь байлгая гэсэн Ардчилсан намын санал бол бодууштай, сонирхолтой санал байгаа юм. Тэгэхээр юу вэ гэхээр бүх улс орнуудад Засгийн газрын нийт өр, Засгийн газрын өр гэж байна л даа. Жишээлбэл манай улс орны нийт өр нийтдээ 29 тэрбум ам. доллар буюу 30 тэрбум дөхөж байна. Бусад бүх улс оронд АНУ, Орос, Япон гээд бүх улс орны нийт өр, Засгийн газрын өртэй байгаа. ДНБ-тэй харьцуулахад ОХУ жишээлбэл өрийн дээд хэмжээ нь 19 хувь байдаг юм байна. Гэтэл АНУ бол 104 хувьтай. Хятад бүүр 303 хувьтай. Тэгэхээр энэ улс орон бүрийн эдийн засгийн цар хэмжээнээс хамаараад Засгийн газрын өрийн дээд хэмжээний хил хязгаар тогтоогддог байгаа. Манай Монголд өнөөдөр судалгаа тооцоогоор манай Засгийн газрын өр бол ДНБ-тэй харьцуулахад 83 орчим хувь байгаа юм байна.

Ер нь Засгийн газрын өрийн дээд хэмжээ гэдгийг ярихад бол одоо төсвийн сахилга бат шууд холбоотой. Улс орны төсвийн сахилга бат гэдэг бол тухайн улс орны гадаад дотоод хөрөнгө оруулалтын нөхцөл байдлыг тодорхойлох, зээлжих зэрэглэлийг тодорхойлох маш чухал үзүүлэлт болдог. Жишээлбэл одоо Засгийн газрын өрийн дээд хэмжээ нь хил хязгаартай байсан улс орнуудын зээлжих зэрэглэл буюу лайбор нөхцөл, хүү нь бага болж байх жишээтэй. Энэ талаасаа бол төсөв нь сахилга баттай. Засгийн газрын авч байгаа хүү олон улсын хэмжээнд зөвшөөрөх дундаж харьцаатай юм орж ирэх эдийн засгийн сайн талуудтай байдаг юм байна. Манай улс өмнөх хөгжлийнхөө жилийн он жилүүдийг хараад байхад энэ өрийн хэмжээ маань ДНБ-ээсээ хэт давсан тал руугаа хазайх гээд байгаа учраас өнөөдөр энэ саналыг оруулж ирж байгаа байх. Ер нь одоо өнөөдөр 83 хувьтай байна. Цаашдаа нэг 60, 65 хувь байхад бол болохгүй гэх юу алга л даа, болох хязгаар.

Нэг хэсэгтээ төсвөө сахилга баттай эдийн засгийг тогтвортой хямралгүй байлгахын тулд энэ хязгаарыг тодорхой хугацаанд тавьж үзэх нь зүйтэй юм гэж бодож байна. Мэдээж хэрэг Үндсэн хуулиа хүндэтгэж байна.

Үндсэн хууль бол тэр бүр хүрээд байдаг хууль биш. Гэтэл өнөөдөр манай нийгэм, эдийн засгийн маань байдал зарим юмыг хуульчилж тэрийгээ хатуу дагаж мөрдөхөөс өөр аргагүй байдалд орсон байгаа учраас Үндсэн хууль дээрээ Засгийн газрын өрийн дээд хэмжээг зааж өгье гэсэн саналыг бол зүйтэй юм байна. Энийг тодорхой хэмжээнд дагаж мөрдөх нь зүйтэй байх. Тодорхой жилүүдэд улс орныхоо эдийн засгийг тогтворжтол, төсвийн сахилга бат нь хатуу чанга болтол тэр үе хүртэл бид нар энэ өрийн дээд хэмжээг дагаж унах нь зүйтэй байх гэж бодож байна.

Ер нь энэ өр зээл бол бүх урсгал нь байдаг л даа. Хөрөнгө оруулалтын асуудлууд. Яагаад тэр хөрөнгө оруулалтын асуудал нь төлж чадахааргүй одоо бүтээгдэхүүнээсээ даваад гараад яваад байдаг. Хамгийн гол нь бид нар энэ хөрөнгө оруулалт зээлдээ эдийн засгийн тооцоо судалгаа сайн хийдэггүй, шингээх чадвар байхгүй төслүүдэд зээл авдаг. Эргээд төлөлт нь байдаггүй. Мөн одоо инфляц болохоор тооцдоггүй. Ийм учраас өнөөдөр Монгол Улс маань ийм байдалтай орж ээ гэж харагдаж байна. Жишээлбэл улс орны хэмжээнд бүсчилсэн хөгжлийг түрүүн манай гишүүд ярилаа л даа. Урт хугацаандаа тогтвортой хөгжлийн бодлогууд чухал байна. Энийг бол дэмжиж байгаа. Даанч энэ санал уначихлаа.

Дараагийн хэлэлцүүлэг энэ дээр энэ саналыг би дахин болдог бол арай өөрөөр томъёолж өргөн барина гэж бодож байна гишүүдтэйгээ хамт. Тэгэхээр урт хугацааны тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалт энэ зээлжилтийн зэрэглэлийг одоо маш нарийн тооцсон тийм бодлоготой хөрөнгө оруулалтууд хэрэгтэй байдаг. Жишээлбэл, манай улс орны энэ Хөгжлийн банк байна шүү дээ. Хөгжлийн банканд ямар бодлогоор арилжааны банкнуудтай адилхан өндөр хүүтэй зээл өгөөд доллароор зээл өгөөд, Засгийн газрынхаа бодлогын эсрэг зээл өгөөд эргээд одоо аж ахуйн нэгжүүд дээрээ тэр долларынхоо хямралыг, долларын алдагдлыг аж ахуйн нэгжүүдээрээ төлүүлэх бодлого барьж байна. Өөрөөр хэлбэл Засгийн газар өр хэмжээгээ хэтрүүлээд буруу бодлого бариад эцэст нь аж ахуйн нэгж рүүгээ тэр алдагдлыг чихэж, бид нар дампуурахгүй ээ, та нар дампуур гэдэг бодлогыг барьж байгаа шүү.

Тэгэхээр энэ зээл хөрөнгө оруулалтын бодлогыг бол аль аль талдаа хязгаарлах хэрэгтэй гэж би бодож байгаа. Ямар үед зээл авах ёстой вэ. Ямар үед хөрөнгө оруулалт авах ёстой гэдэг эдийн засгийн тооцоо судалгаа шингээх төслүүд дээрээ бид нар энэ засаг төр маань зээл авч байх ёстой. Ялангуяа энэ экспортыг нэмэгдүүлэх гаднаас валют орж ирэх ийм төслүүдээ хамгийн түрүүнд дэмжих ёстой. Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, баялаг үйлдвэрлэх ийм төслүүдээ дэмжих ёстой. Ингэж байж одоо Засгийн газар маань зээл авахгүй бол манай гишүүдийн түрүүн ярьсан төсвийн алдагдлаа нөхөх, өмнөх өр зээлээ ондоо хүүтэй зээлээр дарах ийм үр ашиггүй, улс орны зээлийг хийдүүлсэн улам алдагдалд орсон ийм зээлүүдийн, чанаргүй зээлүүдийн юуг багасгах хэрэгтэй байгаа юм нийт хувь хэмжээг. Тэгэхээр энэ утгаасаа гэхэд би бол Монгол Улс нь ДНБ-тэйгээ харьцуулсан энэ зээлийн дээд хязгаар байх нь зүйтэй гэж бодож байна.

Харин тэр зээлийн дээд хязгаар нь түрүүний миний хэлсэн шиг 60 байх юм уу, 80 байх юм уу, 65 байх юм уу энийгээ бид нар хэлэлцэж тодорхойлох нь зүйтэй байх. Жишээлбэл, Япон Улсад Засгийн газрын нийт өр нь дотоодынхоо нийт бүтээгдэхүүнтэй харьцуулахад 104 хувь байна. Би түрүүн хэлсэн, Хятад Улсад бүр 303 хувь байна. Тэгэхээр өрийн дээд хэмжээний асуудал нь хэд ч байж болдог байна, ганцхан эдийн засгийн чадавх, дотоодын нийт бүтээгдэхүүний хувь хэмжээ, эдийн засгийн өсөлт, инфляц энэ бүхнээ нарийн тооцож байж тэр хил хязгаарыг тогтоох ёстой гэж бодож байна. За баярлалаа.

Г.Занданшатар: Одоо санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимдаа орж ирнэ. Олон гишүүд санал хэллээ. Мөнх-Оргил гишүүний, төрийн бодлого тогтворгүй байгаа чинь гүйцэтгэх засаглал тогтворгүй байгаатай шууд холбоотой. Жишээ татаад байгаа Хонконг, Сингапур зэрэг улсууд бол 5 эрх мэдлийн Үндсэн хуультай, төлөвлөлт, хуучнаар төлөвлөгөөний комисс шиг Эдийн засгийн хөгжлийн яам, төлөвлөгөөний байгууллагууд, Азийн эдийн засгийн загварт байгаа боловч Үндсэн хуулиар зохицуулагддаггүй ээ. Органик хуулиар энэ асуудлуудыг зохицуулах бололцоотой.

Гишүүд чуулганы танхимд орж ирээрэй. Санал хураалт. 64 гишүүн байна. Өнөөдөр цаг сунгаж хуралдаж байгаа, Олонхын саналаар тэгж шийдвэрлэсэн. Гадаа байгаа гишүүд орж ирээрэй. Санал хураалт явуулъя.

Энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

За, санал хураалт явуулъя. Санал хураалтыг хүчингүй болголоо. Санал гаргасан Эрдэнэбат гишүүний саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт. Миний бас хурууны хээ уншигдсангүй. Санал хураалт дууслаа. Дараагийн асуудалд оръё.

Төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалтад Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх аливаа оролдлогыг үл зөвшөөрөх бөгөөд мөнхүү зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг хориглоно гэсэн агуулгатай 2 дахь өгүүлбэр нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг, Төрийн байгуулалтын Байнгын хороо дэмжсэн санал байна.

Эрдэнэбат гишүүнээр тасаллаа, Пүрэвдорж гишүүн орлоо, Эрхэм гишүүн Данзангийн Лүндээжанцан үг хэлнэ.

Д.Лүндээжанцан: Энэ Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн төсөл, саналын нэг заалт нь энэ байгаа. Ер нь өөр газар бие даасан төсөл, заалт болохоор оруулж ирсэн. Бид хорин тавдугаар зүйл дотроо үүнийг байрлуулах нь зүйтэй юм, санал асуулгын нэгдүгээр бүлэгт оруулж ирсэн, үүнийг гуравдугаар бүлэгт Төрийн байгууллын хорин тавдугаар зүйлийн өөрчлөлтүүдтэй холбогдуулаад 35 хувиас хэтэрч болохгүй гэсэн заалттайгаа уялдуулаад ер нь энд байрлах нь зүйтэй юм гэж үзсэн.

Томьёоллын хувьд зарим зүйлийг жаахан янзалсан. Ийм учраас ер нь Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн байдлыг үгүйсгэх аливаа оролдлогыг үл зөвшөөрөх бөгөөд мөнхүү зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг хориглоно гэж. Тэгэхээр энэ өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх аливаа оролдлогыг үл зөвшөөрөх гэдэг нь хэдийгээр нэгдүгээр бүлгийн асуудал боловч санал асуулгатайгаа уялдаж байгаа учраас хорин тавдугаар зүйлдээ байх нь байрлалаа олох нь зүйтэй гэж үзсэн юм.

Хоёрт нь, нэгдүгээрт бид бүхэн 1945 оны 10 сарын 20-нд түүхэндээ анх удаа бөгөөд одоогоор дахин санал асуулга явагдаагүй байна. Тэнд Бүгд Найрамдах Монгол Ард Улс тусгаар тогтносон бүрэн эрхт улс мөн гэдэг энэ асуудлаар ард нийтийн санал асуулга явуулсан. Санал асуулга бол дотроо хоёр төрөлтэй байгаад байгаа юм. Плебисцит, референдум гээд. Тэгэхээр энэ бол плебисцит буюу тусгаар тогтнол бол гадагшаагаа хандсан байдаг учраас Монгол Улсын статус-квог хүлээн зөвшөөрөхтэй холбоотой түүхэн том сонголтоо бид нэгэнт хийсэн. Ийм учраас энэ асуудлаар дахин давтан санал асуулга явуулахгүй юм гэдэг энэ санаагаар энэ санал орж ирсэн гэж бид ойлгосон. Тийм учраас ажлын хэсэг дээр энэ саналын томьёоллыг найруулж хийгээд, байрлалын хувьд хорин тавдугаар зүйл дотроо оруулж өгч байгаа юм гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Дондогдоржийн Эрдэнэбат үг хэлнэ. Татгалзаж, дэмжиж энэ заалтаар үг хэлнэ.

Д.Эрдэнэбат: За баярлалаа. Энэ улсын тусгаар тогтнолтой холбоотой, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалтай холбоотой асуудлаар урьд нь Үндсэн хуульд яг тодорхой заалт ороогүй байсан учраас үүнийг би дэмжиж байгаа юм. Үүнийг бүгдээрээ дэмжих байх. Гэхдээ ганцхан ойлгомжгүй үг байгаад байна. Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх аливаа оролдлогыг үл зөвшөөрөх бөгөөд гэж байгаа, тэгэнгүүтээ мөнхүү зорилгоор гээд, мөнхүү гэж ямар үг байдаг юм бэ.

Үндсэн хуульд ийм нэг үл ойлгогдох үгнүүдийг хийх буруу гэж харж байгаа. Үүнийг харин ийм зорилгоор ч гэдэг юм уу, энэхүү зорилгоор ч гэдэг юм уу, үгийн санд байдаг, Монгол үгийн санд байдаг үгээр зайлшгүй солих ёстой шүү, редакц хийх ёстой шүү гэж би анхааруулж хэлмээр байгаа юм.

Бид нар дэмжих юмаа дэмжээд явна. Бодлогын шинжтэй гол зүйлүүдээ орхигдуулсан юм дээр бид нар саналаа гаргаад явж байгаа. Аль хүртэл явахыг би хэлж мэдэхгүй байна. Тэгэхдээ түрүү бидний гаргасан Засгийн газрын өрийн хэмжээний асуудал дээр манай гишүүд жаахан хойрго хандав уу гэж би бодож байна.

Ер нь цаашдаа хурлын дарга зарчим бариарай. Ямар ч санал хураасан, унах ч бай, босох ч бай санал хураасан гишүүдээ бүрэн бүтэн байлгаж байж санал хураалт зайлшгүй явуулах хэрэгтэй шүү. Одоо жишээлбэл, түрүүн гишүүд бүрэн орж ирээгүй байхад санал хураалт явууллаа. Одоо энэ санал хураалтаа шууд явуулах ёстой шүү гэдгийг би бас хэлмээр байна. Гишүүдийг хүлээгээд өөрсдийнхөө дэмжихгүй санал дээр нэг ч хүнийг хүлээгээд аваад байдаг, бид нарын асуудал дээр дэмжих ёстой шүү, зарчмын юм дээр хоорондоо яриагүй бол дэмжихгүй гэсэн байдалтай хандлага гаргаж байгаа нь тун буруу шүү гэж хэлмээр байна. Түрүү Үндсэн хууль дээр ямарваа нэгэн намын ялгаа байх ёсгүй, бүгдээрээ ярилцах ёстой гээд ярьж байгаа боловч үйлдэл чинь өөрөө ярианаасаа зөрж байгаа шүү гэдгийг би Их Хурлын даргад дашрамд нь хэлье гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Ойлголоо. Пүрэвдорж гишүүн. Пүрэвдорж гишүүн алга байна. Эрхэм гишүүн Сандагийн Бямбацогт. Одоо санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимдаа орж ирээрэй.

С.Бямбацогт: Энэ заалтыг Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн төсөл, саналдаа оруулж ирсэн. Манай гишүүд, олон нийтэд бас ойлголтууд зөрүүтэй явж байгаа. Гишүүдийн өргөн мэдүүлсэн төслөөс гадна өөр төслийг хэлэлцээд байна, зэрэгцүүлж санал хураалгаж байна, энэ чинь журмын тухай хуулиа зөрчиж байгаа юм уу гэсэн асуудал ярьж байгаа. Би тэгэхээр хууль тайлбарлаад өгөх нь зөв болов уу гэж бодож байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч чуулганд өөрийн тааллаар оролцоно, хэдийд ч оролцож болно, улс орны гадаад, дотоод байдлын нэн чухал асуудлаар мэдээлэл хийж, саналаа оруулж болно гэж заасан байдаг. Үүний дагуу Үндсэн хуулийн эхний хэлэлцүүлгийн дараа Монгол Улсын Ерөнхийлөгч “би одоо Үндсэн хууль дээр саналаа өгнө” гэж хэлээд наадмын өмнө, наадмын дараа 7 сарын 16-нд Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл, саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Энэ нь Үндсэн хуульд заасан Монгол Улсын Ерөнхийлөгч чуулганы хуралдаан, Байнгын хорооны хуралдаанд тааллаараа оролцож өөрийнхөө саналыг хэдийд ч гаргаж болно гэсэн Үндсэн хуулийн заалттай бол нийцэж байгаа гэдгийг нэгдүгээрт нь хэлье.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11.3-ийн дөрөвт Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хоёр төслийг зэрэгцүүлж хэлэлцэж болохгүй, хэрвээ өөр үзэл баримтлал бүхий төслийг хууль санаачлах эрх бүхий субъект өргөн мэдүүлсэн тохиолдолд түүнийг саналын түвшинд харгалзан үзнэ гэсэн ийм журмын тухай хуулийн 11.3-ийн дөрөвт ийм

заалт байдаг. Энэ заалтын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл, саналыг бид нар саналын түвшинд харгалзан үзсэн.

Ингэж саналын түвшинд харгалзан үзэхдээ Улсын Их Хурлын 72 дугаар тогтоолоор Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн төслийг судалж үзэх, олон нийтийн дунд хэлэлцүүлэг хийх, санал бодол солилцох, мөн саналын түвшинд харгалзан үзэх ажлыг судлах ийм ажлын хэсэг байгуулагдсан. Энэ ажлын хэсэгт Ерөнхийлөгч бас ахалж оролцоод, Ардчилсан намын дарга, Ардчилсан намын зөвлөлийн дарга, шинэ намаас Болд гишүүн, Ардын намын холбогдох гишүүд оролцож үүнийг саналын түвшинд харгалзан үзээд, Улсын Их Хурлын 68 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг буюу Энхтүвшин даргаар ахлуулсан ажлын хэсэгт саналаа танилцуулаад, ажлын хэсэг маань энэ саналыг авч үзэж болох юм байна гэж шийдвэрлээд Байнгын хороонд оруулсан. Байнгын хороонд оруулахаас өмнө бас бүлгээр оруулж танилцуулж, энэ саналыг дэмжих нь зүйтэй юм байна гэж үзсэн байгаа.

Байнгын хороон дээр 68 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн оруулсан санал байдлаар орж, энэ санал маань хураагдаж, Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Үндсэн хууль болоод Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг зөрчөөгүй, энэ санал хураагдаж байгаа.

Зарим нэг гишүүд ярьж байгаа. Адилхан хууль санаачлах эрхтэй субъект, тийм болохоор бид нар бас бидний санал, бүлгийн саналыг та нар саналын түвшинд харгалзан үзэх ёстой гэсэн байгаа. Үүн дээр бас журмын тухай хуульд маш тодорхой заалт заасан байгаа. Журмын тухай хуулийн 13.3-т байнгын хороо болон түүний гишүүн, нам эвслийн бүлэг нь төсөлд тусгагдаагүй шинэ хэсэг, заалтын томъёоллыг санал дүгнэлтэд оруулж болохгүй гэсэн зохицуулалттай. Энэ нь Улсын Их Хурлын субъектүүдэд хамаарах ойлголт. Хэдийгээр Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүд адилхан хууль санаачлах эрхтэй, санал гаргах эрхтэй боловч Ерөнхийлөгч Үндсэн хуульд зааснаараа өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд хэдийд ч саналаа гаргах эрхтэй. Үүний дагуу саналаа гаргасан. Улсын Их Хурлын гишүүдийн санал гаргах асуудлыг хөндөгдөөгүй заалтаар санал гаргахыг хязгаарласан заалт байгаа юм. Энэ хүрээндээ энэ зохицуулалт орж ирж байгаа. Үүнтэй адилхан бас хэд хэдэн заалтууд, Ерөнхийлөгчийн саналууд авагдсан байгаа. Саяны, гишүүд энэ журмын дагуу, журмын тухай хуулийн дагуу, Үндсэн хуульд заасны дагуу явах ёстой гэдгийг мэдээлэл болгоод хэлчихье гэж бодож байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд чуулганы танхимд орж ирээрэй. Сайд нар, гишүүд чуулганы танхимд орж ирээрэй. Содбаатар гишүүн үг хэлнэ.

Я.Содбаатар: Би больчихъё, нэрээ татъя.

Г.Занданшатар: Нэрээ татаж байгаа юм уу. Мөнхүү гэдэг дээр үү, мөнхүү гэдэг дээр би ч тайлбар хэлэхгүй л дээ. Тайлбар хэлэхгүй, харин найруулгаар, гурав дахь хэлэлцүүлэг дээр үүнийгээ засаж мөнхүү гэсэн үгээ, гуравдугаар хэлэлцүүлэгт оруулахдаа ажлын хэсэг засаж ирээрэй гэсэн чиглэл өгч байна. Тайлбар би өгч мэдэхгүй.

Та чинь өөрөө л тайлбар нэхсэн шүү дээ. Мөнхүү шалтгаанаар гэж энэ 40 оны Үндсэн хуулиас Чимид гуай авч хэрэглэсэн үг байна.

Хадгална гэдэг үг байна, Улсын Их Хуралд хадгалагдана гэдэг үг шүүмжлэгдээд, 1924 оны Үндсэн хуульд.

Ингээд төслийн заалтыг дахин уншиж танилцуулъя.

11.Төслийн 2 дугаар зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалтад Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх аливаа оролдлогыг үл зөвшөөрөх бөгөөд мөнхүү зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг хориглоно гэсэн агуулгатай хоёр дахь өгүүлбэр нэмэх.

Санал гаргасан, ажлын хэсэг. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, ороогүй гишүүн байвал, Эрдэнэбат гишүүний микрофоныг өгье, протоколд тэмдэглэх.

Д.Эрдэнэбат: Энэ санал сая нийт гишүүдээр дэмжигдэж байна л даа. Гэхдээ би саналаа өгөхдөө миний хурууны юу контакт авсангүй. Протоколд дэмжсэнээр тэмдэглүүлье.

Г.Занданшатар: Техникийн саатал гардгийг баталгаажлаа. Бат-Эрдэнэ гишүүн, Эрхэм гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ.

Б.Бат-Эрдэнэ: Би санал дэмжсэн. Энэ уншигдсангүй, дэмжиж санал өгсөн, протоколд тэмдэглүүлж байна.

Г.Занданшатар: Бат-Эрдэнэ гишүүн дэмжсэн байна. Чойжилсүрэн гишүүн.

Б.Чойжилсүрэн: Саяын санал хураалт дээр миний санал хураах тоног төхөөрөмж дээр техникийн саатал гарсан юм шиг байна. 3 удаа дараад, би дэмжиж санал өгсөн шүү. Протоколд тэмдэглүүлье.

Г.Занданшатар: Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Энэ шар нь асаад, тийм гэдгийг дарсан мөртөө эсрэг гарч байна шүү дээ. Энийгээ анхаар. Минийхийг нэг бол ерөөсөө дандаа эсрэг өгнө гээд автоматаар тэгчихсэн юм уу, тэгвэл би энд суугаад байх шаардлага байхгүй шүү дээ. Тэгвэл би явчихсан нь дээр биз дээ. Та нар битгий надыг ирсэнгүй гээд бай л даа. Тэртээ тэргүй л эсрэг гарахаар программчилсан байна шүү дээ.

Г.Занданшатар: Санал хураалтад 64 гишүүн оролцсоноос 62 гишүүн дэмжиж энэ санал дэмжигдлээ. Төхөөрөмж дээр 51 санал дэмжигдсэн. 4 гишүүн санал нь зөрүүтэй гарсныг протоколд тэмдэглүүлсэн учраас 62 гишүүнээр тооцож дэмжлэгийг тооцлоо. Протоколд тэмдэглэж байна. Цааш үргэлжлүүлнэ.

12. Энэ 12 дугаар бүлэг заалтуудыг хойшлуулах саналд орсон зүйлүүд байна. Одоо 13- руу орно.

Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж Улсын Их Хурал шийдвэрлэсэн бол Улсын Их Хурал тарна. Төслийн заалт.

13.1-ийг уншиж танилцуулах ёстой юу, үгүй юу.

За, төслийн заалтаар санал хураалт явуулъя. Төслийн заалтыг дэмжинэ биз дээ. Үүнийг бас ярихгүй бол. За санал хураалт явуулъя.

Дараагийн заалт 13.1. Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

2. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэн эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн санал болгосноор Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар өөрөө тарах шийдвэр гаргаж болно.

Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн.

Санал хураалт. Санал хураалтад 64 гишүүн оролцож, 60 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ.

14.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

6.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуулийг Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар батална. Төслийн заалт. Санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцож 11 гишүүн дэмжиж санал дэмжигдсэнгүй.

Санал дэмжигдээгүй учраас дараагийн санал.

14.1.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу Хорин долдугаар зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах. Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийг гэж хэлээч, 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

6.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуулийг Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонхийн саналаар эцэслэн батална.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн.

Бүхэлд нь эцэслэн батална гэсэн томъёоллыг найруулгын хувьд засаад авахаар дэмжигдсэн гэсэн тайлбартай байна. Найруулгын хувьд бүхэлд нь гэсэн санал. Санал хураалт. Дордуулсан долоон өөрчлөлт, дордуулсан ч юу байх вэ, долоон өөрчлөлтийг засна гэж байгаа юм. Содбаатар гишүүн.

Я.Содбаатар: Би сая санал өгч байхад хэлсэн, техникийн шалтгаанаар миний санал орсонгүй, энэ саналыг анхнаасаа дэмжиж байсан учраас саяны санал

хураалтыг хүчингүй болгож өгнө үү. Дахин санал хураана шүү дээ. Дэгээрээ явна гэсэн шүү дээ.

Г.Занданшатар: Дахиад өөр, Учрал гишүүн.

Н.Учрал: Саяын саналыг дэмжиж байгаа учраас санал хураалтыг дахин явуулах санал гаргаж байна. Санал хураалтыг хүчингүйд тооцож өгнө үү.

Г.Занданшатар: Болдын Жавхлан гишүүн.

Б.Жавхлан: Бас адилхан, протоколд бүртгүүлээд дэмжсэнээр санал оруулаад, нэмээд болно гэвэл тэгээд явъя, болохгүй гэвэл саналаа дахин хурааж өгөөч ээ, энэ саналыг хүчингүй болгож өгнө үү. Алинаар нь явах юм бэ.

Г.Занданшатар: 3 гишүүний санал техникийн шалтгаанаар буруу хураагдсан санал гаргасан учраас, 58 гэсэн дүн гарч байгаа учраас, энэ санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

Санал хураалт явж байна шүү дээ. Энэ санал хураалт хүчингүй боллоо. Одоо саяны санал хураалтаар дахин санал хураалт явна. 1 дэх санал хураалтыг дахиж явуулна. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

Санал хураалтад 63 гишүүн оролцож 57 гишүүн дэмжиж энэ санал дэмжигдлээ. Содбаатар гишүүн. Протоколд тэмдэглэгдэхгүй бол дараа нь бас.

Я.Содбаатар: Сая дахиад техник ажилласангүй, гэхдээ 57 даваад батлагдсан учраас, протоколд тэмдэглэгдсэн учраас баярлалаа.

Г.Занданшатар: Содбаатар гишүүний төхөөрөмжийг шалгаж үзээч, санал дэмжигдлээ. 58-аар тооцлоо.

Дараагийн санал хураалт. 14 дүгээр санал хураалт. Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах. Дараагийнх нь 15 дугаар санал хураалт. 15 дугаар санал хураалт байна. Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17 дахь заалт буюу Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийг нэмэх.

17. Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг.

1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно. Санал гаргасан ажлын хэсэг. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн.

Үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Үг тасаллаа.

Эрхэм гишүүн Жамъянгийн Мөнхбат үг хэлнэ.

Ж.Мөнхбат: Энэ, манай гишүүд нэг зүйл дээр анхаараарай. Улсын Их Хурлын гишүүн бол хууль санаачилж, Их Хурал батална. Энэ үндсэн, хэнтэй ч хуваалцдаггүй бүрэн эрх нь, үүрэг нь. Улсын Их Хурлын гишүүдийн хууль санаачлах эрхийг, хүрээ хязгаарыг хуулиар тогтооно гээд ийм бас нэг хуульд тодорхой хэмжээний хязгаарлалт орсон ийм юм ороод явах юм биш биз дээ. Үүнийг Лүндээжанцан гишүүн сайн яаж байгаа биз дээ. Үүн дээр чинь хэд хэдэн удаа ярьсан шүү дээ. Санал гаргасан. Тийм учраас Их Хурлын гишүүдийн, Их Хурлын бүрэн эрх рүү гар дүрсэн ийм заалт Үндсэн хуульд суугаад явж байгаа юм биш биз дээ. Үүнийг, одоо асуулт байхгүй юу. Тийм учраас үүн дээр тодруулга өгөөч. Бямбацогт гишүүн.

Г.Занданшатар: Лүндээжанцан даргын микрофоныг. Тодруулга биш үг хэлэх маягаар, таны үг энд байсан, хасагдчихаж.

Д.Лүндээжанцан: Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар чуулганд өөрийн тааллаар оролцон үг саналаа оруулж болно гэж заасны дагуу мөн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11.3-ийн 4-т зааснаар урьдчилан тогтсон нэг төсөл буюу Их Хурлын гишүүдийн өргөн мэдүүлсэн төслийг нэгэнт хэлэлцэж эхэлсэн тул Ерөнхийлөгчийн төслийг мөн заалтын саналын түвшинд харгалзана гэсний дагуу, энэ хуулиудын дагуу бид энэ асуудлыг ажлын хэсэг дээр ярьж оруулж ирсэн.

Энэ Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн. Ер нь бусад улсын Үндсэн хуульд ийм жишиг байх нь байдаг, Улсын Их Хурлын хууль санаачлах эрх бол Парламентын гишүүнд байна, Ерөнхийлөгчид байна, Засгийн газарт байна, мөн тодорхой тооны иргэд, 100 мянган иргэн ч гэдэг юм уу, ингээд хууль санаачлах эрхтэй гэсэн ийм хувилбарууд бусад улсын Үндсэн хуульд байгаа юм.

Мөн хүрээ хязгаарыг тогтоосон, 8-аас доошгүй гишүүн нийлж хууль санаачилна гэдэг ч юм уу, тодорхой тооны тоо тавьсан ийм зүйл зарим улсуудын Үндсэн хуульд байна. Засгийн газар Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой хууль санаачлахгүй, Парламентын үйл ажиллагаатай холбоотой хууль санаачлахгүй гэсэн ийм заалттай улс орон байна.

Тэгэхээр хуулиар, Ерөнхийлөгчийн хувьд Үндсэн хуульд заасан Үндсэн хуулийн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрээнд заасан эрх эдэлнэ гэсэн заалтыг бид үүнд оруулж өгч байгаа. Үүнтэй холбогдуулаад Ерөнхийлөгч зөвхөн Зэвсэгт хүчний ерөнхий командлагч, гадаад харилцаанд улсаа төлөөлөх болон бусад хуулиар тогтоосон эрхийн, тэр шагналын ч юм байдаг юм уу, өршөөлтэй холбоотой ийм хуулиудаа санаачлах нь Ерөнхийлөгчийн эрх.

Засгийн газар бол татвартай холбоотой, төсөвтэй холбоотой хууль санаачлах нь Засгийн газартаа байх жишээний. Салбарын хуулиуд. Улсын Их Хурлын гишүүдийн хувьд албан татвартай холбоотой ч байдаг юм уу хууль санаачлахгүй байх гэсэн энэ агуулгаар орж ирсэн юм байна гэж би тайлбараас ойлгосон. Тэгэхээр энэ асуудлыг манай 62 гишүүний оруулж ирсэн төсөлд байхгүй. Ерөнхийлөгчийн оруулж ирсэн төсөлд энэ заалт энэ агуулгаар орж иржээ гэж хууль санаачилж оруулж ирсэн Ерөнхийлөгчийн төлөөлөл бол тэр 5 хоногийн хэлэлцүүлгийн явцад тайлбарлаж байсан гэдгийг би та бүхэнд дамжуулж хэлье гэж бодож байна.

Ер нь энэ асуудал байнга яригддаг. Бид бол Их Хурал байсан гээд энэ талын шүүмжлэлд ордог, хууль санаачлагч нэг хэсэг, энэ Парламент бол харьцангуй гайгүй байна. Ер нь хууль санаачлах тоогоороо уралддаг явдал ч гардаг. Тэгээд л юу санасан хуулиа санаачилж байдаг, ийм л зүйл гардаг гэдэг шүүмжлэл их олон жил яригдсан. Тэгээд онол практик, эрдэм шинжилгээний хурлууд дээр энэ асуудал их яригддаг. Иргэдийн түвшинд ч яригддаг. Засгийн газрын санаачлах ёстой хуулийг Их Хурлын гишүүн шүүрч аваад юм уу, санаачлаад явдаг энэ бүхэн бол хуулийн чанар, хуулийн боловсруулалтын түвшин, бас зарим тохиолдолд лоббины асуудал гэх мэтчилэн ийм шүүмжлэлүүд гардаг учраас энэ санал орж иржээ гэж ингэж ойлгож байгаа юм.

Би бол тодруулга, тайлбар өгч байна.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Лхагвын Мөнхбаатар үг хэлнэ.

Л.Мөнхбаатар: Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөө хэлэлцэж байгаа энэ явцад тодорхой бусад хуулиудыг зөрчиж болохгүй. Хэрвээ зөрчигдвөл Үндсэн хуулийн маань өөрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал, хууль зөрчиж баталсан ийм асуудал үүсэх юм бол их төвөгтэй байдал руу орох юм байгаа юм.

Тэгэхээр үүн дээр, хэд хэдэн зүйл дээр, Ерөнхийлөгчийн оруулж ирсэн санал дээр ч гэдэг юм уу бас хууль зөрчигдөх байдал үүсчхээд байна гэж хэлэх гээд байна. Сая Лүндээжанцан гишүүн ч хэлж байна. Энэ бол өргөн баригдсан төсөлд байхгүй, хөндөгдөөгүй заалт. Одоо 26.1 дэх хэсэг гээд байгаа. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ хязгаарыг хуулиар тогтооно гэж байгаа юм. За яах вэ, хууль санаачлах эрхийг хуульд заасан хэмжээ, хязгаарт хязгаарлах саналыг агуулгын хувьд дэмжиж байгаа боловч өргөн мэдүүлсэн төсөлд байхгүй, энэ зүйлд санал гаргаж, өргөн мэдүүлсэн төсөл байхгүй зүйлийг ажлын хэсэг буюу Их Хурлын гишүүд санал гаргасныг нь Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээд явсан байна.

Улсын Их Хурлын гишүүд буюу энэ ажлын хэсэг Үндсэн хуулийн 26.1 дэх хэсгийг өөрчлөх санал гаргасан нь энэ Төрийн байгуулалтын байнгын хороо үүнийг хэлэлцсэн нь өөрөө хуульд нийцэж байгаа юу. Хуульд нийцэж байгаа юу.

Энэ нэмэлт, өөрчлөлтийн хууль ёсны байх, хүлээн зөвшөөрөгдөх энэ байдалд нөлөөлөх юм биш үү гэж та бүгдэд хэлэх гээд байгаа юм. Үүнийг та бүгд анхааралдаа авч тогтож яримаар байна.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13.3-т байнгын хороо, гишүүн, нам, эвсэл бүлэг төсөлд тусгагдаагүй шинэ хэсэг, заалтын томъёоллыг санал дүгнэлтэд тусгаж болохгүй гэсэн байгаа. Өөрөөр хэлбэл гишүүд ийм санал гаргахыг бол хориглосон байна. Тэгэхээр Байнгын хороо энэ саналыг бас хэлэлцэхийг хориглосон байгаа.

Гэтэл үүнийг хэлэлцээд явсан байгаа. Ерөнхийлөгчид мэдээж хориглоогүй, энд эрх зүйн үндэслэл байгаа. Үндсэн хуулийн 33.3 дахь хэсэгт Ерөнхийлөгч Улсын Их Хурлын чуулганд өөрийн тааллаараа оролцон улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлэл, саналаа оруулж болно гэсэн заалтын хүрээнд оруулж ирсэн гэж ойлгож байгаа. Гэхдээ Ерөнхийлөгчийн гаргасан саналуудыг Улсын Их Хурал хэлэлцэх ёстой. Улсын Их Хуралд хэлэлцэх ёстой.

Учир нь Ерөнхийлөгч чуулганд санал гаргана гээд тодорхой заасан байгаа учраас үүнийг хэлэлцэж болно. Чуулган гэдэг нэгдсэн хуралдааныг ч хэлж байгаа, байнгын хорооныхоо хуралдааныг ч гэсэн хэлж байгаа юм.

Гэтэл одоо хэлэлцэгдэж байгаа энэ санал дээр Ерөнхийлөгчийн санал биш, ажлын хэсгийн буюу Улсын Их хурлын гишүүдийн хамтран гаргасан санал гэдэг томъёоллоор бид хэлэлцээд яваад байна. Ерөнхийлөгчийн санал гээд бид хэлэлцээд явбал болж байгаа, би ойлгож байгаа, хуульд нийцэж байна. Ажлын хэсэг гээд Улсын Их Хурлын гишүүд гаргасан гээд байх юм бол энэ өөрөө хөндөгдөөгүй заалтыг гишүүд оруулж ирсэн хуулийн ийм хийдэл гарч байна. Хууль зөрчсөн байдал үүсэж байна гэж хэлэх гээд байгаа юм. Тийм учраас энэ байдлаа бид нар засаад, Ерөнхийлөгчийн санал гэдэг агуулгаар нь бид хэлэлцээд явахгүй бол агуулга, бичилтээр нь, томъёоллоор нь ингэж явахгүй байж болно. Их Хурлын гишүүд хөндөж оруулж ирж байгаа юм шиг ингэж явах нь энэ бол өөрөө хууль зөрчинө. Ингэх юм бол Үндсэн хуулийн цэц дээр очно. Хүчингүй болно, Үндсэн хуулийн өөрчлөлтийн энэ асуудлууд чинь тодорхойгүй байдал руу очно

гэдгийг би хэлэх гэж байгаа юм. Агуулгын хувьд Ерөнхийлөгч эдгээр саналуудыг дэмжсэн байж болох юм. Гэхдээ хэлбэрийн хувьд Улсын Их Хурлын гишүүд анх өргөн баригдсан төсөлд тусгагдаагүй, хөндөгдөөгүй ийм санал гаргаж хэлэлцүүлэх нь өөрөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиа зөрчинө.

Ийм учраас Ерөнхийлөгчийн санал гэдгээр нь цаашдаа хэлэлцээд, бусад саналуудыг ч гэсэн Ерөнхийлөгчийн саналыг хэлэлцэж болно. Гэхдээ Ерөнхийлөгчийн санал гэдгээр нь явахгүй бол болохгүй гэдгийг би энд зориуд хэлье гэж бодож байгаа. Ер нь энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг хэлэлцэх явцад өчүүхэн төдий ч хууль зөрчиж болохгүй. Хуульдаа бүгдийг нийцүүлж явахгүй бол энэ нь өөрөө сайн хууль батлаад гаргадаг, гэхдээ өөрөө хууль зөрчиж баталсан гэдэг юм уу, аль эсвэл хууль дээдлэх зарчим зөрчигдсэн гэдэг асуудал яригдах юм бол өөрөө Үндсэн хуулийн маань энэ өөрчлөлт хүлээн зөвшөөрөгдөх байдлаа алдана. Энэ байдалд сөргөөр нөлөөлнө гэж би бодож байгаа юм. Энэ асуудал эргээд төслийн 21, 24 дээр бас байгаа шүү дээ, Улсын Их Хурлын гишүүдийн тоо, хугацаатай холбоотой гээд заалтууд мөн адил яг Ерөнхийлөгчийн санал дээр явах ёстой гэж би бодож байна. Үүнийг ажлын хэсгийнхэн, Их Хурлын дарга анхааралдаа аваад, энэ зүйлээ засаад явах нь зүйтэй байх аа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Нямбаатар гишүүн, Бямбацогт гишүүн хоёр саяны хуульд заасан асуудлаар тайлбар өгөх байх гэж бодож байна. Эрхэм гишүүн Хишгээгийн Нямбаатар.

Х.Нямбаатар: Та бүхэнд энэ оройн мэндийг хүргэе. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Үндсэн хуулиар 78 субъект хууль санаачлах эрх эдэлж байгаа. 76 Их Хурлын гишүүн, Засгийн газар, Ерөнхийлөгч гэсэн 78 субъектэд хууль санаачлах эрх хадгалагдаж байгаа.

2017 оны 1 дүгээр сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчилсэн шиг санагдаж байна. Хууль тогтоомжийн тухай хуулиар хууль санаачлах эрх бүхий субъектүүдийн хууль санаачлах хүрээ хязгаарыг хууль тогтоомжийн хуулиар бас тодорхой хязгаарлаж өгсөн.

Хууль тогтоомжийн хууль үйлчилж эхэлснээс хойш яг өнөөдрийн байдлаар Үндсэн хуулийн цэцэд хэн нэг хүн хандаж, Хууль тогтоомжийн хууль нь Үндсэн хуулийн дээрх субъектүүдийн хууль санаачлах эрхийг хязгаарлажээ гэдэг ийм Үндсэн хуулийн маргаан үүсгэсэн зүйл одоогоор алга байна. Хууль тогтоомжийн хуулиар яагаад хязгаар тогтоож өгсөн бэ гэхээр тодорхой салбарын багц хуулиудыг зөвхөн мэргэжлийн Засгийн газар санаачилж, тооцоо судалгааны үндсэн дээр оруулж ирэх ёстой гэдэг ийм шаардлага, шалгуурыг тавьсан.

Тэгэхээр өнөөдрийн энэ бид нарын хэлэлцэж байгаа зүйл заалт дээр бол би саналын түвшинд оруулж ирсэн субъект, дараах үндэслэл нөхцөлүүдийн үүднээс оруулж ирсэн байх гэж ойлгож байгаа.

Өөрөөр хэлбэл мэргэжлийн Засгийн газар, улсын урт болон дунд хугацааны хөтөлбөрт нийцүүлсэн салбарын болон томоохон багц хуулиудыг оруулж ирэхдээ мэргэжлийн Засгийн газрууд нь оруулж ирдэг, хүрээ хязгаарыг нь тогтоодог. Ерөнхийлөгч өөрт олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хуульд заасан 13 орчим чиг үүрэг байдаг, тэр хүрээн дэх хуулийн төслийг санаачлах эрх нь Ерөнхийлөгчид хадгалагддаг. Бусад хууль санаачлах хүрээ хязгаар нь Улсын Их Хурлын гишүүдэд хадгалагдах болов уу гэсэн ийм агуулгаар бид ойлгож, энийг ажлын хэсэг дээр хэлэлцсэн гэдгийг энэ дашрамд хэлье.

Бямбацогт гишүүн та Ерөнхийлөгчийн саналыг саналын түвшинд хэлэлцэж байгаа нь өөрөө Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуультай зөрчилдөөгүй, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуульд нийцэж байгаа гэдэг талаас нь бас нэмээд тодотгоод хэлнэ үү.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Сандагийн Бямбацогт.

С.Бямбацогт: Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11.3.4-т ингэж заасан байгаа, “Чуулганаар урьдчилан тогтсон зөвхөн нэг төсөл хэлэлцэнэ, өөр өөр үзэл баримтлалтай хоёр буюу хэд хэдэн төслийг саналын түвшинд харгалзан үзэж болох ба харин бие даасан байдлаар зэрэгцүүлэн хэлэлцэхийг хориглоно” гээд. Саналын түвшинд харгалзан үзэхийн тулд түрүүн би хэлсэн. Улсын Их Хурлын 72 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг гарсан, зөвшилцсөн, аль зүйл заалтыг нь авч болох вэ, аль зүйл заалтыг нь шингээж болох вэ, аль зүйл заалтыг нь авах боломжгүй байна гэдгээ зөвшилцөөд Улсын Их Хурлын 68 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн. 68 дугаар тогтоолын ажлын хэсэг маань харгалзан үзэж, байнгын хорооны хуралдаанд оруулсан.

Бие даасан байдлаар зэрэгцүүлэн хэлэлцэхийг хориглоно гэдэг маань энэ Их Хурлын гишүүдийн санал, энэ ажлын хэсгийн санал гэж орчхоод, өөр өөр үзэл баримтлал бүхий өөр төслийг энэ бол Ерөнхийлөгчийн өргөн барьсан төслийн санал гэж зэрэгцүүлж болохгүй гэдгийг 11.3.4-т заагаад өгсөн байгаа юм. Тийм учраас бие даасан байдлаар зэрэгцүүлээд явах юм бол Мөнхбаатар гишүүний хэлж байгаагаар Ерөнхийлөгчийн саналыг Ерөнхийлөгчийн санал гэж хураалгах юм бол энэ 11.3.4-т заасан бие даасан байдлаар зэрэгцүүлэн хэлэлцэхийг хориглоно гэснийг зөрчих гээд байгаа юм.

Тийм учраас ажлын хэсэг байгуулагдаад, 72 дугаар тогтоолоор ажлын хэсэг байгуулагдаад зөвшилцөөд саналын түвшинд харгалзан үзээд түүнийгээ 68 тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэгт өгөөд, ажлын хэсэг маань ажлын хэсгийн санал гэж оруулж ирээд, хураалгаж явж байгаа юм. Үндсэн хуулийн 33.3-т Ерөнхийлөгч чуулганд өөрийн тааллаар оролцоно. Улс орны дотоод гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлэл, саналаа оруулж болно гэж заасан байгаа.

Энэ нь үндсэндээ Ерөнхийлөгч бол Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд хэдийд ч оролцож болно, саналаа хэзээ ч гаргаж болно гэдгийг Үндсэн хуульд заагаад өгсөн. Ерөнхийлөгч Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд энэ саналыг гаргасан. Энэ саналыг нь харгалзан үзэх байдлаар бид авсан.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд бас Ерөнхийлөгч ямар заалтуудыг санал гаргаж болохгүй вэ, Улсын Их Хурал ямар заалтуудыг санал гаргаж болохгүй вэ гэдэг хязгаарыг бас заагаад өгчихсөн байж байгаа. Тийм болохоор энэ хязгаарыг бодолцох ёстой юм. Тийм болохоор үндсэндээ Ерөнхийлөгч бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн хязгаарласан, хориглосон заалтуудын хүрээнд биш боломжтой заалтуудын хүрээнд бас санал гаргасан. Энэ бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль зөрчөөгүй.

Энэ заалтын тухай ярихад Их Хурлын гишүүний бүрэн эрхийг тодорхой хэмжээгээр хязгаарлаж байгаа юм биш үү гэсэн асуудал яригдаж байгаа. Үүнийг бас ажлын хэсэг дээр нэлээн ярьсан. Нэлээн ярьсан. Ингээд үндсэндээ сая Лүндээ гишүүн нэлээн сайн тайлбарласан. Дур дураараа, өглөө унтаж босож ирээд хууль санаачилдаг, тэр нь юу гэдэг юм, улс орны нийгэм эдийн засгийн амьдралд

тодорхой хэмжээний нөлөөлөхүйц байдалтай, дээрээс нь ард түмэнд таалагдахын тулд хэт их популист хууль санаачилдаг, эсвэл сонгуулийн амлалт, сонгуульд ялахын тулд юу гэдэг юм, Монгол Улсын эдийн засгийн чадавхаас давсан хууль санаачилдаг барьдаг, баталдаг гээд ийм олон тохиолдлууд гарч байсан.

Тийм болохоор иймэрхүү зүйлүүд дээр яах аргагүй хүрээ хязгаарыг нь хуулиар тогтоож өгөөд, гарцаа байхгүй томоохон, даацтай хуулиуд дээр хууль санаачлах эрхийг нь Ерөнхийлөгч, Засгийн газар, Их Хурлын гишүүдийн 78 субъектийн хууль санаачлах эрхийг нь хязгаарлах байдлаар зохицуулъя гэсэн ийм томъёоллоор орж ирж байгаа.

Үүний нөгөө нэг арга нь бол уул нь бид нар ажлын хэсэг дээр ярилцсан. Нөгөө нэг арга нь бол Үндсэн хуульчилсан хууль буюу органик хуульдаа батлах, босгыг нь өндөрсгөж өгье. Өөрөөр хэлбэл хуучин байсан, түрүүн бид ярьсан, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гэхэд 57 гишүүн буюу гуравны хоёрын саналаар баталдаг, өөрчлөхийн тулд тийм үү, хэлэлцэх эсэхээ шийддэг, ийм жишиг байдаг, олон улсын жишиг. Энэ жишгээр Үндсэн хуульчилсан хууль гэж хэлж байгаа нь Үндсэн хуульд ишилсэн, Үндсэн хуульд яг одоо тусгайлсан, эрх зүйн байдал, зохион байгуулалт, бүрэн эрхийн хэмжээг Үндсэн хуульдаа тусгай хуулиар зохицуулна гээд заасан, ийм хуулиудыг иймэрхүү байдлаар зохицуулаад явах боломж бас байгаа юм.

Хуучин явж байсан жишиг Монгол Улсад ч байсан, гаднын улс орнуудад ч байсан. Ийм байдлаар үндсэндээ хууль батлах босгыг нь, хуулийг хэлэлцэх босгыг нь өндөр болгоод, хаа хамаагүй, популист гэдэг юм уу, хаа хамаагүй хуулиудыг Их Хурлын босго давуулахгүй байх нэг боломж, нөгөө боломж нь хууль санаачлагчдын эрхийг нь хязгаарлах байдлаар хаа хамаагүй, өөртөө ийм бүрэн эрхийг нэмэгдүүлэх, улс орны эдийн засаг, нийгмийн амьдралд нөлөөлөх хуулиудыг хязгаарлах ийм хоёр боломжоос ажлын хэсэг дээр ярьж ярьж байгаад Ерөнхийлөгчийн оруулж ирсэн энэ саналыг бас харгалзан үзээд аваад явж байгаа. Ер нь бол цааш цаашдаа бодох асуудал.

Энэ юу гэдэг юм, Үндсэн хуульдаа тодорхой зааж өгөхгүй бол ерөөсөө нэг мэдэхэд, өмнөх туршлагауд байж байгаа, Монгол Улсын үе үеийн Ерөнхийлөгч нар Үндсэн хуульд заасан өөрийнхөө бүрэн эрхээс гадна бусад байдлаар, өөртөө нэмэх байдлаар Үндсэн хуульд заагаагүй 42 хуулиар өөртөө бүрэн эрхийг нэмээд авчихсан, энэ үе үеийн Ерөнхийлөгч нарын түүхэнд байсан. Эдгээрийг бид нар цааш цаашдаа анхаарах ёстой. Улсын Их Хурлын гишүүдийн, юу гэдэг юм, 68 хувийн татвар гэх мэтийн бас хаа хамаагүй хууль санаачлах байдлыг бас анхаарах ёстой. Тийм учраас энэ заалт бол байхдаа хууль санаачлах эрхийг нь хязгаарлаж байх уу, нөгөө талдаа, эсвэл хууль хэлэлцэх, чуулганаар батлах босгыг нь өндөрсгөх үү гэдэг дээр ярьж байгаад энийг авсан юм.

Г.Занданшатар: Эцсийн эцэст Их Хурал л өөрөө хууль баталж энэ хязгаарыг тогтооно шүү дээ, гишүүдээ хязгаарлах юм уу, юугаа хязгаарлах юм. Одоо эрхэм гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: За баярлалаа. Ер нь Ерөнхийлөгчийн оруулж ирсэн төсөл, санал гээд юм яриад байгаа юм л даа. Ерөнхийлөгч бол тэр Үндсэн хууль дээрээ дотоод гадаад асуудлаар мэдээлэл хийгээд санал оруулж болно гэж байгаа байхгүй юу. Дотоод гадаад асуудлаар мэдээлэл хийгээд, мэдээлэл хийсэн юм уу гэдэг асуудал. Нөгөө нэг талаараа нэгдэх хэлэлцүүлэг дээр зөвхөн Ерөнхийлөгч үг хэлэхээр л заасан байгаа байхгүй юу. Гэтэл нэгдэх хэлэлцүүлэг явснаас хойш Ерөнхийлөгчийн энэ санал чинь орж ирчхээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр би гишүүдийн хэлээд байгаатай асуудал байна гэдгийг, манайхан янз бүрээр

аргалах гээд энд тэндээс нь ухаж аваад тайлбарлаад байгаа юм. Тэгэхдээ энэ дээр бол хуулийн зөрчил харагдаад байгаа юм.

Мэдээлэл хийгээд гэж байгаа юм, мэдээлэл хийгээгүй байх, миний мэдэж байгаагаар бол. Гэхдээ үүнийг зүгээр нэг дэх хэлэлцүүлэг дээр Улсын Их Хурлын гишүүн үг хэлж, санал гаргаж болно гэж байгаа юм. Санал гаргаж болно гээд. Санал гаргах, оруулах хоёрын хооронд бас хуулийн зүйгээрээ авбал ялгаа байна. Яг ингэж нарийвчилж үзэх юм бол.

Тэгээд энэ асуудлыг анхаараач гэж байгаа юм. Ер нь манай төрийн их сонирхолтой, ойлгомжгүй, эрх мэдэл нь хаанаа байгаа юм, мэдэгдэхээ больсон, бие биеийгээ ажлыг нь явуулахаа больсон байдал чинь Ерөнхийлөгчийн засаглал дээр л байгаа байхгүй юу. Манай Ерөнхийлөгчийн засаглалыг аваачаад хууль санаачилдаг болгоод Их Хурлын гишүүн шиг болгоод хаячихсан, нөгөө нэг талаараа гүйцэтгэх засаглал шиг болгоод хууль хүчний байгууллагад оролцуулдаг болгочихсон, түүгээрээ далайлгаад бүх юманд оролцдог болгоод хаячихсан байхгүй юу. Тийм учраас яг бид нар Үндсэн хуулийн өөрчлөлтийг жинхэнэ агуулгаар нь хийе, төрөө зөв болгоё гэж бодсон бол бид нар Ерөнхийлөгчөө парламентаас сонгодог болгох л байсан юм. Үүнийг хийсэнгүй шүү дээ. Тийм учраас энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг дэмжихгүй байгаа нэг шалтгаан бол энэ.

Хэд хэдэн төр бий болчихоод байна шүү дээ. Ерөнхийлөгчийн засаглал ч байгаад байх шиг, парламентын засаглал ч байгаад байх шиг, энэ байдал чинь өнөөдөр бидний чөдөр тушаа болоод байгаа юм аа. Нэг ёсондоо хэрвээ үүнийг оруулъя гэж байгаа бол Ерөнхийлөгчийн хууль санаачлах эрхийг авч хаях хэрэгтэй. Ерөнхийлөгчийн хууль санаачлах эрхийг. Тэгээд парламентаас сонгодог болгох, тэгэх юм бол харин төрийн тогтолцоо зөв явах байх.

Улсын Их Хурлын гишүүний хувьд бол яг манайх шиг тойргоор сонгогддог болчихсон энэ үед хүрээ хязгаар тавина гэдэг бол бас хүндрэлтэй болчихоод байгаа юм. Нэг талаараа татварын зарим хуулиуд дээр манай компанийн захирлууд ялангуяа, одоо ашиг, сонирхлын үүднээс хууль санаачилмааргүй л баймаар байгаа юм, ялангуяа компанитай улсууд. Жирийн гишүүн, иргэн ямар нэг аж ахуйн нэгжгүй хүн бол ард түмний төлөө хууль санаачилж болохгүй гэж үзэхэд бас хэцүү. Яагаад гэвэл өргөн олон түмэн чинь ялангуяа малчин иргэд чинь мал аж ахуйн холбогдолтой хууль санаачилж өгөөч, ингэж өгөөч, нийгмийн даатгалын шимтгэл ийм байна, халамжийн хуулийг ингэж өгөөч гээд ярьдаг л даа. Тэр хүний эрхийг Улсын Их Хуралд илэрхийлэгч чинь өөрөө Улсын Их Хурлын гишүүн болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр яг татварын хуулийг санаачилж болохгүй гээд бас хязгаарлачхаж болохгүй болоод байгаа юм. Наадах чинь их төвөгтэй асуудал шүү. Би түрүүн хэлсэн шүү дээ.

Ерөөсөө Үндсэн хуульд заагаад бүх юмыг цэгцэлнэ гэж хэзээ ч байхгүй. Үүнийг зохицуулж явах, тэгээд ёс суртахууны асуудал, нөгөө талаараа, ёстой нөгөө бусад хуулиудаараа зохицуулаад яваад, түүнийгээ жишээлбэл, Ашиг сонирхлын тухай хуулиараа байдаг ч юм уу ингээд л явах тухай асуудал гарна уу гэхээс биш Үндсэн хууль дээр ялангуяа ард түмний төлөөлөл болж байгаа Улсын Их Хурлын гишүүний хууль санаачлах эрхийг нь хязгаарлаад хаяхаар чинь Хууль тогтоох дээд байгууллага гэж ойлгоход хэцүү болно шүү дээ.

Гишүүдийн чинь эрх нь хязгаарлагдмал болоод ирэхээр. Тэгэхээр энэ заалт жаахан цаг үеэ олоогүй ийм асуудал болчихоод байна. Ямар нэг шалтгаан байгааг би ойлгож байна. Тэгэхдээ энэ бол ялангуяа манайх шиг мажоритар тогтолцоотой,

Улсын Их Хурлын гишүүн ард түмний төлөөлөл болсон улс орны хувьд бол дэмжихэд хүндрэлтэй заалт байна гэж би ингэж хараад байна. Харин ажлын хэсгийн санал гэж ингэж орж ирээд байгааг, нэгдүгээр хэлэлцүүлэг дээр Улсын Их Хурлын гишүүн үг хэлж, санал гаргаж болно гэдгээр л ажлын хэсэг ингэж оруулж ирээд байна уу.

Тэрнээс биш нэгдүгээр хэлэлцүүлэг дээр яс заагаад өгчихсөн шүү дээ, энэ хуулиараа. Би түрүүн үг хэлэхдээ хэлсэн. Ерөнхийлөгч энэ Үндсэн хуулийн төслийг өргөн барихад саналаа ирүүлээгүй юм байна лээ шүү. Тэгээд бид нар хэлэлцсэн, хууль зөрчсөн. Гэтэл энэ дээр дахин хууль зөрчиж байгаа байхгүй юу. Мэдээлэл хийж санал гаргана, санал оруулна гэдгээ аваачаад энд хүчээр оруулаад. Тэгээд нэгдүгээр хэлэлцүүлэг дээр ийм хүн л хууль санаачилж болно, үүнийг зөвшөөрнө, татгалзана гээд яс заачихсан байхгүй юу.

Хоёрдугаар хэлэлцүүлгийг ч бас яс заачихсан. Ерөнхийлөгч нэгдүгээр хэлэлцүүлэг дээр зөвхөн үг хэлэх ёстой, мэдээлэл хийхгүй, санал оруулахгүй, хэлчихсэн байна шүү дээ. Тэгээд та нар болохоор Ерөнхийлөгч нэгдүгээр хэлэлцүүлэг дээр мэдээлэл хийж санал оруулсан юм яриад суугаад байна шүү дээ. Үндсэн хуульд, журмын тухай хуульд хэлчихсэн байна шүү дээ. Зөвхөн үг хэлнэ Ерөнхийлөгч гээд. Тэгэхээр та бүхэн болохоор мэдээлэл хийсэн санал оруулсан гээд суугаад байна шүү дээ.

Энэ чинь хууль зөрчөөд байна шүү дээ.

Г.Занданшатар: Хуулиа ном ёсоороо өргөн барьсан, Их Хурлын даргад. Энэ бол тусдаа, мэдээлэл хийх нь тусдаа, хоёр тусдаа процесс. Одоо Содномын Чинзориг сайд үг хэлнэ, гишүүн үг хэлнэ.

С.Чинзориг: Энэ бас жаахан дэмжихэд эргэлзээтэй, жаахан ойлголтын зөрөөтэй ийм санал болчхоод би гайхаад л байгаа юм. Гэхдээ бүлэг дээр нэлээн ярьж байгаад олонхын санал аваад явсан ийм санал байгаа юм.

Улсын Их Хурлын гишүүн чинь иргэд сонгогчдын төлөөлөл, төрд төлөөлж байгаа төлөөлөл нь. Тэднийхээ мандатыг авсан. Улсын Их Хурлын гишүүний үндсэн үүрэг чинь орон нутгийн өмнө тулгамдаж байгаа аливаа асуудлыг тодорхойлж, хөгжлийн бодлогод тусгах, иргэдийн өмнө шийдвэрлэвэл зохих асуудлыг тодорхойлж, хууль санаачилж, Их Хурлаар батлуулах ийм л үндсэн чиг үүрэгтэй хүн шүү дээ, Улсын Их Хурлын гишүүн, би тэгж л ойлгоод байгаа юм.

Нөгөө талаас Улсын Их Хурал өөрөө хууль тогтоох дээд байгууллага. Тэгээд иргэдийн төлөөлөл болсон, мандатыг нь авсан гишүүний орон нутгийн хөгжилтэй холбоотой асуудал санаачилж, хөгжлийн бодлогод тусгуулах, төсөвт тусгуулах эрхийг нь хязгаарлах гэж байгаа юм шиг, иргэдийн өмнө тулгамдаж байгаа аливаа асуудлыг иргэдийнхээ оролцоотой тодорхойлж, хуулийн төсөл боловсруулж, Их Хуралд оруулах эрхийг нь хязгаарлана гэдэг бол бас оновчтой зөв асуудал биш байхаа гэж би үзээд байгаа юм.

Их Хурал өөрөө хууль тогтоох байгууллага. Хэнтэй ч одоо энэ эрхийг хуваалцахгүй, Их Хурал өөрөө эдэлнэ. Хууль санаачлах эрх нь байж байж болно. Харин тэр санаачилсан хууль нь төсөв санхүүд хүндрэл учруулахаар хий, хэт популист хуулийн төсөл байна уу гэдгийг түүнийг нь хянаж үзээд, хэлэлцээд, батлах үгүй юу гэдэг асуудал нь Их Хуралд өөрт нь байгаа асуудал.

Тийм учраас Их Хурлын гишүүний хууль санаачлах энэ эрхийг нь, хүрээ хязгаарыг нь хязгаарлана гэдэг тийм оновчтой бус байх гэж бодоод байна.

Хоёр дахь асуудал нь гишүүдийн яриад байгаа тэр 62 гишүүний өргөн барьсан хуулийн төсөлд ийм зүйл хөндөгдөөгүй зүйл. Миний санаж байгаагаар ийм утгатай асуудал бол 33 дугаар зүйл дээр ийм агуулгатай төсөл явж байгаа нь үнэн. Хэрвээ оруулж ирж байгаа бол, хөндөгдсөн асуудал гээд оруулж ирж байгаа бол тэр 33 дугаар зүйлтэй холбоотой асуудал дээрээ энэ асуудлыг ярина уу гэхээс биш хөндөгдөөгүй асуудал дээр Их Хурлын гишүүний хууль санаачлах эрхийг нь, хүрээ хязгаарыг нь хуулиар тогтооно гээд ийм хязгаарлалт хийж оруулж ирэх нь бас хууль зөрчсөн асуудал болох юм биш биз дээ гэсэн эргэлзээ надад байгаа юм.

Тийм учраас цаашдаа гурав дахь хэлэлцүүлэг дээр үүнийг бас өөрчлөн найруулах юм уу, эсвэл гишүүд өөрсдийнхөө итгэл үнэмшлээр үүнийг дэмжих дэмжихгүйгээ шийдээд саналаа өгөөд явах нь зүйтэй болов уу гэсэн би ийм бодолтой байгаа юм. Ер нь Улсын Их Хурлын гишүүний эрхийг бид нэлээд, Их Хурлын бүрэн эрхийг нэлээн хэмжээгээр хязгаарлалаа. Парламентын засаглалыг төгөлдөршүүлнэ, төлөвшүүлнэ гээд боловсон хүчинтэй холбоотой нэлээд олон томилгооныхоо бүрэн эрхээс Их Хурал энэ хуулийн дагуу татгалзахаар байгаа.

Төсөв батлахтай холбоотой, онцгой эрхтэй холбоотой Их Хуралд олгогдсон зарим нэг онцгой эрхээсээ бас татгалзаж байгаа ийм асуудлууд бий. Дээр нь Их Хурлын гишүүдийн хууль санаачлах эрхийг нь, хүрээ хязгаарыг нь хуулиар тогтоогоод хумиад өгөх юм бол энэ Улсын Их Хурал чинь тэгээд иргэдийн, сонгогчдын төлөөлөл болоод улс орны хөгжлийн бодлоготой холбоотой асуудлыг тодорхойлоод, төсөв санхүүгийн бодлогыг тодорхойлоод, иргэдийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг иргэдийнхээ оролцоотой тодорхойлоод, хуулийн төсөл боловсруулж Их Хурлаараа батлуулах энэ ажил чинь хэр явах юм бэ.

Ингээд яваад байх юм бол Их Хурлын гишүүдэд бүрэн эрх, Их Хурлын бүрэн эрх гэж үндсэндээ асуудал маш цөөхөн үлдэхээр байна шүү дээ. Манай улс чинь Парламентын засаглалтай улс. Тийм учраас хууль тогтоох энэ эрхийг хэнтэй ч хуваалцахгүй эдлэх нь зүйтэй байх гэсэн бодолтой байгаа юм. Тийм учраас гишүүний хууль санаачлах эрхийг, хүрээ хязгаарыг хуулиар хязгаарлана гэсэн энэ заалтыг эргэж харах нь зүйтэй байх гэсэн ийм саналтай байгаа юм.

Г.Занданшатар: Энэ яах вэ, ирүүлсэн тайлбарыг тодруулчихад энэ чинь Их Хурлын гишүүнийг гэж хэлэхгүй байгаа шүү дээ, Ерөнхийлөгчийг, Засгийн газрын хууль санаачлах эрхийг хуулиар тогтооно гэхээр Улсын Их Хурал өөрөө өөрийнхөө эрхийг хязгаарлах юм уу, Улсын Их Хурал хууль баталж, тэр хүрээ хязгаарыг тогтооно гэсэн санаа л байгааг зөв ойлголт өгөх.

Эрхэм гишүүн Цэндийн Мөнх-Оргил.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Ажлын хэсгийн Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт оруулж байгаа тодотголыг би зарчмын хувьд зөв юм уу гэж бодоод дэмжье гэсэн бодолтой байгаа юм.

Гэхдээ одоо зарчмын энэ томъёоллыг дэмжчихээд, гуравдугаар хэлэлцүүлэг дээр ярьж байгаад гишүүдийн хэлсэн саналыг ямар нэгэн байдлаар тусгаж оруулах нь зүйтэй юм шиг санагдаад байгаа юм. Жишээ нь, Улсын Их Хурлын гишүүн хууль санаачлах эрхээ эдлэхдээ яг ямар хүрээ, ямар хязгаараар ерөнхийд нь хязгаарлаж өгөх юм бэ? гэдэг нэг томъёолол суулгаж өгч болмоор санагдаад байгаа юм. Тухайлбал, төсөв, төсөв биш юмаа, төсвийн бол хязгаартай. Нөгөө татвар, мөнгө төгрөгтэй холбоотой ч байдаг юм уу, тийм ээ, ийм заалтуудыг жишээ нь, 8 юм уу, 10 гишүүн өргөн барина ч гэдэг юм уу. Иймэрхүү хязгаар ерөнхий нөгөө нэг чиглэлүүдээр нь зааж өгмөөр санагдаад байгаа юм.

Засгийн газар ямар нэгэн хүрээ, хязгааргүйгээр хууль санаачлах эрхтэй баймаар юм шиг надад санагдаад байгаа юм. Засгийн газар бол. Ерөнхийлөгч бол Үндсэн хуулиар олгогдсон, нөгөө Үндсэн хуулийн 33 дугаар зүйлд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хууль санаачилна. Тэр нь хуулиараа тодорхой болчихно. Улсын Их Хурлын гишүүн бол аливаа асуудлаар хууль санаачлах эрхтэй. Тэгэхдээ тухайлбал татвар, мөнгө төгрөгтэй холбоотой асуудлаар тодорхой тооны босго давж байж, нэлээн хэдэн гишүүдийн саналыг нэгтгэж байж, хуулийн төсөл оруулна гэдэг ийм хязгаар тогтоож өгвөл болмоор байгаа юм. Засгийн газар ямар нэгэн хүрээ хязгааргүйгээр хууль санаачилж, оруулж ирж байвал яасан юм бэ гэсэн ийм саналтай байгаа юм, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ Үндсэн хуулиар оруулж байгаа одоогийн нэмэлт, өөрчлөлтүүд дээр бид нар Улсын Их Хурлын нэлээд бүрэн эрхийг хязгаарлаж байгаа нь үнэн. Бид Улсын Их Хурал бол өөрөө өөртөө тодорхой хязгааруудыг тогтоож байна. Тухайлбал Засгийн газраас өргөн барьсан төсвийн зарлагыг нэмэгдүүлэхгүй гэдэг бол маш том хязгаар шүү дээ. Энэ Улсын Их Хурал одоо нэг талаас улс төрийн зориг, нөгөө талаас сүүлийн 27 жилийн туршлагыг харгалзаад бодлогоо тогтвортой болгоё, төсвийн зарлагаа нэмэгдүүлдэггүй байя, алдагдлаа багасгая, сахилга баттай байя гэдэг энэ зорилгодоо хөтлөгдөөд ийм хязгаар оруулж байгаа юм. Гэхдээ Улсын Их Хурлын бүрэн эрхийг хязгаарлаж байгаа нь энэ гээд бас байж болохооргүй ганц нэг заалтууд энд нэмж, оруулж ирчхээд байгаа юм. Энэ дараа нь хэлэлцэгдэнэ. Тэгэхдээ би жишээ болгоод хэлж байна. Улсын Их Хурал энэ өргөн барьж байгаа нэмэлт өөрчлөлтүүдээр Засгийн газрын гишүүдийг татахгүй болчихоод байгаа юм. Томилохгүй болчихоод байгаа юм.

Ерөнхий сайд Ерөнхийлөгчтэй зөвшилцөөд Улсын Их Хурал зөвхөн танилцуулаад, Засгийн газрын гишүүдээ ажиллуулахаар захирамж гаргаад, Улсын Их Хурлын гишүүдэд, Улсын Их Хуралд танилцуулаад Засгийн газрын гишүүдээ томилохоор болоод байгаа байхгүй юу. Би энэ жишээнд зохимжгүй юм болов уу гэж бодоод байгаа юм. Бид нар чинь давхар дээлээ одоо ингээд тайлж байна шүү дээ. Ганцхан Ерөнхий сайд Улсын Их Хурлын гишүүн байж болно. Бусад сайд нар нь Улсын Их Хурлын гишүүн байхгүй гээд бид нар давхар дээлээ тайлж байна. Нэгэнт давхар дээлээ тайлж байгаа бол Монгол Улсын Засгийн газрын гишүүнээр ажиллах гэж байгаа, тухайн салбарын хөгжлийн бодлогыг авч явах гэж байгаа хэн гуай ч гэсэн Улсын Их Хуралд орж ирээд, өөрийгөө танилцуулаад, үзэл бодлоо танилцуулаад, гишүүдийн асуултад хариулаад, гишүүдийн итгэл үнэмшлийг төрүүлээд, тэгээд өнөөдрийн Үндсэн хуулийн хүчин төгөлдөр байгаа заалтын дагуу Улсын Их Хурал хүн бүрээр, энэ чинь Үндсэн хууль нь тэгээд биччихсэн байгаа шүү дээ. Хүн нэг бүрээр хэлэлцээд тогтоол батлаад, Засгийн газрын гишүүнээр томилж ажиллуулж байгаа. Тэр заалт бол жишээ нь хэвээр үлдмээр байгаа юм. Ингэж байж энэ гүйцэтгэх засаглал, хууль тогтоох засаглалын хоорондын харилцан уялдаа, тэнцвэрт байдал хадгалагдана. Тэгэхгүй бол Их Хурлын гишүүн нь Засгийн газрын гишүүн байхгүй.

Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал нэг бүрчлэн хэлэлцэж томилохгүй, ганцхан Ерөнхийлөгч Ерөнхий сайдыг томилно. Ерөнхий сайдыгаа бид нар энэ нэмэлт, өөрчлөлтөөр огцроход маш хэцүү болгож байгаа. Ер нь бол бидний оруулж байгаа энэ заалтаар бол бусад улсуудын туршлагыг яг адилхан заалттай бусад улс орнуудын туршлагыг хараад байхад бол Ерөнхий сайд нар бол огцордоггүй. Огцрох бололцоогүй шахам заалт оруулж ирж байгаа юм. Нөгөө итгэл үл хүлээлгэх конструктив санал гээд Ерөнхий сайдаа огцруулъя. Оронд нь энэ хүнийг томилъё гэдэг нэг тогтоолоор оруулж ирж байгаа нь өөрөө ажлаа хийж байгаа Ерөнхий сайдыг бол их хамгаалж, өндөр босготой болгож байгаа юм. Энэ нэг талаар сайн боловч нөгөө талаасаа Ерөнхий сайд бас Улсын Их Хурлын хараа

хяналтаас гарах, дураараа дургих, ажлаа сайн хийж чадахгүй байгаа Их Хурлын итгэлийг авч чадахгүй байгаа Ерөнхий сайдыг огцруулахгүй байх, огцруулах бололцоо бүрдэхгүй байх бас их аюул бий болгож байгаа юм. Энэ бүгдийн харгалзаж үзээд Засгийн газрын гишүүдийг Улсын Их Хурал хэлэлцдэгээрээ хэлэлцээд, томилдгоороо томилоод явдаг байх нь зүйтэй байна.

Одоогийн бидний энэ хэлэлцэж байгаа 62 гишүүний өргөн барьсан нэмэлт, өөрчлөлтүүд батлагдаад явах юм бол Улсын Их Хурал бүүр хийх ажилгүй болчхож байгаа юм шиг бас тэгж ойлгож болохгүй. Манай зарим нэг гишүүд бас тэгж ярих гээд байгаа юм. Тийм биш Улсын Их Хурал хангалттай их ажилтай үлдэнэ. Хуулиа батална. Гол нь хуулийн хэрэгжилтийг хариуцаж хянанна. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавина. Түүнээс гадна хянан шалгах түр хороонуудаа байгуулна, төсвөө батална. Төсвийн гүйцэтгэлд хяналт тавина. Энэ бол хангалттай их чухал үүрэгтэй үлдэж байгаа юм. Тэгээд Их Хурлын даргаас хүсэхэд, ажлын хэсгийн ахлагчаас хүсэхэд энэ 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт оруулж байгаа энэ нэмэлтээ зарчмын дэмжээд явахдаа гурав дахь хэлэлцүүлэг дээр Засгийн газрын хууль санаачлах эрхийг хязгааргүйгээр, Ерөнхийлөгчийнх бол Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийнхээ заалтаар хязгаарлагдаад явна гэж ойлгож байгаа.

Улсын Их Хурлын гишүүдийн хууль санаачлах эрхийг хязгаарлахдаа ерөнхий ямар чиглэлийн асуудлаар хязгаартай байх юм бэ? гэдэг хязгаарын ерөнхийдөө нэг ийм, ийм асуудлуудаар хязгаартай байх юм шүү, тэрийг нь нарийн хэмжээг нь бол хуулиар тогтоож өгөх юм шүү гэсэн тодотголтой байвал яасан юм бэ гэсэн саналтай байна

Г.Занданшатар: Зүйтэй санал байна. Энийг цаашид анхаарч, тэгэхдээ Засгийн газар бас Улсын Их Хурлын дэг энэ тэрийг Улсын Их Хуралд хамаарах асуудлыг санаачилж болохгүй гэсэн бусад улсын бас нэг зарчим байгаа байх. Эрхэм гишүүн Отгоогийн Батнасан үг хэлнэ.

О.Батнасан: Баярлалаа. Эрх зүй хөгжсөн улс оронд жишээ нь байгалийн баялаг гэхэд л 300 орчим хууль гаргачихсан байдаг л даа. Энэ Ерөнхийлөгчийн оруулж ирж байгаа саналууд дээр авахаар саналууд байгаа. Би энэ Их Хурлын гишүүн ч гэдэг юм уу, Ерөнхийлөгч Засгийн газар хууль санаачлах эрхтэй гэдэг энэ халдашгүй, өөрт нь байгаа онцгой бүрэн эрхэд халдаж байгаа асуудал байхгүй юу, хязгаар тогтооно гэдэг чинь. Аливаа нэг сэдвийг схемчилж өгнө гэсэн үг шүү дээ. Тэртэй тэргүй эрх зүйн системд жам ёсыг бол хуульчилдаггүй. Жишээ нь цайны дээж өргөхийг хуульчилдаггүй л байхгүй юу. Хуульчилдаг сэдэв гэж байна. Тэр сэдвийн хүрээнд одоо Их Хурлын гишүүн хууль санаачлахад тэр эрхийн хязгаарлаж бол болохгүй шүү дээ. Амьдрал бол баян. Жишээ нь утааны асуудал гээд тэгье. Утааны асуудалтай холбоотой асуудлыг энэ хуулийн байгаль орчны яам санаачлах ёстой юу, санаачилъя. Гэтэл Үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болохуйц асуудал гарч ирэх юм бол Ерөнхийлөгч санаачилна. Ингээд зөрчилдөөд эхэлнэ. Ийм учраас энэ хүрээ хязгаарыг тогтоож болохгүй. Энэ зүйл дээр гишүүд анхааралтай хандахгүй бол бид схемчилсэн одоо нэг тийм одоо нэг хайрцагт орсон сэдвээр хууль санаачилна гэх юм бол энэ бол болохгүй асуудал.

Хууль гаргаж байна гэдэг чинь өөрөө дэг журмыг сахиулах, урьдчилан сэргийлэх олон талын ач холбогдолтой. Түүнээс биш хэнд ч хэрэггүй хууль гаргаад, өнөөдөр бид бол батлаагүй шүү дээ. Өнөөдөр 700 гаруй орчим хууль байгаа. Хэрэггүй хууль гэж би лав сонсоогүй. Бүгд л одоо эрхзүйн дэг жаягийг сахиулахаар батлагдсан хуулиуд явж байгаа. Зүгээр сая гишүүд бас хэлж л байна лээ. Органик хууль, органик хууль дээр бид бол анхаарах ёстой. Ер нь бол Олон Улсын жишгийг харахад органик хуулийг нийт гишүүдийн 2-ны 3-аар буюу одоо 76

байх юм бол 51 гишүүнээр батлаад явах ёстой. Шалгуур өндөртэй байж органик хуулиуд сайн гарна. Ийм санал байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Нямаагийн Энхболд үг хэлнэ.

Н.Энхболд: Энэ хэзээ, аль үе шатанд нь орж ирсэн тэрийн ярилгүйгээр зүгээр. Би энэ заалт байж байх нь зүйтэй юм болов уу гэж үзээд байгаа юм. Хэдийгээр Үндсэн хуулиар ийм, ийм зүйлүүд хийж болохгүй гэсэн заалтууд байдаг. Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн тангараг өргөхдөө Үндсэн хуулиа баримталж ажиллана гэсэн. Бас янз бүрийн санаагаар, янз бүрийн хууль санаачлахыг үгүйсгэх арга бас байхгүй. Тэгэхээр энэ болох, болохгүй юмаа хууль дээрээ, ямар хязгаартай байх уу гэдгээ яриад, Үндсэн хуультай ийм нэг заалт байж байх нь зөв болов уу гэж бодож байгаа. Одоо жишээ нь Ерөнхийлөгчийн хууль санаачлах эрхтэй холбогдуулаад бид нар зөндөө юм ярьдаг. Үндсэн хуульд ч байж байгаа, бусад хуулиудад ч байгаа. Тэгсэн мөртөө судалгаагаар яг Үндсэн хуульд Ерөнхийлөгчид олгосон бүрэн эрхүүдээс гадна зөндөө олон асуудлаар 1992 оноос хойш Монгол Улсын Ерөнхийлөгч гэдэг үе, үе алба хааж байсан, албан тушаал хааж байсан хүмүүс янз бүрийн байдлаар санаачилсаар байгаад маш их шүүмжлэлд өртөж байгаа, олон тийм Үндсэн хуулиар олгогдоогүй эхүүдийг авчихсан, ийм зүйлүүд байдаг шүү дээ. Би ганц Ерөнхийлөгч гэж хэлж байгаа юм биш. Улсын Их Хурал, Засгийн газрын зүгээс дөнгөж түрүүхэн бид нар бас зарим асуудлуудыг ярьж байгаад түр хойшлуулчихаад байж байна. Санаа нь, жишээ нь Засгийн газраас орж ирсэн төсөвтэй холбоотой заалтуудыг өөрчлөх, Улсын Их Хурлын гишүүнд байхгүй, байх тухай ийм хуулийн заалт хүртэл энэ дотор явж л байгаа шүү дээ.

Бүгдээрээ нэг багц юм болгоод ингээд харахаар, ерөнхий нэг ийм заалт байгаад яг Их Хурлын гишүүн ямар эрхтэй, үүрэгтэй вэ? Засгийн газар ямар эрхтэй, үүрэгтэй вэ? Ерөнхийлөгч ямар эрхтэй, үүрэгтэй вэ? гэдэг үе дээр нь, мэдээж Их Хурлын гишүүдийнх бол хамаагүй илүү өргөн хүрээтэй байх нь ойлгомжтой. Тэгэхдээ бусад зүйлүүдээ бас нэг, нэг раман дотор барьж байх үүднээс ийм ерөнхий заалт байж байх нь зүйтэй болов уу л гэж би бодоод байгаа юм.

Г.Занданшатар: Явж, явж Ерөнхийлөгчийн эрхийг л хязгаарлана шүү дээ. Санал хураалт явуулъя. Гишүүд чуулганы танхимдаа орж ирээрэй. Энэ хүрээ хязгаар тогтоогдсоноор зарим хуулиудын босгыг гуравны хоёроор баталдаг ч байдаг юм уу, органик хууль хуулиудын бэхжилтийг сайжруулах боломж бас нээгдэж өгдөг гэж үзсэн байна.

Жишээлбэл, дэгийн хууль энэ, тэрийг бол Засгийн газраас санал авахгүй Их Хурал өөрөө хуульч байх шаардлагатай. Гишүүд цуглаж байх хооронд бас нэг түрүүн хасагдсан гээд Тэрбишдагва гишүүн болон бусад гишүүд органик хуульдаа оруулъя гээд байсан саналуудын талаар би журмын тухай хуулийн заалтыг уншиж танилцуулъя.

24^{7.6} Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол, дагаж мөрдөх журмын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг энэ хуулийн 21-24 дүгээр зүйлд заасан журмын дагуу хэлэлцэн баталж болно гэж байгаа. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгагдаагүй түрүүний зарим саналуудыг бол нэмэлт, өөрчлөлтөөр, органик, холбогдох хуулиудад нь нэмэлт, өөрчлөлт хийгээд батлаад явж болох юм. Энэ батлагдах ёстой санал гэнэ. Гишүүд санал хэлж дууссан. Чинзориг, Мөнх-Оргил гишүүдийн гаргасан саналаар

гуравдугаар хэлэлцүүлэг дээр, хоёрдугаар хэлэлцүүлгийн дараа найруулга дээр бас ажлын хэсгийнхэнд анхаарах чиглэлийг өгч байна.

Санал хураалт явуулъя. Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг.

1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ хязгаарыг хуулиар тогтооно. Санал гаргасан ажлын хэсэг, Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал байна.

Санал хураалт. Дуламсүрэнгийн Оюунхорол гишүүн үг хэлнэ.

Д.Оюунхорол: Сая техникийн саатал гарсан тул энэ санал хураалтыг дахиж явуулж өгөөч гэж хүсэж байна.

Г.Занданшатар: Лүндээжанцан гишүүн. Цөөнх болж үг хэлж байгаа юм уу.

Д.Лүндээжанцан: Яах вэ техникийн саатал гээд дахиад хураах гэж байх шиг байна. Манай зарим гишүүд ингээд нэг, ер нь бол Их Хурлын гишүүн хүний үүрэг роль гэдэг бол ямар их вэ гэдгийг одоо эндээс харж болно шүү дээ. Нэг, хоёр хүн байхгүй байхад л тийм үү? Тэгэхээр ер нь бол энэ санал зөвшилцөөнөөр гарч ирсэн, бид бол байна шүү дээ, энэ Үндсэн хууль мөрдөгдөөд 27 жил гаран өнгөрч байна. Энэ хугацаанд ер нь яг одоо Их Хурлын гишүүдийн хууль санаачлах эрхийг халдлаа гэдэг юм уу, тийм юм бол байхгүй, энд бол.

Харин энийг журамлах, зохицуулах шаардлага байгаа юу гэвэл байгаа юм. Ийм учраас би энэ саналыг ер нь дэмжих ёстой санал шүү гэдгийг би бас олон жилийн турш энэ парламентын энэ танхим дотор нэг байгууллагад, нэг танхимд ийм удаан жил сууна гэдэг чинь бас нэг дор ажилласан, хүмүүс байгууллагаа солиод л байдаг шүү дээ. Ингээд харахад бол Ерөнхийлөгч, Засгийн газар, Их Хурлын гишүүний хууль санаачлах эрхийн тодорхой зохицуулалт бол байхаас аргагүй юм байна гэдэг нь прагматик судалгаа болон эрдэмтдийн судалгаагаар бас ерөнхийдөө тогтоогдсон зүйл шүү гэдгийг би зүгээр бас нэг сануулаад хэлчихье гэж бодож байна.

Г.Занданшатар: Саяны санал хураалтыг гишүүд, сая Оюунхорол гишүүн горимын санал гаргасан л даа. Ингээд Оюунхорол гишүүний саналаар техникийн саатал гарсан учраас санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

Олонхын саналаар энэ санал хүчингүй боллоо. Үнэмлэхүй олонхын саналаар, 83.9 хувиар энэ санал хүчингүй болсон. Одоо санал хураалтыг дахин явуулна. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалтыг дахин явуулъя, гишүүд. Санал хураалтыг дахин явуулж байна. Батбаярын Ундармаа гишүүн үг хэлнэ.

Б.Ундармаа: Төхөөрөмж маань болсонгүй. Тийм учраас дэмжих санал өгсөн. Протоколд тэмдэглүүлье. Санал хураалтыг хүчингүй болгож дахин санал хураалт явуулъя.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Содномын Чинзориг үг хэлнэ.

С.Чинзориг: Сая Их Хурлын дарга гурав дахь хэлэлцүүлгийн явцад гишүүдийн гаргасан саналыг өөрчлөн найруулахаар анхааръя гэж хэлсэн учраас би дэмжсэн юм. Сая энэ техникийн саатал гараад уншигдсангүй. Тийм учраас энэ саналыг хүчингүй болгож дахиж санал хураалгая гэсэн саналтай байна.

Г.Занданшатар: Хоёр гишүүний санал техникийн саатлаар ахиад буруу гарсан учраас санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Гар

өргөхөөр санал хураагдаад, дэмжигдээгүй. Бямбацогт гишүүн горимын санал гаргаад.

Санал хураалтад 51 гишүүн дэмжиж, 82.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Санал хураалтыг дахиж явуулъя. Гишүүд тоо яваад 9-өөс эхлээд, хуруугаа бас, төхөөрөмжөө бас анхааралтай хандахыг хүсэж байна. Санал хураалт дахин явуулъя.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 57 гишүүн дэмжиж, энэ санал дэмжигдлээ. Саранчимэг гишүүн, за өнгөрсөн. Дараагийн асуудалд орно. Энэ хэсгийг алгасъя.

17.Төслийн 4 дүгээр зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд” гэснийг “Ерөнхий сайд” гэж өөрчлөх. Төслийн заалт. 17 дугаар заалт.

Санал хураалт, санал хураалтыг хүчингүй болголоо. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Мөнх-Оргил гишүүн, Нямбаатар гишүүн, Тэрбишдагва гишүүн. Санал хураалтыг хүчингүй болголоо. Санал хураалтыг хүчингүй болгосон. Нямбаатар, Тэрбишдагва гишүүнээр тасаллаа. Лүндээжанцан даргыг нэмлээ. Тэгээд товч тодорхой саналаа хэлцгээхийг хүсье.

Эрхэм гишүүн Цэндийн Мөнх-Оргил үг хэлнэ.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр байна шүү дээ, бид нар Улсын Их Хурлын бүрэн эрхийг нэлээн хязгаарлаж байгаа шүү, гишүүд ээ. Маш их хязгаарлаж байгаа. Төсөв дээр зарлагын дүн нэмж болохгүй гээд бид нар тохирчихлоо. Сая Улсын Их Хурлын гишүүний хууль санаачлах эрхэд тодорхой хязгаар тавина гээд тохирчихлоо. Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүнээр ажиллахгүй гээд тохирчихлоо. Бид нар маш их эрхээсээ татгалзаж байгаа байхгүй юу. Одоо энэ заалтыг батлах юм бол бид нар зөвхөн Ерөнхий сайдыг батлахаар болж байгаа юм. Засгийн газрын гишүүдийг батлахгүй. Одоо бол бид нар Үндсэн хуулийн хүчин төгөлдөр заалтаар Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Засгийн газрын гишүүдийн хүн нэг бүрээр нь хэлэлцэж томилж байгаа байхгүй юу. Тэр эрхээсээ бид нар татгалзаж байгаа юм. Энэ эрхээсээ татгалзах хэрэггүй, шаардлагагүй гэж би бодож байгаа юм. Шаардлагагүй.

Парламентын засаглалтай улс л юм бол гүйцэтгэх засаглалд гишүүн болж ажиллах гэж байгаа, Улсын Их Хурлын өмнө тухайн салбарын бодлогыг хариуцаж ажиллах гэж байгаа тэр хүний санал бодлыг сонсдог, зүгээр нэг Ерөнхий сайдын танилцуулснаар танилцуулаад өнгөрдөг биш, тэр хүний өөрийнх нь үзэл бодлын сонсьё, асуулт хариултыг нь авъя. Тэр хүн бидний итгэлийг Улсын Их Хурлын ард түмний төлөөлөл болсон Улсын Их Хурлын итгэлийг дааж ажиллах хүн үү, үгүй юу гэдэг дээр өөрсдөө итгэл, үнэмшилтэй больё. Тэгж байж тэр хүнийг Засгийн газрын гишүүнээр ажиллуулъя. Энд бол ерөөсөө Улсын Их Хурал энэ олон жилийн турш, та нар мэдэж байгаа биз дээ. Хэнийг ороод ирэхээр одоо бид нар бөөн бөөнөөр л дэмжихгүй явуулаад байлаа. Ихэнхийг нь дэмжээд, бараг 100 хувь дэмжээд явуулж байгаа шүү дээ, Ерөнхий сайддаа итгээд. Гэхдээ захиа даалгавраа өгч байгаа. Асуултаа асууж байгаа. Үзэл бодлын сонирхож мэдэж байгаа. Мэдэж байх үүрэгтэй байхгүй юу, бид нар. Тэрнээс биш Ерөнхий сайдаа, та одоо ингээд томилогдлоо. Тэгээд тэр Засгийн газартаа хэнийг ч хамаагүй аваад ажиллуул, харин тэр хүмүүс чинь хариуцлагагүй ажиллах юм бол бид нар тантай хариуцлага тооцно шүү гэж хэлчхээд явуулж болохгүй шүү дээ. Бид нар бол хангалттай эрхээсээ татгалзаж байна.

Давхар дээлээ татгалзана гэдэг бол том улс төрийн зориг, төсвийн зарлага нэмэгдүүлэхгүй гэдэг бол том хязгаар. Дөнгөж сая бид нар хууль санаачлах эрхээ хязгаарлана гээд тохирчихлоо. Тэгчхээд одоо Засгийн газрын гишүүнийг нэг бүрчлэн хэлэлцэж, томилох эрхээсээ татгалзаж байх ямар хэрэг байна. Парламентын Бүгд Найрамдах улс л юм бол бид нар энийгээ авч үлдэх ёстой. Ерөнхийлөгчийн засаглалтай Америкийн Нэгдсэн Улс хүртэл Сенатаар Засгийн газрын гишүүдээ оруулж, гуравны хоёрын дэмжлэг авч ажиллуулж байгаа шүү дээ, гишүүд ээ. Тэрийгээ хүртэл бодоод үзье л дээ. Одоо энэ саналыг унагаагаад, дараагийн миний гаргасан саналыг дэмжээд яваарай гэж би гишүүдээсээ хүсэж байна.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Хишгээгийн Нямбаатар үг хэлнэ.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би бол Мөнх-Оргил гишүүнээс арай өөр саналтай байгаа юм. Тэгэхээр манай энэ удаагийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бол хяналт, тэнцэл, хариуцлага гэсэн ийм гурван уриа, лоозон дэвшүүлж энэ удаагийн Үндсэн хуулийн өөрчлөлтийг оруулж байгаа. Тэр ч утгаараа Улсын Их Хурал өөрийнхөө зарим эрхээсээ, эрхээ шилжүүлэх, өөрийнхөө эрхийг хязгаарлах ийм нэмэлт, өөрчлөлтүүд энэ удаагийн нэмэлт өөрчлөлтүүдээр зонхилж байгаа. Үндсэн хуульд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хуулиар Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх, эрх нь бүхэлдээ Их Хуралд хадгалагдаж байгаа.

Энэ удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр зөвхөн Засгийн газрын тэргүүнийг томилж, чөлөөлөх эрхийг нь Их Хуралд хадгалуулж үлдээе. Засгийн газрын тэргүүн өөрөө Засгийн газрынхаа кабинетыг бүрдүүл ээ. Элдэв шахалт, шаардлага, лоббинд одоо авталгүйгээр Их Хурлын лоббинд авталгүйгээр мэргэжлийн Засгийн газраа бүрдүүлэх тэр боломжийг Ерөнхий сайдад олгоё. Ерөнхий сайд өөрөө кабинетаа бүрдүүлээд, өөрөө Засгийн газрынхаа өмнөөс Их Хуралд бүрэн хариуцлагаа хүлээе. Засгийн газрыг илүү тогтвортой ажиллуулъя гэсэн ийм агуулгатай нэмэлт, өөрчлөлт орж байгаа. Тийм учраас та бүхэн энэ саналын томъёоллыг дэмжиж өгөөч. 1992 оноос хойш Монгол Улсын Засгийн газар ойролцоогоор 1.6, 7 сарын настай. Маш олон Засгийн газар нүүрээ үзсэн. Хоёрхон Засгийн газар, Жасрайн Засгийн газар, Энхбаярын Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацааг дуусгасан. Бусад тохиолуудад Засгийн газар дандаа 1.6 жилийн настай ингээд үйл ажиллагаагаа явуулсан. Тэгэхээр Ерөнхий сайд сонгуульд ялсан, мөрийн хөтөлбөрөө дэвшүүлж ялсан тухайн намын дарга Ерөнхий сайд болох, болсон Ерөнхий сайд өөрийнхөө сонгогчид, олон түмний итгэл хүлээлгэсэн мөрийн хөтөлбөрийг сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд бүрэн дүүрэн хэрэгжүүлэх тийм боломжтой, чадварлаг, мэргэжлийн хүмүүсээр Засгийн газраа бүрдүүлж байя. Манайд өнөөдөр салбарын сайдууд ч гэсэн зарим тохиолдолд фракц, фракцын төлөөллөөр Засгийн газар бүрдэж байсан ийм тохиолдлууд маш олон байгаа шүү дээ. Зарим тохиолдолд бүүр портфельтэй сайд хүртэл ийм албан тушаалыг гаргаж ингэж Засгийн газар бүрдэж байсан. Тийм учраас цаашид энэ маань өөрөө Засгийн газар мэргэжлийн, илүү тогтвортой байх талаасаа энэ нэмэлт, өөрчлөлтийг дэмжээсэй гэсэн бодолтой байна.

Г.Занданшатар: Товч, тодорхой хэллээ. Эрхэм гишүүн Дэндэвийн Тэрбишдагва үг хэлнэ.

Д.Тэрбишдагва: Энд 2 зүйл байгаа юмаа. Нэгдүгээрт энэ ерөнхий, ер нь Парламентын засаглалтай улсад ард түмнийхээ саналыг аваад Парламентын гишүүн болоод Засгийн газрын гишүүн байж болдог л зарчимтай л даа. Одоо нэг нөгөө нийгмийн сүлжээ, ард түмний нөлөөлөөд нэг давхар дээл гээд хаана ч

байхгүй тийм, дэлхийн ямар ч одоо хуульд байхгүй ийм нэг тодорхойлолт гарч ирээд, тэрэндээ өөрсдөө итгээд давхар дээл гэж яриад байгаа юм. Ер нь ард түмнийхээ саналыг аваад, сонгуульд оролцоод ялсан хүмүүсээс тодорхой хэмжээгээр бол Засгийн газрын гишүүн байх ёстой гэсэн байр суурьтай байдаг, би бол. Тэгэхгүй бол сонгуульд унасан, цүнх барьсан нөхрүүд бол Засгийн газрын гишүүн болчих гээд байдаг л даа. Зүгээр яг энэний хувьд бол Ерөнхий сайд Засгийнхаа газрыг байгуулна гэдэг чинь өөрөө эрхийг нь өгчхөж байгаа шүү дээ, Ерөнхий сайд Засгийнхаа газрыг.

Гэхдээ сайдуудын нөгөө ямар ч туршлагатай юм, ямар ажил өмнө хашиж байсан юм, яг юу хийх гэж байгаа гэдгийн бид Их Хурал нэг асууж, лавлаж тэр хүмүүсийг чинь ард түмэндээ танилцуулж, олны өмнө хийх гэж байгаа ажлын харуулж, ингэж явахгүй бол болохгүй ээ. Нөгөө сүүлийг нь сөхөж, шүдийг нь үзэж байж л уг нь Засгийн газар тогтвор суурьшилтай ажилд үнэхээрийн мэргэжлийн Засгийн газрын хүн байна уу, үнэхээрийн мэргэжлийн өндөр түвшинд ажиллаж чадах нь уу гэдгийг харахгүй бол зүгээр одоо ингээд Ерөнхий сайд нь шууд томилчихоод, өөрөө асуултад хариулчихаад, ингээд гараад явчхаж болохгүй л дээ.

Ийм учраас би энэ Мөнх-Оргил гишүүний ярьж байгаа саналыг бол үнэхээрийн дэмжиж байгаа юм. Энийг олон жил ярьж байгаа шүү дээ. Их Хурал дээр энийг чинь ярихгүй бол ард түмэн хэний ч мэдэхгүй нэг юм авчраад тавьчихдаг. Ямар сайдтай болох уу, ямар салбарын хүн юу хийсэн юм, юу бүтээсэн юм гэдгийг чинь зүгээр нэг намтрыг нь уншаад ойлгож чадахгүй шүү дээ.

Тийм учраас би энэ Засгийн газрын гишүүдийг заавал ч үгүй Их Хурал дээр Ерөнхий сайд нь өөрөө кабинетаа бүрдүүлдэг юм байгаа биз, орж ирж асууж, лавлаж, тодруулж, санал бодлоо хэлж, захиа даалгавраа өгөх нь бол өөрөө зарчмын хувьд бол маш зүйтэй. Тийм учраас энэ Мөнх-Оргил гишүүний гаргаж байгаа саналыг дэмжиж байна. Эхний санал болохгүй ээ. Энийг бол эсрэг саналаа өгнө.

Л.Энх-Амгалан: Лүндээжанцан гишүүн.

Д.Лүндээжанцан: Гишүүд ээ, энэ асуудал бол маш төвөгтэй, их ярьж, судалж орж ирсэн асуудал. Парламентын засаглал гэж яриад байхаар төрийн эрх барих дээд байгууллага Парламентад бүх эрх мэдэл төвлөрснийг Парламентын засаглал гэж хэлдэггүй. Ерөнхий сайд нь Засгийн газар нь хүчтэй, тогтвортой, хяналт, эрх мэдлийн хяналт тэнцвэртэй байхыг Парламентын засаглал гэж хэлдэг. Одоо энийг Япон, Герман, Их Британи зэрэг улсуудын жишээнээс харж болно. Өнөөдөр бас ардчилал гайгүй хөгжсөн түвшинд яваа, тэгээд бас эдийн засгийн хөгжлөөр тэргүүлж байгаа 30-аад орны гуравны хоёр нь парламентын засаглалтай. Тэгээд бас Ерөнхий сайд нь танхимаа өөрөө бүрдүүлж чаддаг. Энийг бол парламентын засаглалтай улсууд гэж хэлдэг гээд манай судлаачид бол олон удаа та бүхэнд, бидэнтэй ярьсан. Өнгөрсөн парламентын үед ч гэсэн фракц, фракцын төлөөлөл болсон Засгийн газрыг Ерөнхий сайд удирдаад, сүүлдээ Ерөнхий сайдынхаа үгэнд ч ордоггүй ийм байдал бий боллоо гэдэг асуудал яригдсан. Тэгээд энэ асуудал орж ирээд одоо бараг 3 жилийн хугацаа болж байна. Энэ хугацаанд ард нийтээр их хэлэлцүүлэг өрнүүлсэн. Ерөнхийдөө дэмжиж байгаа, ойлгож байгаа. Нэг Ерөнхий сайд тавигддаг. Мөн адилхан Их Хурлаас томилогдсон та Ерөнхий сайд Их Хурлаас томилогдсон бол би адилхан Их Хурлаас томилогдсон гээд, тэгээд нэг нэг фракцын төлөөлөл болоод явчихсан. Ийм нөхцөл байдал ажил хийлгэхгүй байхыг бид өмнөх Засгийн газруудаас харж байсан. Өмнөх тогтолцооны үеийн.

Хоёрдугаарт бид бүхэн байна шүү дээ, мушгиж яриад байна лээ, түрүүн. Яасан гэхээр, Дээд Шүүхийн шүүгчдийн Их Хуралд танилцуулаад, ядахдаа асуулт асуугаад, шүүмжлээд гаргадаг байсан бол одоо болохоо байсан гээд яриад байна лээ. Тийм юм байхгүй. Энд бол асуудлыг хэлэлцэхдээ тэр ард байгаа Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх асуудлыг Улсын Их Хуралд Ерөнхийлөгчид танилцуулж, томилно гэсэн ийм заалт ард нь байж байгаа юм. Арынх нь заалтууд дээр гүйцэтгэх эрх мэдлийн хэсэг дээр байж байгаа. Тэгэхээр тэр дотор орж ирж байгаа Ерөнхий сайдаар томилогдсон хүн танхимаа өөрөө бүрдүүлж, Их Хуралд танилцуулахдаа нэг бүрээр танилцуулна. Тэр дээр нь Их Хурал авч үзээд, асуултаа тавиад, хариултаа аваад, санал шүүмжлэлээ хэлээд гаргана. Нөхөр минь ээ ингэнэ шүү, тэгнэ шүү гээд. Дээр нь бол Ерөнхий сайдад анхааруулна. За танай энэ хүн ч барахгүй юм байна даа, танай Засгийн газарт, таны ажилд, энэ шаардлагад тэнцэхгүй юм байна гэдгийг нь хэлээд гаргана. Тэгээд Ерөнхий сайд өөрөө томилох эрх нь өөрт нь байгаа учраас, чөлөөлөх эрх нь байгаа учраас өөрөө шийдэх нь.

Дээр нь Засгийн газрын гишүүд Улсын Их Хуралд тангараг өргөнө гэж энэ дээр байж байгаа. Тэгэхээр байна шүү дээ, энэ асуудлыг бид ингэж нэг, яг тэр жам ёсных нь дагуу Германы, сайн дураа хүрэхээр Германыг ярьдаг, Германы юмаар ярьж байна. Ерөнхийлөгчид томилуулаад тэр нь формальный. Үгүй харин тэр, тэр давхар дээлтэй. Юун дээр бол Японд болоод ирэхээр тэр Ерөнхий сайд нь өөрөө томилчхож байна. Германд болохоор Холбооны Ерөнхийлөгч буюу тэр төрийн тэргүүн нь символический хүнээрээ томилуулж байна гээд. Бид одоо хар дээр цагаанаар бичсэнийг танд үзүүлж болно оо, Батнасан гишүүн ээ. Тэгээд энэ мэтчилэнгээр. Эзэн хаандаа танилцуулаад Их Британийн юу бол ингээд томилуулж байна. Ерөнхий сайд нь танхимаа бүрдүүлээд. Ингээд энэ улсууд хөгжөөд явчихсан байна шүү дээ. Бид 2 жил гаран ярилаа. Хэрвээ энэ асуудал байна шүү ингээд орж ирээд гэнэтхэн энэ танхимд ийм байдалтай болох юм бол энийг хойшлуулж өгөөч ээ. Нэлээн хэдэн сонгуулийн асуудалд гишүүн тоо, олон юм хойшлуулчихлаа шүү дээ. Үүнтэй адилхан багцаар нь ярьж, энийг нэлээн сайн ярихгүй бол зүгээр өнөөдөр 57 хүний ирц хүрэхгүйгээр өнөөдөр энэ унах юм бол энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын гол зүйлийн нэг алга болох юм.

Тийм учраас Ерөнхий сайд гэдэг хүн бол тэр танхимынхаа гишүүдийг өөрөө толгойгоо мэдэж томилдог. Гэхдээ Их Хуралдаа танилцуулдаг. Ерөнхийлөгчдөө танилцуулдаг. Тэд нар нь үгээ хэлдэг, тэгээд өөрийнхөө тэр Парламент, Засгийн, танхимынхаа гишүүдийн ажил хэрэг, зан төлөв бүгдийн өөрөө толгойгоороо хариуцдаг, тийм учраас Ерөнхий сайдын хариуцлага дээшилнэ гэж ингэж үзэж байгаа юм. Ерөнхий сайд муу хүн томилох юм бол өөрөө хар толгойдоо гай болно. Өөрөө огцрохын цондон болно. Ийм учраас бол Ерөнхий сайдын хариуцлагыг, хариуцлагын ч, эрх мэдлийн ч аль алийг нь давхар үүрүүлж байгаа ийм зүйл болж байгаа учраас бид бүхэн 3 жил ярилаа шүү дээ. Өмнө нь энийг Мөнх-Оргил гишүүн эрдэм шинжилгээний хурал дээр өөрийнхөө өнөөдрийн энэ ярьсан зүйлийг ярьсан, тийм үү? Их сургууль дээр бас. Бусад нь юу ярьж байсан юм бэ, бараг ярьж байгаагүй шүү дээ. Тэгээд гэнэтхэн өнөөдөр орж ирээд давхар дээл дээр л ярьж байсан Тэрбишдагва гишүүн бол. Давхар дээл бол парламентын засаглалтай улсуудад байдаг, тийм үү. Давхар байдаг гэдгийг ярьж байсан. Гэхдээ 500 хүнтэй парламент, 76 хүнтэй парламент өөр учраас бид бол тайлахаас аргагүй тухайгаа л ярьж байгаа. Энэ мэтчилэн зөрүүнүүд бий. Гэтэл өнөөдөр тал талаас энэ бол нэг ийм юм байна гээд ингээд яривал энийг хойшлуулж өгөөч ээ. Дахиж сайн ярихгүй бол өнөөдөр шууд одоо санал хураалтаар энэний хувь заяаг нэг тийш нь шийдэж болохгүй байх гэж би бодож байна.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Сандагийн Бямбацогт үг хэлнэ.

С.Бямбацогт: Гишүүд ээ, жаахан анхааралтай байгаач ээ. Юу яамаар байна. Энэ Улсын Их Хурлын 62 гишүүн, Лүндээжанцан нарын 62 гишүүний өргөн барьсан төсөл дээр энэ заалт байгаа. Бид нар өөрсдөө гарын үсэг зурсан. Энэ заалтыг ажлын хэсэг, Төрийн байгуулалтын байнгын хороо, Ерөнхийлөгч ямар нэгэн байдлаар хөндөөгүй. Ерөөсөө бидний 62 гишүүний өргөн барьсан төслөөрөө л байж байгаа юм. Энэ тэгээд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг Улсын Их Хурлаас томилдог байсан бол, сайд нарыг нэг бүрчлэн томилдог байсан бол, Ерөнхий сайдын Их Хурлаас томилдог байя. Ерөнхий сайд нь сайд нараа Улсын Их Хуралд танилцуулаад өөрөө томилдог болъё гэж байгаа юм. Энэ нь яаж байгаа вэ гэвэл өнөөдөр нөгөө кабинеттай ажиллаж байгаа сайд нартаа эргээд хариуцлага тооцож чаддаггүй. Тэгээд бөөн асуудал болдог. Тэгээд одоо сайд болгохын тулд бөөн зөвшилцдөг. Таардаггүй сайд нар ажиллаж байсан олон жишээ туршлага байгаа. Тийм болохоор тэр Ерөнхий сайд нь Парламентын өмнө бүрэн одоо өөрөө хариуцлагаа бүрэн хүлээдэг байя.

Харин сайд нараа өөрөө бүрэн томилоод, сайд нарынхаа өмнөөс хариуцлага хүлээдэг. Сайд нартаа бас хариуцлага тооцож чаддаг болгоё гэсэн ийм агуулгаар оруулж ирсэн заалтаа. Энэ дээр тэгээд танилцуулна гэдгийг зүгээр ингээд нэг царайг нь харуулаад өнгөрчих юм шиг бодоод байх шиг байна. Танилцуулна гэдгийн цаана чинь асуудалт асуух, захиа даалгавраа өгөх тийм үү, энэ бүх боломжууд нь байж байгаа. Мөн одоо Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай хуулийг Улсын Их Хурал батална. Ямар ямар яамтай байх юм. Хэдэн яамтай байх юм. Тийм үү? Ямар ямар чиг үүрэгтэй байх юм тэр яамнууд нь гэдэг юмыг Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг бүгдийг нь Их Хурал батална. Батлах юм. Дээрээс нь дахиад Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна. Засгийн газрын гишүүн нь Улсын Их Хуралд тангараг өргөнө. Тангараг өргөнө. Ийм байдлаар томьёолж өгсөн юм. Энэ бол Их Хурлын гишүүд бидний 62 гишүүний оруулсан төсөл яг хэвээрээ байж байгаа. Хаана нь ч ямар ч өөрчлөлт ороогүй шүү гэдгийг бас гишүүддээ хэлье. Ингэж байж Засаг нь Засаг шиг, парламент нь парламент шиг, парламенттай барьцаалагддагт, сайд нараа чөлөөлж, томилж, огцруулж чаддаггүй парламентаас айсан, ичсэн одоо юу гэдэг юм. Нөгөө талдаа өөрөө хариуцлагаа хүлээдэггүй. Та нарын томилсон сайд шүү дээ, би одоо мэдэхгүй, би чадахгүй гэдэг биш.

Парламент юм уу, Ерөнхий сайд нь бүрэн хариуцлагаа хүлээдэг байя. Харин сайд нар нь Ерөнхий сайдынхаа өмнө хариуцлагаа хүлээдэг байя. Энэ сонгодог зарчмаар нь явуулья гэдэг үүднээс олон жил ярьж байгаад, манай 62 гишүүн өөрсдөө яг гарын үсэг зураад, оруулж ирсэн төсөл байгаа юм шүү. Гишүүд энийг бас зөв ойлгоод яваач ээ, бас тийм. Мэдээж тэгээд танд сайд нар болгоныг нэр бүрчлэн танилцуулах, асуултаа асууж, үгээ хэлэх, захиа даалгавраа өгөх, сайд болгон нь Их Хуралд орж ирээд тангаргаа өргөх энэ бололцоо нээлттэй байж байгаа. Мэдээж өргөсөн тангаргаасаа няцах юм бол эргүүлээд хариуцлага тооцох асуудлыг Ерөнхий сайдад нь хэлээд, хариуцлага тооцуулж болох ийм гарц бас байгаа. Тэгээд энийгээ органик хуулиараа зохицуулах бололцоотой гэж үзэж байгаа гэдгийг гишүүддээ хэлье.

Г.Занданшатар: Кабинетын зарчмаар ажиллах зарчим. Ерөнхий сайдтайгаа адилхан томилогддог зарчимтай болохоор болохгүй байна гээд байна шүү дээ. Ингээд гишүүд чуулганы танхимдаа орж ирээрэй. Санал хураалт явуулья.

Төслийн 4 дүгээр зүйл буюу Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд,” гэснийг “Ерөнхий сайд,” гэж өөрчлөх. Төслийн заалт.

Санал хураалт. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн босоо санал байна. Дэмжье гэсэн саналаар санал хураалт.

Данзангийн Лүндээжанцан дарга, цөөнх үг хэлнэ.

Д.Лүндээжанцан: 39, энэ асуудлыг одоо 62 гишүүн гарын үсэг зурж, өргөн барьчхаад одоо тэрнээсээ буцацгааж байгаа юм. Энэ дээр бол ажлын хэсэг шинэ санал оруулаагүй. Бүлгээр оруулсан, энэ саналуудыг дэмжиж байна уу гэсэн дэмжсэн. Мөнх-Оргил гишүүн бол 62-ын юун дотор гарын үсгээ зураагүй. Гол зураагүйн шалтгаан энэ байх. Сүүлийн 2 жил гаран энүүгээр туж бид нарын хооронд маргаан явсан. Манай гишүүд бол дэмжиж байсан. Ер нь бол парламентын засаглал руу шилжихэд Ерөнхий сайдад бол танхимаа бүрдүүлэх эрхийг нь өгье. Улсын Их Хурал оруулж ирж байгаа Засгийн газрын гишүүдтэй нэг бүрчлэн танилцъя, тэгээд хэлэх үгээ хэлээд гаргая. Их Хуралд байдаг юм уу, хаана байдаг юм тангаргийг нь өргүүлбэ гээд тэр ард томьёоллыг нь хийгээд өгчихсөн байгаа юм. Энэ бол бусад парламентын засаглалтай улсуудын эрх мэдлийн хяналт, тэнцвэрийн гол зүйл нь байдаг.

Ерөнхий сайд Улсын Их Хурлын өмнө хариуцлагаа хүлээсэн шиг хүлээе. Тэгээд одоо өөрөө танхимаа бүрдүүлбэ. Засгийн газрын гишүүдээ өөрөө томилж, чөлөөлж, огцруулъя. Болохгүй байгааг нь тэр дор нь огцруулчихъя. Тэгээд оронд нь ийм хүн томилох гэж байна гээд Их Хуралдаа оруулж ирээд танилцуулъя, Ерөнхийлөгчид. Ингэж л одоо оруулж ирж байгаа шүү дээ. Яах вэ өнөө, маргаашийн юмыг бол харж байж болно. Бид өнгөрснөө нэлээн харсан. Ер нь бол парламентын ая таалалд нийцүүлж, фракцын тоогоор 19 хүртэл Засгийн газрын гишүүдийн тоог нэмэгдүүлж байсан. Тэгээд тэр бүхэн нь өөр өөрсдийн фракцын тулгууртай, Ерөнхий сайд нь Засгийн газрын гишүүдтэйгээ хариуцлага тооцож чаддаггүй. Салбар, салбарт бодлого унадаг. Мэргэшсэн, мэргэжлийн Засгийн газрын үйл ажиллагаа явуулж чаддаггүй. Ийм л одоо зүйл байгаа шүү дээ.

Тэгэхээр Ерөнхий сайд өөрөө хар толгойгоороо хариуцах хэрэгтэй. Би энэ парламентын өмнө хариуцлага хүлээж, Засгийн газрыг толгойлж, Улс орны хууль биелүүлэх ажлыг, улс орныг удирдах ажлыг авч явъя гэвэл би ийм баг, ийм салбаруудыг одоо удирдах найдвартай ийм хүнд итгэж байгаа хүмүүсээ тавьж ажиллуулж, хариуцлагаа би өөрөө хүлээнэ гээд. Тэгээд болохгүй байгаа тэр сайд нараа өөрөө дор нь хариуцлага тооцоод хусаад хаячихдаг ийм л байлгая гэж хүмүүс ярьсаар байгаад энэ асуудал орж ирсэн. Ардчилсан намын зөвлөлийнхөн ч гэсэн одоо байна шүү дээ, гарын үсэг зурснаас дарга нар нь сууж байна шүү дээ. 47 гишүүний 2015 онд өргөн барьсан төсөл дээр та нар гарын үсгээ зурсан, зарим шинэ гишүүд нь зураагүй байх. Тэгээд юу гэж орж ирсэн бэ гэхээр 2015 оныхоо төсөл дээр бол бид тэр санал дээрээ санал нэг байгаа гэдгээ бол бичгээр илэрхийлсэн байж байгаа. Бүлэг дээр энэ асуудлыг дэмжээд гаргасан. Ийм учраас бүлгийн энэ санал одоо ингээд унах гэж байгаа бол бүлэг завсарлага аваад, дахиж ярих нь зүйтэй гэсэн саналыг би хэлэх байна.

Г.Занданшатар: Горимын санал гэж санал хураалт дээр байхгүй. Завсарлах бүлгийн санал гэж л байна. Тогтохсүрэн дарга.

Д.Тогтохсүрэн: Энэ асуудал, би ийм л горимын санал хэлэх гээд байгаа юм. Энэ асуудлаар Монгол Ардын намын бүлэг дахиж нэг ярилцах шаардлага үүсэж

байна. Тийм учраас энэ асуудлыг хойшлуулаад бид нар 1 дэх өдөр ч юм уу бүлгийн хурлаараа хэлэлцээд, дараа нь бид нар хойшлуулсан олон асуудал байгаа шүү дээ. Тэр хүрээндээ энэ асуудлыг авч үзээд явчихъя гээд ингэж бодож байна. Тийм учраас энэ асуудал дээр дахиж санал хураахгүй. Манайх бүлгээрээ дахиж нэг ярьсны дараа үргэлжлээд явуулбал яасан юм бэ гэж бодож байна. Тийм учраас миний горимын санал энэ асуудлыг хойшлуулъя гэсэн горимын санал гаргаж байгаа юм. Завсарлага авчихаар өнөөдрийн чуулган зогсчих гээд байгаа учраас би хойшлуулъя гэсэн ийм саналтай байна. Энэ асуудлаа хойшлуулаад.

Г.Занданшатар: Хойшлуулаад, энэ асуудлаар гэж байгаа юм. Бүлгийн даргын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалтад 62 гишүүн оролцож 50 гишүүн дэмжиж, энэ асуудлыг түр хойшлууллаа. Дараагийн асуудалд орно. Дараагийн асуудал энэ асуудалтай хамт асуудал учраас хамт хойшлогдох уу, дэгээр тийм ээ? 17.1. Одоо 20 дугаар заалтаас эхэлнэ.

20 дугаар заалт, санал хураалт явуулна. Төслийн 4 дүгээр зүйл буюу Хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тавиас доошгүй” гэснийг “далан таваас доошгүй” гэж өөрчлөх. Төслийн заалт. Долоон өөрчлөлтийн эхний өөрчлөлт нь. Санал хураалт.

Болдын Жавхлан, Лүндээжанцан, Гарамжав гишүүд гар өргөж байна. Болдын Жавхлан гишүүн.

Б.Жавхлан: Яах вэ, протоколд хэлээд нэмээд явуулах уу, санал дахиж хураах юм уу? Дахиж хураах юмуу? Тэгвэл техникийн саатлын улмаас дахиж санал хураах болсон шалтгаантай саяын саналыг хүчингүй болгож өгнө үү.

Г.Занданшатар: Таны санал буруу гарсан гэсэн үү?

Б.Жавхлан: Тийм.

Г.Занданшатар: Дэмжсэн санал өгсөн чинь дэмжигдсэнгүй ээ гэж. За тэгж ойлголоо. Лүндээжанцан гишүүн.

Д.Лүндээжанцан: Би саяны Жавхлан гишүүнтэй адилхан. Дэмжсэн санал өгсөн. Тэгээд техникийн саатал гараад болсонгүй. Тийм учраас хүчингүй болгоод дахиж санал хурааж өгнө үү. Энэ бол онол биш, өөрчлөлтийг сэргээж байгаа нэг заалт байгаа юм.

Ц.Гарамжав: Энэ санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү. Бас адилхан, би дэмжсэн санал өгсөн. Техникийн саатал гарлаа.

Г.Занданшатар: Гишүүд суудлаа эзлээрэй. Санал хураалт дахиж явуулах гэж байна. Энэ саяны санал хураалт 3 гишүүний төхөөрөмж ажиллаагүй. Санал хураалт буруу болсон учраас саяны санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

89.8 хувийн саналаар энэ саналыг хүчингүй болголоо. Санал хураалтыг дахин явуулна. Санал хураалт.

Оюун-Эрдэнэ сайд, Оюун-Эрдэнэ гишүүн, дараа нь Батнасан гишүүн.

Л.Оюун-Эрдэнэ: Техник ажилласангүй ээ. Тийм учраас саналыг хүчингүй болгодог юм уу эсвэл протоколд тэмдэглүүлэхгүй бол. Уг нь өнөөдрийг хүртэл их амжилттай явсан. Нэг ч удаа алдаа гаргаж байсангүй.

Г.Занданшатар: Оюун-Эрдэнэ гишүүний дэмжсэн санал, дэмжигдээгүйгээр гарсан учраас дахин санал хураалт явуулъя гэсэн санал хэллээ. Батнасан гишүүн.

О.Батнасан: Оюун-Эрдэнэ гишүүнтэй санал нэг байна.

Г.Занданшатар: Отгоогийн Батнасан гишүүний бас төхөөрөмж ажиллаагүй, буруу санал өгчихсөн байна гэж, зөв үү? Зөв гэнэ. Энэ санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Орой болоод бас энэ төхөөрөмж хүртэл ядардаг бололтой. 11 хүртэл явна.

Хүчингүй болгох санал. Оюун-Эрдэнэ, Батнасан гишүүн нарын горимын санал дэмжигдэж 90.3 хувийн саналаар өмнөх санал хураалт хүчингүй боллоо.

Одоо санал хураалтыг дахиж явуулна. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт дахиж явуулъя.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 60 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

20.1.Төслийн 4 дүгээр зүйлийн Хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ээлжит чуулганы ажлын өдрийг тухайн жилийн 3 дугаар сарын 01-ээс, мөн 7 дугаар сарын 29-нөөс эхлэн тоолно.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэг. Санал хураалт явуулъя.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 15 гишүүн дэмжиж, 47 гишүүн татгалзаж, энэ санал дэмжигдсэнгүй. Дараагийн санал.

21.Төслийн 4 дүгээр зүйл буюу Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн дугаарыг “4” гэж, “Байнгын” гэснийг “Байнгын болон бусад” гэж өөрчлөх. Төслийн заалт. Санал хураалт.

Энэ санал дэмжигдсэнгүй.

21.1.Төслийн 4 дүгээр зүйлийн ““далан таваас доошгүй” гэж” гэсний дараа “Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн дугаарыг “4” гэж, “Байнгын” гэснийг “Байнгын болон бусад” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 58 гишүүн дэмжиж, 93.5 хувиар санал дэмжигдлээ.

22.Төслийн 4 дүгээр зүйл буюу Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Ерөнхий сайд, Засгийн гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь” гэснийг “Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол албан үүрэгт нь” гэж өөрчлөх. Төслийн заалт.

Санал хураалт.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, энэ санал дэмжигдсэнгүй.

22.1.Төслийн 4 дүгээр зүйлийн “Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь” гэснийг “Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол албан үүрэгт нь” гэснийг хасаж,

төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18 дахь заалт буюу Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг нэмэх.

18.Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайдаас бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангарагаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн, Ардчилсан намын зөвлөлөөс ижил утгатай санал ирүүлсэн.

Харин тэгээ. Кнопоо дараад үгээ авцгаа. Баасанхүү гишүүн, Тэрбишдагва гишүүн. Эрхэм гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн үг хэлнэ.

Д.Тогтохсүрэн: Би бас горимын санал хэлэх гээд байгаа юм.

Г.Занданшатар: Болорчулуун гишүүн одоо гарахгүй шүү. Бүгд суудалдаа суугаарай.

Д.Тогтохсүрэн: Гишүүд ээ, энэ 22.1 дүгээр заалт дээр би горимын санал хэлэх гээд байгаа юм. Энэ заалтыг тэр нөгөө 108, 99 гэдэг нөгөө хойшлогдсон саналуудтай хамтатгаж хэлэлцэх санал байгаа юм. Энэ чинь багц асуудал байхгүй юу. Засгийн газар Улсын Их Хурлын харилцааны энэ хамаарал бүхий асуудал байгаа юм. Тийм учраас бид нар Нямбаатар гишүүний өчигдрийн саналаар хойшлогдсон тэр сонгуулийн тогтолцоо, тэр нөгөө гишүүдийн тоо, эд нарын дараа энэ асуудлыг хэлэлцэх ёстой юм. Тийм учраас миний санал бол энэ 22.1 гэдэг заалтыг хойшлуулаад тэр асуудалтай хамтатгаад хэлэлцчихье гэсэн ийм хойшлуулах горимын санал гаргаж байгаа юм.

Г.Занданшатар: Бүлгийн дарга Тогтохсүрэн гишүүний саналаар, горимын саналаар санал хураалт явуулъя. Хойшлуулъя гэсэн санал хураалт. Одоо тэртэй тэргүй бид нар шийднэ. Тэгээд маргааш, нөгөөдөр.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 82.8 хувийн саналаар энэ саналыг хойшлууллаа.

Одоо 2 дугаар бүлэг асуудал руу дөнгөж орж байна. Гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлт.

23.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу Дөчин зургадугаар зүйлийн 4 дэх хэсэг нэмэх.

“4.Төрийн жинхэнэ алба нь мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай байх, шатлан дэвших зарчимд үндэслэнэ. Төрийн албан хаагчийг улс төрийн шалтгаанаар ялгаварлан гадуурхах, сонгуулийн үр дүнгээр, эсхүл хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөх, халахыг хориглоно. Төрийн албаны чадахуйн зарчмын хэрэгжилтэд тавих хяналт хараат бус байна.” Төслийн заалт.

Санал хураалт явуулъя. Баасанхүү гишүүн үг хэлнэ.

О.Баасанхүү: Баярлалаа. Төрийн жинхэнэ албаны мэргэшсэн тогтвортой, хариуцлагатай байх гэдэг яг энэ үгийг бол дэмжиж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол мэргэжлийн хүн ажиллах юм байна. Ажил, албан тушаалаас нь хамаагүй чөлөөлөхгүй юм байна. Дээрээс нь төрийн алба бол өөрөө хариуцлагатай байх юм байна гэж. Асуудлын гол нь энэ дээр би юун дээр санаа зовоод байгаа вэ гэхээр

шатлан дэвших зарчимд үндэслэнэ гэдэг энэ үг чинь хоёр талтай болчихоод байгаа юм. Би шатлан дэвшүүлэх, дэвших зарчим гэдгийг юу гэж ойлгож байгаа вэ гэвэл мэргэжилтнээр ажилд ороод, ахлах мэргэжилтэн, газрын дарга, хэлтсийн дарга, төрийн нарийн ч гэдэг юм уу хамгийн дээд талын төрийн албаны өндөр албан тушаал нь Төрийн нарийн бичгийн дарга хүртэл явж байна гэсэн. Ингээд ерөнхий харахад ийм байдаг. Гэтэл өнөөдөр эндээс бид нар юун дээр их санаа зовж байгаа вэ гэхээр мэргэшсэн гэдэг ойлголт чинь яг шаталснаараа мэргэшиж чадах уу, дээрээс нь өнөөдөр чадамжтай албан тушаалтныг шатлаагүйгээр бас албан тушаалын тодорхой шалгуураар томилох бололцоо байна уу гэж.

Мерит гэдэг одоо бид нар бас Төрийн албаны хууль санаачлаад одоо юу гэдэг юм мерит гээд байсан чинь тэр чинь бол чадамжийг нь үнэлэх гэж тавиад байгаа байхгүй юу. Манайд өнөөдөр ямар асуудал үүсээд байдаг вэ гэхээр цүнх барьдаг, намд үйлчилдэг, сонгуульд ордог, сонгуулийн сурталчилгаанд явсан гэдгээр нь хамаараад 20 жил, 30 жил ажилласан хүн ахлах мэргэжилтэн ч болж чадаагүй байхад нь тэрний дарга гээд нэг хүүхэд тавьчихдаг. Нөгөөдөх нь төрийн албаа явуулж чаддаггүй, нөгөө төрийн албан хаагчийн чинь хувьд бол итгэл үнэмшил хэцүү, ажиллахад хэцүү байдаг. Энэ зайлшгүй шалтгааны улмаас ингээд нэг тал руугаа туйл болгоод за энийг бид нар заслаа гэж ярьж болно. Гэтэл нөгөө талаасаа аваад үзэхэд насаараа сургууль соёл энээ тэрүүгээр яваад, гадаад, дотоодод байгаад одоо жишээлбэл юу байдаг юм. Apple компанид ажиллаж байгаа хүнийг монголын нэг компани тодорхой газар ажиллуулъя гэвэл яаж ажиллуулах юм жишээлбэл. Эсвэл одоо Самсунг ч гэдэг юм уу эсвэл одоо Форд компанид ажиллаж байгаа хүнийг тэр хүн л төрийг нарийн мэргэшсэн мэдлэгтэй хүн. Тэрийгээ тэгэнгүүт одоо юу гэдэг юм захирлаар ч юм уу газар, хэлтсийн даргаар менежментийнх нь хувьд дээр гээд ингээд тавих бололцоо бас хаагдах вий дээ гэж би их санаа зовоод байгаа юм.

Өөрөөр хэлэх бол ард түмэнд таалагдах байдлаар төрийн албаны яг ний нуугүй хэлэхэд энэ амьдрал чинь баялаг шүү дээ. Төрийн албан хаагч ч гэсэн өөрөө тангараг өргөөд явж байгаа ч гэсэн нөгөө талаасаа бол бас дэвшиж дээшлэх гэдэг юм чинь хоёр шалгуураар явна шүү дээ. Нэгдүгээрт нь бол ажлын ур чадвар, мэдээж ажилласан жил орохыг бол үгүйсгэхгүй. Тогтвортой байгаа гэдэг утгаараа. Нөгөө талаасаа аваад үзэхээр бас үнэхээр мэргэжлийн, онцгой ур чадвартай менежментийн баг орж ирвэл яах вэ гэж. Жишээлбэл эмнэлгийг заавал настай хүн удирдах ёстой гэж ойлголт байхгүй шүү дээ. Эмнэлгийн дарга залуу хүн байж болно. Гадаад, дотоодын эмнэлгийн байгууллагад ажиллаад, өндөр мэс заслын ур чадвартай болчихоод менежментийн чадвартай эсвэл одоо дэлхийн эмнэлгийг удирдаж байгаа хүн хүрч ирээд би эмнэлгийн дарга хийе гэх юм бол энэ мундаг юмаа гээд тавих гэхээр ажилласан жил нь таарахгүй байна, тогтвортой биш байна, хариуцлага нь бас ойлгомжгүй байна Монголд биш учраас ч гэдэг юм уу ингэх вий гэж бодоод байгаа учраас энэ хоёр бололцоог аль алиныг нь олгож өгөх ёстой. Аль алиныг нь.

Тэрнээс биш би бол энийг нөгөө төрийн албаны нөгөө албаныг барьцаалах байдлаар за чи миний сонгуульд ажиллаарай, чамайг төрийн албан хаагч болгоно, манай нам өнөөдөр ажлын багаа бүрдүүлж байна, би өөрийнхөө сонгуулийн штабынхныгаа энд тэнд байршуулж байна. Багаар ажиллах чадвартай гээд гарч ирэнгүүтээ оптоор нь халдаг энэ байдлыг би дэмжээд байгаа юм бишээ. 20 мянга гаруй хүн шалтгаангүйгээр ажлаас халагдаад өнгөрсөн 2015 оны нээлттэй сонсголын хэлэлцүүлгээр манай Өргөдлийн байнгын хороо хийж байхад 15 мянган хүн, 15 тэрбум төгрөг улсад хохирол учирсан. Одоо энэ тоо бас дахиад нэмэгдэж байгаа. Яагаад вэ гэвэл харин Үндсэн хууль дээр хэрвээ үндэслэлгүй халчих юм уу эсвэл улс төрийн шалтгаанаар хүнийг ажлаас халах юм бол тэр хүн Үндсэн

хуулийн цэцэд хандаад намайг намыг нь дэмжээгүй гээд намайг одоо энэ улс төрийнх нь, намын үйл ажиллагаанд нь туслаагүй гээд намайг ажлаас зориуд ингэж халлаа. Энэ нам ялаад намайг ялсан нам нь ялагдсан гэдэг утгаар халлаа гээд иргэд гомдол гаргадаг. Энийгээ нотлоод Үндсэн хуулийн цэцээр очвол энэ Үндсэн хуулийн цэц нь улс төрийн шалтгаанаар байна гээд тогтоовол тэр халсан этгээдийг бол улс төрийн албан тушаалтан байна одоо бид нар өмнө нь ярьж байгаа шүү дээ. Үндсэн хууль зөрчсөн шалтгаанаар Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татна гэдэг шиг энэ бол ингээд Үндсэн хууль зөрчсөн байна, шахаа хийсэн байна ч гэдэг юм уу, юу гэдэг юм ингээд энийг зайлуулах, өөрчлөөд дахиж улс төрийн шалтгаанаар ямар нэгэн байдлаар төрийн албыг тогтворгүй байлгаж болохгүй ээ.

Тийм учраас энэ асуудлыг шууд одоо ингээд сонгууль ойртож байгаа, бид одоо өмнө нь 20 мянган хүнийг халдаг байсан, манай нам ялахаараа одоо юм уу, ялагдахаараа ямар нэгэн хүн халагдана, эсвэл халагдахгүй гэдэг баталгаа өгөх гэсэн зорилгоор Үндсэн хуульд ингэж оруулж болохгүй ээ. Тэгэхээр төрийн алба гэдэг бол дэлхийд ямар байдаг юм яг тэр жишгээр л тогтоогоод өгөөч. Дэлхийд бол нэг л ойлголт байгаа шүү дээ. Төрийн албан хаагч бол улс төрийн албан тушаал хашдаггүй бөгөөд ямар нэгэн байдлаар шууд болон шууд бусаар оролцдоггүй. Тэр оролцдоггүй байдал нь өнөөдөр юу вэ гэвэл төрийн алба тогтвортой болоод байгаа юм. Хоёрдугаарт нь, өнөөдөр юу вэ гэвэл тодорхой ажил, мэргэжлийн ур чадвараасаа хамаараад шатлаад бас дэвшээд явах бололцоо нь байгаа юм. Тийм учраас ур чадварын тэр шалгуурыг нь гаргах ёстой юм. Тэрнээс биш тогтвортой гэдэг байдлаараа энэ 20 жилийг тавина гэвэл яах юм. 30 жил ажиллаж байгаа хүнийг ахлах мэргэжилтэн болно гэвэл яах юм. Ийм ноцтой юу гэдэг юм алдаанууд гарах учраас одоо нийт төрийн албан хаагч нар өнөөдөр яг өөрсдөө хараад сууж байгаа. 3 зүйлийг би бол энэ дээр анхаарч батлах ёстой.

Нэгдүгээрт нь бол мэдээж улс төрийн намын шахалтыг тэр ялсан нам нь төрийн албаар тоглогдгийг болиулах ёстой. Хоёрдугаарт нь, төрийн албан хаагч нь энд байхдаа ажил, амьдрал ахуй, цаашдаа дэвшин дээшлэх бололцоотой гэдгийг нь олгох ёстой. Гуравдугаарт нь, үнэхээр мэдлэгтэй бол ажилла л даа. Юунд ч ажиллаж болно, ямар ч удирдлага байж болно. Мэддэг нь ажиллая, мэддэггүй нь суралцъя гэсэн зарчмаар мэдлэгт суурилсан төрийн бодлого явахын тулд мэдлэгтэй, чадвартай хүн нь гол шатлахаасаа давсан бас давуу эрх эдлээд явах ёстой. Тийм байж байж бид нар өнөөдөр дэлхийтэй хөл нийлүүлэн явах бололцоотой гэдгийг хэлмээр байна. Тийм учраас саналаа өгөхдөө энийг дахин нэг бодоорой гэж хэлмээр байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Баасанхүү гишүүн минь энэ чинь дэмжигдэхгүй санал. Дараагийнхад нь тэр чадахуйн зарчим буюу мерит чинь, ёс зүй энэ тэр бүгд байгаа шүү дээ. Юмаа уншихгүй юмаа бас.

За санал хураалт явуулъя.

Санал хураалтад 63 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

23.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу Дөчин зургадугаар зүйлийн 4 дэх хэсгийг “Төрийн жинхэнэ алба нь мэргэшсэн, тогтвортой, ёс зүйтэй, хариуцлагатай байх, шатлан дэвших чадахуйн зарчимд үндэслэх бөгөөд түүний хэрэгжилтэд тавих хяналт хараат бус байна. Төрийн жинхэнэ албан хаагчийг хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөх, халахыг хориглоно.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүн

Д.Лүндээжанцан, Л.Мөнхбаатар. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн. Ядаж дараагийн заалтаа уншиж байж үг хэлж баймаар байна. За Баасанхүү гишүүн, Ганбаатар гишүүн.

О.Баасанхүү: За уучлаарай Ганбаа даргаа. Тэгэхээр ийм байна. Дахиад одоо нөгөө туйл руу явчихаж байгаа байхгүй юу. Өмнө нь бол нөгөө шатлана гэдгээр байсан бол одоо зөвхөн чадавх, чадавхид суурилсан гээд. Яг одоо нөгөө юм чинь буцаад одоо нөгөө мерит гэдэг үг чинь мерит гэдэг үгээ та нар бас энэ чинь орчуулж болдоггүй үг биш шүү дээ. Популизм гэдэг үгийг чинь хийрхэл гэж орчуулаад байгаа шүү дээ, би. Хийрхдэг хүмүүс гэж. Тэрэн шиг өнөөдөр мерит гэдэг үгийг чинь бас орчуулж болно. Чадахуйн дээр суурилсан буюу мэдлэгт суурилсан төрийн бодлого гэдгийг гаргахын тулд мэдлэгтэй хүнийг төрийн албанд оруулах нь зөв өө. Гэхдээ нөгөө талаасаа аваад үзэхээр дахиад л 20 жил ажиллалчихаад өнөөдөр байж байхад нэг хүүхэд гүйгээд ирдэг. Чадавхитай нь юугаараа тогтоогдох юм. Туршлага байхгүй байна шүү дээ гэж. Тийм учраас төрийн албанд өнөөдөр ямар хүн хэрэгтэй вэ гэвэл мэдлэгтэй, сэтгэлтэй, туршлагатай хүнийг оруулмаар байна. Зөвхөн сэтгэлтэй биш, зөвхөн мэдлэгтэй биш, би үг хэлээд байдаг, энэ манай гишүүдийг за байз мэдлэгтэй, сэтгэлтэй, туршлагатай хүмүүсийг оруулмаар байна.

Г.Занданшатар: Баярлалаа.

О.Баасанхүү: Тийм, тэгэхээр өнөөдөр ганцхан мэдлэгтэй гэдгийг энд оруулж болохгүй ээ. Төрийн албанд бол сэтгэл, туршлага гэж бас бий.

Г.Занданшатар: Кнопоо дараад үгээ хэл, энэ чинь хүн үг хэлж байна. Чи битгий олон юм яриад бай. Хурал удирдаж байна. Чи дуугүй гараад яв тэгвэл. Хүн үг хэлж байна, чи дуугүй бай.

О.Баасанхүү: Тэгэхээр бас энэ заалтан дээр чинь дахиад нэг аюул байна. За за би дараа нь яая.

Г.Занданшатар: Үг хэлэх гишүүд кнопоо дараад үгээ оруулдаг юм. Заримынх нь орчихсон байна. Үгүүд нь ороод байна. Кнопоо дараад үгээ оруул. Гишүүд кнопоо дарж нэрээ өгөөрэй. Энэ төхөөрөмжөө ажиллуулаарай. За Учрал гишүүнээр тасаллаа. Мөнх-Оргил гишүүн үг хэлнэ. Мөнх-Оргил гишүүний өмнө Ганбаатар гишүүн үг хэлэх юм байна. Ганбаатар, Лүндээжанцан гишүүн хоёрын нэр алга болсон байна, эхэнд нь оруулъя. Мөнх-Оргил гишүүнийх алга болчихлоо оруулъя.

Ж.Ганбаатар: Баярлалаа. За энэ заалт чинь харин ингээд иргэдийг ялгаварлан гадуурхаж байна гэж би бол үзэж байгаа. Төрийн албанд ажиллаж байгаа одоо хувийн хэвшлийнхнийг болоод бизнес эрхлэгчдийг дэмжсэн нэг өгүүлбэр, нэг заалт оруулахгүй байж байж төрийн албаныхныг болохоор ингээд хуулиар, бүр Үндсэн хуулиар хамгаалж байгаа ийм том заалт оруулж байгаагийн хувьд би бол дэмжихгүй байна. Одоо иргэд ерөөсөө төрийн албанд орохыг л одоо хүсдэг. Баялаг бүтээхийг хүсэхгүй болох нь байна шүү дээ. Төрийн албанд орсноороо маш том хамгаалалттай болох нь байна. Хэн ч халахгүй юм байна, хэн ч шийтгүүлж чадахгүй юм байна. Төрийн албанд орсон хүн бол ерөөсөө найдвартай ажлын байртай, найдвартай ийм халамжтай ийм болж хувирах юм байна.

Тэгээд Монгол Улс чинь одоо бараг бүгдээрээ төрийн албанд орж ажиллах нь байна шүү дээ. 250 мянга байгаа бол одоо энэ чинь тав, зургаан зуун мянга болох юм байна. Тэгээд хэн баялаг бүтээж, хэн татвар төлж, хэн энэ улс орныг авч явах вэ. Тийм учраас энэ ялгаварлан гадуурхсан ийм заалтыг бол дэмжихгүй

гэдгийгээ илэрхийлье. Би ер нь 10 минутаар үг хэлж байгаа энэ заалтаа бол одоо болиулаач ээ. 2 минутанд багтаад санаагаа хэлчихэж чадаж байна шүү дээ. Ярьж байгаа хүмүүсийн үг нэг минутанд гарч ирээд байдаг. Тэгээд 9 минутанд нөгөөдөхийгөө эргүүлээд тойруулаад яриад байдаг. Би бол одоо энийг нь болиулаад 2 минутанд багтаагаад санаагаа хэлчихье. Үүнээс хойш хэлж байгаа хүмүүс 2 минут хэлээсэй гэж уриалж байна. 2 минут хэлнэ шүү.

Г.Занданшатар: За Лүндээжанцан дарга үг хэлнэ.

Д.Лүндээжанцан: Энэ төрийн албаны заалтыг бол олон түмэн дэмжиж оруулсан. Дээр нь манай мөрийн хөтөлбөрт байгаа. Би энэ хэдэн гишүүдийн ярихыг мэднэ. Ганбаатар гишүүн, Билэгт гишүүн, Учрал гишүүн. Энэ 3 бол хамгийн их ярьсан, хэлэлцүүлэгт хамгийн их орсон. Ганбаатар гишүүний хувьд бол хувийн хэвшил, бизнесийн салбарыг дэмжсэн ямар заалт орсон бэ гэдэг асуудал тавьдаг. Энд нь бол одоо бид бодлоготой, хөгжлийн бодлогын асуудлыг бол нэлээн түлхүү тавьсан. Энэ бүхэн бол хүмүүсийг ажилтай, орлоготой байлгахад чиглэсэн гол заалт байгаа юмаа гэдгийг бол хэлмээр байна.

Дээр нь байгалийн баялгийн асуудал үндэсний баялгийн сантай холбоотой асуудал тэгш шударга хуваарилахтай холбоотой асуудлууд нь бол тэнд явж байгаа юм. Манай Билэгт гишүүний хувьд бол энэ ёс зүйн асуудлыг төрийн албаны ёс зүйн асуудлыг их ярьдаг. Бид энийг оруулсан. Тэгэхээр төрийн албанд л ажиллаж байгаа хүн бол буг болсон, хүнд сурталтан, авлигач гэж үргэлж ярьцгааж байгаа. Үнэндээ ч тийм зүйлүүд байна төрийн албанд. Хүнд суртал байна уу байна, албан тушаалд авлига одоо авдаг хүмүүс байна уу байна. Энэ болгоныг хариуцлага тооцоод ёс зүйтэй, хариуцагатай болох асуудлыг бол бид Үндсэн хуулийнхаа түвшинд бол авч үзэж байгаа юм.

Хоёрдугаарт бол залуу хүмүүс дэвших бололцоо нөхцөл муу байна гэж. Шатлан дэвших чадахуйн зарчим гэж хэчнээн ч чадалтай байлаа гэсэн шууд шат алгасахгүй ээ. Харин чадахуйн зарчим бол чухал аа. Тэр мерит гэж сая Баасанхүүгийн яриад байдаг. Энийг бол одоо оруулж өгсөн. Гол одоо зарчим бол чадахуйн зарчим байгаа юм. Тэгэхээр төрийн албаа бол бид тогтвортой байлгахаас өөр арга алгаа. Мэргэшсэн байлгахаас өөр арга алгаа, шатлан дэвших чадахуйн зарчимтай байлгахаас өөр арга алгаа. Ёс зүйтэй, хариуцлагатай байхыг иргэд байнга ярьж байна. Энэ болгоныг оруулж өгсөн. Дээр нь төрийн жинхэнэ алба гэдгийг оруулж өгөхгүй бол үйлчилгээний алба нь бол юугаараа явчихна. Хөдөлмөрийнхөө хууль, бусад хууль, дүрмээрээ явна. Улс төрийн алба нь болоод ирэхээр бол нүүдлийн шувуу шиг ингээд өөрчлөгдөөд явдаг албан тушаал. Цаана нь бол төрийн жинхэнэ алба нь бол одоо захиргааны албан тушаал, тусгай албан тушаал бол ногдож байгаа юм. Энэ бүхэнд бол тэр мэдлэг, шалгалтаа өгдөг, шалгаруулалтын системтэй, тангараг өргөдөг тэгээд тогтвортой, тэгээд хамгийн гол шалгуур нь бол хэн ажиллаж чадаж байна вэ тэр л цаашаага шатлан дэвшиж ажиллах юмаа.

Тэгэхээр энэ болгон бол иж бүрэн байхгүй юу. Тэрнээс биш бид Төрийн албаны хуулинд хүртэл хийгээд өгсөн шүү дээ. Хэрэв үнэхээр одоо гайхамшигтай чадалтай хүн байх юм бол хугацаанаас нь өмнө 50 хувиар байна шүү дээ 10 жил ажиллаж очих албан тушаал дээр 5 жилийн дараа очих боломжийг нь бол бид хуулиар нээгээд өгчихсөн байгаа юмаа. Үнэндээ бол өнөөдөр энэ төрийн албыг бид анхаарч энэ Үндсэн хуулийнхаа түвшинд хуульчлахаас өөр арга алга болчихоод байна шүү дээ. Нэг сонгуулийн дараа 20, 30 мянгаараа халагдаж солигддогийг чинь бид зогсоох шаардлагатай байна. Мөн намын янз бүрийн

дэмжлэгээр гэдэг юм уу ар, өврийн хаалгаар оччихоод ажилдаа тэнцэхгүй байгаа хүмүүстэй нь тэр ёс зүйн дүрэм, төрийн албаны сахилга, хариуцлагын хууль гараад хариуцлагаа тооцоод явчих юм. Энийг бас нэг зөв ойлгож манай гишүүд үзээч ээ гэж.

Тэгэхээр ерөөсөө л энэ төрийн алба болохгүй байна. Тийм учраас бол энийг зааж болохгүй. Бүгдээрэнгээр нь хуйгаар нь өөрчлөөд сольчих ёстой гэж нэг хэсэг нь яриад байдаг. Нэг хэсэг нь болохоор удсан тийм тогтвор суурьшилтай хүмүүс бол одоо ингээд хөдөлгөөнгүй хүнд суртал гаргаад суугаад байдаг. Шинэ залуу боловсон хүчин орж ирээд ажиллаж болохгүй байна гэж шүүмжлээд байдаг. Энэ болгоныг чинь харгалзсан хуулийн Төрийн албаны хуулиараа хийж өгөөд, дээр нь энд бид хийгээд өгсөн байхгүй юу. Тэгэхээр тэр ажилд авдаг шалгуур бол маш өндөр шалгууруудыг тавих ёстой. Тэр шалгуур тэнцээд очоод чадахуйн зарчмаараа ажиллах ёстой. Тэгээд Японд бол ингэж байгаа шүү дээ. Ажилласан жил гэдэг бол том шалгуур байдаг. Үнэхээр цөмөөрөө мэрийж хичээж, зүтгэж ажилладаг учраас өмнө нь одоо ажилд орсон хүн нь тэр ахлах мэргэжилтнээ болдог, тасгийн даргаараа болоод явдаг.

Манайд харамсалтай нь дарга, цэрэг хийгээд явдаг мөртлөө чадвар муутай гээд ингээд гологдоод хүнд суртал гаргадаг гээд ингээд хариуцлага алддаг. Энэнтэй нь бол хариуцлагыг нь тооцоод, тэр аттестатчилал гэнэ үү, шалгалт нь гэнэ үү, олон түмний аттестатчилал эд нарыг нь явуулна гэдэг заалт бол Төрийн албаны хуулинд ороод өгчихсөн юм. Гол үндсэн зарчмуудыг нь бол бид энд суулгаад өгсөн. Ёс зүйтэй байх, хариуцлагатай байх, чадахуйн зарчимд суурилах гэдэг энэ гол зарчмуудыг бол суулгаж өгсөн нь үнэхээр чухал байгаа юм. Тийм учраас энийг одоо бид олон түмнээр хэлэлцүүлэхэд бол маш өндөр хувиар дэмжсэн. Ийм ч учраас бол төрийн байгууллага, төрийн албан хаагч иргэндээ үйлчилдэг энэ тогтолцоог л яаж зөв тогтвортой байлгах вэ. Нэг яамны салбар хариуцсан дэд салбар хариуцсан мэргэжилтэн нь 4 жилд 4 солигдчихоор чинь яаж тэр төрийн бодлогын залгамж чанар хадгалагдах юм бэ. Үнэхээр чадахгүй байгаа хүнийг нь солих ёстой. Гэтэл бол ийм одоо хөдөлгөөнтэй байдлаар явж ирсэн байна шүү дээ. Энийг л одоо бид таслан зогсоож, тэгэхдээ хамгийн гол тулгуур зарчим нь бол чадахуйн зарчим. Чадахуйн зарчим гэдэг бол тэр мэдлэг чадвар, ур чадвар цөмөөрөө багтаж байгаа юмаа гэдгийг бол хэлмээр байна.

Тийм учраас болохгүй бүтэхгүй байгаа нэг зүйл дээр жишээ аваад энэнээс болоод энийг нь ингэж өөрчлөөд, энийг одоо ингэж туйлшруулж одоо хандаад байдгаа бол энэ дээр болимоор байна гэдгийг хэлмээр байна. Бүх юмыг тооцож, маш нарийн судалгаатайгаар оруулж ирсэн шүү. Бүтэн одоо судалгаануудыг та бүхэнд өгч болно. Гадаадын судалгаа, дотоодын судалгаа, иргэдийн санаа бодол дээр тулгуурлаж, энэ заалт орж ирж байгаа гэдгийг хэлье.

Засгийн газрын гишүүд бид хүн халах эрхгүй байна гэж бачимдаад байдаг. Ерөөсөө л гүйцэтгэх засаглалд очсон хүн болгон төрийн албыг бол ерөөсөө л тогтворгүй байлгах санал тавьж байдаг. Мөн одоо нөгөө талаар аж ахуй удирдаж байсан хүмүүс ерөөсөө л өөрснөө дур дураараа халж солих тухай л юм ярьж байдаг. Энэ сэтгэхүйгээсээ салах цаг болсон. Тийм ч учраас үнэндээ төрийн алба тогтвортой, мэргэшсэн, хариуцлагатай, ёс зүйтэй, чадвартай байх ёстой гэдэг юмыг л зааж өгсөн шүү. Харин тэр алдаад, оноод байгаагий нь юугий нь бол алдаа гаргаад, хүнд суртал гаргаад, авлига аваад байгаагий нь бол тэгээд мэдлэг чадвараараа хоцрогдоод, хоцрогдсоныг нь бол сольж холих, арга хэмжээ авах эрхийг нь бол харин бас давхар зааж өгч байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Цэндийн Мөнх-Оргил үг хэлнэ.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ Төрийн албаны тухай хуулиар хангалттай зохицуулагдсан асуудал л даа. Олон жил. Гарч ирсэн намууд нь Төрийн албаны хуулиа сахидаггүй л байхгүй юу. Хуулиа зөрчөөд, янз бүрийн юм гаргаж орж ирээд хүмүүсээ халчихдаг. Баг бүрдүүлнэ ч гэдэг юм уу, бүтцийн өөрчлөлт хийнэ ч гэдэг юм уу. Нөгөө Төрийн албаныхаа хуулийг одоо энд байж байна. Төрийн албаныхаа хуулийг ерөөсөө баримталдаггүй. Тэгээд Төрийн албаны хуулиа биелүүлэхгүй байгаа учраас одоо бид нар Үндсэн хуулинд ерөнхий зарчмаа суулгаж өгч байна л даа. Лүндээ даргын хэлж байгаагаар суулгахаас өөр аргагүй байдалд орж байна. Тэгэхээр би ерөнхий санаагий нь дэмжиж байна. Тэгэхдээ үг үсгэн дээр нь бид нар янзлах юмнууд их байгаа юм. Жишээ нь одоо төрийн албанд мэргэшсэн, тогтвортой, ёс зүйтэй, хариуцлагатай байх гээд энийг бол бид нар бүгд дэмжиж байгаа байхгүй юу. Гэтэл энэ бүх үгнүүд чинь, энэ бүх санаанууд чинь Төрийн албаны тухай хуулийн 3.1.3 дээр чадахуйн зарчим /мерит/ зарчим гэж иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлна гээд Төрийн албаны хуулиндаа бид нар хангалттай заачихсан байхгүй юу.

Тэгэхээр шаардлагатай гэж үзвэл Үндсэн хуулийнхаа энэ заалтанд төрийн алба чадахуйн зарчим меритэд, меритийн зарчимд үндэслэнэ гээд нэг өгүүлбэр оруулчихад хангалттай хамгаалалт болж байгаа юм. Гарцаагүй Үндсэн хуулиндаа ийм заалт оруулах шаардлагатай гэж үзвэл. Эцсийн дүндээ зүгээр л хуулиа биелүүлээд, Төрийн албаныхаа хуулийг сахиад биелүүлээд, улс төрчид юм уу тэр улс төрчдийн дагуулж ирж байгаа багийнхан хариуцлагатай хандаад, хуулиа биелүүлдэг л бол энэ асуудал байхгүй байхгүй юу нэг талаас. Нөгөө талаас энэ үг үсгэн дээр анхааралтай хандах юм гэдэг дотор бас ийм санаа хэлмээр байгаа юм.

Одоо энэ санал хураах гэж байгаа заалтын сүүлийн өгүүлбэр ингэж байгаа юм. Төрийн жинхэнэ албан хаагчийг хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөх, халахыг хориглоно гэж байгаа юм. Нэг талаас ингээд сонсоход бол ерөөсөө буруу юм байхгүй юм шиг. Зөвхөн хуулиар л заачихсан бол одоо халах юм байна гээд. Гэтэл тэр хүн ёс зүйн зөрчил гаргасан байвал яах вэ. Жишээ нь мэргэжлийн ёс зүйгээ алдсан байвал яах вэ. Эсвэл одоо дипломат албаны дүрмээ зөрчсөн байвал яах вэ. Тэр чинь хууль биш шүү дээ. Дипломат албаны дүрэм гээд сайдын тушаалаар батлагдаж байгаа хууль биш байгаа байхгүй юу. Гэтэл өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа дипломат албаны хуулиараа тэр хүн дипломат албаны дүрмийг зөрчсөн байгаад ёс зүйн дутагдал гаргасан бол тэр хүн ажлаасаа халагдана. Заавал хууль зөрчих албагүй. Ёс зүйн алдаа гаргахад л тэр хүнийг заавал хална. Энэ заалтыг бид нар баталчих юм бол тэр Ёс зүйн дүрмийг бид нар хуульчлах хэрэгтэй болж байна шүү дээ. Тэгэхээр энэ үг үсгийг нь хармаар байна.

Тэгээд гурав дахь энэ дээр нэг хэлэх гэсэн санаа энэ гишүүд яагаад энэ бужигнаад явчихав гэхээр энэ шатлан дэвших чадахуйн зарчим гэдэг хоёрыг ингээд нийлүүлээд хольчихоод байна. Ерөөсөө зүгээр л шатлан дэвших гэдэг үг чинь энэ чадахуйн зарчим дотроо сууж байна гэж ойлгоод, чадахуйн зарчим дээрээ үндэслэнэ гээд явчихад хангалттай байгаа байхгүй юу. Шатлан дэвших гэдгийг чинь би бол жишээ нь хувьдаа юу гэж ойлгоод байна вэ гэвэл карьерын зарчим гэж ойлгоод байна. Анх ажилд орлоо, 4 жил нэг ажил хийлээ, тасгийн дарга боллоо, ахиад 5 жилийн дараа газрын дарга боллоо, тэрний дараа Төрийн нарийн бичгийн энийг бол би одоо жишээ нь шатлан дэвших зарчим гэж ойлгох гээд байна. Би тэгж хэлж байна гэж ойлгохгүй байгаа юм. Энэ чадахуйн зарчим ярьж байна гэж ойлгож байгаа.

Чадахуйн зарчим дотор чинь ерөөсөө хүн ажлаа хийж чадаж байна уу, үгүй юу гэдэг нэг зарчим. Хоёр дахь зарчим нь улс төрийн нөлөөллөөс ангид байнаа гэдэг ерөөсөө л энэ хоёр юм явж байна гэж би ойлгож байгаа. Энийгээ суулгачихад хангалттай байгаа юм биш үү. Улс төрөөс хараат бус байна. Төрийн албаны хуулийн 3.1.3 дээрээ заасан тэр мерит буюу чадахуйн зарчим дээрээ суурилна гээд л хэлчихэд хангалттай байна шүү дээ. Тэгээд тэр шатлан дэвшинэ гээд тэгсэн мөртлөө араас нь чадахуйн зарчим гэхээр чинь будилагдаад байна шүү дээ, ойлгогдохгүй байна шүү дээ. Нэг болохоороо эхнээс нь авахуулаад явж явж байж л карьер хийх юм байна гэж ойлгоно. Тэгсэн мөртлөө чадахуйн зарчим гээд. Хэрвээ чадахуйн зарчим дээрээ суурилнаа гэх юм бол ажил хийж чадаж байгаа хүнийг нь авчраад л тавих хэрэгтэй болно шүү дээ.

Тэгээд энэ зүйл, заалтуудыг нь харж янзалж байж энийг бид нар гурав дахь хэлэлцүүлэг дээр батлах хэрэгтэй байх аа. Ер нь бол эцсийн дүндээ одоо байгаа хуулиа хэрэгжүүлэхгүй, одоо байгаа хуулиа нулимаад, дураараа дургиад байгааг бид нар Үндсэн хуулийн заалтаар үүрэгжүүлж зогсоох гээд л оролдоод байна шүү дээ. Одоо Төрийн албаны хуулиа хэрэгжүүлэхгүй байгаа хүмүүс Үндсэн хуулиа хэрэгжүүлнэ л гэж бид нар горьдлого тавьж байна шүү дээ. Аргаа л ядаж байгаа хэрэг. Энэ зөв үү.

Г.Занданшатар: Энэ Азийн 5 эрх мэдлийн Үндсэн хуульд сонгон шалгаруулалтын засаглал гээд тусдаа нэг төрийн албаны эрх мэдэл байдаг. Тэрнээс бас санаа авсан юм ч байгаа байх. Эрхэм гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг үг хэлнэ.

М.Оюунчимэг: Төрийн жинхэнэ албан хаагч мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай байх ёстой гэсэн энэ заалтыг Үндсэн хуулиар баталгаажуулж өгч байгааг бол би дэмжиж байгаа юм. Яагаад гээд ингэхээр энэ төрийн албан хаагч өөрөө мэргэшсэн, чадварлаг, хариуцлагатай байж байж иргэнийхээ өмнө тулгарч байгаа асуудлыг мэргэжлийн өндөр түвшинд хариуцлагатай, хурдан шуурхай гүйцэтгэдэг байх ёстой гэдэг үүднээс л энэ асуудлыг ингэж оруулж ирж байгаа байх гэж бид нар харж байгаа. Гэтэл бид нар өнөөдөр бодит амьдрал дээр энэ Төрийн албаны тухай сая батлаад, хэрэгжиж эхлээд байгаа хууль маань ч гэсэн зөрчилтэй юмнууд бас их байгаад байна. Яг энэнтэй адилхан өнөөдрийн Үндсэн хууль дээр саяын өмнө нь хэлсэн гишүүдтэй би бас санал нэг байна л даа. Шатлан дэвших чадахуйн зарчим гээд хэлчихээр шатлан дэвших гэдэг юу бас хэрэггүй юм болов уу. Яг мерит зарчмаараа энэ чадахуйн үнэлэмж дээрээ түшиглээд цаашаа явчих нь илүү ач холбогдолтой гэж хараад байгаа юм.

Өнөөдөр Өргөдлийн байнгын хороонд яг энэ төрийн албан хаагчдаа Төрийн албаны тухай хууль хэрэгжээд эхэлсэнтэй холбоотой гарч байгаа асуудлууддаа гомдол их ирээд байна. Тэр нь юу юм бэ гэхээр жишээлбэл орлон гүйцэтгэгчидтэй холбоотой асуудлууд одоо нэг жирэмсний амралтаа аваад явсан гэдэг юм уу, эсвэл урт хугацаагаар чөлөө авчихсан төрийн албан хаагч байлаа гэхэд түүний оронд түр ажиллуулах хүнийг туршилтаар авлаа гэхэд энэ нь өөрөө хаа хамаагүй хүн гаднаас авчрах бололцоогүй. Тэгэхээр юу юм бэ гэхээр төрийн албаны шалгалтаа өгчихсөн нөгөө мерит зарчмаар тэр ерөнхий шалгалтаа өгчихсөн нөөцөнд байгаа хүмүүсээс авна. Гэтэл тэр хүмүүс нь өнөөдөр цөөхөн.

Одоо жишээлбэл дүүрэг, яамдад нэг хүн 3, 4 хүний ажил хийж байгаа. Нөгөө ингэж нэг хүн 3, 4 хүний ажил хийхээр ачаалал ихтэй, нөгөө уурлаж бухимдсан нэг л их стресстэй хүн. Нөгөө иргэндээ үйлчилж чадахгүй, асуудал шийдэж чадахгүй, дугаарлал оочер нь дүүрэг, хороон дээр уртын урт дугаар болчихсон ийм байдал бол газар авч байна гээд байгаа юм. Тэгэхээр энд төрийн албаны мерит зарчмын

дагуу нөгөө ерөнхий шалгалт хэрвээ өгч байгааг одоо нэг жилд 2 удаа аваад байх шиг байгаа юм. Тэгэхээр нөгөө шалгалт өгөөгүй хамаагүй хүн төрийн албандаа орж чадахгүй энэ ажил өөрөө ингээд гацаад яваад байгаа зүйлүүд байна. Тийм учраас бид нар энэ хуулийн зарим заалтууд амьдрал дээр бас хэрэгжихгүй юм байгаа учраас эргэж харах зайлшгүй шаардлага байна. Харин одоо Үндсэн хуульд энийг тусгаад өгвөл Үндсэн хууль бол Үндсэн хууль. Энийг зайлшгүй дагаж мөрдөх ёстой. Тиймээс бид нар бас энэ үг үсэг, найруулгын тал дээр нь сайн анхаарахгүй бол нэг үг өөрөө асар их агуулга, асар их асуудлыг араасаа дагуулчихна шүү дээ. Тиймээс энийг би бол маш сайн харах ёстой гэж бодоод байна.

Энэнээс гадна ер нь энэ төрийн албын асуудлыг бид нар ер нь нэг сайн харахгүй бол төрийн албыг илүү их ингээд бэхжүүлээд байна, төрийн алба руу илүү их анхаарал хандуулж, төр асар их нүсэр болчихоод байгаа гээд л яриад байдаг. Гэтэл бодит амьдрал дээр нөгөө төр гээд байгаа юун дээр орон тоо нь цомхотгосон, боловсон хүчин, цалин хөлснөөс өгсүүлээд асар их шийдэх асуудлууд байгаад байна шүү дээ өнөөдөр. Дээрээс нь сүүлийн үед үүсэж байгаа асуудал нь юу юм бэ гэхээр ирж байгаа өргөдлөөс хараад байхад хүн халж чадахаа байчихсан, авч чадахаа байчихсан бараг тийм байдалд орчихоод байна гэж байгаа юм. Яагаад халж чадахгүй байна гэхээр түрүүн яг хэлээд байгаа сүүлийн үед ялангуяа ёс зүйн зөрчил төрийн албан дээр гаргаж байгаа асуудал маш их байгаад байдаг. Гэтэл энэ нь одоо халах шалтгаан болж чадахгүй, тэр хүн өөрөө бичээд өг гэдэг юм уу одоо яадаг юм гээд. Өнөөдөр дарга нарын хувьд бараг толгойны өвчин болсон ийм асуудал бол маш их байгаад байна л даа.

Тэгээд нөгөө хуучин шиг сэтгэлгээтэй, нөгөө чадамжтай энэ чадахуйн хариуцлагатай, ёс зүйтэй ийм хүн гэтэл өнөөдөр тэнд байгаад нөгөө ийм хариуцлагагүй, ёс зүйгүй, дээрээс нь чадамжгүй, удаан хугацаанд олон жил ажиллачихсан тэр хүнээ халж чадахаа байчихаад байна. Эсвэл тэр хүнийг өөрчлөөд өндөр чадамжтай гадаад, дотоодод юм яваад үзээд, сураад ирсэн, асуудлыг хөнгөхөн төрийн ёстой жинхэнэ албан хаагч шиг хийчих хүн ажилд орж чадахгүй байгаад байна. Дээрээс нь нөгөө төрийн албаны шалгалтаа өгөх гээд бөөн оочер хүлээгдчихсэн. Шалгалт нь ч өнөөдөр нэг хаана ч тэр мэргэжлээр тийм шалгалт 11 сард л орно. Одоо байхгүй ч гэдэг юм уу. Энэ мэтчилэн гажуудал маш их үүсээд байна. Бид уг нь төрийн албыг чадавхижуулах сайхан хууль гаргаж ирсэн ч бусад улс орны тэр одоо жишээ нь Японы туршлагыг бид судлаад л яваад ирсэн. Тэнд жинхэнэ энэ үйлчлээд байдаг. Бид нуухыг нь авах гээд нүдийг нь сохлох тийм юм хийчих гээд байгаа учраас ядахдаа энэ найруулга, үг үсгэн дээр чинь анхаарах, дээрээс нь энэ алдаагаа хурдан засаад явчихгүй бол өнөөдөр дүүргийн Засаг дарга толгойны өвчин болчихсон байж байна шүү дээ.

Газрын албан дээр гэхэд тавхан хүн ажиллаж байгаа. Тэгээд нөгөөдөх нь бас түр орлон гүйцэтгэгч нь гаднаас хүн хамаагүй чадварлаг хүн авъя гэхэд нөгөө хууль шалгалт өгөөгүй гээд авч чадахгүй. Тэгээд нэг хүн дээр бүтэн өдрийн ачаалал, иргэд бөөн бухимдал, урт оочертой. Тэгээд эндээс юу вэ гэхээр төр ажлаа хийж чадахгүй байна, төрд дандаа чадваргүй хүмүүс нь үүрлэхчээд байна гээд асуудал асар их үүсээд байна л даа. Тэгэхээр одоо энэ заалтан дээр бид нар бас юуны төлөө ингэж бүгдээрээ хэлэлцвэл буруугүй гэдэг шиг одоо ингэж хэлэлцэж байгаа юм чинь төрийн жинхэнэ албанд мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай байх, шатлан дэвших гэдэг дээр энэ дээр ажлын үнэлэмж эд нарыг нь хараад яг тодорхой заалтуудыг нь сайн хэлж өгөхгүй бол энэ нь өөрөө бас эргээд нэг юмны дэгээ болоод садаа болчих вий дээ. Тиймээс энэ дээр бид нар эргэж харах нь зөв болов уу гэж байр сууриа илэрхийлж байна.

Ер нь энэ төрийн алба гэдэг бол төр, иргэн хоёрын жинхэнэ тэр гүүр нь болдог хамгийн чухал төрийн албан хаагч. Иргэн өнөөдөр цаашдаа асуудлаа хурдан шийдээд, улс орон хөгжөөд явах уу, явахгүй юу гэдэг энэнээс их шалтгаалах учраас бид энийг нухацтай хандах ёстой гэж байр сууриа илэрийлмээр байна

Г.Занданшатар: За одоо эрхэм гишүүн Даваажанцангийн Сарангэрэл үг хэлнэ.

Д.Сарангэрэл: Баярлалаа даргаа. Санал давхцаж байгаа учраас нэрээ татлаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Одоо эрхэм гишүүн Лувсанцэрэнгийн Энх-Амгалан үг хэлнэ.

Л.Энх-Амгалан: Би энэ Төрийн албаны тухай хуулийн бас санаачлагчийн нэг л дээ. Тэгээд Төрийн албаны тухай хууль маань Улсын Их Хурлаар батлагдаад одоо 2020 оноос хэрэгжиж эхлэх гэж байгаа юм. Энэ бол үнэхээр Монголын ард түмний төрд итгэх итгэлийг дээшлүүлэх, Монголын ард түмэнд төрийн үйлчилгээг хүргэж байгаа энэ төрийн албан хаагч нарын баталгаа бас чухал хууль л даа. Тэгээд сая Мөнх-Оргил гишүүн хэлсэн. Хамгийн гол нь бид нар Үндсэн хуулиараа баталгаажуулах нь нэг асуудал. Нөгөө асуудал бол хамгийн гол нь хуулиа хэрэгжүүлэх л ёстой гэж Монгол Улсад нэг ийм хуулийн засаглал байх ёстой л гэж би ойлгодог юм. Бүх юм хуулийн дор байх ёстой.

Тэгэхээр өнөөдөр бид нар энэ өнгөрсөн хугацаанд ардчилалд шилжээд 29 жил болж байгаа. 29 жил болоход 13 Засгийн газар гараад, нэг Засгийн газрын дундаж хугацаа 1.8 жил гэж ярьж байгаа юм. Тэгээд 300 сайд төрсөн гэж байгаа шүү дээ. Тэгээд энэ бүхэнтэй уялдуулаад ер нь энэ төрийн алба Монголд бол төрийн алба үнэхээр тогтворгүй болчихсон ийм том эмгэнэл байгаа. Энэ бол Монголын төрийн эмгэнэл, монголын эмгэнэл гэж би ойлгоод байгаа юм. Тэгээд яг үндсэндээ ингээд судалгаа хийгээд үзэхээр одоо Монголд бол Монгол Улсын хөдөлмөр эрхэлж байгаа 5 хүний нэг нь төрийн албанд ажилладаг гэсэн нэг ийм судалгаа. 5 хүний нэг нь төрийн албанд ажилладаг. Тэгээд нийт хүн амд эзэлдэг төрийн албан хаагчдынхаа тоогоор олон улсын дунджаас Монгол Улс хамгийн дээгүүр байна гэж. Бид нар 3.2 сая иргэнтэй. Тэгээд одоо 200 гаруй мянган төрийн албан хаагчидтай. Ингээд эргээд харахаар яг энэ төрийн албан хаагчдын маань ур чадвар, мэдлэг, ёс зүй, яг нөгөө монголын ард түмний хүсэж хүлээж байсан ийм төрийн алба мөн үү гэхээр үнэхээр биш байгаа юм л даа.

Тэгээд сонгуулийн дараа ингээд 30 мянгаас 40 мянган хүний ийм шилжилт хөдөлгөөн хийгддэг ийм улс орон ерөөсөө байдаггүй юм байна лээ байдаггүй. Уг нь бол одоо хэдийгээр бид нар төрийн алба болон төрийн үйлчилгээний албанд одоо 200 мянга орчим хүн ажиллаж байгаа ч гэсэн Монгол Улсад улс төрийн албан хаагч гэдэг ийм томъёолол байдаг шүү дээ. Улс төрийн албан хаагч. Энэ улс төрийн албан хаагч бол 500 орчим л байдаг байхгүй юу 500 орчим. Уг нь бол сонгуульд аль нам ялна яг энэ 500 орчим улс төрийн албан хаагч нарын хүрээнд л энэ төрийн албаны шилжилт хөдөлгөөн хийгдэж байх ёстой, халаа сэлгээ хийгдэж байх ёстой. Гэтэл бид нар өнөөдөр 30 мянга, 40 мянган хүний тоонд хүрчихсэн байна гэдэг бол үнэхээр их эмгэнэл. Тэгээд би санаж байна. 2015 онд бас энэ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс үнэхээр одоо ингээд энэ Монголын төрийн албанд байгаа шилжилт хөдөлгөөн бол Монголын аюулгүй байдлын түвшинд хүрчихээд байна гэдэг ийм эмгэнэлтэй сэтгэл харамсмаар бас ийм тайланг танилцуулж байсан.

Тэгээд үнэхээр энэ Монголын төрийн алба бол одоо үнэхээр тогтворгүй болчихсон, чадваргүй болчихсон. Монголын төрд хамгийн чадваргүй, хамгийн ёс зүйгүй энэ хүмүүс нь шургалдаг ийм орон зайг бол энэ улс төрийн сонгуулиар бид нар бий болгоод өгчихсөн гээд бид нарын л алдаа байгаа байхгүй юу, бид нарын эмгэнэл байгаад байгаа юм. Тэгээд энэ бүх зүйлийг одоо бас бид нар нэг талдаа гаргаж Үндсэн хуульдаа ямар ч байсан төрийн алба нь бол мэргэшсэн, тогтвортой, ёс зүйтэй, хариуцлагатай, шатлан дэвших чадахуйн зарчимд үндэслэж байх ёстой гэсэн ийм зүйлийг одоо оруулж өгч байгаа бол их чухал заалт гэж би бол их олзуурхаж байгаа юм.

Нөгөө талаасаа бол бид нар энэ Төрийн албаны зөвлөлийг бол нэлээн бие даасан улс төрөөс ангид байх энэ эрх зүйн орчнуудыг нь энэ органик хуулиараа Үндсэн хууль батлагдсаны дараа бол зайлшгүй хийж өгөх ёстой. Ер нь бол энэ Төрийн албаны тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль гэсэн энэ улс орны амьдралд зайлшгүй шаардлагатай байгаа энэ хуулиудыг бол Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёрын ийм босго зайлшгүй тавьж байж энэ бол цаашдаа ийм тогтвортой байх, төрийн бодлого, залгамж халаатай байх энэ нөхцөл байдлууд нь үүснээ л гэж би ойлгоод байгаа юм.

Тэгэхээр одоо өнөөдрийн энэ Үндсэн хуулийн хийж байгаа энэ өөрчлөлтийнхөө дагуу бид нар дахиад одоо Төрийн албаныхаа зөвлөлийн бие даасан улс төрөөс хараат байх энэ эрх зүйн орчинг зайлшгүй бид нар бий болгож өгөх ёстой. Ер нь бол энэ Төрийн албаны зөвлөл 200 мянган хүнийхээ төлөө бас хариуцлага хүлээж байх ёстой гэж ойлгож байгаа шүү дээ бид нар. Тэгээд одоо нэг сайд томилогдож очдог, нэг сайдын нүүрийг хардаг, нэг сайдад таалагдаж ажиллах гэж өнөөдөр төрийн албанд ажиллаж байгаа хүмүүс үнэхээр зовж байгаа шүү дээ. Дандаа нэг дарга нарынхаа зан араншинд, дарга нарынхаа одоо тэр арга барилд зохицож ажиллах гэж ёстой дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу байгаа ийм л үлгэр байгаад байхгүй юу. Ер нь Монголын төрийн алба бол сайн засаглалтай хувийн компаниудаас долоон дор орчихсон байгаа шүү. Монголын төрийн алба бол сайн засаглалтай.

Өнөөдөр бол хувийн хэвшил, хувийн компаниуд бол энэ удирдлагын засаглалыг нэлээн нээлттэй болчихсон байж байгаа. Гэтэл өнөөдөр монголын төр яг энэ хувийн хэвшлийн энэ засаглалтай, компанийн засаглалтай харьцуулахад бол энэ түвшинд бид нар хүрч чадаагүй байгаа. Энэ бол бид нарын маш том эмгэнэл байгаа юм. Тэгэхээр энэ асуудлуудыг бол бид нар үнэхээр харж хандаж, одоо энэ өнгөрсөн хугацаанд 29 жилийн хугацаанд хийсэн энэ алдаа завхралуудаа бид нар зайлшгүй арилгаж байж энэ монголын төрд итгэх энэ ард түмний итгэлийг бид нар монголын төрийн албыг сайжруулж байж монголын төрийн албанд нь хамгийн чадварлаг, хамгийн ёс зүйтэй, мэргэшсэн энэ хүмүүсийг ажиллах энэ эрх зүйн орчин энэ хаалтуудыг бид нар хийж өгөх зайлшгүй бас шаардлага байгаа л гэж би хараад байгаа юм.

Одоо ингээд сүүлийн үед төрийн албанд зарлагдаж байгаа энэ зарлалууд, энэ тавьж байгаа шалгуурууд бол дандаа тухайн албанд авъя гэсэн хүндээ зориулсан дандаа ийм шалгуурууд тавьдаг байхгүй юу авъя гэсэн. Гэтэл өнөөдөр тэр Харвард төгссөн, Стэнфорд төгсөөд ирсэн өнөөдөр энэ дэлхийн шилдэг улсуудыг төгсөөд ирсэн энэ залуучууд монголын төрд ажиллах тэр шалгуур, тэр босгыг давж чадахгүй байна гэдэг дээр бол үнэхээр том эмгэнэл байгаа юм. Тэгэхээр энэ бүх асуудлуудыг бол бид нар цэг тавихаас одоо өөр арга. Одоо бид нар Англи гэдэг юм уу, Англи өнөөдөр хэдэн хүн амтай билээ. Өмнөд Солонгос бид нар өнөөдөр хэдэн хүн амтай билээ, энэ бүх хөгжсөн дэвжсэн Сингапур гээд

энэ бүх улсуудтай харьцуулахад бол эд нар яагаад хөгжсөн юм бэ гэхээр төрийн албандаа хамгийн чадварлаг улсуудыг л одоо ажиллуулж чадсан учраас энэ улс орон хөгжсөн байдаг юм байна лээ. Сингапурыг үүсгэн байгуулсан, Сингапурын эцэг гэж яригддаг Ли Куан Ю гэж хүний үг байдаг шүү дээ. Сингапурын хөгжлийн нууц нь юу байсан юм бэ гэхээр бид нар төрийнхөө албанд хамгийн чадварлаг хүмүүсийг ажиллуулсан нь өнөөдөр Сингапур улсын хөгжлийн ийм хөгжил дэвшилд хүргэсэн ийм нууц байдаг гэж хэлсэн байдаг.

Тэгэхээр өнөөдөр цаашдаа бол бид нар Монголын төрийг Монголын төрд бол хамгийн чадварлаг, хамгийн мэргэшсэн энэ залуучууд орж ажиллах энэ боломжуудыг бид нар энэ Үндсэн хуулийнхаа өөрчлөлтөөр бас хийх, дагаад энэ Үндсэн хуулийн өөрчлөлтүүдийг дагаж гарах органик хуулиараа энэ боломжуудыг олгох зайлшгүй одоо шаардлага бол Монгол Улсад үүссэн байгаа гэдгийг би бас хэлэхийг хүсэж байна.

Г.Занданшатар: Одоо Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн үг хэлнэ. Алга байна. Одоо эрхэм гишүүн Содномын Чинзориг үг хэлнэ.

С.Чинзориг: Үндсэн хуулинд төрийн жинхэнэ албатай холбоотой ийм бас хуулийн заалт орж байгааг нь би бас зарчмын хувьд бол дэмжиж байгаа юм. Монгол Улсад өнөөдөр төрийн албанд ажиллаж байгаа 192 мянган албан хаагчид бол байна. Эдгээр 192 мянган иргэдийн албан хаагчдын чинь бол ихэнх нь, дийлэнх нь тэр үйлчилгээний одоо албан хаагчид байгаа шүү дээ эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллаж байгаа албан хаагчид. Тийм учраас төрийн жинхэнэ алба хааж байгаа иргэдийг нийт төрийн алба хааж байгаа ажилтнуудтай адилтгаад 192 мянган хүн гээд бас одоо энийг ярьж өрөөсгөл байгаа юм.

Ер нь төрийн алба тогтвортой байж байж, мэргэшсэн байж байж энэ монгол төрийн бодлого шинжлэх ухааны үндэслэлтэй, тооцоо судалгаатай боловсрогдох ийм одоо үндэслэл нь бүрдэнэ. Бид сүүлийн 20 гаруй жил төрийн албыгаа дэндүү одоо тогтворгүй ажиллуулж ирсэн, төрийн албаны бүтэц нь тогтворгүй байдаг, улс төрийн сонгуулийн дараагаар төрийн албан хаагчид хомроглон, жинхэнэ албан хаагчид хомроглон халагддаг ийм байдлаар олон жил явж ирсэн. Тийм учраас төрийн жинхэнэ албатай холбоотой асуудлыг зарчмыг нь Үндсэн хуульдаа оруулаад томъёолоод одоо явахыг нь би зөв зүйтэй гэж бас дэмжээд байгаа юм.

Ер нь энэ төрийн алба тогтворгүй байгаагаас болоод Монгол Улсын хөгжлийн бодлого шинжлэх ухааны үндэслэлгүй болж ирж байгаа юм. Төрийн албан хаагчид мэргэжлийн бус, мэргэшсэн бус одоо болж ирж байгаа юм. Түүнийгээ дагаад Монголд төрийн бодлого чадамжгүй байх, түүнээсээ улбаалаад монгол төрийн нэр хүнд иргэдийн дунд унах энэ асуудлууд энэнээс улбаатай гэж үзэж байгаа. Ер нь төрийн албатай холбоотой асуудлыг Үндсэн хуулинд оруулж байгаа нь бол нэлээхэн том дэвшил болж байгаа. Харин үүнийгээ дагаад чаддаг бол төрийн албаны бүтэц, ялангуяа Засгийн газрын бүтэц тогтвортой байх тухай асуудлыг нь уг нь давхар хийгээд өгөх юм бол бидний яриад байгаа энэ төрийн алба бол мэргэшсэн байх, тогтвортой байх гэдэг асуудал бол жинхэнэ утгаар хэрэгжих нөхцөл нь одоо боломж нь бүрдэх юм.

Төрийн алба Засгийн газрын бүтэц тогтворгүй байдгаасаа шалтгаалаад төрийн алба өөрөө тогтворгүй байх, мэргэшсэн бус байх ийм нөхцөл байдал руу орчхоод байгаа юм. Тийм учраас гишүүд бас энэ дараагийн асуудлууд ярихдаа Засгийн газрын бүтэцтэй холбоотой асуудал дээр Засгийн газрын бүтэц тогтвортой одоо байх асуудлыг ч гэсэн бас зэрэгцээ авч үзээд, Үндсэн хуулиндаа оруулчих юм бол төрийн алба мэргэшсэн байх, тогтвортой байх, монгол төрийн одоо бодлого тогтвортой байх, монгол төрийн бодлого шинжлэх ухааны үндэслэлтэй, тооцоо

судалгаанд үндэслэгдсэн байх энэ одоо асуудлууд нь бол шийдэгдээд явах ийм бүрэн боломжтой болох юм. Үүнийгээ дагаад монгол төрийн чадамж нэмэгдэх, монгол төрийн нэр хүнд иргэдийн дунд өсөх ийм одоо үндэс нь болно гэсэн би ийм бодолтой байдаг юм.

2020 оноос эхлээд 2019 оноос эхлээд Их Хурлаас баталсан Төрийн албаны тухай шинэчилсэн найруулгаар батлагдсан хууль хэрэгжээд эхэлж байгаа юм. Энэ хуулинд бол төрийн алба ялангуяа төрийн жинхэнэ алба мэргэшсэн байх, тогтвортой байх, шатлан дэвших зарчимд үндэслэсэн байх, чадахуйн зарчимд үндэслэсэн байх гээд маш одоо олон дэвшилттэй заалтууд бол орсон. Үүнийгээ тодорхой зарчмыг нь Үндсэн хуулинд баталгаажуулж өгөөд явахыг нь би зарчмын хувьд дэмжиж байгаа юм.

Ер нь улс төрийн албан тушаалтнууд нь сонгуулийнхаа үр дүнгээр чөлөөлөгдөөд л явдаг. Төрийн албанд тогтвортой ажилладаг байх ийм нөхцөл боломжийг нь бид нар нээж өгөх цаг нь болсон. Сонгуулийн үр дүнгээр төрийн албан хаагчдыг хоморголон халдаг, мэргэжлийн бус улсууд төрийн албанд авдаг энэ одоо байдлаас чинь болоод монгол төрийн чадамж одоо унаж байгаа, нэр хүнд унаж байгаа, монгол төрийн бодлого шинжлэх ухааны үндэслэлгүй, тооцоо судалгаагүй гарах ийм байдлууд бол үүсээд байгаа юм. Харин энэ зүйлийг, заалтыг хэлэлцэхдээ Их Хурлын даргаас санал болгоход хэлэлцүүлгийн гурав дахь шатны хэлэлцүүлгийн явцдаа найруулгаар зарим зүйлийг нь засаад аваад явчих аа гэсэн чиглэл өгөөд явчих юм бол би болох юм байнаа гэж бодож байгаа юм. Тухайлбал тэр шатлан дэвших чадахуйн зарчимд үндэслэх гээд биччихээр энэ хоёр чинь нэг үг шиг ингээд гишүүдэд ойлгогдоод байгаа нь үнэн. Энэ хоёр чинь өөр одоо хоёр зарчим аа. Нэг нь бол шатлан дэвших зарчим, нөгөөдөх нь бол чадахуйн зарчим гээд. Өөрөөр хэлбэл нэг нь карьерын зарчим, нөгөөдөх нь тэр одоо төрийн албан хаагчийн ажлын туршлага, ур чадварт нь түшиглэсэн байх энэ бол зарчим гээд.

Тийм учраас бол гурав дахь шатны хэлэлцүүлэг дээрээ шатлан дэвших болон чадахуйн зарчимд гээд одоо найруулаад аваад явчих юм бол энэ гишүүдийн яриад байгаа ойлголтын зөрүүтэй холбоотой асуудал бол аль аль цэгцлээд явчихна. Хоёр дахь асуудал нь төрийн жинхэнэ албан хаагчийг хуульд заасан үндэслэлээр, бусад үндэслэлээр халах, чөлөөлөхийг хориглоно гээд бас заачихаар ёс зүйн дүрэмтэй холбоотой асуудал яах уу гэж бас гишүүд яриад байгаа нь энэ бас үнэн үг л дээ. Тийм учраас гурав дахь шатныхаа хэлэлцүүлэг дээр энэ зүйлийг найруулаад хууль, тогтоомжид зааснаас бусад үндэслэлээр гээд ингээд найруулгаар аваад явчих юм бол хууль нь ч орно, хууль, тогтоомж нь ч орно, тэр дотор нь дүрэм, журам нь ч гэсэн одоо ороод явчих ийм бас боломжтой болох юм.

Тийм учраас ийм одоо чиглэлүүдээр гурав дахь шатны хэлэлцүүлэг дээр энэ асуудал ярихдаа найруулгаар аваад явчих аа гэсэн энэ одоо чиглэл өгөөд явах юм бол энэ одоо Үндсэн хуулинд ороод явахад бүрэн хэрэгжээд явах ийм боломж нь бүрдэнэ гэсэн ийм саналтай байна.

Г.Занданшатар: За тэмдэглэж авлаа. Эрхэм гишүүн Сүхбаатарын Батболд үг хэлнэ.

С.Батболд: Чухал асуудал л даа. Энэ бол бас Төрийн байгуулалтын байнгын хорооноос дэмжсэн энэ санал дээр төрийн албан хаагчийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр халж болно гэж ингэж тусгасан байна. Тэгэхээр төрийн албан хаагчид ерөнхийдөө Үндсэн хуулийн хэмжээнд хамгаалалттай болж байнаа гэсэн үг. Тэгээд хууль бусаар халсан дарга даамал нар бол Үндсэн хууль зөрчиж байнаа

гэсэн ийм одоо зүйл болж байна л даа. Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол Үндсэн хууль зөрчсөн учраас өөрсдөө ажлаасаа халагдах ийм үндэслэл болно. Тэгэхээр энэ төрийн албыг тогтворжуулахад бол маш чухал ач холбогдолтой ийм заалт орж байнаа гэж ингэж дэмжиж байгаа юм.

Тэгээд үүн дээр нэмээд бас шатлан дэвших чадахуйн зарчмыг Үндсэн хуульд зааж өгч байгаа нь бол бас онцгой ач холбогдолтой. Тэгээд энэ зарчмыг зөрчсөн дарга даамлууд бас Үндсэн хууль зөрчсөн ийм асуудалд орно. Тэгэхээр энэ бол төрийн албыг нэгдүгээрх нь тогтворжуулна, бас зэрэгцээд маш чанаржуулах төрийн албан хаагчдыг төрийн албыг чанаржуулах ийм одоо чухал ач холбогдолтой заалт болж орж байнаа гэж ингэж дэмжиж байгаа юм. Харин нөгөө талаасаа бол төрийн албан хаагч нь өөрөө мэргэшсэн, ёс зүйтэй байх хариуцлагын тогтолцоогоо Төрийн албаны зөвлөлөөс сайн бүрдүүлэх ёстой юм. Илүү одоо сайтар бүрдүүлж. Тэгээд өнөөдрийн байдлаар бол төрийн албан хаагчдын ур чадвар, ажлын үр дүнг үнэлэх тогтолцоо бол яг тийм бодитойгоор бүрдэж чадаагүй байна. Энэний жишээ бол олон ярьж байна л даа сая одоо гишүүд маань бол мерит зарчмын тухай, ер нь одоо чадахуйн зарчмыг хэрэгжүүлэхгүй байгаа олон жишээ бодит байдлуудыг ярьж байгаа юм.

Тэгээд энийг зөвхөн одоо төрийн албанд нэгэнт орчихсон төрийн албан хаагчдын тухай ярихаас гадна ер нь төрийн албанд орох энэ одоо чанартай, энэ шалгуур ямар байх вэ гэдгийг бол бас давхар бодож байх ёстой л доо. Тэгээд энд бол хэрэгжихгүй байгаа зүйлүүд олон байгаа юм. Жишээлбэл одоо Монгол Улсын тэргүүлэх сургуулиудыг Монгол Улсын Их Сургууль байна, ШУТИС, Анагаах, Хөдөө аж ахуй, Санхүү, эдийн засгийн сургууль ч гэдэг юм уу олон тэргүүлэх сургуулиудыг амжилттай, тэр голч дүн нь одоо маш өндөр ингэж төгсгөж чадсан залуучууд маань бол төрийн ажилд орох энэ ямар нэгэн давуу тал байхгүй байгаа юм. Тэгэхээр энэ маш их хөдөлмөрөөр олон жил сайн сураад, өндөр голч дүнтэй байгаа мөртлөө яг төрийн албанд орох энэ нөхцөл боломж нь энэ давуу тал, ямар нэгэн одоо урамшууллын хөшүүрэг бол энд байхгүй байгаа нь дахиад анхнаасаа энэ чадахуйн зарчмыг эхнээс нь төрийн албанд хэрэгжүүлэх ажил бол бас дутагдалтай байнаа гэсэн ийм зүйл бас яригдаж байгаа юм.

Тэгээд энэ хөшүүргийг бол бас нэмж өгөх ёстой. Эдгээр сургуулиудыг маш сайн дүнтэй төгссөн хүүхдүүд жишээлбэл төрийн албанд элсэж ороход ур чадвар, мэргэжил мэдлэгийн хувьд бусдаасаа бас тодорхой давуу ийм нөхцөл байх ёстой гэж үзэж байгаа юм. Дахиад нэг жишээ хэлэхэд бол шатлан дэвших чадахуйн зарчмыг Төрийн албаны тухай хуулийг шинэчилж батлаад, энэ оны эхнээс хэрэгжүүлээд эхэлсэн. Гэтэл хэрхэн, яаж хэрэгжүүлэх талаар тодорхой заавар, журам бол харьцангуй дутмаг байгаа. Тийм учраас ихэнхдээ одоо өнөөдрийн гишүүдийн яриад байгаа үзэмжээр юм уу ямар нэгэн одоо тийм давуу эрхээр томилолт хийгдээд байна. Улс төрийн болон бусад гэж. Энэ асуудал бол ерөөсөө тасрахгүй байна. Тэгэхээр Төрийн албаны зүгээс шатлан дэвшүүлэх зарчмаа журмаа нарийвчилж тогтоогоод, чадахуйн зарчмыг хэрхэн яаж үнэлэх, тэр журмаа маш нарийн заахгүй бол ерөнхийдөө энэ маань нэг тийм хоосон зорилт болоод байнаа гэсэн үг.

Тэгээд ер нь одоо хүмүүс шүүмжлээд байгаа шүү дээ. Аль ч яаманд очсон ажлаа хийдэг нэг цөөн тооны хэсэг байна. Мөн одоо наана цаанаас одоо янз бүрийн ар өврийн хаалгаар орж ирээд ажил хийхгүй нэг хэсэг байнаа гэж. Тэгэхээр энийг бас чанаржуулах, анхаарах асуудал энэ журамтай холбоотой. Тэгээд төрийн албыг Үндсэн хуулийн хэмжээнд хамгаалалттай болгож, тогтворжуулах заалт оруулж байгаа учраас одоо эргээд төрийн албаа мэргэшүүлэх, чадваржуулах ажлыг бол энд бас Төрийн албаны зүгээс тодорхой болгож өгөх ёстой гэж. Тэгээд

Үндсэн хууль төрийн албан хаагч ёс зүйтэй байна гэж зааж байгаа учраас Төрийн албаны ёс зүйн дүрмээ бол бас маш нарийн батлах ёстой гэдэг ийм зүйлүүдийг нэмж хэлье гэж бодсон юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Магваны Билэгт.

М.Билэгт: Төрийн албыг, албан хаагчдыг тогтвортой ажиллуулах талаас нь Үндсэн хуульд оруулж өгч байна л даа. Гэхдээ одоо байгаа энэ сүүлийн хэдэн жилд энэ тэр тусмаа яамны аппаратад олон жил ажиллачихсан энэ хүмүүс маань ихэнхдээ ерөөсөө энэ ямар нэгэн арын хаалгаар, за тэгээд яах вэ гэхээр бүр тэнд байх тийм өөр хүн ирүүлэхээргүй тийм арга залиг тэнд бий болгож чадсан, тэгж өөрөө тогтож байх арга заль муу аргаар тэнд байх арга олчихсон ийм хүмүүс нь байгаа байхгүй юу. Өнөөдөр байгаа төрийн албан хаагчдыг иргэд маань үнэхээр тэд нар иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх тийм хэмжээнд тийм ёс суртахуунтай, хариуцлагатай хүн нь ховор байгаа шүү дээ. Эндээс болоод иргэдийн төрд итгэх итгэл, урам нь хугараад байгаа юм байхгүй юу.

Тийм учраас одоо хуульчилж ингэж заах гэж байгаа бол нэг нь Үндсэн хуулиндаа оруулах гэж байгаа бол энийг харин одоо 2020 оны 1 сарын 1-нээс эхлээд наана нь тэр жинхэнээс нь сонгон шалгаруулалтыг нь зөв хийгээд, тэр чадахуйн зарчим, ёс суртахуунтай, хариуцлагатай ийм хүмүүсийг сонгон шалгаруулж одоо шинэчилж оруулах энэ нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй. Одоо энэ байдлаар харахаар зэрэг өмнө нь байгаа л нөгөө иргэдэд маань гологдоод байгаа, энэ 20 хэдэн жил тухайн яаманд байгаа аппаратын ажилтнууд тухайн салбараа авч явж чадаагүй, тухайн салбарын менежментийг зөв хийж явж чадаагүй, яг л тэр төлөвшил нь бий болчихсон нөгөө авлигаар заавал ажлыг явуулдаг, тэр арга нь юу вэ гэхээр зэрэг үгүй гэсэн шантаажийг бий болгодог, ямар ч аргаар хамаагүй. Ийм төлөвшилтэй болчихсон хүмүүс нь одоо бол төрийн албанд дийлэнхдээ байгаа шүү гэдгийг бас хэлмээр байна.

Яагаад гэвэл энэ чинь дандаа улс төрчдийн томилгоогоор нөгөө сонгуульд нь ажилласан гэдгээр томилогдож очсон тийм л хүмүүс нь одоо байгаа шүү дээ. Тийм учраас энэ дээр одоо төрийн албыг ингээд албан хаагчдыг тогтвор суурьшилтай байлгах гээд Үндсэн хуульд оруулдаг нь зөв. Гэхдээ одоо байгаагаа жинхэнэ шилж сонгож, дахиад шинээр орох боломжтойгий нь энд сонгон шалгаруулалтыг нь зөв хийх хэрэгтэй. Тэгэхдээ сонгон шалгаруулалт хийхдээ энэнээс өмнө бол одоо энэ мөчөөс өмнө бол тухайн сонгон шалгаруулалтад оруулах гэж байгаа хүндээ тааруулж тэр сонгон шалгаруулалтын заалтыг нь бичдэг л дээ. Энийг бүх хүн мэддэг шүү дээ. Тэгэхээр зэрэг одоо байгаагаа яг байгаагаар нь дахиж халахааргүй хэмжээнд болгоод дархлаажуулах гэж байгаа бол монголын төрийн алба сайжрахгүй ээ. Монголын төрийн албанд иргэдийн итгэдэг итгэх итгэл дээрдэхгүй ээ. Яагаад гэвэл тэдний төлөвшил нөгөө л авлига, хүнд суртал тэр нь бүр гүн бат суучихсан учраас энэ бол дээрдэхгүй гэдгийг л хэлэх гээд байна л даа.

Тэгэхээр зэрэг яаж байж одоо энэ төрийн албыг, албанд ажиллаж байгаа хүн тухайн одоо цалинд нь болж биш чин сэтгэлээрээ төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх монголын ард түмэнд жинхэнэ одоо эцэг шиг нь, эх шиг нь тийм сэтгэлээр хандаж үйлчлэх ийм хүмүүсийг тавих юм бэ гэдэг байгаа юм. Жишээ нь одоо төрийн өмчит компаниудад л ингээд хүмүүсийг солиод тавиад л байдаг. Тэгсэн мөртлөө төрийн өмчит компаниуд бол бүгд алдагдалтай ажилладаг. Алдагдалтай ажиллаж байгаа мөртлөө нөгөө удирдлага нь тэр 5 сая, 10 саяынхаа тэр цалинг

аваад л байж байдаг. Ийм байж болохгүй шүү дээ. Тэгээд яг ийм байдлаараа яваад л энэ 20 хэдэн жил болсон.

Тэгэхээр зэрэг одоо Эрүүгийн хуулинд ч гэсэн бас ажлын хэсэг төрийн эрх мэдэлтэй албан тушаалтан тэгээд шийдвэр гаргахдаа хэрэв 10 саяас дээш хэмжээний хохирол учруулах хэмжээний шийдвэрийг гаргасан бол эрүү үүснэ гээд байж байгаа. Тэгсэн мөртлөө жирийн иргэн бол 300 мянган төгрөг, тэрнээс дээш хэмжээний хэн нэг нь хохирол учруулсан бол эрүү үүсэхээр байж байгаа. Ийм л өдөр шөнө шиг ялгаатай байгаа шүү дээ. Тэгэхээр энийг зохицуулаагүйгээр одоо байгаагий нь дархлаажуулах гэж байгаа бол энэ бол болохгүй ээ. Харин одоо сая Энх-Амгалан гишүүний хэлж байгаа тэр юу санал нэг байна. Хувийн хэвшил бол үнэхээр сайн ажиллаж чадаж байгаагаа ажилд нь байлгадаг юмаа. Сайн ажиллаж чадаж байгаа хүн нь ажлаас гарах гэх юм бол харин нэмэгдэл одоо амлалт болзол тавиад тэр хүнийг ажилд нь байлгаж тогтоохыг хүсдэг юмаа. Гэтэл төрийн алба бол тийм бишээ. Тэгэхээр зэрэг одоо байгаагаа дархлаажуулах гэж байгаа бол шинээр одоо энэ жинхэнэ одоо шударга, ёс зүйтэй, өндөр боловсролтой, чин сэтгэлээсээ энэ монголын төрд ажиллаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх гэсэн чин зорилготой нэг хэсэг нь бол орж чадахгүй юм байна гэж эндээс харагдаж байна гэдгийг би дахиад хэлэх гэж байна.

Тэгэхээр яг өнөөдрийн хувьд бол энэ байгаагий нь байгаа төрийн албан хаагчдыг дархлаажуулна гэж үзэж байгаа бол энэ бол бэлтгэгдээгүй гэж хэлмээр байна. Тэгэхээр зэрэг энд нэг тодорхой хугацаа тавих ёстой юм уу, яах ёстой юм мэдэхгүй. Тэгээд одоо бол яадаг вэ гэхээр зэрэг ер нь нийт хөдөлмөр эрхлэх насны иргэд бол сая 200 мянга байгаа. Эндээс зөвхөн 200 мянга орчим иргэн л төрийн албанд тогтмол цагаа л бүртгүүлсэн бол цалингаа аваад л явж байгаа. Хувийн хэвшлийнхэн бол хоёр нарны хооронд ажиллаж, үнэхээр алдагдалгүй бол хөөрхий минь тэр цалингаа авна уу гэхээс биш алдагдалтай ажиллаж байх юм бол тэр компани дампуураад, ямар ч цалин авах аргагүй л байдалд хүрдэг байхгүй юу. Тэгэхээр зэрэг хувийн хэвшлээ дэмжих юмыг энэ төр, засаг өнөөдөр 20 хэдэн жилийн хугацаанд хийгээгүй шүү дээ. Тэгсэн мөртлөө зөвхөн 200 мянган хүнийг л одоо ажлаас нь халахгүйгээр байлгах юмыг энэ Үндсэн хуулиараа баталгаажуулах гэж байгаа нь өнөөдрийн хувьд бол би бэлтгэгдээгүй гэж хэлмээр байна гэж. Энэ дээр тэгэхэд тодорхой хэмжээнд өөрчлөлт оруулаад, тэр ёс зүйтэй, хариуцлагатай байх юмыг нь хэрвээ тийм алдаа гаргах юм бол энэ халагдах ёстой гэдгийг энэ төрийн албан хаагчийг хуульд зааснаас бусад үндэслэлээр гэдэг дотор энэ үг ормоор байна. Тийм учраас энэ болгон дээр бас нэлээн өөрчлөлт хийх хэрэгтэй юм байна, энэ заалтыг бол дэмжиж чадахгүй нь ээ гэж хэлмээр байна.

Харин ч эсрэгээрээ хувийн хэвшилд ажиллаж амь амьжиргаагаа залгуулж байгаа иргэд бол аливаа ажлыг хийх гарцыг хайх гэж жинхэнэ толгойгоо ажиллуулдаг ийм л иргэд нь тэнд байдаг юм л даа. Тийм учраас энэ заалтыг бол энэ удаад бол шууд ингээд хэрэгжүүлнээ гэх юм бол одоо байгаа төрийн албан хаагчдыг дархлаажуулна гэж, хэрэгжүүлнэ гэж энэ заалтыг оруулж байгаа бол энийг бол дэмжиж чадахгүй нь ээ гэдгийг хэлье.

Г.Занданшатар: За одоо эрхэм гишүүн Ням-Осорын Учрал үг хэлнэ.

Н.Учрал: Би зарчмын зөрүүтэй санал бол гаргасан. Тэгээд энэ санал дээр та бүхэн бол харж байгаа. Энэний дараа санал хураагдах гэж байгаа, нэг санал байгаа. Тэр нь юу вэ гэхээр шатлан дэвших гэдэг энэ үгийг энэ Үндсэн хуулиас авъя гэдэг ийм одоо би саналтай байгаа. Яагаад вэ гэхээр энэ Үндсэн хуулин дээр шатлан дэвших гэсэн үгийг оруулж ирэх юм бол цаашдаа ирээдүйн олон залуучуудад төрийн албанд орох хаалгыг хаана. Өнөөдөр төрийн алба чинь хүн

ажиллахаа больчихсон, тэгээд одоо сайн, мэдлэг боловсролтой залуучуудыг оруулж ирээд ажиллуулъя гэхээр тэр босгыг нь давдаггүй. Гадаадад сургууль төгсөөд өндөр боловсрол эзэмшээд эх орондоо хөгжил цэцэглэлтэнд хувь нэмрээ оруулъя гэхээр Төрийн албаны хууль гээд нэг том босго тавьчихсан. Ийм болчихсон шүү дээ.

Тийм учраас би тэр Төрийн албаны хууль гэдэг энэ хууль чинь энэ Парламентын түүхэнд хамгийн их тод хар мөрөөр үлдсэн хууль шүү. Тийм Төрийн албаны хуулийг бид нар баталсандаа бол би бас санаа зовж байгаа. Үнэхээр энэ Төрийн албаны энэ хуулийг гарснаас хойш энэ төрд чинь өнгөлөх залуучууд байхгүй болчихсон шүү. Тийм учраас Үндсэн хуулиндаа одоо шатлан дэвших гэдэг ийм зарчмыг оруулж өгөх юм бол цаашдаа энэ чинь ер нь юу болох юм бэ. Шатлан дэвших гэдэг үгийг ер нь юу гэж ойлгох юм. Шатлан дэвших гэж ер нь юу юм. Одоо бүр сүүлдээ шатлан дэвших зарчимтай байнаа гээд тэгээд одоо нэг шат шатанд нь ажиллана гээд ингээд нэг хонины ээлж өнгөрүүлдэг хэдэн хүмүүсийн дэвшдэг нэг ийм алба боллоо шүү дээ энэ төрийн алба чинь. Тэгээд одоо аль болох л урьж авчирмаар байна шүү дээ. Залуучууд аа, та нар энэ цалин нь бага ч гэсэн монгол төрдөө зүтгээч, цалин нь бага ч гэсэн энэ эх орныхоо төлөө нэг сэтгэл гаргаач ээ, сэтгэлээрээ ажиллаач ээ, үнэхээр энэ төрд чинь та нарын дуу хоолой хэрэгтэй байнаа гээд урих гэхээр энэ нэг Төрийн албаны хууль чинь үнэхээр одоо түвэгтэй байна.

Тэгээд одоо бүр сүүлдээ Үндсэн хуулиндаа шатлан дэвших гэдэг ийм зарчим оруулчхаад тэгээд бид нар одоо шатлан дэвшинэ, бид нар одоо энэ дотроо байнаа, ийм одоо шатлан дэвших зарчмаар ажилланаа, чи шатлан дэвшээгүй ээ гээд. Тэгээд өнөөдөр гадаадын их, дээд сургуулиудад сураад, дотооддоо ч гэсэн сураад, эрдмийн зэрэг хамгаалаад, төрд ажиллая гэхээр авахгүй. Авлаа ч гэсэн аваачаад нөгөө нэг анхны мэргэжилтэнгээс нь авахуулаад ажиллуулна. Тэгээд хэн тэнд ажиллах юм бэ. Тэгээд нөгөө залуучууд чинь хувийн компанид ажилладаг эсвэл хувиараа бизнес эрхэлдэг. Тэгээд одоо энэ төрийн алба гэдэг чинь ерөөсөө булингартчихсан юм байна. Энэ төрийн алба гэдэг чинь ерөөсөө бид нарын байх ёстой газар биш юм байнаа гээд ингээд иймэрхүү л ойлголтонд хүрч байна шүү дээ. Яаж монгол төр өндөр боловсролтой, мэдлэгтэй залуучуудыг төрдөө оруулж ирэх вэ гэдэг бодлогыг боловсруулах ёстой болохоос биш Үндсэн хуулиндаа шатлан дэвших гэдэг зарчмыг хийж өгчихөөд хэдэн хүнийг хамгаалах гээд сууж байж болохгүй ээ.

Үнэхээр энэ төрийн албанд ажиллаж байгаа хүмүүс бас намайг буруутгаж магадгүй. Гэхдээ би бол чин шударгаар хэлж байгаа юм. Төрийн албаны олон залуучуудтай уулзсан. Үнэхээр сайн залуучууд энд орж ирэх юм бол бид нар энэ дунд хөгжмөөр байна. Одоо тэгээд л нэг тав, арвуулаа нийлчихсэн. Нөгөө л хэд маань сууж байдаг. Батаа чи одоо дарга болсон одоо Доржоо чи бол гээд ингээд цаашдаа суух нь байна шүү дээ. Одоо цаашдаа ийм байдлаараа яваад монгол төрийг, монгол орныг өөд нь татна гэвэл байхгүй ээ. Ер нь үзэж харснаараа шүү, сурч мэдсэнээрээ шүү. Тэрнээс биш ингээд нэг хоногийн бор хоногийг өнгөрүүлээд нэг явж байгаа нэг хэдэн нөхдүүд энэ төрийг нэг цэвэрлээд, энэ төрд нэг шударга ёс тогтоогоод байнаа гэж байхгүй ээ.

Наад хэд чинь угаасаа сурчихсан ажлаа л хийнэ. Та нар харж байгаа шүү дээ. Төрийн албаны нэр хүнд унаад, шал дээр очсон. Тэгээд наад хэд чинь ийм одоо байдалтай хүмүүс яаж энэ төрийг өөрчлөх юм бэ. Төрийн албанд сайн залуучууд ажиллаж байгаа. Гэхдээ та нарын дунд салхи оруулах цаг ирсэн. Энэ салхийг оруулах гэхээр Үндсэн хуулиндаа шатлан дэвших гээд нэг ийм лоозон тавих гээд байх юм. Одоо энийгээ боливол яасан юм бэ. Шатлан дэвших гэдэг үг

чинь ер нь монгол хэлэнд их ойлгомжгүй үг шүү. Шатлан дэвшинэ гэж ер нь юу юм. Мерит гэдэг үгийг орчуулсан юм шиг байгаа юм. Мерит гэдэг чинь тэгж шатлан дэвших гэдэг үгээр ч орчуулагддаг ч юм биш. Монгол хэлнийхэн хэлж л байна лээ. Мерит гэдэг үгийг чинь ингэж орчуулахгүй ээ.

Тэгэхээр одоо Их Хурлын гишүүдээсээ би хүсэж байна. Ирээдүйн төлөө чин сэтгэл гаргаад энэ Үндсэн хуулинд энэ үгийг авч хаяа. Тэгсэн цагт монгол төрд салхи орно, тэгсэн цагт Монгол орон хөгжил цэцэглэлтийн замдаа орно. Олон сайхан залуучуудыг монгол төр уримаар байна. Бүгдээрээ сайхан эх орондоо хүрээд ир. Одоо гадаадад байгаа хүмүүс харж байгаа шүү дээ. Та нарыг эх оронд чинь авчраад энэ монгол төрд, энэ олон салбарт урьж ажиллуулмаар байна. Та нар маань эх орондоо хүрээд ир. Та нарыг ирсэн цагт та нарын салхи, та нарын дуу хоолой, та нарын мэдлэг боловсрол энэ төрд орж ирж байж цаашдаа улс орон хөгжинэ шүү гэдгийг би бас хатуу хариуцлагатайгаар хэлье.

Г.Занданшатар: За одоо эрхэм гишүүн Ж.Мөнхбат алга байна. Одоо эрхэм гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Би нэг товчхон санал хэлье. Энэ уг нь Үндсэн хууль дээр бол 14.2 дээр ингээд хүнийг ажил албан тушаал, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхаж үл болно гээд байж байгаа юм л даа. Өөрөөр хэлэх юм бол одоо ингэж улс төрийн шалтгаанаар хүнийг халж болохгүй гээд байж л байгаа юм л даа. Тийм учраас бол тэр хэрэгжсэнгүй. Гэтэл одоо ингээд бичлээ гээд яах вэ арай дээрдэх байх л гэж би бодож байна. Тэгэхдээ энийг хэрвээ ингээд одоо төгс сайн болгоё, төрийн албаа одоо мэргэшсэн, тогтвортой байлгая гэвэл тэр тавих хяналт, хараат бус байна гээд байна шүү дээ. Хараат бус байна гээд байгаа юм. Энийгээ тодорхой болгох хэрэгтэй.

Төрийн албаны зөвлөл Үндсэн хуулийн байгууллага болж байж энэ чинь хэрэгжинэ. Хэрвээ яг одоо энийг та нар төгс хийе гэж байгаа юм бол Төрийн албаны зөвлөлөө Үндсэн хуулийн байгууллага болгоод ингээд явах юм бол жинхэнэ хараат бус болно. Тэгээгүй цагт нөгөө улс төрийнхөө томилгоогоор л байгаад байна. Тэгж чадсан улс орнууд бол харин одоо үнэхээр тэр Төрийн албаны зөвлөлдөө явна. Би бас гишүүдийнхээ хэлж байгаатай санал нэг байна. Одоо бол тэр нөгөө нэг бидний 1990 оны, өмнө ажиллаж байсан шиг биш болсон нь бас үнэн. Тийм учраас ер нь яаж одоо чадавхитай болгоод, энийгээ тогтвортой байлгах вэ гэдэг асуудал. Тэр Учралын хэлээд байгаа асуудал. Тэгэхдээ Стэнфорд төгссөн ч бай, хэн ч бай одоо энэ баячууд чинь ухаантай нэг нь бол хүүхдээ мэргэжилтнээс нь эхлүүлж байгаа шүү. Тийм учраас мэргэжилтнээсээ эхлэх бол хэнд ч нээлттэй байгаа.

Тийм учраас их сургуульд шууд сурсан мундаг амьтан гэнгүүтээ газар, хэлтсийн дарга болгож болохгүй. Зүгээр харин тэр дотроо дүрэм журмаа гаргахдаа бол дэвших тэр карьерын системд нь бас эд нарын хэлээд байгаа шиг бас тэр хурдан дэвших ахих тэр юугий нь зөвхөн жилээр нь биш бас ажлын өндөр шалгуураар нь байдаг энэ юуг л зүгээр оруулж өгөх л асуудал юм байгаа юм. Тэрнээс хэнбугай ч бай, ямар ч сургууль төгссөн бай мэргэжилтнээсээ эхэлнэ.

Ер нь бол Төрийн албаны зөвлөл дээрээ л бид нар ач холбогдол өгөөд л Үндсэн хуулийн байгууллага болгочих юм бол энийг бас одоо ингээд гурав дахь хэлэлцүүлгийнхээ өмнө та бүгд энэ хяналт хараат бус байна гэдгээ жаахан тодотгоод өгвөл яачихсан юм бэ. Төрийн албаны зөвлөл байнаа гээд ингээд хэлчих юм бол одоо ёстой асуудалгүй болж эхэлнэ. Энэ улс төрийн хараат бус байгууллага болж эхэлнэ гэдгийг л хэлэх гэсэн юм.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Билэгт гишүүн сонгон шалгаруулалтын шилэн сонгох зарчмыг, Мөнх-Оргил, Учрал, Чинзориг сайд, Даваасүрэн гишүүд бас гаргасан саналыг энэ гуравдугаар хэлэлцүүлэг дээрээ дэмжихэд бол сайтар анхаарч үзэх нь зүйтэй. Тухайлбал Даваасүрэн гишүүний санал тэр Төрийн албаны зөвлөлийг хараат бус байнаа гэсэн ийм томъёоллоор анх бол бид боловсруулж өгсөн боловч энэ ажлын хэсгийн олон явцын дунд энэ өөрчлөгдсөн. Энийг бол энэ Азийн төрт ёсны ижил төстэй уламжлалтай улсуудад одоо Япон, Солонгос, Хятад, Сингапур, Тайвань зэрэг улсууд төрт ёсны Төрийн албаны зөвлөл сонгон шалгаруулалтын засаглал буюу Үндсэн хуулийн эрх мэдлийн байгууллага байж сонгон шалгаруулж, Төрийн албаны зөвлөл нь улс төрөөс бүрэн хараат, зөвхөн сонгон шалгаруулалтаар чадвартай хүмүүсийг элсүүлдэг, шатлан дэвшүүлдэг тэр зарчим дээр үндэслэдэг. Ийм тохиролцооны хэлбэрийг ярьж байгаад ингээд мөлийсөөр байгаад нэг ийм зарчмуудыг оруулчихсан.

Тэгэхээр энэ зарчмууд чинь сонгон шалгаруулалттай л байх зарчим учраас Билэгт гишүүний хэлсэн дээр зөвхөн сонгон шалгаруулдаг ёс зүйтэй, зарчимтай хүмүүсээ сонгон шалгаруулж авдаг, тэгээд чадвартай хүмүүс нь төрийн албанд ажилладаг байх энэ зарчмыг, энэ Учрал гишүүний хэлсэн тэр зөвхөн шатлан дэвших гэдэг үгийг орчихоор мерит буюу чадахуйн зарчим гэдэг нь бүдэгрээд, чадахуйн зарчим дотор л одоо энэ сонгон шалгаруулалт эд нарыгаа оруулаад, найруулж өөрчлөхгүй бол энэ бол бас энэ Төрийн албаны энэ бугшрал ялзрал, ёс зүйгүй, дорой байдал, хариуцлагагүй байдал, авлигад нэрвэгдсэн байдлыг өөрчилж чадах том шинэчлэл болоход эргэлзээтэй боллоо гэж гишүүдийн саналыг харгалзан үзэх чиглэлийг өгч байна. Яах вэ тэр нь шатлан дэвших нь байвал тэгээд тэр органик хуульд байдаг юм уу аль эсвэл өөр зарчимдаа байдаг юм уу.

Гол нь сонгон шалгаруулалтыг яриад байна. Төрийн албаны зөвлөлийг хараат бус байх асуудлыг яриад байна. Өөр олон асуудлуудыг гишүүд гаргаж тавьж байгаа. Эцсийн хэлэлцүүлэгтээ анхаарах нь зүйтэй гэж бодож байна. Одоо санал хураахын тулд гишүүдээ ирцээ бүрдүүл. Тогтохоо дарга горимын санал. За Тогтохсүрэн дарга.

Д.Тогтохсүрэн: Би нэг горимын санал хэлье. Цаг ч бас орой болсон байна. 22.30 болсон байна. Гишүүд ч зарим нь гарч ороод байна. Тийм учраас би өнөөдрийн чуулганаа ингээд завсарлуулаад, гурав дахь өдөр үргэлжлүүлээд хэлэлцээд явбал яасан юм бэ гэсэн ийм горимын санал гаргаж байгаа юм.

Г.Занданшатар: Одоо горимын саналаар чинь санал хураалгах шаардлагагүй. Угаасаа ажлын цаг ингээд тарчихаж байгаа юм тарж болно. Тэгэхээр нэг зарлал байна. Гуравдахийн өглөө чуулган 10 цагаасаа хуралдана. Бүлгийн хурал нэг дэх өдрийн бүлгийн хурал хичээлийн шинэ жилийн нээлттэй учраас хойшлуулах саналууд гишүүдээс ирсэн тул хойшлуулаад, бүлгээс жич зарлаад ингээд гуравдахийн өглөө 10.0 хувь ирцтэй байна шүү гэдгийг хатуу анхааруулж байна. Өнөөдрийн чуулган үүгээр өндөрлөлөө. Гуравдахийн чуулганд бүрэн ирээгүй гишүүдтэй хатуу хариуцлага тооцох болно шүү.

Дууны бичлэгээс буулгасан:

ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Б.БАТГЭРЭЛ

Ц.АЛТАН-ОД

Д.ЦЭНДСҮРЭН

П.МЯДАГМАА

Б.БААСАНЖАВ Гэрээт/

Б.УРАНЧИМЭГ /Гэрээт/

Д.ЭНЭБИШ /Гэрээт/